



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл

Цуврал 1 (81)

Улаанбаатар хот
2021 он

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Эх бэлтгэгч, дизайнер: З.Эрдэнэтөгс

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/,
Хуульчдын гудамж 1,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.nli.gov.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:	Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн ухааны доктор (<i>Dr.jur.</i>), Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Эрхлэгч:	П.Амаржаргал Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Гишүүд:	С.Нарангэрэл Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (<i>Sc.D.</i>), МУИС-ийн эмерит профессор Ц.Сарантуяа Хууль зүйн шинжлэх ухааны доктор (<i>Sc.D.</i>), профессор, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төслийн удирдагч Д.Зүмбэрэлхам Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), профессор, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Сарпеков Р.К. БНКаЗУ-ын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэнгийн захирал, БНКаЗУ-ын Гавьяат ажилтан Анна Тумурова Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), ОХУ-ын Буриадын Улсын их сургуулийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхимийн профессор Пак Жеон Вон Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), профессор, БНСУ-ын Кужмины их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хууль зүйн коллежийн тэнхимийн эрхлэгч Том Гинсбург Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), АНУ-ын Чикагогийн их сургуулийн профессор Ж.Эрхэсхулан Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), профессор, МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн эрхлэгч Д.Сүнжид Хууль зүйн ухааны доктор (<i>Dr.jur.</i>), Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Удирдлагын академийн дэд профессор Накамура Масаки Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), Япон Улсын Нагоягийн их сургуулийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор Ц.Цогт Хууль зүйн ухааны доктор (<i>LL.D.</i>), Улсын дээд шүүхийн шүүгч М.Уянга Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), МУИС-ийн ХЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор Б.Улаанбаатар Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор Ц.Давхарбаяр Хууль зүйн ухааны доктор (<i>Ph.D.</i>), МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор
Хариуцлагатай нарийн бичгийн дарга:	Г.Тэгшжаргал Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

EDITORIAL BOARD

- Editor-in-Chief:** **Kh.Erdem-Undrakh** *Dr.jur., Director, The National Legal Institute of Mongolia, Honorary Assoc. Prof., NUM*
- Executive Editor-in-Chief:** **P.Amarjargal** *Ph.D., Scientific Secretary, The National Legal Institute of Mongolia*
- Editorial Board:**
- S.Narangerel** *Sc.D., Member of the Academy of Sciences, Emeritus Professor, National University of Mongolia*
- Ts.Sarantuya** *Prof. Sc.D., Hanns-Seidel Stiftung der Mongolei, Germany*
- D.Zumberellkham** *Prof. Ph.D., Member of the Civil Service Council of Mongolia*
- Sarpekov R.K.** *Director of the Institute of Legislation and Legal Information of The Republic of Kazakhstan, Honored Worker of The Republic of Kazakhstan*
- Anna Tumurova** *Prof. Ph.D., the Department of Theory and History of Law, Buryat State University, Russian Federation*
- Park Jeon Wong** *Prof. Ph.D., Dean, College of Law & Graduate School of Legal Affairs, Kookmin University, South Korea*
- Tom Ginsburg** *Prof. Ph.D., The University of Chicago, USA*
- J.Erkheskhulan** *Assoc. Prof. Ph.D., Director of the Legal Clinic, School of Law, National University of Mongolia*
- D.Sunjid** *Assoc. Prof. Dr.jur., National Academy of Governance, Member of the NHRC, Mongolia*
- Masaki Nakamura** *Assoc. Prof. Ph.D., Faculty of Business Administration, Nagoya University of Economics, Japan*
- Ts.Tsogt** *LL.D., Judge, Supreme Court of Mongolia, Honorary Assoc. Prof., School of Law, NUM*
- M.Uyanga** *Assoc. Prof. Ph.D., Scientific Secretary, School of Law, National University of Mongolia*
- B.Ulaanbaatar** *Assoc. Prof. Ph.D., Private Law Department, School of Law, National University of Mongolia*
- Ts.Davkharbayar** *Assoc. Prof. Ph.D., Private Law Department, School of Law, National University of Mongolia*
- Associate Editor:** **G.Tegshjargal** *Researcher, The National Legal Institute of Mongolia*

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute publishes
Mongolian Journal of Law five times
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ

Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага, үндсэн өөрчлөлтүүд	11
--	-----------

Удирдлагын Академийн профессор, доктор Б.Уранцэцэг

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Пробацийн үйл ажиллагааны онцлог, анхаарах асуудал	27
---	-----------

ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн дарга, хууль зүйн доктор, хурандаа Ц.Очгэрэл

ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн мэргэжилтэн, докторант, хошууч А.Цэнгэл

Цахим сүлжээ ба цахим хэлцэл	37
-------------------------------------	-----------

СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч В.Амартүвшин

Монгол Улс дахь хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчим, практик хэрэглээ	48
--	-----------

Өмгөөлөгч Б.Билгүүн

Монгол Улсад цахим худалдааны бие даасан хууль боловсруулах, батлах ажилд хэрэгцээт санал гаргах нь	59
--	-----------

МУИС-ийн ХЗС-ийн магистрант Б.Гүнзаяа

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Иргэний хуулийн 498-р зүйлийн талаарх судалгаа: Харьцуулалт, дүгнэлт	70
---	-----------

МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, Магистр Р.Пүрэвбаатар

Нийтийн дэг журам гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзах үндэслэл болох нь: Ойлголт, хандлага	82
--	-----------

МУИС-ийн ХЗС-ийн докторант Н.Энхцэцэг

Төрийн эрх мэдлийн хязгаарлалт ба Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал	102
---	------------

МУИС-ийн ХЗС-ийн магистрант Г.Билгүүн

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН

Хорин тав хүртэлх насны залуучуудын дундах бэлгийн зан үйл ба бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг хандлага	112
---	------------

УЕПГ-ын хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа

НҮБ-ын дүрэм ба улс орнуудын хилийн талаар баримталж буй бодлого, эрх зүйн хэм хэмжээ	125
<i>ДХИС-ийн доктор, дэд хурандаа Ш.Чулуунбат ДХИС-ийн докторант, М.Баярсайхан</i>	
Хөвсгөл аймагт сүүлийн 10 жилийн хугацаанд гарсан амиа хорлосон тохиолдлуудад хийсэн судалгаа, түүнийг бууруулах арга зам	135
<i>ДХИС-ийн докторант, Т.Бүрэнхаан</i>	
Ковид-19 цар тахлын үеийн гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрх зүйн зохицуулалтын олон улсын чиг хандлага, үр нөлөө	150
<i>МУИС-ийн ХЗС-ийн магистрант Б.Анхбаяр</i>	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал	163
<i>МУИС-ийн ХЗС-ийн магистрант Б.Энхболор</i>	
МЭНДЧИЛГЭЭ	
Монгол Улсын Гавьяат Багш, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Баярсайхан	171
ШИНЭ ЭРДЭМТНИЙ ИНДЭР	
Хууль зүйн ухааны доктор Д.Сундуйсүрэн	172
Хил судлалын ухааны доктор Ч.Сайнтөр	174
МЭДЭЭЛЭЛ	
Шинэ бүтээлийн танилцуулга	175
“Хууль дээдлэх ёс” сэтгүүлд тавигдах шаардлага /Загвар/	178

CONTENT

BEFORE CREATING A LAW

- Labor Law Reform Requirements, Main Changes** 11
B.Urantsetseg, Ph.D., Professor, National Academy of Governance

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTION

- Features of Probation, Issues to be Emphasized** 27
Ts.Ochgerel Colonel, Chief of the Internal Affairs and Legislation Division of Administration and Management Department of the General Executive Agency of Court Decision of Mongolia
A.Tsengel Major, Officer of the Internal Affairs and Legislation Division of Administration and Management Department of the General Executive Agency of Court Decision of Mongolia
- Origin of Electronic Networks and Electronic Contract** 37
V.Amartuvshin, Judge, Civil Court of First Instance, SonginoKhairkhan District
- The Principle of Shareholders' Limited Liability of Company in Mongolia and Practical use** 48
B.Bilguun, Advocate
- Proposals on the Drafting and the Adoption of Independent Laws on E-Commerce in Mongolia** 59
B.Gunzaya, LL.M. Candidate, School of Law, NUM

IMPLEMENTATION OF EFFICIENCY AND LAW

- ARTICLE 498 of the Civil Code: Comparison and Analysis** 70
R.Purevbaatar, LL.M., Lecturer of Private Law Department, School of Law, NUM
- Public Policy as a Ground for Refusal of Recognition and Enforcement of Foreign Arbitral Award: Concept and Approaches** 82
N. Enkhtsetseg, Ph.D. Candidate, School of Law, NUM
- Ristrictions on State Power and Independence of Justices of The Constitutional Court of Mongolia** 102
G.Bilguun, LL.M. Candidate, School of Law, NUM

LEGAL RESEARCH OVERVIEW

- Appendix Research Report on "Sexual Behavior, Knowledge and Attitude of Sexual Disease Prevention among Young People Under the Age of Twenty-five"** 112
B.Unurmaa, Ph.D., Prosecutor, The State General Prosecutor's Office of Mongolia

Border Policies of the Countries and UN charter	125
<i>Sh.Chuluunbat, Ph.D., Associate Professor, University of Internal Affairs</i>	
<i>M.Bayarsaikhan, Ph.D.Candidate, University of Internal Affairs</i>	
Basic Research on Suicide Cases in Khuvsgul Province Over the Last 10 years and Ways to Reduce	135
<i>T.Burenkhaan, Ph.D. Candidate, University of Internal Affairs</i>	
International Trend and Effectiveness of Restrictions to Foreign Direct Investment Amid Covid-2019 Pandemic	150
<i>B.Ankhbayar, LL.M. Candidate, School of Law, NUM</i>	
Challenges in The Civil Proceedings as Per the Time Limits	163
<i>B.Enkhbolor, LL.M. Candidate, School of Law, NUM</i>	
GRATITUDE POST	
<i>D.Bayarsaikhan, Prof. Ph.D., Public Law Department, School of Law, NUM, Honored teacher of Mongolia</i>	171
NEW SCHOLARS IN THE FIELD	
<i>D.Sunduisuren, Ph.D., University of Internal Affairs, Mongolia</i>	172
<i>Ch.Saintur, Ph.D., University of Internal Affairs, Mongolia</i>	174
NOTES	
<i>Recent publications</i>	175
<i>Standard Operating Procedures of the Mongolian Journal of Law (Example)</i>	178

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм уншигч та бүхэндээ хишиг ерөөлөө хайрласан ам цагаан хулгана жил алсран одож, ээл буянаа дэлгэх эзэндээ ээлтэй үхэр жил морилон ирж буй сайн цаг дор амар мэндийг тань айлтган мэндчилж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг хууль зүйн судалгаа, шинжилгээ, онол, практикийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь Эрхэм уншигч Танд 81 дэх дугаараа өргөн барьж буйгаа үүгээр илэрхийлэхийн сацуу энэ удаагийн дугаарын онцлогийг товч дурдъя.

Бид сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнээ өргөтгөж БНКаЗУ-ын “Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэн”-гийн захирал, доктор, профессор Р.К. Сарпековыг сэтгүүлийн зөвлөлийн гишүүнээр томилсноо хүндэтгэлтэйгээр мэдэгдэж байна.

Мөн энэ удаагийн дугаараас эхлэн ХБНГУ-ын салбартаа тэргүүлэгч технологийн компани болох PLAGSCAN GmbH-ийн Монгол Улс дахь албан ёсны төлөөлөгч “Юнисолюшн Партнерс” ХХК-тай хамтран ажиллахаар болж санамж бичиг байгууллаа. Тус компанитай хамтран ажилласнаар бид давхцал шалгах программыг (*Plagiarism*) шинээр нэвтрүүлж, сэтгүүлд ирүүлсэн бүтээл бүрийн давхцлыг шалгаж, сэтгүүлийнхээ агуулгын шаардлагыг өндөрсгөж, чанартай сэтгүүл, чадвартай зохиогч, шилдэг бүтээлийг бий болгохыг зорьж байна. Энэхүү шинэ программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээрээ бид олон улсад нэр хүнд бүхий Скопус (*Scopus*)-ийн судалгааны бүтээлийн санд сэтгүүлээ бүртгүүлэх эрхэм зорилтдоо хүрэх нэгэн томоохон алхмыг хийлээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцэх эсэхийг дэмжин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор “Хууль төрөхийн өмнө” буландаа хөдөлмөрийн эрх зүйн тэргүүлэх эрдэмтдийн нэг болох Удирдлагын академийн профессор, доктор Б.Уранцэцэг багшийн хөдөлмөрийн хуулийн шинэчлэлийн талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүллийг нийтэлж буйгаараа онцлог юм.

Мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг хөгжүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх зорилготой бидний үйлсэд нийтлэлээ ирүүлсэн, ирүүлдэг, ирүүлэх гэж буй зохиогч Та бүхний оюуны бүтээл хамгийн чухал байр суурь эзэлдэг тул эрдэмтэн, судлаачид, хуульчдаа талархаж буйгаа илэрхийлье.

Төгсгөлд нь, Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмрээ оруулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйт төрийг төлөвшүүлэн хөгжүүлэх их үйлсэд оюун бодол, сэтгэл зүрхээ зориулж ирсэн сэтгүүлийн зөвлөлийн үе үеийн гишүүд Та бүхнийхээ эрдмийн их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
хууль зүйн ухааны доктор

Х.ЭРДЭМ-УНДРАХ

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ҮНДСЭН ӨӨРЧЛӨЛТҮҮД



Б.Уранцэцэг

Удирдлагын Академийн профессор, доктор

ТОВЧЛОЛ:

Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэх асуудал бүр 10-аад жилийн өмнөөс яригдан ажлын хэсэг байгуулагдан төслийг боловсруулаад өмнөх хоёр парламентын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нь орж байлаа. Улмаар эдгээр парламентын холбогдох байнгын Хорооны хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж байсан түүхтэй. Энэ удаагийн парламентаар хуулийн төсөл батлагдах найдлага өндөр байх тул ажлын хэсгийн гишүүн бөгөөд хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр мэргэшиж буй судлаачийн хувьд хууль чухам яагаад шинэчлэгдэх болсон шалтгаан, ийнхүү шинэчлэгдсэнээр ямар чухал өөрчлөлтүүд орох гээд байгаа талаар тоймлон дурдах болно.

ТҮЛХҮҮР ҮГ:

Олон улсын хөдөлмөрийн стандарт, хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, дотоод хэм хэмжээ, нийгмийн түншлэл, хөдөлмөрийн маргаан.

ҮНДСЭН ХЭСЭГ

НЭГ. Хууль зорилтоо оновчтой томъёолсон байх нь чухал

Үйлчилгээний зорилтоо зөв тодорхойлж тусгасан байх нь зөвхөн онолын төдий бус, түүний агуулга оновчтой тогтоогдож, үйлчилгээний хүрээнд нь хамрагдах харилцааны талууд хуулийг зөв хэрэглэхэд буюу уг хууль батлагдах болон цаашдаа хэрэглэгдэх хүрээнд арга зүйн ихээхэн ач холбогдолтой. Техник бүтцийн үүднээс үйлчилгээний зорилт, зохицуулах харилцаагаа эхлээд тодорхойлох явдлаас хууль эхэлдэг. Гэхдээ хууль яагаад заавал “зорилт”-оо эхлээд тодорхойлох ёстой вэ? гэдгийг тэр болгон ойлгодоггүй, ойшоодоггүй.

1990 онд шилжилтийн үеийн анхны Хөдөлмөрийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байх үед хуулийн чиглэлийн нэг байгууллагын удирдах албан тушаалтан, эрдэмтэн хүн тухайн төслийн хэлэлцүүлэгт оролцож байхдаа “Хуулийн зорилтыг тодорхойлсон заалт бол нэг их ач холбогдолтой биш, за яахав, энэ Их сургуулийн хуулийн багш нарт хичээлээ заахад нь хэрэгтэй байдаг байх” гэж хэлж байж

билээ. Тэгээд ч Хөдөлмөрийн тухай хууль (1991 он)-ийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг: иргэд хөдөлмөрийн гэрээ байгуулж хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах явдал¹ гэж тодорхойлчихсон. Гэтэл ямар ч хууль нийгэм дэх ямар нэг төрлийн харилцааг л зохицуулах гэж батлагддаг, үүнийг тухайн хуулийн үйлчилгээний үр нөлөө буюу зорилт гэж үзэх нь үндэс муутай ойлголт болно. Харин төр тухайн хуулиараа дамжуулж зохицуулагдах харилцаандаа ямар нөлөө үзүүлэх, хуулийн үйлчилгээний үр дүн юу болохыг хураангуйлж шинжлэх ухааны үндэстэй томьёолсноор энэ нь сая хуулийн зорилтыг тодорхойлсон хэрэг болно. Ийнхүү хуулийн зорилт зөв, үндэстэй томьёологдон хуульчлагдах нь хуулийнхаа "...агуулгыг илэрхийлж, түүнийг хангах арга замыг тусгах"²-д гол ач холбогдолтой.

Одоо үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 1 дүгээр зүйлд: Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан тэгш байдлыг хангахад оршино гэж заажээ. Энэхүү заалтыг өмнөх хуульд байсан заалтын агуулгатай харьцуулбал зорилтоо түүний үйлчилгээний үр дүнтэй нь холбон тодорхойлж тусгаснаараа дэвшилттэй хэдий ч Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагддаг харилцааны нь мөн чанартай холбож томьёолж тусгаагүй, учир дутагдалтай гэж шүүмжлэлтэй хандахаар байдаг. Учир нь, энэ хуулиар зохицуулагдах гол харилцаа-хөлсний хөдөлмөрийн харилцаа нь хувийн өмч давамгайлсан эдийн засгийн нөхцөл дэх харилцаа, энэ үед өмчийн эзний давуу байдал.. ноёрхдог учраас төрийн зөв бодлого явуулахгүй бол хөлсний ажиллах хүчийг мөлжих аюул нүүрлэж нэг талд баячууд хөлжиж, нөгөө талд ядуучууд хавтгайрч үндэсний аюулгүй байдал алдана³. Эдийн засгийн талаасаа нэг нь нөгөөгөөс хараат байдал бүхий ажил олгогч (өмчийн эзэн буюу эзэмшигч) ба ажилтан хоорондын харилцаанд төр хууль тогтоон оролцох бодит шаардлага бол тухайн тэнцвэргүй байдлыг хууль зүйн хувьд аль болох зохистой түвшинд тэнцвэржүүлэх явдал юм. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн үндсэн зорилт нь ажил олгогч ба ажилтны хооронд мөн тэдгээрийг төлөөлөх этгээд хоорондын хөдөлмөрийн харилцаанд зохистой тэнцвэрт байдлыг тогтоох явдал билээ. Чухам ийм утгаар хуулийн төсөлд тусгагдчихаад байгаа, энэ нь зөвхөн онолын төдийгүй хуулийн агуулга ямар байдлаар бүрдэж тогтоогдохыг ч тодорхойлсон арга зүйн ач холбогдолтой юм. Хөдөлмөрийн тухай хуульд эдийн засгийн хувьд давуу тал болох ажил олгогчдод түлхүү үүрэг, хязгаарлалт (хориглолт хэлбэрээр ихэвчлэн илэрхийлэгддэг), хараат тал-ажилтанд түлхүү эрх, баталгаа тогтооход чиглэгдсэн агуулгатай зохицуулалтууд ихэвчлэн тусгагдсаны зэрэгцээ эдгээрийн хэн алиныг хамгаалах хамгаалалт, хариуцлагыг бас давхар агуулсан. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх явцад түүнд оролцсон ажил олгогчдын төлөөллийн байгууллагынхан ажил олгогчдын эрх ашиг сонирхлыг хэтэрхий боож хязгаарласан гэж хуулийн төслийг шүүмжлэх нь байнга гардаг. Улсын Их Хурлын холбогдох Байнгын Хорооны хурал болон УИХ-ын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн үед ч гишүүдээс энэ шүүмжлэл нэлээд сонсогддог. Эдгээр нь хуулийн төсөлд ажил олгогчид үүрэг хүлээлгэсэн болон түүний зарим үйл ажиллагааг хязгаарласан агуулгатай зохицуулалтууд ажилтныхаас илүү олон байгаатай холбоотой, гэхдээ өмнө дурдсаныг энд давтахад Хөдөлмөрийн тухай хууль бол хөдөлмөрийн зах зээл дээрх тэнцвэргүй тал хоорондын харилцаанд хууль зүйн зохистой тэнцвэр тогтооход чиглэгдсэн суурь хууль тул агуулга нь ийм байхаас өөр аргагүй билээ. Чухам ийм байдлаар хуулийн

¹ ОТИС, ГТХАН, МУИС, ХЗС. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиуд (1925, 1930, 1933, 1940, 1973, 1991, 1999 он). УБ., 2003. 84 дэх талд.

² Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2018. 43 дахь талд

³ Н.Содномдорж, С.Дамбий., Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засгийн онолын үзэл баримтлалын бодлого. Зууны мэдээ. УБ., 2018.04.23. №82, 83 (5789, 5790) 10 дахь талд

агуулга илэрхийлэгдэж байгаа нь хуулийн зорилттой шууд холбоотой.

Үүнээс гадна талууд хооронд зохистой тэнцвэрийг тогтоох хамгийн оновчтой арга зам бол тэдний хоорондын түншлэлийн харилцааг төр хуулиараа дэмжиж уг харилцааны эрх зүйн үндсийг тогтоож өгөх явдал юм. Иймээс ч хуулийн төсөлд талууд өөрсдийн төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулж хөдөлмөр-нийгэм ахуйн шинжтэй асуудлаа хэлэлцэж зохицуулах, зөвлөлдөх зэрэг бололцоог агуулсан “хэлэлцээ” гэсэн бүлэг шинээр орсон.

Хөдөлмөрийн харилцаанд зохистой тэнцвэрт байдлыг төрийн зүгээс тогтоох хууль зүйн өөр нэг арга зам нь талуудын хүлээх хариуцлагыг хуульчлах явдал юм. Ажилтанд хүлээлгэх эд хөрөнгийн болон сахилгын хариуцлага одоогийн хуульд байгаагаас зарчмын гэх өөрчлөлтгүйгээр төсөлд тусгагдсан. Ажил олгогч эд хөрөнгийн хариуцлагыг ажилтны өмнө, харин захиргааны хариуцлагыг төрийн өмнө “Зөрчлийн тухай хууль”-иар тус тус хүлээнэ.

ХОЁР. Хөдөлмөрийн харилцаанд нийгмийн түншлэлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хуульчлах шаардлага тулгарч байна.

Үйлчилж байгаа хуулийн 5 дугаар зүйлд ажилтны эдлэх эрх, үндсэн эрхүүд тусгагдсаны дотор ажилтан (ажилтнууд) нь төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх эрх багтжээ. Харин ажил олгогчид ийм агуулга бүхий эрхийг олгосон заалт байхгүй. Энэ нь манай практикт өмнөх тогтолцооны үеэс улбаалсан, эвлэлдэн нэгдэх эрх нь зөвхөн ажилтнуудад хамааралтай мэт ойлголт тогтож хэвшсэн холбоотой юм. Гэтэл Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба зохион байгуулах эрхийг хамгаалах тухай” 87 дугаар конвенц (1948 он), “Зохион байгуулах эрх ба хамтын хэлэлцээний тухай” 98 дугаар конвенц (1949 он) тус бүрд тодорхойлогдсоноор бол эвлэлдэн нэгдэж өөрийн байгууллагыг байгуулах эсхүл ийм байгууллагад гишүүнээр элсэн орох нь хөдөлмөрийн харилцааны талуудын хэн алинд адил тэгш олгогдох ёстой. Монгол Улс эдгээр конвенцод 1969 онд нэгдэн орсон. Гэтэл одоо эдгээр конвенцын агуулгад нийцүүлж ажил олгогч, ажилтан нь өөр өөрсдийн төлөөллийн байгууллагаа байгуулах, гишүүнээр элсэн орох эрхтэй гэсэн заалт оруулах нь хуульд тодорхойлогдсон зорилтыг хангахад учир холбогдол бүхий заалт төдийгүй Олон Улсын хэм хэмжээнд үндэсний хуулийн агуулгыг нийцүүлж буй хэрэг юм. Үүнтэй зэрэгцэн ажил олгогч, ажилтан хоорондын нийгмийн түншлэлийг хангаж ажиллахад, хэн аль нь эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхэд нөгөө талдаа саад учруулах, дарамт үзүүлэхээс сэргийлэхэд чиглэгдсэн зохицуулалтыг төсөлд давхар тусгасан нь талуудын эвлэлдэн нэгдэх эрхийн чухал баталгаа болох ач холбогдолтой. Ийм баталгааг хуулийн төсөлд буй “Хөдөлмөрийн харилцаанд шударга бус үйлдлийг хориглох” гэсэн зүйл тусгаж өгснөөр хангах юм.

Шударга бус үйлдлийг хориглосон энэхүү зохицуулалт нь ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, өөрийн байгууллагаа байгуулах, уг байгууллагын үйл ажиллагаанд өөрийн эрхшээл нөлөөллөө тогтоох эсхүл ажилтны байгууллагын зүгээс ажил олгогчийн болон түүнийг төлөөлөх байгууллагын үйл ажиллагаанд зүй бусаар саад учруулах зэргээс сэргийлэхэд чиглэгдсэн.

ГУРАВ. Олон Улсын Хөдөлмөрийн стандарт хэм хэмжээнүүдэд үндэсний хуулийн агуулгыг нийцүүлэх шаардлагыг харгалзсан нь.

Олон Улсын хөдөлмөрийн стандарт хэм хэмжээ нь олон улсын конвенц ба зөвлөмжийн хэлбэрээр тогтоогддог бөгөөд ийм хэм хэмжээнд хөдөлмөрийн харилцааны гурван талын төлөөллийг хамарсан бүтэц бүхий Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын конвенц, зөвлөмж зонхилох байр суурийг эзэлдэг.

Монгол Улс ОУХБ-ын гишүүн орны хувьд өөрийн соёрхон баталж нэгдэн орсон ОУХБ-ын конвенцуудад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх, эдгээрийн агуулгыг тусгах улмаар хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг.

1999 оны 4 сард болсон Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт дээр НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга “хөдөлмөрийн харилцаа, хүний эрх, хүрээлэн буй орчныг хамгаалах” гэсэн гурван хүрээнд улс орон бүр дагаж мөрдөх 9 зарчмыг агуулсан “Глобал компакт” хэмээх үзэл баримтлалыг анх дэвшүүлсэн. Тухайн үзэл баримтлалд тусгагдсан 9 зарчмаас 4 нь хөдөлмөрийн харилцааны хүрээнд дэх суурь зарчимд тооцогдох болсон. “Глобал компакт” гэдэг үзэл баримтлалд хүний хөдөлмөр амь зуулгын шинжтэй бус, харин эрх чөлөөтэй, нэр төртэй, шударга, аюулгүй нөхцөлд бүтээмжтэй, чанарлаг байх нь зохист хөдөлмөрийн хүмүүнлэг шинжийг илэрхийлдэг. Ийм хөдөлмөр эрхлэхийн тулд хөдөлмөр эрхлэгч хэн боловч аливаа албадлага болон ялгаварлан гадуурхлаас ангид байх, хөдөлмөрлөх эрх ашиг сонирхлоо хангаж хамгаалахын тулд эвлэлдэн нэгдэх хамтын хэлэлцээ хийх эрхтэй байх, хүүхдийн хөдөлмөрөөс татгалзах нөхцөлийг төр засаг, ажил олгогч бүрдүүлсэн байхыг олон улсын хэм хэмжээгээр шаардах болсон. Ийм нөхцөлийг бүрдүүлэх нь улс орны нэр хүндэд ч түүний эдийн засгийн хөгжилд ч чухал түлхэц болох ач холбогдолтой. Эдгээрээс үндэслэн хуулийн төсөлд хөдөлмөрийн харилцаанд дах хүний суурь дөрвөн эрхийг тунхаглан мөн суурь зарчмуудыг тодорхойлсон конвенцуудын агуулгыг тусгасан зүйл заалтууд орсон. Үүнд, ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, албадан хөдөлмөрийг хориглох ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд эвлэлдэн нэгдэх эрхийг хангах, хүүхдийн хөдөлмөрөөс татгалзах түүнийг хязгаарлах, зарчмууд ОУХБ-ын холбогдох конвенцод тодорхойлогдсон агуулгаараа тодорхой зүйлүүд болж тусгагдаад байгаа юм.

ОУХБ-ын суурь конвенцууд агуулгаараа хуульчлагдах нь Монгол Улс ОУХБ-ын гишүүн улс орны хувьд хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй нэг хэлбэр төдийгүй олон улсын эдийн засгийн харилцаанд түүн дотроо худалдааны харилцаанд манай улс оролцоход эерэг таатай нөлөө үзүүлэх юм. Үүнийг Европын холбооны тарифын хөнгөлөлтийн хэлэлцээрийн дагуу манай аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэгчид бараа бүтээгдэхүүнээ экспортлох үед эдлэх эрх боломжоор жишээ авч тайлбарлаж болно.

Европын холбооноос хөгжиж байгаа орнуудыг дэмжих зорилгоор гадаад худалдааны тарифын хөнгөлөлттэй нөхцөл (гаалийн татварыг хөнгөлөх, чөлөөлөх) олгох тогтолцоог бий болгосон байдаг. Монгол улс энэхүү нөхцөлийг эдлэх бололцоотой улс орны жагсаалтад бүр 1991 оноос багтсан. Харин 2006 онд Европын холбоотой Монгол Улсын Засгийн газар тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр (ТХЕХ) байгуулснаар “Европын улс орнуудад экспортолж болох 7200 нэрийн бараа бүтээгдэхүүн гаалийн татвараас бүрэн чөлөөлөгдөж, тоо хэмжээний хувьд хязгааргүй нийлүүлэх боломж албан ёсоор бүрдсэн”⁴ байна. Ийнхүү ТХЕХ-ийг хэрэгжүүлэх, татвараас чөлөөлөгдөх хөнгөлөгдөх эрхээ эдэлж хадгалахын тулд уг хэлэлцээрийн нэмэлт нөхцөл гэж Европын холбооноос баталсан “GSP+” нөхцлүүдийг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нийлүүлэгч, аж ахуйн нэгж, байгууллага түүн дотроо зайлшгүй хангах, бүрдүүлэх ёстой ажээ. Энэ нь экспортод бүтээгдэхүүн гаргагч нь тухайн бараа бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэн гаргахдаа хүний үндсэн эрхүүд хөдөлмөрлөх эрхийг зөрчөөгүй, байгаль орчинд хор хохиролгүй үйл ажиллагаа явуулаагүй байх гэсэн нөхцлүүд юм. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн харилцааны хүрээнд суурь эрх, суурь зарчмуудыг тодорхойлж өгсөн ОУХБ-ын 4 конвенцын агуулгын хэрэгжилт нь дурдагдаж буй хавсралтын гол харгалзах үзүүлэлт буюу нөхцөлд тооцогдож байна.

⁴ Европын холбоо, ХНХЯам, МАОЭНХ, УХБ. Европын холбооны тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу бараа бүтээгдэхүүн экспортлоход тавигддаг GSP+ нөхцлийн биелэлтийг өөрөө үнэлэх гарын авлага. УБ., 2018.

ДӨРӨВ. Хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрүүд үүсэж хөдөлмөрийн гэрээний төрөл олширч, агуулга баяжихад нөлөөлсөн.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл нь хөдөлмөрийн харилцаанд хуулиар зохицуулагдаагүй шинээр бий болж буй харилцааг зохицуулж, Олон Улсын түвшинд хүргэхэд чиглэх хэрэгтэй⁵. Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах гол харилцаа болох хөдөлмөрийн гэрээний харилцаа агуулгаараа баяжин гүнзгийрч байгаа нь шинээр хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрүүд буй болж хэрэгжиж байгаагаас үүдэлтэй юм.

Одоо үйлчилж байгаа болон өмнө нь үйлчилж байсан хуулиуд дахь хөдөлмөрийн гэрээ нь ажил олгогч ба ажилтан гэсэн хоёр тал хоорондын тохиролцоонд суурилсан хөдөлмөрийн уламжлалт буюу “стандарт” гэрээ гэж онолын талаас тооцогдоно. Харин хөдөлмөрийн зах зээл дээр гурван талт хөдөлмөрийн харилцаа үүсэх болсон нь стандарт бус гэрээнд хамаарах бөгөөд уг харилцаа нь манай практикт хэдийнээ хэрэглэгдээд эхэлсэн ч хөдөлмөрийн уламжлалт гэрээний өнөөгийн зохицуулалт түүнд хэрэглэгдэх бололцоогүй тул хуулийн зохицуулалтын гадна үлдэх эрсдэлтэй.

Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж байгууллагууд хүний нөөцөө хөндлөнгийн этгээдээр дамжуулан олж авах практик манайд бий болжээ⁶. Хүний нөөцийн хэрэгцээг хангах хууль зүйн үндсэн гурван арга зам нь өөрсдөө хөдөлмөрийн гэрээгээр хүн авч ажилд зуучлах үйлчилгээгээр дамжуулах, тодорхой чиглэлийн ажлын байранд хэрэгцээтэй хүний нөөцийг бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд захиалгаар нийлүүлэх үйлчилгээгээр дамжуулан авах эдгээр байна.

Эдгээрийн аль аль нь манай улсад хэрэглэгдэх болсноос хүний нөөцөөр хангах үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлдэг тусгай компаниуд сүүлийн жилүүдэд бий болж тодорхой нэрийн ажлын байранд шаардагдах мэргэжлийн хүмүүсийг бэлтгэн хэрэгцээтэй аж ахуйн нэгж, байгууллагад ажиллуулах болсон. Харин хөдөлмөр зуучлалаар дамжуулахтай харьцуулбал хүний нөөцөөр хангах мэргэжлийн үйл ажиллагаа нь хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийг холбох агуулгаар хязгаарлагдахгүй, тодорхой ажлын байранд ажиллах хүнийг чадваржуулж бэлтгэх, мэргэшүүлэх замаар хэрэглэгч талыг тогтмол ажиллах хүчээр хангах, гол нь хувь хүнийг ажлаар, аж ахуйн нэгж байгууллагыг хэрэгцээт хүний нөөцөөр хангах үйл ажиллагааг тогтмол эрхлэх хэрэгжүүлдэг. Энэ нь “...аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцөд зарцуулах зардал буюу хөдөлмөрийн зардлыг хэмнэж, ингэснээр хүний нөөцийн хүрэн дэх олон асуудлаас хөндийрөн зөвхөн үндсэн үйл ажиллагаандаа анхаарах бололцоо бүрддэг”⁷ тул хэрэглэгч талд өгөөжтэй. Гэхдээ ажил эрхлэгч хувь хүн нь хүний нөөцийн компани, түүнтэй гэрээ байгуулан авч ажиллуулагч талын чухам алинтай нь хөдөлмөрийн харилцаа тогтоосон нь ойлгогдохгүй байх, эндээс хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горим журам зөрчигдсөнөөс гарсан хохирлыг хариуцах эзэн нь тодорхойгүй болж хүн хохирох зэрэг сөрөг үр дагавар ч гарч байна. Үүнд, тухайн 3 тал бүхий харилцаа эрх зүйн зохицуулалтгүй байгаа явдал голлон нөлөөлөх ажээ. Эдгээрээс үндэслэн хуулийн төсөлд гурван тал бүхий хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах зүйл орсон.

Хүний нөөцийн компани зохих чиглэл (барилга, зам засвар гэх мэт)-ээр бэлтгэгдсэн эсхүл инженер, засварчин зэрэг тодорхой мэргэжил эзэмшсэн хувь хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилтнаа бүрдүүлэх, мэргэшүүлж, дадлагажуулах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж бэлтгэнэ. Тэгвэл тодорхой чиглэл, мэргэжлийн ажиллах хүч шаардлагатай хэрэглэгч талтай ажиллах хүч нийлүүлэх гэрээ байгуулж түүндээ заавал талууд тохирч тусгах нөхцөлүүдийг (ажилтны хөдөлмөр нийгэм ахуйн шинжтэй) хуульд урьдчилан тодорхойлж заах замаар энэ харилцаа зохицуулагдах нь оновчтой.

⁵ МАОЭНХ, НХХЯ, МУ-ын ЗГ, ОУХБ, МҮЭХ. “Хөдөлмөр-хөгжлийн үндэс” хөдөлмөрийн үндэсний чуулган (Чуулганы үндсэн ба салбар хуралдааны илтгэл, судалгаа, мэдээллийн материал). УБ., Төрийн ордон. 2010.10.14. 92 дахь талд.

⁶ Б.Уранцэцэг, Хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь шинэ үзэгдлүүд, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл өөрчлөлт. Удирдахуйн онол практикийн асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг. УБ., №14, 26 дахь талд

⁷ Мөн тэнд

Энэ тохиолдолд хүний нөөцийн компани ба хувь хүн хоорондын харилцаа нь Хөдөлмөрийн тухай хуульд байгаа “хөдөлмөрийн гэрээ”-ний ердийн зохицуулалтаар, харин ажиллах хүч нийлүүлэгч ба хэрэглэгч хоорондын харилцаа нь ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр тус тус зохицуулагдах юм. Ажиллах хүч нийлүүлэх гэрээ нь иргэний эрх зүйн гэрээний зарим шинжийг агуулах боловч угтаа энэ нь “ажиллах хүч” гэсэн өвөрмөц таваарыг нийлүүлэхэд чиглэгддэг тул гэрээний зүйлтэй холбоотойгоор хөдөлмөрийн эрх зүйн харилцааны шинжүүд ч түүнд давамгайл агуулагдах ажээ. Өөрөөр хэлбэл, гурван талт энэ харилцаанд Иргэний эрх зүйн гэхээсээ хөдөлмөрийн эрх зүйн хөдөлмөрийн гэрээний зохицуулалтыг хэрэглэх нь илүү тохиромжтой. Гэхдээ хөдөлмөрийн стандарт гэрээний бус, шинэ хэлбэрийн зохицуулалт шаардлагатайг харгалзан хуулийн төсөлд ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллах гэсэн зүйл орсон. Энд ажиллах хүч нийлүүлэгч ба хэрэглэгч тал хоорондын харилцааг бэлтгэн нийлүүлэх зүйл нь хүний хөдөлмөр буюу ажилтны ажиллах хүч болохыг нь харгалзан “гэрээнд зайлшгүй тохирч оруулах нөхцөлүүд” тусгагдсан. Түүнчлэн хэрэглэгч талын нийт ажилтны тоотой харьцуулан ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллах ажилтны хязгаарыг, уг гэрээгээр ажилтан авч ажиллуулах тохиолдлыг нэрлэн заасны сацуу хэрэглэгч талд очиж ажиллах ажилтны эрхийн баталгааг тогтоон төсөлд тусгаад байна.

Хөдөлмөрийн стандарт гэрээ бүхий ажилтан нь өөрийн амьдардаг газраасаа ажил олгогчийн талын оршин байрлаж байгаа эсхүл түүний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа явагддаг объект, нэгж хэсэг рүү очиж ажиллаад ажлын цаг дуусахад буцаж харьдаг, Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажил, амралтын цаг нь ч ийм байдлаар хөдөлмөрлөхөд тохирсон байдаг. Тэгвэл эдүгээ хэвшсэн дээрх зохицуулалт хэрэглэгдэх бололцоогүй тийм практик буюу хөдөлмөр эрхлэлтийн бас нэг шинэ хэлбэр бий болжээ. Энэ нь алслагдсан газарт очиж байрлан ажил үүргээ гүйцэтгэх ажлын байр бүхий үйлдвэрлэл аж ахуйн өвөрмөц үйл ажиллагаа манай эдийн засгийн зарим салбар тухайлбал, уул уурхай, олборлох салбар дахь аж ахуйн нэгж, байгууллагууд эрхлэх болсонтой холбоотой. Ийм аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын байр, түүн дээр ажиллах ажилтны хийх ажил үүрэг нь алслагдсан газар уул уурхай үйлдвэрийн объект орон нутагт оршин байрлах тул тэнд ажиллах ажилтнууд нь ихэвчлэн тээврийн хэрэгслээр тухайн орон нутагт тодорхой хугацаагаар ирж суурьшин ажиллаад буцаж гэртээ харьж нэлээд хугацаагаар амарч алдагдсан энерги хүчээ нөхөн сэлбэдэг билээ. Энэ тохиолдолд ажилтанд ээлжийн ажлын цаг хэрэглэгдэх боловч ердийн ээлжийн цаг бус, өвөрмөц зохицуулалт бүхий өөр хэлбэрийн ээлжийн цаг шаардагдаж байна. Хуулийн төсөлд “жасаагаар ажиллуулах горим бүхий ажлын цаг” гэсэн тусгай зохицуулалт орсон нь дурдсан практик тохиолдолд тохирох ажээ.

Жасаагаар ажиллуулах горим бүхий ажлын цагтай ээлжийн ажилтан нь ердийн ажлын цаг, түүн дотроо ердийн ээлжийн ажлын цаг бүхий ажилтны адил ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах боловч гэрээгээрээ тохирох зарим нөхцөл нь тун онцлог байх юм. Жасаагаар ажиллах ээлжийн цаг нь нэг өдрийн үргэлжлэх цагаар бус үргэлжилсэн буюу дараалсан нэлээд олон өдрийн тоогоор, мөн амралтын цаг нь ч дараалан үргэлжлэх нэлээд өдрийн тоогоор (24/14 гэх мэт) тодорхойлогдон ээлжийн уг цагтаа очиж ажиллах газрын болон уурхайн нэрээ, ажлын объект руу хүрэлцэн очих тээврийн хэрэгслийн нэр, төрөл зэргийг ажилд орох хүнд урьдчилан тодорхой мэдээлж тохиролцох ёстой. Мөн жасаагаар ажиллах ажилтны тээврийн зардал (алслагдсан объект дээр ирэх ба тэндээс буцах), байрлах орон байраар хангах, хоолны зардал зэргийг ажил олгогч хариуцах тул энэ тухай тодорхой мэдээллийг ажилд орох хүнд өгч байх үүрэгтэй. Эндээс үзвэл, жасаагаар ажиллуулах горим бүхий ажлын цагтай ажил олгогч ба хувь хүн хоорондын гэрээнд заавал тусгах нөхцлүүд нь ердийн хөдөлмөрийн гэрээнд тохирвол зохих нөхцлүүд дээр нэмэгдэх байдлаар хуульд тусгагдах юм.

ТАВ. “Дотоод хэм хэмжээ”-ний талаар тусгай зохицуулалт орсон.

Одоо “...үйлчилж буй Хөдөлмөрийн тухай хуульд “дотоод хэм хэмжээ” гэсэн ойлголт, тусгагдаагүй, судлаачдын бүтээлд ч байхгүй”⁸. Гэсэн ч ийм хэм хэмжээний тодорхой хэлбэрүүд хуульд тусгагдан зохицуулагдсан. Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн III бүлэгт ажил олгогч ба ажилд орж байгаа хувь хүн хоорондын тохиролцоо болох “хөдөлмөрийн гэрээ”-ний, II бүлэгт нийт ажилтан ба ажил олгогч (төлөөлөх этгээд) хоорондын тохиролцоо болох “хамтын гэрээ”-г, 130 дугаар зүйлд ажил олгогчоос батлах “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг тус тус зохицуулсан заалтууд байгаа нь дотоод хэм хэмжээний илрэх тодорхой хэлбэрүүдийг хуульчилсан хэрэг билээ. Гэхдээ “дотоод хэм хэмжээ” гэсэн нэршлээрээ бус, харин ийм хэм хэмжээний тодорхой хэлбэр Хөдөлмөрийн тухай хуульд тус тус нэрлэгдэн тусгагдаж⁹ хэрэглэгдсээр байна. Дотоод хэм хэмжээ гэсэн нэг ойлголт, хууль зүйн нэг нэр томьёо дор түүний илрэх олон хэлбэрийг нэгтгэн хуулийн төсөлд оруулж тусгасны нэн чухал ач холбогдол бол эдгээрийг “Дотоод хэм хэмжээ” гэж нэрээр томьёолох замаар уг хэм хэмжээний аль ч хэлбэрт тавигдах хууль зүйн нэгдсэн нөхцөлүүд (агуулгаараа төрийн хууль, хуульчилсан актуудад нийцсэн байх зэрэг)-ийг давхар хуульчлах¹⁰ бололцоог бүрдүүлж байгаад оршино.

Төсөлд ажил олгогч тал дангаараа болон ажилтан (түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд)-тай тохиролцсоны үндсэнд ажилтан (нийт ажилтан)-ы хөдөлмөр, нийгэм ахуйн шинжтэй харилцааг үйл ажиллагаа, ажил үүргийн онцлог, тухайн үеийн нөхцөл байдал, ажилтны мэдлэг, дадал дүй, ур чадвар эсхүл гэр бүлийн өмнө хүлээх онцлог үүрэг хариуцлага (бага насны олон хүүхэдтэй, өвчтэй хүн асардаг гэх мэт), эрүүл мэндийн байдал зэрэг түүний хөдөлмөрийн харилцаанд нөлөөлөх, харгалзан үзвэл зохих хүчин зүйлсэд үндэслэн боломжит бөгөөд уян хатан зохицуулалтыг тогтооход чиглэгдсэн ямар ч хэлбэрийн “дотоод хэм хэмжээ”-г гаргах эрхийг олгосон. Гэрээ, тушаал, дүрэм, журмын аль ч хэлбэрээр дотоод хэм хэмжээ тогтоосон ялгаагүй тавигдах хууль зүйн нийтлэг шаардлагуудыг төсөлд тусгасан. Үүнд, дотоод хэм хэмжээ агуулгаараа хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх, хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулаагүй харилцааг зохицуулах гэх зэрэг шаардлагыг багтаасан. Эдгээр нь дотоод аль ч хэм хэмжээ хууль зүйн талаасаа хүчин төгөлдөр байхад хуулиар тавигдаж байгаа хууль зүйн цогц нөхцөл юм.

Төрийн хууль тогтоомжоор ажил олгогч ажилтан хооронд өдөр тутам тогтмол үүсдэг болон тохиолдлын шинжтэйгээр заримдаа үүсдэг хөдөлмөр нийгэм ахуйн харилцааг нарийвчлан зохицуулах бололцоогүй, ингэж зохицуулах ч шаардлагагүй. Гагцхүү суурь хэм хэмжээ, хамгаалалтыг хуулиар тогтооно. Ийм нөхцөлд дотоод хэм хэмжээ болох Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн болон хамтын гэрээ, ажлын байрны тодорхойлолт, эд хөрөнгийн хариуцлагын гэрээ зэрэг гэрээ, бусад дүрэм, журам (тухайн ажил олгогчоос тогтоосон)-аар нарийвчилсан зохицуулалтыг тогтоох нь чухал. Харин төсөлд дотоод хэм хэмжээ нь аль болох тухайн ажил олгогчийн санхүүгийн бололцоо, чадавхад тохирсон байх нөхцөлийг тусгаагүй (хассан) байгаа нь хожим маргаан, үл ойлголцол үүсгэх үр дагаврыг агуулж болох юм.

“Дотоод хэм хэмжээ” гэсэн ойлголт нь хөдөлмөрийн эрх зүйн шинжлэх ухаанд цоо шинээр орж ирж байгаа хууль зүйн нэр томьёо, энэ нь ажил олгогч ба ажилтан хоорондын хөдөлмөрийн харилцаа, түүнээс үүдэлтэй нийгэм-ахуйн зарим харилцааг зохих хууль тогтоомжийн агуулгын хүрээнд тухайлан нарийвчлан эсхүл тодорхой болгон зохицуулахаар тохирч тогтоосон гэрээ, хэлэлцээр, ажил олгогч дангаараа тогтоосон дүрэм журмыг нэгтгэсэн ерөнхий нэр томьёо юм. Дотоод хэм хэмжээ ийнхүү Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдан зохицуулагдсанаараа хөдөлмөрийн эрх зүйн шинжлэх ухаан дахь хөдөлмөрийн

⁸ Б.Уранцэцэг, Аж ахуйн нэгж, байгууллагад тогтоогдон үйлчлэх хэм хэмжээ (дотоод хэм хэмжээ) түүнийг хөдөлмөрийн маргаан шийдвэрлэхдээ шүүх хэрэглэж буй практик. Шүүх эрх мэдэл. УБ., 2017.№4, 48 дахь тал

⁹ Мөн сэтгүүлд 49 дэх талд.

¹⁰ Мөн тэнд.

хууль тогтоомж буюу хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээний бүрэлдэхүүнд ч шинэчлэл болох ажээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх “хөдөлмөрийн хууль тогтоомж” гэсэн гарчиг бүхий зүйлд: Ажил олгогч, түүний төлөөлөгчид хууль тогтоомжид нийцүүлэн ажилтны төлөөлөгчидтэй харилцан тохирч хамтын гэрээ хэлэлцээрийг, ажилтантай харилцан тохирч хөдөлмөрийн гэрээ, түүнийг дагалдах гэрээг байгуулах бөгөөд хөдөлмөрийн гэрээ, түүнийг дагалдах гэрээг байгуулах бөгөөд хөдөлмөрийн харилцааны асуудлаар дотоод бусад хэм хэмжээг тогтооно. Хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, дотоод бусад хэм хэмжээ нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэсэн заалтууд бий. Эндээс дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. Ажил олгогч ба ажилтан хооронд, тэдгээрийн төлөөлөгчдийн хооронд тус тус үүсч хэрэгжих хөдөлмөрийн болон дагалдах нийгэм-ахуйн шинжтэй бусад харилцааг зохицуулах зохицуулалт нь Хөдөлмөрийн тухай хууль, эрх бүхий этгээдээс тогтоосон хуульчилсан актуудаар хязгаарлагдахгүй.

2. Эдгээр хэм хэмжээтэй зэрэгцэн дотоод хэм хэмжээг тохирч тогтоох эрхийг хөдөлмөрийн харилцааны талуудад, мөн дангаараа тогтоох эрхийг ажил олгогчид тус тус хуулиар олгож байна.

3. Хуульд заасан шаардлагуудыг бүхэлд нь ханган тогтоогдсон дотоод хэм хэмжээнүүд нь хууль ба эрх бүхий этгээдээс тогтоосон хуульчилсан актын адил хүчинтэй үйлчилнэ.

4. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүрэлдэхүүнд багтах нийт хэм хэмжээ (түүнд дотоод хэм хэмжээг багтаагаад)-г хууль зүйн хүчин чадлаар эрэмбэлэхэд дотоод хэм хэмжээнүүд нь бүхэлдээ хууль, хуульчилсан бусад актад захирагдах шатлалаар хуулийн төсөлд тусгагдсан. Үүний зэрэгцээ дотоод хэм хэмжээнд багтах хэм хэмжээнүүдийг ч бас эрэмбэлсэн байдлаар төсөлд тусгагдсан нь ажилтны эрхийн байдлыг дордуулахгүй байх хууль зүйн баталгаа гэж үнэлж болох юм.

Дурдсан бүгдийг дүгнэвэл дотоод хэм хэмжээ нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүрэлдэхүүнд багтах эрх зүйн өвөрмөц хэм хэмжээ болж байна. Гэхдээ эрх зүйн онолын хүрээгээр авч үзвэл нэгэнт хуулиар эрх олгогдсоноор тогтоогдох тул дотоод хэм хэмжээ нь хуульчилсан актын шинжтэй, гагцхүү үйлчлэх хүчин чадлаараа бол хэм хэмжээ тогтоогоогүй хуульчилсан акт гэхээр байна. Хэм хэмжээ тогтоогоогүй хуульчилсан акт гэж “тодорхой салбарын буюу нутаг дэвсгэрийн тодорхой нэгжийн хүрээнд мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичиг”¹¹ гэж эрх зүйн онолын эрдэмтэд, судлаачид үздэг юм. Дотоод хэм хэмжээг тогтоох эрхийг хөдөлмөрийн эрх зүйн харилцааны талуудад Хөдөлмөрийн тухай хуулиар олгосон, уг хэм хэмжээ нь зөвхөн тухайн талууд хоорондын хөдөлмөрийн харилцааг л зохицуулах, үйлчлэх хүрээ нь хязгаарлагдмал онцлогтой. Өнөөгийн практикт шүүх хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэрэг дотоод хэм хэмжээ шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэл болгон ашигладаг¹².

¹¹ Д.Баярсайхан. УБ., 2018, 88 дахь талд.

¹² Энэ талаар өгүүлэл бичигч “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийн 2017 оны №4-т “Аж ахуйн нэгж, байгууллагад тогтоогдон үйлчлэх хэм хэмжээ” (дотоод хэм хэмжээ) түүнийг хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүх хэрэглэж буй практик гэсэн нэртэй өгүүлд нэлээд дэлгэрэнгүй хөндсөн. Түүнчлэн МУИС-ийн ХЗС-ийн ...жилийн ойд зориулж Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: Өнөө ба ирээдүй сэдвээр 2015 онд зохион байгуулсан Олон Улсын эрдэм шинжилгээний хуралд “Хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалж бүрэлдэхүүний өөрчлөлт, шинэчлэл” сэдвээр илтгэл бэлдэн хэлэлцүүлсэн. Мөн МУИС-ийн ХЗС-аар санхүүжилтийн дэмжлэг авч хийсэн “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэглээнд нэгдмэл практик тогтооход шүүх анхаарах асуудлууд” сэдэвт судалгааны тайланд тодорхой дурдсан. УБ., 2018,

ЗУРГАА. Албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлтийн зарим хэлбэрийн харилцааг хуулийн үйлчилгээний хүрээнд багтаахад анхаарсан нь

Хөдөлмөрийн тухай хууль нь зах зээлийн тогтолцоо бүхий улс орны албан секторын хүрээн дэх хөдөлмөрийн гол харилцаа-хөлсний хөдөлмөрийн харилцааг зохицуулж үйлчилдэг. Тэгвэл албан бус секторын хүрээнд хэрэгждэг зарим хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай төдийгүй зохицуулалтад оруулах бололцоотой юм. Албан бус секторын хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэх, хувь хүн хооронд аман тохиролцоо төдийд үндэслэн хөдөлмөрлүүлэх, өрхийн аж ахуйд хөдөлмөрлөх зэрэг олон хэлбэрийн хөдөлмөр багтдаг ч эдгээрээс хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн аж ахуйдаа тухайн өрхийн гишүүн хөдөлмөрлөх зэрэг нь бусдын төлөө бус, өөртөө хөдөлмөрлөж олсон орлого нь хөдөлмөр эрхлэгчдээ үлддэг зэрэг хууль зүйн шинжээрээ эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах бололцоогүй, ийнхүү зохицуулах ч шаардлагагүй хөдөлмөр юм. Харин хувь хүн хооронд нэг нь нөгөөдөө тодорхой ажил үүрэг гүйцэтгэн зохих хөлс авч хөдөлмөрлөх явцад нийгмийн харилцаа үүсэж үүнийг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлага бий болдог. Практикт хувь хүн хоорондын хөдөлмөрийн харилцаа багагүй хэмжээнд үүсэж хэрэгждэг, хуулиар энэ харилцааг тухайлбал, Иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажил гэрээгээр зохицуулах нь түгээмэл байна. Тэгвэл Хөдөлмөрийн тухай хуульд ч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон Монгол Улсын иргэн хоорондын хөдөлмөрийн гэрээний болон түүнээс уламжилсан хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулна гэсэн утга бүхий зохицуулалт (ХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2) бий. Харамсалтай нь хувь хүн хоорондын хөдөлмөрийн гэрээний харилцаа нь Хөдөлмөрийн тухай хуульд дурдагдсан төдий, харин түүний онцлогт үндэслэсэн тусгай зохицуулалт хуульчлагдаагүй тул энэ гэрээ практикт огт хэрэглэгддэггүй. Амьдралд айлын гэрт үйлчилгээний ажлыг тогтмол гүйцэтгэх (харуулын ажилтан, гэрийн үйлчлэгч, хүүхэд асрагч гэсэн ажлын байранд голлон) нь нэлээд өргөн болсон. Иймд эдгээрийг хөдөлмөрийн гэрээний харилцаа гэж тооцон гэрийн үйлчилгээний ажлын онцлогт тохирсон зарим зохицуулалтыг тусгайлан хуульчлан зааж төсөлд оруулсан.

Гэрийн үйлчилгээний ажилтны хөдөлмөрийн харилцаанд уг ажилтан ихэнхдээ ажил олгогч хувь хүний гэрт буюу түүний өмчлөл, эзэмшлийн сууц, орон байранд байрлан ажил үүргээ гүйцэтгэдэг онцлогтой тул орон байр амьдрах хэвийн орчноор нь хангах явдал ажил олгогчийн үүрэг байхаар хуульчлах шаардлага тулгардаг. Мөн нэгэнт байршин ажилладгаас уламжлан гэрийн үйлчилгээний ажилтны ажил, амралтын цаг ч бусад ажилтнахаас ялгаатайгаар зохицуулагдахад хүрдэг. Эдгээрийг хуулийн төсөлд тооцон зохих зохицуулалт тусгагдаад байгаа юм.

Албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлтийн нэг чухал хэлбэр бол туслах малчны хөдөлмөр билээ. Өөрөөр хэлбэл, бусдын малыг тохиролцоогоор маллах малчны хөдөлмөр нь хуулийн зохицуулалтад ороогүй.

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын судалгааны институтээс 2018 онд бүсийн төлөөлөл болгон 8 аймгийг сонгон түүний 24 сум, нийслэлийн орчим дахь мал аж ахуй, фермерийн өрх амьдардаг хоёр дүүргийн төлөөллийг хамруулан нийт 1050 малчин өрхийн хүрээнд хийсэн судалгааны тайлантай танилцахад судалгаанд хамрагдсан "...малчдын 3.5% нь бусдын малыг ямар нэг байдлаар хариулдаг туслах малчин"¹³ байжээ. Үндсэн малчид буюу өөрийн малыг малладаг малчидтай харьцуулахад "туслах малчид 39% нь 1000-2000 мал, 26.1% нь 501-999 мал малладаг"¹⁴ гэснээс үзвэл мал аж ахуйн салбарт туслах малчдын эрхлэн гүйцэтгэх хөдөлмөрийг үнэлэхгүй, хайхрахгүй байхын аргагүй, төр хуулиараа эдгээр хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг журамлан зохицуулах шаардлагатайг ч харуулах юм.

¹³ ХНХЯ. ХНХСИ. Институт. Малчдын аж байдлын судалгаа. УБ., 2018, 50 дахь талд.

¹⁴ Мөн тэнд. 52 дахь талд.

Бидний туслах малчид гэж нэрлэдэг малчин буюу бусдын малыг маллан ямар нэг хэлбэрээр (бараа, бүтээгдэхүүн, төл мал, мөнгө зэрэг) хөлс авч хөдөлмөрлөж буй хүмүүсийг дотор нь хоёр ангилж болох юм. Энд, олон малтай хүн (мянгат малчин гэж ч нэрлэдэг), түүний гэр бүлийн хаяаг түшиж мал ахуйн ажилд нь туслан амьдралаа залгуулдаг туслах малчин, хувь хүний тодорхой тооны малыг орон нутагт хариуцан маллаж өгдөг малчин ордог. Эдгээрийг бусдад хөлсөөр мал малладаг малчин гэж нэрлэн хувь хүн хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид тооцон хөдөлмөрийн харилцааг нь хуульчлан зохицуулах болж байна.

Малчны хөдөлмөр нь байгаль цаг агаараас ихээхэн хамааралтай, ажлын цагийн хатуу хязгаар тогтоох бодит бололцоогүй, хуулиар эдгээрийг зохицуулах аргагүй ч түүний хөдөлмөрийн харилцаанд амралтын цагийг нь, цалин хөлсний асуудлыг нь тодорхой хэмжээгээр хуульчлахаар Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд оруулсан. Малчны хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн гэрээний нийтлэг зохицуулалт хэрэглэгдэхийн сацуу тухайлсан зарим нэг онцлог заалтыг зориуд тусгасан. Үүнд, хэрвээ малчин зөвшөөрсөн бол түүний цалин хөлсний 30 хувиас илүүгүйг мөнгөн бус хэлбэрээр олгож болохоор, гэхдээ ийнхүү цалин хөлсөнд тооцогдох бараа бүтээгдэхүүн, бусад эд хөрөнгө хэлбэрээр олгогдож болох зүйлсийн үнэ нь зах зээлийн дундаж үнээс хэтрэхгүй үнэлгээтэй байх, тамхи согтууруулах ундаа, эм, тусгай зөвшөөрөлтэй худалдах бараа бүтээгдэхүүнийг цалин хөлсөнд тооцож үл оруулахыг хориглосон зэргийг дурдаж болно.

ДОЛОО. Хөдөлмөрийн маргааны харилцааны зохицуулалт дах шинэчлэл

...ажилтан бүрийн болон ...тэднийг ажиллуулагч ажил олгогчийн хүсэл сонирхол өөр өөр¹⁵, энэ утгаар нь авч үзэхэд хөдөлмөрийн маргаан нь аль ч нийгмийн үеийн хөдөлмөрийн харилцаанд байх бодит үзэгдэл¹⁶ юм. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд ийнхүү хөдөлмөрийн маргаан үүсэх нь бодит шинжтэй үзэгдэл учраас хуульд энэхүү маргааныг журамлахад чиглэгдсэн тодорхой зохицуулалтууд зайлшгүй багтаж ордог.

Энэ удаагийн хуулийн төсөлд хөдөлмөрийн маргааныг зохицуулах зүйл заалтууд уламжлагдан орсон, гэхдээ өмнө нь хэрэглэгдэж байсан хууль зүйн нэр томьёо нь өөрчлөгдсөн. Уг өөрчлөлт бол нэршлийн төдийгүй хууль зүйн агуулгын талаас цоо шинэ ойлголтыг бий болгосон гэж үзэж болно. 1991 оноос хойшхи Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын гэсэн хоёр төрлийн маргааныг өөр өөрөөр зохицуулах зохицуулалт хуульчлагдах болсон. Харин хуулийн төсөлд хөдөлмөрийн сонирхлын маргаан, хөдөлмөрийн эрхийн маргаан гэсэн шинэ ойлголтууд тэдгээрийн оронд томьёологдон тусгагдаад байна. Энэ нь хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан гэсэн хууль зүйн ойлголтуудын нэршлийг өөрчилж засварласан төдий ойлголт биш, харин хуульд тусгагдан хэрэглэгдэж буй хууль зүйн нэр томьёоны агуулга шинэчлэгдсэнээс тухайн ойлголтыг шинэ нэршилтэй болгосон өөрчлөлт билээ.

Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн арав дугаар бүлэгт “хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулалт”, арван нэгдүгээр бүлэгт “хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан зохицуулалт” гэсэн бие даасан бүлгүүд бий. Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д: хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд хөдөлмөрийн гэрээний талуудын хооронд үүссэн саналын зөрүүг хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан гэж, харин уг зүйлийн 3.1.9-д: хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, биелүүлэх, биелэлтэд хяналт тавих явцад гэрээ хэлэлцээрт оролцогч талуудын хооронд үүссэн саналын зөрүүг хөдөлмөрийн хамтын маргаан гэж тус тус тодорхойлсон. Харин хуулийн төсөлд Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, өөрчлөхтэй холбоотойгоор түүний талуудын хооронд үүсэх саналын зөрүүг “хөдөлмөрийн сонирхлын маргаан” гэж, “хөдөлмөрийн хууль тогтоомж,

¹⁵ Л.Баасан., Хөдөлмөрийн маргааны онол, практикийн асуудал. УБ., 2009, 5 дахь талд

¹⁶ Мөн тэнд.

салбар (салбар дунд)”-ын хамтын хэлэлцээр, хамтын болон хөдөлмөрийн гэрээ, дотоод бусад хэм хэмжээг хэрэгжүүлэх эсхүл эдгээр хэм хэмжээг тайлбарлахтай холбоотойгоор ажил олгогч болон ажилтан (ажилтнууд) хооронд үүссэн саналын зөрүүг “хөдөлмөрийн эрхийн маргаан”¹⁷ гэж тус тус тодорхойлчихоод байгаа юм. Товчоор хэлбэл, хөдөлмөрийн сонирхлын маргаан нь зөвхөн хамтын гэрээ, эсхүл хамтын хэлэлцээр байгуулах, мөн эдгээрийн аль нэгийг өөрчлөх хоёр үе шатны аль нэгэнд талууд хооронд үүсэх маргаан юм. Харин хөдөлмөрийн эрхийн маргаан нь нэгэнт байгуулагдаад хүчин төгөлдөр үйлчилж буй (энэ утгаараа хамтын гэрээ хэлэлцээр нэгэнт байгуулагдчихсан л бол төрийн хууль, хуульчилсан бусад хэм хэмжээтэй адил түвшинд үйлчлэх хэм хэмжээ болдог) хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн бусад дотоод хэм хэмжээний хэрэгжилт (үл биелүүлэх зохих ёсоор биелүүлээгүй байх)-тэй болон эдгээрийн агуулгыг аль нэг тал буруу ойлгох буюу нөгөө талын ойлголтыг үл зөвшөөрөх зэргээс үүсэх ажээ.

Хамтын гэрээ хэлэлцээрийг нэгэнт байгуулчихсан бол эдгээр дотоод хэм хэмжээ нь хууль, хуульчилсан актын адилаар хүчин төгөлдөр үйлчлэх шинжтэй болдог. Иймд хамтын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад үүссэн маргаан нь хөдөлмөрийн эрхийн буюу хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа хэм хэмжээг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдон үүссэн саналын зөрүүд тооцогдох болсон. Энэ нь эцэстээ хөдөлмөрийн эрх зүйн харилцааг зохицуулах эх сурвалжийн бүрэлдэхүүнд гарсан чанарын өөрчлөлттэй бүр тодорхой хэлбэл, дотоод хэм хэмжээ түүн дотроо хамтын гэрээ, хэлэлцээр гэдэг дотоод хэм хэмжээ хөдөлмөрийн эрх зүйн нэг эх сурвалж болох болсонтой холбоотойгоор хөдөлмөрийн маргааны зохицуулалтад гарч байгаа өөрчлөлт юм.

Хуулийн төсөлд урьд нь хэрэглэж буй зарим нэр томьёо хэр зэрэг үндэслэлтэйг анхаарах нь зүйн хэрэг. Шинжлэх ухааны талаас нарийвчлан үзвэл эргэлзээ төрүүлэх буюу үндэслэл багатай хэдий ч олон жил хэрэглэсээр зөв зүйтэй мэт хэвшил болсон зарим нэр, үг хэллэг байгаа гэж Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Т.Сэнгэдорж нэгэн өгүүлэлдээ дурдсан байдаг¹⁸. Хөдөлмөрийн тухай хуульд өмнөх хуулиас уламжлагдан үлдсэн хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан гэсэн ойлголтуудыг орчин үед хэвээр үргэлжлүүлэн хэрэглэх нь Олон Улсын хөдөлмөрийн стандарт хэм хэмжээнд байгаа хөдөлмөрийн маргааны нэр томьёотой ч агуулгатай ч нийцэхгүй болсон юм.

Олон Улсын хөдөлмөрийн стандарт хэм хэмжээнүүдэд “хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан”, “хөдөлмөрийн хамтын маргаан” гэсэн нэр томьёо, ойлголт байхгүй, харин “хөдөлмөрийн эрхийн маргаан”, “хөдөлмөрийн сонирхлын маргаан” гэсэн ойлголтууд томьёологдон тусгагддаг ажээ.

НАЙМ. Хөдөлмөрийн хяналтын байцаагчийн эрх зүйн статусыг хуульчлан баталгаажуулахад анхаарсан.

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт биелэлтийг хангахад тэдгээрт тавигдах төр, олон нийтийн хяналт гол үүрэг гүйцэтгэнэ. Иймд Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн хяналтын асуудал ямагт тусгагддаг, хяналттай холбоотой харилцаа хуулийн зохицуулах зүйлд зүй ёсоор хамаарагддаг билээ. Үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хуульд хяналтын тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсны зэрэгцээ хяналтын цөм хэсэг-Төрийн хяналтын хэлбэр болох хөдөлмөрийн хяналтын тухай тусгай бүлэг бий. Тэгвэл Улсын Их Хуралд өргөн бариад байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд хөдөлмөрийн хяналтыг хөдөлмөрийн удирдлагад багтааж бус, харин түүнээс зааглан тусгасны сацуу хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтын тогтолцооноос гадна хөдөлмөрийн мэргэжлийн үндсэн хяналтыг хэрэгжүүлэх гол субъект болох хөдөлмөрийн хяналтын байцаагчийн эрх зүйн статусыг анх удаа хуульчлахыг зорьсон билээ.

¹⁷ УИХ-ын гишүүдэд зориулж ХНХЯ-наас бэлтгэсэн гарын авлага. УБ., 2020.11. Өргөн барьсан хууль. 5 дах талд

¹⁸ “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2016, 22 дахь талд.

Хөдөлмөрийн хяналт нь хэдийгээр төрийн хяналт шалгалтын нэг төрөл ч салбар дундын хяналт бөгөөд ажлын байран дээрх хөдөлмөрийн бүхий л үйл явцад тавигддаг, хяналтад хамаарах объект, субъектын хүрээ харьцангуй өргөн зэрэг шинжүүдээрээ тодорхой нэг салбарт тавигдах төрийн хяналтын төрлүүдээс ялгаатай юм. Тэгээд ч хөдөлмөрийн хяналт нь хөдөлмөрийн харилцааны бүхий л цогц төрлийн хүрээнд хэрэгждэг тул эдгээр цогц харилцааны суурь зарчим, суурь хэм хэмжээг тогтоодог гол хуульд нь хяналтын онцлогоос хамаарал бүхий зохицуулалт тусгагдах нь илүү оновчтой юм.

Хуулийн төсөлд хөдөлмөрийн хяналтын байцаагч хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд шаардлагатай тохиолдолд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар ажил олгогч, түүний төлөөлөгч, эсхүл ажилтнаас ганцаарчлан болон гэрчийг байлцуулж мэдээлэл авах, ярилцах асуулт асуух зэрэг онцлог эрхийг ажил олгогч ба ажилтанд хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж, зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол гаргасан ажилтны талаар ажил олгогч, түүний төлөөлөгчид мэдэгдэхгүй байх зэрэг үүргийг тус тус хуульчлахаар заажээ.

ОУХБ-ын "... хөдөлмөрийн хяналтын тухай 81, 129 дүгээр конвенцууд Хөдөлмөрийн хяналтын үр дүнтэй тогтолцоог төлөвшүүлэхэд засаглалын хувьд хамгийн чухалд тооцогддог, хяналтын байгууллагын үр дүнтэй тогтолцоог боловсруулахад маш хэрэгтэй удирдамж, чиглэлийг өгдөг лавлагаа баримт бичиг"¹⁹ юм. Эдгээр конвенцод Монгол улс нэгдэн орох боломжийг төрийн тодорхой байгууллагын түвшинд судлан соёрхон батлах сонирхолтой байгаа юм. Энэ үед хөдөлмөрийн хяналтын тухай ерөнхий зохицуулалтыг хуульд нарийсган тодорхой болгосноор ОУХБ-ын "Хөдөлмөрийн хяналтын тухай" 81 дүгээр конвенц (1947 он) зэрэг хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хууль зүйн гол хөшүүрэг болсон хөдөлмөрийн хяналтын тогтолцоог олон улсын түвшинд дүйцэхүйц байдлаар төлөвшүүлж бүрдүүлэхэд, мөн конвенцуудад Монгол Улс нэгдэн ороход үндэсний хууль агуулгаараа дэмжлэг үзүүлэх болно.

ЕС. Цалин хөлсний зохицуулалтад төрийн оролцоог хумиж нийгмийн түншлэлийн талуудад болон ажил олгогчид илүү боломж олгосон.

Юуны өмнө цалин хөлс тогтоох үйл ажиллагаанд хуулиар олгогдсон эрхийн дагуу оролцож буй аль ч этгээд баримтлах үзэл баримтлал буюу зарчмууд төсөлд тусгагдан нь цалин хөлсний зохицуулалт агуулж буй хэм хэмжээнүүдийн агуулга, хүрээг нарийвчлан тодорхой болгох арга зүйн ач холбогдолтой. Үүнд, ОУХБ-ын суурь конвенцод тусгагдсан цалин хөлс тогтоохдоо ялгаварлан гадуурхалтаас ангид байх, ижил үнэлэмжтэй хөдөлмөрийн цалин хөлс адил хэмжээтэй байх гэсэн зарчмуудыг мөн зах зээлийн эдийн засгийн хөгжлийн зүй тогтлоос хамаарч хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, инфляцийн түвшинг харгалзах, ажилтны ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулах зарчмуудыг ч тусгаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ажилтны цалин хөлсний асуудал гол бөгөөд шийдвэрлэгч хүчин зүйл болдог. Үйлчилж байгаа хуулиар цалин хөлсний зохицуулалтад төр голлох үүрэгтэй оролцох ажээ. Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 48 дугаар зүйлийн 48.2-т зааснаар мэргэжил, албан тушаалын тариф мэргэшлийн лавлах зохиох, хөдөлмөрийн норм норматив тогтоох аргачлалуудыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталдаг. Хуулийн төслөөр эдгээр аргачлалыг батлах эрхийг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт байгууллагад олгохоор тусгасан. Улмаар цалин хөлс тогтооход голлох ач холбогдол бүхий баримт бичиг болох Үндэсний ажил мэргэжлийн ангилал, ажил мэргэжлийн лавлахыг боловсруулах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод (барилгачдын, уурхайчдын гэх мэт)-ыг оролцуулах заалтыг төсөлд

¹⁹ МХЕГазар Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын "Хөдөлмөрийн хяналтын тухай" 81, 129 дүгээр конвенцэд нэгдэн орох боломжийн шинжилгээ. УБ., 2017, 5 дахь талд

оруулсан нь цалин хөлсийг ажил мэргэжлийн онцлогтой уялдуулан оновчтой, бодитой тогтооход таатай нөлөө үзүүлэх юм.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд “үндсэн цалин” гэсэн ойлголт нь зөвхөн цалин хөлсний бүрэлдэхүүнийг тодорхойлсон 47 дугаар зүйлд дурдагдах төдийгээр орхигдсон. Тэгвэл хуулийн төсөлд үндсэн цалингийн талаар тусгай зүйл орж байгаа бөгөөд ажил олгогч нь үндсэн цалингийн сүлжээг ажлын байрны ангилал зэрэглэл, ажилтны ур чадварт үндэслэн тооцож боловсруулж мөрдүүлж байхаар тусгагдсан. Ингэснээр цалин нь тухайн ажлын байрны ажил үүргүүдийг гүйцэтгэхийн тулд ажилтнаас зайлшгүй шаардагдах мэргэшил, ур чадварын түвшинг харгалзсан байх нөхцөлийг олгох юм. Үүний зэрэгцээ хуульд заасан зарим төрлийн нэмэгдэл, олговор зэрэг нь дундаж цалин хөлснөөс, зарим нь үндсэн цалингаас тус тус тооцогддог. Жишээ нь: Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 56 дугаар зүйлийн 56.2-т: сул зогсолтын олговрын хэмжээ нь уг ажилтны үндсэн цалингийн 60 хувь, түүнээс дээш байхаар, 55 дугаар зүйлийн 55.2-т: ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно гэх зэргээр зохицуулжээ. Тэгвэл хуулийн төсөлд сул зогсолтын үеийн болон ээлжийн амралтын олговрын тухай дээрх заалтууд тус тус уламжлагдан үлдээд байгаа юм. Хуульд ийнхүү нэрлэн тусгагдсан тодорхой тохиолдолд тухайн ажилтны ажлын байрны үндсэн цалин заавал тогтоогдчихсон, тодорхой байх шаардлагатай бөгөөд жишээ нь, сул зогсолтын үед ажилтанд үндсэн цалингийн нь 60 хувь, түүнээс дээш хэмжээгээр олговор олгоно. Ийнхүү ажил олгогчийн бүтэц дэх ажлын байр бүрийн үндсэн цалин нь урьдчилан тогтоогдсон байх шаардлагатай болж байна.

АРАВ. Зарим бүлгийн ажилтны хөдөлмөрийн харилцаа

Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-д эмэгтэй хүний, насанд хүрээгүй болон одой хүний ахмадын хөдөлмөр мөн гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөрийн харилцааг гурван тусгай бүлэгт ангилан багтааж зохицуулж байна. Харин төсөлд эдгээрийг “Хүн амын зарим бүлгийн ажилтны хөдөлмөрийн харилцаа” гэсэн бүлэгт нэгтгэн оруулсан нь хууль зүйн техник талаасаа цэгцэрч, мөн агуулгын хувьд нас, бие махбод эрхтний тогтолцооны онцлог байдал, гэр бүлийн хүрэн дэх үүрэг хариуцлагын онцлог зэргийг нь харгалзан хөдөлмөр эрхлэлтийг нь онцгойлон дэмжвэл зохих зарим бүлгийнхний хөдөлмөрийн харилцаанд тохируулсан зохицуулалтууд нэмж тусгагдсан гэж үзэж болно. Энэ бүлэгт өмнө нь насанд хүрээгүй хүн гэж нэрлэж байсан 18 хүртэлх насны хүнийг Олон улсын хөдөлмөрийн стандартын дагуу “хүүхэд” гэж өөрчлөн томьёолж ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөртэй холбоотой суурь конвенцуудын агуулгад нийцсэн дэлгэрэнгүй зохицуулалтыг оруулсан. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор одоогийн хуульд байхгүй хэд хэдэн чухал заалт багтаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин уг хүний, эсхүл түүнийг гэртээ асарч буй гэр бүлийн гишүүний нь хийсэн бараа бүтээгдэхүүн буюу ажил үйлчилгээг гэрээгээр тогтмол худалдан авч хэрэглэж буй ажил олгогчийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулбал зохих ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх буюу хөнгөлөхөөр заасан. Мөн нийт ажил олгогч боломжит ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулахад зориулж тохируулж засч бэлдэх үүргийг ч хуульчлан төсөлд оруулсны сацуу одоо үйлчилж байгаа хуульд тусгагдсан квотыг зөөлрүүлж 25 ба түүнээс дээш ажилтантай ажил олгогч аж ахуйн нэгж нь нийт ажилтны дөрвөөс доошгүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн авч ажиллуулах өөрчлөлт тусгагдаад байна. Манай ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын үнэмлэхүй олонх нь 9-25 хүртэл ажилтантай байдаг онцлогийг харгалзсан оновчтой зохицуулалт гэж үүнийг үзэж болно.

ДҮГНЭЛТ:

1. Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн батлах бодит шаардлага нь Монголын хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлт, хөдөлмөрийн харилцааны практикт гарч буй шинэ үзэгдлүүд төдийгүй хөдөлмөрийн эрх зүйн шинжлэх ухааны онол-арга зүйн хэрэгцээтэй ч холбоотой юм.
2. Зах зээлийн эдийн засаг бүхий улс орны нийгэмд үүсэж хэрэгжих хөдөлмөрийн олон төрөл хэлбэрийн харилцааны дотроос зонхилох гол хэсэг болох хөлсний хөдөлмөрийн харилцааг бүхэлд нь, харин төрийн алба хаших зэрэг бусад төрлийн хөдөлмөрийн харилцааны тодорхой хэсгийг зохицуулдаг суурь хууль-Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчлэх хүрээ тэлж зохицуулагдах харилцааг өргөжүүлэх шаардлагатай болж байна. Хөдөлмөрийн гэрээний төрөл нэмэгдэж, албан бус хэвшлийн хүрээнд багтаж хэрэгжиж байгаа зарим төрлийн хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчилгээнд хамруулах шаардлага практикт үүсэх болсон.
3. Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах хөлсний хөдөлмөрийн харилцааны мөн чанарт тулгуурлан хуулийн үйлчилгээний зорилтыг тодорхойлох нь онол арга зүйн талаасаа оновчтой байх болно. Хөдөлмөрийн тухай хууль нь ажил олгогч ба ажилтны хоорондын хөдөлмөрийн харилцаанд аль болох зохистой тэнцвэрт байдлыг тогтоох зорилтыг агуулж үйлчлэх ёстой.
4. “Дотоод хэм хэмжээ” гэсэн өвөрмөц хэм хэмжээ нь хөдөлмөрийн эрх зүйн харилцааг хууль болон хуульчилсан бусад акттай хамт хөдөлмөрийн хууль тогтоомжийн бүрэлдэхүүнд багтах болсон. Үүнийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгаж хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байхын тулд дотоод хэм хэмжээнд тавигдах хууль зүйн шаардлагуудыг хуульд тусгах шаардлагатай болсон.
5. Хөдөлмөрийн харилцааны талууд хооронд зохистой тэнцвэр тогтоох нэг чухал хөшүүрэг бол ажилтны болон ажил олгогчдын төлөөлөгчдийн байгууллага оролцсон “нийгмийн түншлэл”-ийг дэмжиж төлөвшүүлэх явдал юм. Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд энэ чиглэлээр нэлээн чухал зохицуулалтууд тусгагдаад байна. Үүнд, эвлэлдэн нэгдэх эрхийг хөдөлмөрийн харилцааны хоёр талд адил тэгш олгох, мөн эдгээр тал харилцан бие биеийн үйл ажиллагаанд шударга хандахад чиглэгдсэн тусгай зохицуулалтыг оруулсан. Түүнчлэн хамтын хэлэлцээнд зориулсан бүлэг төсөлд багтаж байгаа зэргийг дурдаж болох юм.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- ОУХБ-ын Эвлэлдэн нэгдэх ба зохион байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар эвлэлдэн нэгдэх ба конвенц (1948 он)
- ОУХБ-ын “Зохион байгуулах эрх ба хамтын хэлэлцээний тухай” 98 дугаар конвенц (1949 он)
- Хөдөлмөрийн тухай хууль. 1991 он
- Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он
- БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль. 1973 он
- Хөдөлмөрийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл Улсын Их Хурлын гишүүдэд зориулан ХНХЯамнаас бэлтгэсэн материал. 2020 оны XI сар.

Ном, өгүүлэл:

- Н.Содномдорж, С.Дамбий. *Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засгийн онолын үзэл баримтлалын бодлого*. Зууны мэдээ. 2018.04.23, №82, 83 (5789, 5790), 10 дахь нүүрэнд
- Д.Баярсайхан. *Эрх зүйн онол*. УБ., 2018 он
- Б.Уранцэцэг. Аж ахуйн нэгж, байгууллагад тогтоогдон үйлчлэх хэм хэмжээ (дотоод хэм хэмжээ) түүнийг хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүх хэрэглэж буй практик. *Шүүх эрх мэдэл сэтгүүл*. УБ., 2017 он, №4
- Б.Уранцэцэг. Дотоод хэм хэмжээ, аж ахуйн нэгж байгууллага түүнийг тогтоон хэрэглэж буй практик. *Удирдахуйн онол, практикийн асуудлууд сэтгүүл*. УБ., 2018. №1(19)
- Б.Уранцэцэг. Хөдөлмөрийн эрх зүйн эх сурвалжийн бүрэлдэхүүний өөрчлөлт, шинэчлэл. *МУИС, ХЗС. Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: Өнөө ба ирээдүй*. (Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл) УБ., 2015 он,
- Б.Уранцэцэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь шинэ үзэгдлүүд, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлт. *Удирдахуйн онол, практикийн асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг*. №14.
- ХНХЯ, ХНХСИ институт. *Малчдын аж байдлын судалгаа*. УБ., 2018 он.
- Л.Баасан. *Хөдөлмөрийн маргаан онол, практикийн асуудлууд*. УБ., 2009 он
- “Хөдөлмөр-хөгжлийн үндэс” хөдөлмөрийн үндэсний чуулган (Чуулганы үндсэн ба салбар хуралдааны судалгаа, мэдээллийн материал). УБ., 2010 он
- Европын холбоо, ХНХЯ, МАОЭНХ, ОУХБ. Европын Холбооны тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу бараа бүтээгдэхүүн экспортлоход тавигддаг GSP+ нөхцөлийн биелэлтийг өөрөө үнэлэх гарын авлага. УБ., 2018 он
- Т.Сэнгэдорж. Монгол Улсын хууль зүйн нэр томъёо судлал: сургамж ба шийдэл. “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2016 он
- МХЕГ. *Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн хяналтын тухай”* 81, 129 дүгээр конвенцод нэгдэх орох боломжийн шинжилгээ. УБ., 2017 он.

LABOR LAWS REFORM REQUIREMENTS, MAIN CHANGES

B.Urantsetseg

Ph.D, Professor at The National Academy of Governance

ABSTRACT:

The discussion about the reform of the Labor law was discussed for the last 10 years, and a working group was formed to make a draft and to put into the agenda of previous two parliaments. It has a history of being discussed and supported by the relevant standing committees of these parliaments. As a member of the workig group and a researcher specializing in Labor law, I would like to give an overview of why the Law was amended and what importance changes are expected to be made as a result of this reform, as there is high hope that the draft law will be approved by this parliament.

KEYWORDS:

Intenational Labor Standards, Forms of Employment, Internal Norms, Social Partnership, Labor Disputes.

ПРОБАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ



Ц.Очгэрэл

ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн дарга, хууль зүйн доктор, хурандаа



А.Цэнгэл

ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн мэргэжилтэн, докторант, хошууч

ТОВЧ АГУУЛГА:

Эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах, ялын бодлогыг нийгэм, хувь хүнд өгөөжтэй байдлаар чиглүүлэн хэрэгжүүлэхэд ял эдлүүлэх институтийн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт ихээхэн хамааралтай. Пробацийн үйл ажиллагаа нь ял шийтгэгдсэн этгээдийг нийгэмшүүлэх, олон нийтээс тусгаарлагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, нийгэм-сэтгэл зүйн нөлөөллийн цогц арга хэмжээг багтаасан тогтолцооны онцлог хэлбэр юм.

ТҮЛХҮҮР ҮГС:

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, нийгэмшүүлэх ажил, пробаци, ял шийтгэл, нийгэмд дасан зохицох, нийгэм-олон нийтэд тулгуурласан ял эдлүүлэх ажиллагаа.

УДИРТГАЛ

Энэхүү өгүүллээрээ дэлхийн улс орнуудын ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй пробацийн тогтолцоо ба үйл ажиллагааны онцлогийг судалж, улмаар Монгол Улсын эрүүгийн ялын бодлоготой уялдуулан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, тэр дундаа ял эдлэгсдийг нийгэмшүүлэх асуудлын хүрээнд нэвтрүүлэх арга замыг тодорхойлохыг зорьсон болно.

Монгол Улсад нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт хийгдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрч байгаа хэдий ч хууль зүйн салбарт хийгдэж өөрчлөлтүүд үе шаттайгаар үргэлжилж байна. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, техник, технологийн салбар үсрэнгүй хөгжсөнөөр улс орны дотоод нөхцөл байдал, нийгмийн амьдралд эерэг болон сөрөг үр нөлөөг үзүүлсээр байна.

Түүнчлэн олон улсын эдийн засаг, геополитик, цэрэг дайны бодлого үлэмж хэмжээгээр хувьсан өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ цар тахлын улмаас өнөөгийн нөхцөлд нийгмийн аюулгүй байдлыг хангаж, хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн шинэтгэлийг шийдвэртэйгээр гүнзгийрүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд “... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”¹ хэмээн зарлан тунхаглаж баталгаажуулсан манай улсын хувьд нийгмийн ухааны бүхий л салбар нь хүний хөгжлийг, нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлж, хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг бий болгоход чиглэгдэх учиртай.

Нийгмийн харилцаа, тэр дундаа хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн амьдралыг зохицуулах, шударга ёсыг сэргээн тогтоох зорилго бүхий эрх зүйн салбар шинжлэх ухаанууд нь дээрх зорилтыг хангахад үзэл баримтлалаа уялдуулан хөгжүүлэх нь зүйн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн болон нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилгын үүднээс авч хэрэгжүүлж буй эрх зүйн шинэчлэл, төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн дээрх заалтыг тулгуур болгон баримталсан байвал зохино.

Нэрт эрдэмтэн Б.Чимид “Төр нь ардчилсан нийгэмд байдаг хүний эрхийг хангахдаа эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”² гэж үзсэн байдгийг энд дурдах нь зүйтэй болно.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд ял шийтгэл эдлүүлэх, аливаа хүнийг шүүхийн шийдвэрээр нийгмээс тусгаарлах эсхүл нийгмийн орчинд нь зохих шийтгэлийг эдлүүлэх ажиллагаа нь онцлох сэдэв байсаар ирсэн бөгөөд цаашид ч эрх зүйн зохицуулалт болон тогтолцооны нэн чухал судалгааны объект байх юм.

Тэр дундаа ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, тэдгээрийг эргэн нийгмийн амьдралд хууль сахин биелүүлэгч зөв иргэн болгон төлөвшүүлж оруулах асуудал нь судлаач эрдэмтдийн анхаарлыг татсаар ирсэн боловч гадаад улс орнуудын жишгийг судлан нэвтрүүлэх, зохистой тогтолцооны шинэчлэл хийх бодит хэрэгцээ шаардлага байсаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуультай хамтран 2018 онд Шинжлэх ухаан, технологийн сангийн төслийн хүрээнд хэрэгжүүлсэн “Дэлхийн зарим улс орны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны зүй тогтол, арга зүй, эрх зүйн зохицуулалт, чиг хандлагын харьцуулалт” сэдэвт судалгааны ажил нь гадаадын улс орнуудын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, ялангуяа пробацийн тогтолцооны чиглэлээр хийгдсэн томоохон судалгаа юм.

Та бүхэн тус судалгааны ажлаас пробацийн тогтолцоо, түүний онцлог, зорилго, арга хэлбэрийн талаар дэлгэрэнгүй үзэх боломжтой.

ҮНДСЭН ХЭСЭГ

Пробац гэсэн нэр томъёо нь **probatio** гэсэн латин үгнээс гаралтай ба энэ нь Оросоор испытания, Монголоор туршилт, дадлагажуулалт хэмээн орчуулагдаж байгаа хэдий ч олон улсын хэмжээнд шүүхээс тогтоосон тодорхой хугацааны явцад тусгайлсан байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь тогтоогдон ял шийтгэгдсэн болон хорих байгууллагаас суллагдсан этгээдэд өөр өөр хувилбар бүхий нэмэлт хязгаарлалтыг хяналт хэлбэрээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг илэрхийлж иржээ.

Өөрөөр хэлбэл, пробацийн үйл ажиллагааг ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад хоригдол, ялтанг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжиж эхэлсэн гэж үзэж болно.

Олон улсын практикт анх хэрэглэгдэж эхлэхдээ хорихгүйгээр хянан харгалзах шийтгэлийг хэрэгжүүлэх суурь нөхцөл дээр Пробацийн алба үүсэж бий болсон бөгөөд

¹ “Монгол Улсын Үндсэн Хууль” Улаанбаатар 1992 он. Албан ёсны хэвлэл 3 дах тал.

² Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл” Улаанбаатар 2004 он 17 дахь тал.

хорих ялын сөрөг үр дагавар бүхий нөхцөл байдлыг өөрчлөх чиг хандлага бүхий эрх зүйн тогтолцооны өндөр хөгжил бүхий улс орнуудад XVIII зууны хоёрдугаар хагаст үүсэж бий болжээ. Тухайн цаг үед эрүүгийн ял, шийтгэлийн зорилго дахь хууль зөрчигчийг нийгэмд эргэн нэгтгэх, засан сайжруулах зорилтууд хэрэгжихгүй байгаа талаар эрдэмтэн судлаачдын болон олон нийтийн зүгээс хурц шүүмжлэлүүд гарч эхэлсэн байдаг. Энэхүү нөхцөл байдал нь нийгмийн хор аюул багатай, онц хүндээс бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шууд хорихгүйгээр хоёр дахь боломж олгох үзэл санааг эрүүгийн эрх зүйн салбарт оруулж ирсэн.

Анх 1872 онд Английн Лондон хотод анх удаа зохион байгуулагдсан Олон улсын хорих байгууллагын конгрессийн үеэр хэлэлцэж улмаар 1885 онд Римд, 1889 онд Брюссельд хэлэлцэж байсан түүхэн баримт бий бөгөөд 1890 онд ОХУ-ын Санкт-Петербург хотноо зохиогдсон Олон улсын хорих байгууллагуудын IV их хурал дээр хорих ялыг урт хугацаагаар бус харин хяналтын өөр хэлбэр бүхий ял, хязгаарлалтаар орлуулан хэрэглэх талаар тусгайлан хэлэлцжээ³.

Судлаачдын үзэж байгаагаар хорих газарт хорихгүйгээр тодорхой нөхцөлд нийгэмд нь хянан харгалзах ял нь 1869 онд Хойд Америк, 1820 онд Англи, 1884 онд Франц, 1888 онд Бельги зэрэг улсад хууль тогтоомжид тусгалаа олон хэрэгжиж эхэлсэн гэж үздэг. Хөгжлийн үе шатны явцад пробаци нь анхны хувилбараас илүү олон сонголт бүхий хэлбэрээр өргөжин хөгжсөөр хянан харгалзахаас өөр хэлбэрүүд бүхий бие даасан ял шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл болон хөгжжээ.

Дээрх улс орнуудын хувьд 1940-өөд оныг хүртэлх хугацаанд пробацийн албаны үйл ажиллагаа нь зөвхөн тэнсэн хянан харгалзсан этгээдэд хяналтыг өндөр түвшинд тавих замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой хэмээн үзэж байсан боловч өнөөдрийн байдлаар гэмт хэрэгтэн бие хүнийг олноор бий болгохоос зайлсхийх, улмаар нийгэмд эргэн нэгтгэх зэрэг цөөнгүй шинжийг агуулан хөгжиж байна.

Норвегийн нэрт криминологч Н.Кристи өөрийн бүтээлдээ пробацийн албаны хөгжлийн талаар “XX зууны хоёрдугаар хагас гэхэд ихэнх иргэншсэн улс орнууд хэт их шоронжсон эрүүгийн бодлогын хямралыг хүлээн зөвшөөрсөн юм”⁴ гэж үзсэн байдаг бөгөөд дэлхийн бусад улсын судлаачид пробацийн албаны үүсэл нь хорих ялын сөрөг үр дагавараас үүдсэн нийгмийн хөгжлийн зайшлгүй хэрэгцээнд суурилсан талаар авч үзсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний хуралдаанаар хэлэлцэн батласан “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийн 1.5-д “Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрх зүйн зөрчил гаргагчийг хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны болон хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрх зүйн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна”⁵ хэмээн пробацийн үйл ажиллагааг хэлбэршүүлэн тунхагласан байна.

Харин Европын холбооны Сайд нарын 1992 оны хуралдаанаас баталсан “Эрх зүйн хариуцлагын болон шийтгэлийн арга хэмжээний тухай дүрэм”-р эрх зүйн зөрчил гаргагч этгээдийг нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн хяналт, хязгаарлалтыг хөгжүүлэх чиглэлийг баталсан бөгөөд 1997, 1999, 2003 оны хуралдааны зөвлөмжөөр дэмжсэн байдаг.

Дэлхий улс орнуудын эрх зүйн практикт өнөөдрийн байдлаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт

³ <http://www.zakon.kz/4598354-otdelnye-voprosy-probaciai-akkulev-a.sh.html> 2021.03.10.

⁴ Нильс Кристи. Причинная боль. Роль наказания в уголовной политике. Норвегия., 2011.

⁵ Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. 2012., Уб. 159 дэх тал.

хэрэг үйлдсэн зэрэг цөөн тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна.

Түүнчлэн улс орнуудын ял эдлүүлэх тогтолцоонд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь өндөр хэмжээний зардлыг үүсгэж байгаагийн зэрэгцээ хорих ял эдлээд суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэх, ял эдэлж байсан орчиндоо буцаж очихоос үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ял хамгийн үр дүн багатай ялын төрөл хэмээн тооцогдож байна.

Судлаачдын үзсэнээр АНУ-д жилд нэг хоригдолд гарч буй зардлыг тооцож үзвэл 25,000 орчим доллар зарцуулж байгаа бол хорихоос өөр төрлийн хяналт, хязгаарлалтыг ашиглавал 1,500 доллар байх тооцоо гарсан байна⁶. Харин Монгол Улсын хувьд нэг хоригдолд өдөрт зөвхөн урсгал зардалд 8000 орчим төгрөг, жилд 2,8 сая орчим төгрөгийн зардал гарч байгаа талаар холбогдох тайланд дурджээ. Энэ тоог нийт ял эдлэгсдийн тоонд шилжүүлэн тооцвол бага бус хариу гарах нь ойлгомжтой юм.

Эндээс үзвэл пробацийн үйл ажиллагаа нь эрүүгийн бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн илүү уян хатан болгохоос гадна улс орны эрх зүйн тогтолцооны болон эдийн засгийн хөгжил, хувь хүний хөгжилд илүү бодит эерэг нөлөөллийг авчирдаг болох нь харагдаж байна.

Дэлхийн улс орнууд өөрсдийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт тохируулан пробацийн албыг нэршил, чиг үүрэг, харьяаллын хувьд өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүрж гэх мэт улсад Пробацийн алба, Норвеги, Финлянд, Дани, Эстони зэрэг улсад Хяналтын алба гэсэн нэршилтэйгээр ажиллуулж байгаа бол харьяаллын хувьд Англи, Дани, Япон, Финлянд, Норвеги, Латви, Чех, Эстони зэрэг улсад пробацийн алба нь Хууль зүйн яаманд, АНУ, ХБНГУ, Унгар зэрэг улсад шүүхэд, Голланд улсад прокурорын байгууллагад, Швед, Казакстан зэрэг улсад хорих байгууллагад, Сингапур улсад Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагддаг⁷.

Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоо өөр өөр онцлогтойгоор үүсэж, хөгжсөн хэдий ч пробацийн албаны талаар явуулж байгаа үйл ажиллагаа, зорилго, ач холбогдлын хувьд ижил төстэй байдлаар хөгжиж ирсэн.

Нийтлэг байдлаар буюу гадаад улс орнуудад хэрэгжүүлж буй байдлаас авч үзвэл авч үзвэл пробацийн албаны **гол зорилго нь:**

- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг нийгмийн харилцаа, орчноос тусгаарлахгүй байх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмийн зохист амьдралд ороход туслалцаа үзүүлэх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хууль сахин биелүүлэх, бусадтай зөв харилцаанд орох чадварт сургах, хөгжүүлэх явдал юм.

Пробацийн албаны үйл ажиллагааг хэрэгжүүлж буй олон улсын практикаас үзвэл чиглэл болон агуулга нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй этгээдийн хувийн зан байдал, пробацийн албанаас өгсөн үүргийг сахин мөрдсөн байдал, хувийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, оногдуулах ял, шийтгэлийн төрөл, хэмжээ зэргийг багтаасан тайланг шүүхэд гаргах. /Англи, Уэльс, Швед г.м./
- Тэнхсэн харгалзах ял шийтгэгдсэн этгээдэд тавих хяналт./Англи, АНУ, Латви, Швед г.м./

⁶ <http://www.zakon.kz/4598354> 2020.10.15

⁷ “Дэлхийн зарим улс орны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны зүй тогтол, арга зүй, эрх зүйн зохицуулалт, чиг хандлагын харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажил. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. Харьцуулсан судлал. Уб. 188 дэх тал

- Албадан хөдөлмөрлүүлэх ялын хэлбэрээр./мөн дээрх улсууд, Финлянд, Япон/
- Хорих ял хойшлуулсан бөгөөд шүүхээс тодорхой төрлийн эрхийн хязгаарлалт тогтоосон.
- Гэрийн хорионд байлгах ялын хэлбэрээр. /ОХУ, Канад г.м/
- Хорих газраас суллагдсан хүмүүст нийгмийн амьдралд ороход туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх. /Дангаар Эстони, хамтатган дээрх орнууд/
- Насанд хүрээгүй этгээд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд.
- Гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүнд туслалцаа үзүүлэх.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрүүлэн зуучлах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Ихэнх улс орнуудад пробацийн албаны үйл ажиллагааг төрийн бусад байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгж, хувийн хэвшлийн болон сайн үйлсийн байгууллагууд, иргэд, сайн дурын ажилтнуудын өргөн оролцоонд тулгуурлан зохион байгуулдаг бөгөөд энэ нь тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, түүнчлэн пробацийн албанаас чиглэл болгосон эрх хязгаарласан үүргийг хэрэгжүүлэх үр дүнг бий болгох гол нөхцөл болдог.

Ингээд дэлхийн зарим улс орнуудын пробацийн албаны чиг үүрэг, үйл ажиллагааны талаар харьцуулсан судлалын үүднээс товч авч үзье.

Их Британи улсын пробацийн үйл ажиллагааны тухай

2017 оноос хорих ба пробацийн алба болон өөрчлөгдөн зохион байгуулагдан Хууль зүйн яаманд харьяалагдан үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү албаны чиг үүргийг товч байдлаар авч үзье. Үүнд:

- Төрийн болон хувийн гэсэн хоёр чиглэлд хуваагдан үйл ажиллагаа явуулдаг.
- Төрийн пробацийн алба нь бэлгийн хүчирхийлэл бүхий гэмт хэрэг үйлдсэн болон 12 сараас дээш хугацаагаар ял шийтгэгдсэн, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хяналт тавьдаг.
- Пробацийн албаны үйл ажиллагаа нь аливаа хүн гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан буюу шалгагдаж эхэлсэн үеэс эхэлдэг.
- Шүүн таслах ажиллагаа хүртэлх хяналт, дэмжлэгийн үүргийг хэрэгжүүлдэг.
- Оногдуулах ял шийтгэлийн талаар зөвлөмж бэлтгэж шүүхэд танилцуулдаг ба тус улсын статистик мэдээгээр шүүхийн практикт шийтгэх тогтоолын 70 хувь нь пробацийн албаны зөвлөмжийн дагуу ял шийтгэдэг байна.
- Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн шүүн таслах ажиллагаа хүртэлх нөхцөл байдлын талаарх тайланг шүүхэд танилцуулах, энэ чиглэлээр хэлэлцүүлэг явуулах, албан мэдээлэл солилцох хэлбэрээр хамтран ажилладаг.
- Суллагдсаны дараах үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энгийн амьдралд шилжихэд туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ ажлын хүрээнд суллагдсан иргэнд үзүүлэх нөлөөллийн ажил буюу олон нийтийн оролцоог хангах, бусад ахуй нөхцөлийг тогтворжуулах дэмжлэгийг үзүүлдэг бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэх үндэсний комисс хэлбэрийн бүтэц ажилладаг.

Латви улсын пробацийн үйл ажиллагааны тухай

Латви улсын пробацийн албан үндсэн чиг үүргийг судалж үзвэл дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Хяналтад орсон хүний талаарх бүхий л мэдээллийг багтаасан урьдчилсан илтгэл бэлтгэх.
- Хяналтанд орсон хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зан үйлийг засах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
- Албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх.

- Насанд хүрээгүй этгээдийн талаар шүүхээс гаргасан хязгаарлалтын шийдвэрийг хэрэгжүүлэх.
 - Эрүүгийн хэрэг түдгэлзсэн этгээдэд туршилтын хугацаа тогтоосон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх.
 - Хорих байгууллагатай суллагдахад бэлтгэх талаар хамтран ажиллах.
 - Тэнсэн харгалзсан болон хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих.
 - Хорих байгууллагаас суллагдсан этгээдэд туслалцаа үзүүлэх.
- Мөн хорих байгууллагаас суллагдсан этгээдэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлээр:
- Суллагдах хүнийг урьдчилан судалгаанд авах.
 - Тухайн хүнийг судалсны дараа түүнтэй бичгээр хэлцэл байгуулах.
 - Ял эдлэх үеийн бүхий л зан төлөв, хувийн байдлыг үндэслэн зан үйлийг төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулах.
 - Орон байргүй тохиолдолд түр амьдрах байранд зуучлах, мэдээлэл өгөх.
 - Төрийн бусад байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллагатай суллагдагсдыг нийгэмшүүлэх талаар хамтран ажиллах.
 - Хэрэгцээт мэргэжлийн сургалтад хамрагдах, түүнийг олж сонгоход туслалцаа үзүүлэх.
 - Хувийн бичиг баримттай болоход туслах.
 - Түүнийг нийгэмшүүлэх зорилго бүхий тодорхой туршилтын хөтөлбөрт хамруулах санал тавих.
 - Нийгмийн амьдралд ороход шаардагдах бусад зөвлөгөө, тусламжийг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Эстони улсын пробацгийн үйл ажиллагааны тухай

Ингээд Эстоний пробацгийн албаны чиг үүргийг товч авч үзье:

- Прокурор болон шүүхэд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нийгэм сэтгэл зүйн хандлага, онцлогууд, хувийн шинж байдал, амьдралын буюу нийгмийн нөхцөл байдал, цаашид хяналтанд авах туршилтын хугацаа, хүлээлгэвэл зохих үүрэг, хязгаарлалтын талаарх дүгнэлт, тайланг танилцуулах.
- Шүүхээс тогтоосон хугацаанд нийгмээс тусгаарлахгүйгээр зохих хяналтыг хэрэгжүүлэх.
- Пробацгийн албаны ажилтан нь хяналтанд буй хүнд сурах, мэргэжил эзэмших, ажлын байр, амьдрах орон байр олох зэргээр нийгэмд дасан зохицоход тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, нийгэмд тустай ажил хийхэд зуучлах, бие даан хувийн амьдралын аливаа асуудлаа шийдвэрлэх чадвар эзэмшихэд эерэгээр нөлөөлөх, чадваржуулах үүрэгтэй.
- Хяналтад байгаа хүний хувийн байдлын талаарх мэдээлэл, хяналт тогтоосон шийдвэрийн гүйцэтгэлийн талаар шүүхэд танилцуулах.
- Хяналтад байгаа хүн хяналт тавихад саад учруулсан эсхүл дахин гэмт хэрэг үйлдсэн, шүүхээс тогтоосон үүргийг биелүүлээгүй зэрэг тохиолдолд ээлжит бус илтгэл, дүгнэлтийг шүүхэд танилцуулах
- Шүүхэд хугацааны өмнө тэнсэн суллагдагдах хүсэлт гаргасан хоригдлын талаар хорих байгууллагаас асуулга авч, мэдээлэл цуглуулах, шүүхэд тэнсэн суллагдах боломжийн талаар танилцуулах
- Хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих.
- Насанд хүрээгүй хүнд тавих хүмүүжлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, нийгмийн харилцаанд оролцох чадвар эзэмшүүлэх.
- Нийтэд тустай ажил хийлгэх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах г.м.

Швед улсын пробацийн үйл ажиллагааны тухай

Шведийн пробацийн алба нь дараах ялын болон хяналтын чиглэлээрх шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Нийтэд тустай ажил хийлгэх ял.
- Тусгай хөтөлбөрийн дагуу эмчилгээ хийх шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах.
- Хорихоос гадуур тэнсэн хянан харгалзах.
- Хүч нэмэгдүүлсэн цахим хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
- Хорих газраас хугацааны өмнө суллагдсан хүмүүст тавих хяналтыг хэрэгжүүлэх зэрэг болно.

БНСУ-ын пробацийн үйл ажиллагааны тухай

БНСУ-ын пробацийн үйл ажиллагаа нь Хууль зүйн яаманд харьяалагддаг бөгөөд албан ёсны нэршлийг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын газар” хэмээн томъёолсон. Тус газрын харьяанд пробацийн үйл ажиллагааг багтаан хэрэгжүүлдэг 5 үндсэн чиглэл байдаг. Үүнд:

- Хуулийн байгууллагын хяналтанд хөдөлмөр эрхлүүлэх, нийгэмшүүлэх.
- Цалин хөлсгүй нийтэд тустай хөдөлмөр эрхлэх.
- Албадан сургалтад хамруулах.
- Ял шийтгэл авсан этгээдийн зан байдал, хувийн болон нийгмийн нөхцөл байдлын судалгаа явуулах.
- Цахим хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх зэрэг багтана.

Финлянд улсын пробацийн үйл ажиллагааны тухай

Финляндын пробацийн алба нь өнөөдрийн байдлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх.
- Насанд хүрээгүй хүний ял шийтгэл болон хяналтыг хэрэгжүүлэх.
- Тэнсэн хянан харгалзсан шийтгэлийг хэрэгжүүлэх.
- Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих чиг үүргийг 21 дүүрэг, орон нутгийн 11 нэгжийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Казахстан улсын пробацийн үйл ажиллагааны тухай

Казахстаны Пробацийн тухай хуульд зааснаар пробацийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байхаар зохицуулжээ. Үүнд:

- Шүүн таслах ажиллагаа хүртэлх пробаци. Сэжигтэн, яллагдагчид эрх зүй, нийгмийн асуудлаар туслалцаа үзүүлдэг цогц арга хэмжээ.
- Шүүн таслах ажиллагааны дараах үеийн пробаци. Тэнсэн хянан харгалзсан, эрх хязгаарлан этгээдэд тавих хяналт, тусламжийг багтаасан цогц арга хэмжээ.
- Ял эдлэх үеийн пробаци. Хорих ял шийтгэгдсэн хүнийг дахин нийгэмшүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээ.
- Суллагдсаны дараах пробаци. Хорих ял эдлээд суллагдсан хүнд нийгэмд дасан зохицох, нөхөн сэргээхэд чиглэгдсэн цогц арга хэмжээг тус тус багтаан хэрэгжүүлж байна⁸.

⁸ <http://duisastana.kz/department/probation/> [Сүүлд үзсэн: 2018.10.17.]

ДҮГНЭЛТ

Дээрх бүгдээс дүгнэн үзвэл, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр ял шийтгэлийг эдлүүлэх, ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, тэдгээрийг эргэн нийгмийн амьдралд хууль сахин биелүүлэгч зөв иргэн болгон төлөвшүүлж оруулах асуудал нь дэлхийн улс орнуудын эрүүгийн ялын бодлогын үндсэн тулгуур асуудал болж хөгжлийн голдирлоо нэгэнт олсон нь харагдаж байна.

Харин манай улсын хувьд 2017 онд шинэчлэн батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-иар хорих ангийн төрөл дэглэм, зорчих эрхийг хязгаарлах ял, баривчлах шийтгэл зэрэг эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд зарчмын болон эрүүгийн ялын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн бодлогын томоохон өөрчлөлт орсон.

Энэ нь Монгол Улсын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн хангахад тодорхой хэмжээнд нөлөөлж байгааг сүүлийн 3 жилийн статистик тоо, дүн мэдээллээс харж болно. Тухайлбал, хорих байгууллагуудад ял эдэлж байгаа хоригдлын тоо 2017 оны мөн үетэй харьцуулж үзвэл 1300–аар буюу 30,2 хувиар, цагдан хорих байруудад хоригдож байгаа хоригдогсдын тоо 2017 оны мөн үеэс 40 хувиар тус тус өссөн бөгөөд 2020 онд баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн хүний тоог 2019 оны дүн мэдээтэй харьцуулж үзэхэд 2491-ээр буюу 57,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хэмжээнд нийт хорих ял эдлэгсдийг насанд хүрсэн хүн амын тоонд харьцуулж үзвэл 100.000 хүн тутамд 220 орчим хоригдол ноогдож байгаа нь бүс нутгийн хэмжээнд харьцуулж үзвэл өндөрт тооцогдох үзүүлэлт юм. Энэ нь ял эдлүүлэх ажиллагааны явцад аюулгүй байдлыг хангах арга ажиллагааг боловсронгуй болгох, мэргэжлийн үйл ажиллагааны арга хэлбэрийг өнөөгийн нийгмийн харилцааны онцлог, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Пробацийн үйл ажиллагаа нь хорих болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, хорих байгууллагаас суллагдах дөхсөн, түүнчлэн ял эдлээд суллагдсан иргэдэд туслалцаа үзүүлэх, тэдэнд хяналт тавихад чиглэсэн зэрэг цогц нөлөөллийн механизм боловч Монгол Улсын өргөн уудам газар нутаг, байршил, түүний онцлогоос хамаарч ял эдлээд суллагдсан иргэнд хяналт тавих асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай юм.

Өөрөөр хэлбэл, гэмт хэрэгт холбогдон цагдан хоригдсон үеэс эхлэн хорих ангиас суллагдах, хорихоос өөр төрлийн ял эдэлж дуусах хүртэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, харин суллагдсанаас хойших хяналт тавих, туслалцаа үзүүлэх үйлчилгээг бие даасан тусгай институт хэрэгжүүлэх нь зүйтэй гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Гэмт явдлын хор уршгийг бууруулах, ял шийтгэгдсэн хүн дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгах хэрэгцээ, шаардлага байсаар байгаа өнөө цагт гадаадын зарим улс орны жишгийг судлан түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, нөхцөлийг бий болгох, тэр дундаа хорих ял эдлэгсэд болон хорихоос өөр төрлийн ялтан, цагдан хоригдогсдод чиглэсэн нийгэмшүүлэх ажлыг нэгтгэх замаар пробацийн тогтолцоо нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Ингээд цаашид хэрэгжүүлэх шаардлагатай зарим саналыг доор дурдъя. Үүнд:

- Пробацийн үйл ажиллагааг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хоригдсон үеэс нь эхлэн хэрэгжүүлж, хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд нэгдсэн хэлбэрээр нэвтрүүлэх хувилбарыг боловсруулах. Өөрөөр хэлбэл, зохион байгуулалтыг асуудлыг шийдвэрлэх;
- Пробаци судлалыг эрдэм шинжилгээ, судалгааны болон практик түвшинд хөгжүүлэх, нэр томьёо, зорилго, зарчим, агуулгыг бодлого гаргах түвшинд хүргэн сурталчлах;
- Пробацийн үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагын хүлээх үүрэг, төрийн бус байгууллага, сайн дурын ажилтны оролцоо зэргийг нарийвчлан тодорхойлох;
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгмийн ажлын болон сэтгэл зүйн цогц үйл үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинг бий болгох;

- Алба хаагчдыг гадаад, дотоодын их дээд сургуулиудад тус чиглэлээр сурган бэлтгэх замаар пробагийн үйл ажиллагааг явуулах мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх;
- Хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, суллагдах дөхсөн, хорих ял эдлээд хугацаа дуусаж болон хугацааны өмнө суллагдсан хүнд зориулсан нийгэмд эргэн нэгтгэх, нийгэм сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх тусгайлсан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

Эрүүгийн ялын болон ялын гүйцэтгэлийн бодлогыг сонирхон судлах, илтгэлд хөндөгдсөн асуудлаар санал бодлоо солилцохыг хүсвэл бид найрсаар хүлээн авч, хамтран ажиллах болно гэдгээ илэрхийлж байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- *Монгол Улсын Үндсэн Хууль*. 1992 он.
- *Эрүүгийн хууль*. УБ 2015 он.
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль*. 2017 он.

Монгол хэлээр:

- Б.Чимид. *Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл* 2004 он.
- Д.Баярсайхан, Т.Золбоо. *Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл*. 2012., Уб. Б.Алтангэрэл, Ц.Очгэрэл, Г.Галсанжамц. *Дэлхийн зарим улс орны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны зүй тогтол, арга зүй, эрх зүйн зохицуулалт, чиг хандлагын харьцуулсан судалгаа* сэдэвт судалгааны ажил. Уб., 2018 он.
- Ц.Очгэрэл. *Анх удаа хорих ял шийтгүүлсэн хоригдлын ял эдлүүлэх ажиллагааны онцлог, анхаарах асуудал*. Ази номхон далайн бүс нутгийн хорих байгууллагын удирдах ажилтны 39 дүгээр бага хурал. Сүлд-инфо тусгай дугаар. Уб., 2019
- Ц.Очгэрэл. *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдал анхаарах асуудал*. ШШГЕГ-ын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт чиг хандлага сэдэвт ЭШХ-ийн эмхэтгэл. Уб., 2019.
- Цэдэвсоном Очгэрэл. *Особенности работы с заключенными с психическими расстройствами*. Сборник IV Международной пенитенциарный форум “Преступление, наказание исправление” Том №1. Рязань., 2019.
- Ц.Очгэрэл. *Гадаадын зарим улс орны нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, түүний онцлог*. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, чиг хандлага сэдэвт ЭШХ-ын эмхэтгэл. Уб., 2020.

Гадаад хэлээр:

- Нильс Кристи. *Причинная боль. Роль наказания в уголовной политике. Норвегия.*, 2011.

Цахим эх сурвалж:

- www.duisastana.kz
- www.zakon.kz

FEATURES OF PROBATION, ISSUES TO BE EMPHASIZED

Ochgerel.Ts

Colonel, Chief of the Internal Affairs and Legislation Division of Administration and Management Department of the General Executive Agency of Court Decision of Mongolia

Tsengel.A

Major, Officer of the Internal Affairs and Legislation Division of Administration and Management Department of the General Executive Agency of Court Decision of Mongolia

ABSTRACT

In order to achieve the goals of criminal liability and implement the beneficial execution of criminal sentences for society and individuals heavily depends on the institutional system and structures of Penitentiary. Probation is a complex and special system including social and psychological influencing measures to rehabilitate offenders without custodial sentence into the correctional facility.

KEY WORDS

Criminal sentence execution activity, rehabilitation, probation, punishment, transition processes into society, community based correction.

ЦАХИМ СҮЛЖЭЭНИЙ ҮҮСЭЛ БА ЦАХИМ ХЭЛЦЭЛ



В.Амартүвшин

СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

ТОВЧЛОЛ:

Цахим хэлцэл, эрх зүйн зохицуулалтыг судлахын өмнө түүнийг ашиглахад шаардагдах технологийн үүсэл хөгжил, зүй тогтлыг танин мэдэх, иргэний хууль, хэрэглээний хувьд хэрхэн яаж энэхүү зохицуулалтыг хэрэглэх, бодит амьдралд цахимаар хийгдэж буй иргэний эрх зүйн шинжтэй олон төрлийн хэлцэл, аливаа үйлдлийг технологи, эрх зүйтэй уялдан зохицуулах арга зүйг судалж байна. Монгол Улсын Иргэний хууль дахь Цахим хэлцлийн эрх зүйн зохицуулалт хэт явцуу, практикт шийдвэрлэгдсэн маргаан гараагүй атал амьдралд цахимаар хэлцэл хийгдсээр л, түүнийг тайлбарлан хэрэглэх, эрх зүйн зохицуулалт хангалтгүй тул энэхүү өгүүллээрээ өөрийн санаа бодлыг зохих судалгааны хамтаар та бүхэнтэй хуваалцахаар толилуулж байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Цахим хэлцэл үүсэх урьдчилсан нөхцөл

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүн төрөлхтөн 1969 онд анхны цахим сүлжээний үүсэл, нээлтийг бий болгож, тухайн үед дараагийн эрин буюу мэдээллийн эринийг нээж байгаагаар мэдээгүй байсан ч 1991 оноос хойш эрчимтэйгээр хөгжсөнөөр өнөөдөр цахим сүлжээ, цахим эрх зүйн харилцаа, цахим орчин, хөгжил нь дэлхийд өөрийн байр сууриа тогтоосон хүчин зүйл болж үүсэж, хөгжсөн бөгөөд цаашид түүний туслалцаатайгаар эрх зүйн оновчтой зохицуулалт шаардлагатай болжээ.

Монгол улсын хувьд 1990 он гарснаас хойш нийгэм эдийн засаг, технологи, эрх зүйн хөгжилд тодорхой өөрчлөлт, дэвшил гарч үүний хэрээр технологи, сүлжээ, хурд, орчин, эрх зүйн харилцаа, зохицуулах зүйлийг судлах шаардлага тулгарч ирсэн. Энэ шаардлагыг үндэслэн зохицуулах зүйл, зохицуулалтын аргыг судлахад юун түрүүнд түүний үүсэл хөгжлийг судлах нь зүй ёсных юм.

Нийгэм, эдийн засгийн харилцаа өргөжиж, интернет орчин үүссэн 1960 оноос хойш бид шинэ ертөнц, шинэ харилцаанд орж эхэлсэн, шинэ ертөнц, шинэ харилцаа нь улс орны хил хязгаар, орон зайнаас үл хамааран эрх зүйн этгээд хоорондын электрон-цахим харилцааг бий болгосон, уг харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт дутмаг, хомс,

ирээдүйн эрх зүйн харилцааны хурдыг нөхөн зохицуулах боломжгүй.

Орчин үеийн техник, технологийн тусламжтайгаар /компьютер, гар утас-телефон, телефакс, и-мэйл, мессэнжер, дүрстэй дуудлага, утасгүй интернет орчин/ хэлцэл хийх боломж бий болсноор харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт хийх, зохицуулах зүйлийг судлах шаардлага тулгарсан нь сэдвийг сонгох үндэслэл болсон.

Цахим үүсэл, цахим хэлцэл, эрх зүйн зохицуулалтыг тухайлан судалсан бүтээл хомс, Л.Очирбат “Интернет ба эрх зүй”, Т.Туяа “Интернет хэрэглээ, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, “Интернет дэх электрон худалдааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, мөн Б.Болорсайхан “Цахим сургалт, өнөөгийн байдал, ахиц дэвшил, сорилт”, Д.Дашдаваа “Цахим ертөнц дэх хувь хүний аюулгүй байдал”, П.Оюунчимэг “Олон улсын гэрээ хэлэлцээрийг шүүх хуулийн практикт хэрэглэх нь”, Г.Сарнай “Электрон худалдаа ба оюуны өмч”, Ж.Ундрэм “Онлайн худалдан авах зан төлөвт нөлөөлж буй эрсдэлийн хүчин зүйл” магистрын зэрэг горилсон судалгааны ажил судлагдсан байсныг түүвэрлэв.

Цахим хэлцэл нь мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан, тэр дундаа интернет ашиглан иргэн, хуулийн этгээдээс бусад 1 ба түүнээс дээш эрх зүйн субъект /чадамж/-тэй ил тод санал гаргах, хүлээн авах, зарим төрлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хүлээн авах, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хангах, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагаа, харилцааг зохицуулан дэлхий нийтийн дотоод, гадаад эдийн засгийн болон бусад харилцаа, үйл ажиллагааг оновчтой зохицуулах арга хэрэгсэл юм.

Энэхүү судалгааны хүрээнд цахим хэлцэл, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудлыг судлах, энэ талаарх төрийн болон засгийн газрын бодлогын хэрэгжилт, интернет харилцаа үүссэн түүхэн уламжлал, шинэчлэл, харьцуулсан судлалын асуудал, цахим хэлцлийн тухай ойлголт, онцлог, шинж чанар, нөгөө талаар хувийн эрх зүйн асуудлыг цогц байдлаар нь судалсны үндсэн дээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал дэвшүүлэх, таамаглал, төсөөлөл гаргах, цахим хэлцлийг хянан шийдвэрлэх, оновчтой үр нөлөөтэй арга замыг тодорхойлох, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн шаардагдах нөхцөлүүдийг онол болоод практикийн талаас нь судлан дүгнэж цаашид цахим хэлцлийн өнгөрсөн болон өнөөгийн байдлыг судалсны үндсэн дээр ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох нь судалгааны ажлын нэг зорилго.

Энэхүү өгүүлэлд хууль зүйн шинжлэх ухааны танин мэдэхүйн нийтлэг арга болох индукцийн болон дедукцийн хандлагыг хослуулан хэрэглэсэн ба эхний шатанд баримт материал цуглуулах, ажиглах, түүвэрлэх, судалгааны асуудлыг тодорхойлж үр дүнгийн талаар таамаглал дэвшүүлсэн, дараагийн шатанд мэдээллийг боловсруулж задлан шинжилгээ, тайлбар хийх, таамаглал шалгах, анализ-синтез, индукц-дедукц, системд хандлага, ярилцлага хийх, түүхчлэх, харьцуулах, бичиг баримтын болон ажиглалтын аргуудыг ашиглана.

Хүмүүний агуу нээлтүүдийн тоонд интернет сүлжээ буюу цахим сүлжээ зүй ёсоор орж байна. Цахим сүлжээ нь хэлцэл хийгч талуудын орон зай, хил хязгаараас үл хамааран хилийн чанадаас мэдээлэл солилцох, санал гаргах, хэлцэл хийх өргөн талбар болж, дэлхийн олон сая хэрэглэгчдийг холбосон харилцаа холбооны, цахим худалдааны, оролцогчдын зан төлөвт нөлөөлж буй хүчин зүйлийг харуулсан сүлжээ бий болон үүсэжхөгжжээ.

Үүсэл хөгжлийн явцад нийтийн болон хувийн эрх зүйн харилцаанд маргаанууд гарч эхэлсэн. Эрх зүйн туйлын зорилго болох нийгмийн харилцааг эрх зүйн ямар ч хийдэлгүйгээр зохицуулах ёстой боловч энэ цахим сүлжээг ашиглан хийгдэж буй эрх зүйн харилцааг зохицуулахад нэг салбар эрх зүйгээр зохицуулах нь явцуу, холимог-салбар эрх зүйгээр зохицуулах шаардлагыг цахим сүлжээ буюу цахим харилцаа хэдийнээ биднээс шаардаж байна. Энэ нь, уг харилцааг зохицуулах, амьдрал ойр, хэрэгжих боломжтой эрх

зүйн зохицуулалтыг биднээс шаардаж байгаа болохоос тунхаглал төдий зүйлийг хараад суувал Төр, Засгийн газар, иргэн, хуулийн этгээд эдийн засгийн алдагдал хүлээх, хямралд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, эрх зүйн хоцрогдлыг нотлон харуулна.

1.Цахим сүлжээний үүсэл ба эрх зүйн зохицуулалт

Олон улсын тvvхэн дэх хамгийн том ололт дэвшилт, нээлтүүдийн нэг нь Интернет юм. Анхлан АНУ-н цэрэг, боловсролын салбарын компьютеруудыг нийлүүлсэн сүлжээ байсан бол, өнөөдөр Интернет сүлжээ нь дэлхий даяар олон арван сая компьютер, гар утас, таблетыг холбосон сүлжээ болон хөгжжээ.

Одоогоос 50 жилийн өмнө (1969 онд), АНУ-ын Батлан Хамгаалах Яам нь Интернетийг ARPANET гэдэг нэртэйгээр анх 4 компьютерыг хооронд нь холбож үүсгэжээ. Үүний гол зорилго нь цэргийн судалгаа шинжилгээ хийж байсан цөөн хэдэн их дээд сургуулиудын компьютеруудыг холбох явдал байжээ. Энэ сүлжээнд компьютеруудыг нэмж холбосноор, 1974 он гэхэд 62 компьютер холбогджээ.

1983 онд уг сүлжээг хоёр салгасан бөгөөд, нэг нь цэвэр цэргийн хэрэгцээнд (Milnet), нөгөөдөхийг нь их дээд сургуулиудын эрдэм шинжилгээ судалгааны ажилд зориулж Интернет гэж нэрлэжээ.¹ Үүнээс хойш олон удаа шинэчлэлт хийгдсээр 1994 онд интернетэд 4 гаруй сая толгой компьютер холбогдсон байхад, ихэнх нь бизнесийн зорилгоор холбогдсон байсан тул, АНУ, Канадын Засгийн газрууд өөрсдөдөө харьяалагдах цөөн хэдэн сүлжээндээ санхүүжилт хийхээ зогсоосон ба удалгвй бусад байгууллагууд, бусад орны засгийн газрууд ижилхэн арга хэмжээ авчээ. Ингээд интернет нь цэвэр бизнесийн үйл ажиллагаа, харилцаан дээр оршин тогтнох болжээ, улмаар интернет нь зүгээр л нэг шинжлэх ухааны нээлт бус дэлхийн хамгийн том зах зээл болох бизнесийн зах зээл, иргэний эрх зүйн гэрээ, хэлцэл болон бусад харилцаанд хүч түрэн орж үүнийгээ дагаад маш эрчимтэйгээр хөгжиж дэлхийн улс гүрнүүдийн эдийн засгийг бүрдүүлэгч нэгэн томоохон нөлөөлөл болсон байна.

Орчин үеийн эдийн засаг, нийгэм, эрх зүйн харилцаанд харилцаа холбооны хэрэгсэл, интернетийн сүлжээг ашигласнаар электрон худалдаанаас олох ашиг орлого дэлхийн хэмжээнд өсөж байгааг судалгааны байгууллагын тоо баримтаас харж болно. Энэ нь Цахим хэлцлийн эрх зүйн талаарх ойлголт, цахим эрх зүйн харилцаа, тодорхойлолт шаардлагатай болсныг илтгэнэ.

Дэлхийн интернет хэрэглэгчдийн өсөлтийг харвал:²

Огноо	Хэрэглэгчдийн тоо	Дэлхийн хүн амд эзлэх хувь
1994 он	4 сая	-
1995 оны 12-р сар	16 сая	0,4 %
1996 оны 12-р сар	36 сая	0,9 %
2000 оны 12-р сар	361 сая	5,8 %
2003 оны 3-р сар	608 сая	9,7 %
2005 оны 12-р сар	1 тэрбум 18 сая	15,7 %
2008 оны 12-р сар	1 тэрбум 565 сая	23,3 %
2010 оны 6-р сарын 30	1 тэрбум 966 сая	28,7 %
2020 оны 12-р сарын 28	4,929,926	63.2 %

World Regions	Population (2020 Est.)	Population % of World	Internet Users 30 Sept 2020	Penetration Rate (% Pop.)	Growth 2000-2020	Internet World %
Africa	1,340,598,447	17.2 %	631,940,772	47.1 %	13,898 %	12.8 %
Asia	4,294,516,659	55.1 %	2,555,636,255	59.5 %	2,136 %	51.8 %
Europe	834,995,197	10.7 %	727,848,547	87.2 %	593 %	14.8 %

¹ Л.Очирбат, *Интернет ба эрх зүй*, УБ, 2009 он, 5 дахь тал

² www.internetworldstats.com -тоон судалгаа

Latin America / Caribbean	654,287,232	8.4 %	467,817,332	71.5 %	2,489 %	9.5 %
Middle East	260,991,690	3.3 %	184,856,813	70.8 %	5,527 %	3.7 %
North America	368,869,647	4.7 %	332,908,868	90.3 %	208 %	6.8 %
Oceania / Australia	42,690,838	0.5 %	28,917,600	67.7 %	279 %	0.6 %
WORLD TOTAL	7,796,949,710	100.0 %	4,929,926,187	63.2 %	1,266 %	100.0 %

Гар утас, компьютер зэрэг техник хангамжийн хөгжил, сүлжээний тархацтай холбоотойгоор дэлхийн хүн амын дийлэнх хэсэг нь өнөөдөр цахим хэрэглэгч болсон. Интернет нь хөгжлийнхөө эхэн үед интернет сүлжээний мэдээллийн электрон орон зайн харилцааг зохицуулахад техникийн зохицуулалт үр нөлөөтэй байсан боловч сүүлдээ хүмүүсийн мэдээллийн сүлжээний нууцлалыг алдах, цаашлаад хувийн эрх зүйн харилцаа, гэрээний эрх зүйн маргаан гарах болсон нь хувийн эрх зүйн зохицуулалт хэрэгтэй болсныг илтгэнэ.

Техникийн зохицуулалт – Мэдээллийн буюу хувийн нууц, зохиогчийн эрх, худалдах худалдан авах, хамтран ажиллах зэрэг маш олон хувийн эрх зүйн харилцаанд технологи ашиглаж санал тавих, хуулбарлах, хүргэх, хүсэл зоригийн илэрхийлэл нэгдэх, хариу өгөх, баталгаажуулах үйлдлүүдийг техник аргаар зохицуулж байна.

Эрх зүйн зохицуулалт–Цахим харилцааг хуульчлан зохицуулахдаа үндэсний хууль тогтоомж, эсхүл олон улсын гэрээ конвенцоор зохицуулах боломжтой ч энэ нь хэт туйлширсан зохицуулалтын арга бөгөөд дэлхийн улс орнууд тухайн аргыг хослуулан ашиглаж байна. Учир нь Цахим харилцаа нь нэг улсын үндэсний дотоодын асуудал бус олон улсын эрх зүйн харилцааны асуудал болж өргөн, цар хүрээгээ тэлж байгаатай туйлын хамааралтай.

Цахим сүлжээ нь нийгмийн харилцааны хэрэглүүр учир тухайн сүлжээгээр харилцаж буй хувийн эрх зүйн харилцааны мөн чанараас хамаарч нийтийн болон хувийн эрх зүйн харилцааны аль алиныхаа шинжийг агуулдаг онцлог төрлийн харилцаа юм. Үүнийг М.М.Рассолов, А.С.Солдатов нар “Нийтийн болон хувийн хүсэл зоригийг илэрхийлдэг тул комплекс зохицуулах нь зүйтэй” хэмээн тайлбарласан.³ Иймээс тухайн харилцааны төрөл, хэлбэр, онцлогоос хамааран холимог байдлаар тодорхойлж болохоор байна.

Жишээ нь: Цахимаар хэлцэл хийх, гэрээ байгуулахтай холбогдсон харилцааг хувийн эрх зүйгээр, цахим сүлжээн дэх оюуны өмчийг хамгаалахтай холбогдсон харилцааг оюуны өмчийн эрх зүйгээр, цахим хэрэглээн дэх гэмт хэрэг, зөрчил түүнд хүлээлгэх хариуцлагатай холбогдсон харилцааг эрүүгийн эрх зүйгээр гэх мэтчилэн тухайн салбар эрх зүйгээр зохицуулах нь зохимжтой бөгөөд тухайлсан нэг салбар эрх зүйгээр зохицуулах шаардлагагүй, боломжгүй. Өөрөөр хэлбэл цахим сүлжээ нэг эрх зүйгээр хязгаарлагддаггүй юм.

2.Олон улс дахь эрх зүйн зохицуулалтыг товч танилцуулбал:

Цахим харилцааг зохицуулах олон улсын хамтын ажиллагаа 1990-ээд оноос идэвхтэй хөгжиж эхэлсэн байх бөгөөд 1985 онд НҮБ-ын олон улсын худалдааны эрхийн комиссын 17 дугаар чуулганы баримт бичгээр Засгийн газар болон Олон улсын байгууллага нь олон улсын худалдаанд автоматжуулагдсан боловсруулалтыг ашиглахыг хүлээн зөвшөөрч, эрх зүйн хамгаалалт тогтоохоор зааснаас гадна НҮБ-ын ерөнхий ассамблейн 1996/12/16-ны 51\162 тогтоолоор батлагдсан “Электрон худалдааны загвар хууль”, мөн байгууллагаас 2001 онд батлагдсан “Электрон гарын үсгийн тухай жишиг хууль” зэрэг нь электрон харилцааг зохицуулсан улс орнуудын үндэсний хууль тогтоомжийг ижилсүүлэхэд чухал нөлөө үзүүлсээр байгаа боловч олон улсын хэмжээнд интернетийн сүлжээ болон түүнтэй

³ Т.Сэнгэдорж, Хууль зүйн шинжлэх ухаан, УБ, 2006 он, 88 дахь тал

холбоотой харилцаанд маргаан гарсан тохиолдолд аль улсын хуулиар зохицуулах, ямар эрх зүйн эх сурвалжийг хэрэглэх, уг харилцаа үүссэн газар нутгийг тогтоох, түүнчлэн мэдээллийг дамжуулагч компани буюу провайдерт хариуцлага хүлээлгэж болох эсэх гэх зэрэг шийдвэрлэвэл зохих олон асуудал нарийвчилсан зохицуулалтгүй хэвээр байна гэжээ.⁴

Одоогоор дэлхийд мөрдөгдөж буй цахим сүлжээний эрх зүйн зохицуулалтаас дурдвал, “Зохиолчийн эрхийн гэрээ” Дэлхийн оюуны өмчийн байгууллага. 1996 он, “Цахим худалдааны талаарх загвар хууль” Нэгдсэн үндэстний байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн хороо. 1996 он, “Нууцлалын бодлогын удирдамж” Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага. 1997 он, “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай” Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблей 2005 он зөвлөмж, “Электрон хэлцлийн тухай жишиг хууль” НҮБ-ын олон улсын худалдааны байгууллага / тодорхойгүй/-ууд холбогдох эрх зүйн актуудыг баглан гаргаж мөрдөж байна.

Олон улсын түвшинд эрх зүйн зохицуулалт хийх зарим оролдлогууд хийгдэхийн хажуугаар улс орнууд дотоодын эрх зүйн зохицуулалтыг идэвхтэй хийж байна. Интернет сүлжээний тархац дэлхий дахинд харилцан адилгүй байгаа бөгөөд АНУ, ЕХ, ИБУИНВУ, Япон, БНСУ зэрэг хөгжингүй улсуудад интернет хэрэглээ маш өргөн хүрээтэй байгаа юм. Энэ ч утгаараа эрх зүйн зохицуулалт илүү өндөр төвшинд хөгжиж байгаа гэж хэлж болно. Гэхдээ дээр дурдсан хөгжингүй улсууд төдийгүй Монгол Улстай эдийн засгийн хөгжлийн түвшингийн хувьд дээрх орнуудаас илүү ойролцоо улсуудад ч интернет сүлжээний хэрэглээ, түүнийг дагасан эрх зүйн зохицуулалт хөгжиж байгааг дор дурдсан жишээнээс харж болно. Үүнд:

Венесуэл Улс: Төрийн байгууллага, хувийн салбарын бизнес эрхлэгчид хамтран “Венесуэлийн цахим худалдааны Танхим” нэртэй байгууллагыг байгуулсан ба товчоор “CAVECOM” гэж болно. Энэхүү бие даасан байгууллага нь Венесуэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эрхэлдэг цахим худалдааг дэмжих, цахим худалдааг хөгжүүлэх, дотоод бодлогоороо дэмжих, цахим худалдаатай холбоотой судалгаа шинжилгээ хийх гэсэн гол чиг үүргийг хэрэгжүүлж олон улсын бусад байгууллагатай харилцаа тогтоож ажилладаг байгууллага юм.

Тунис Улс: 1997 оны 11 дүгээр сарын эхээр Тунисын Засгийн газар Цахим худалдаа болон цахим мэдээлэл солилцооны үндэсний хороог байгуулсан. Хэд хэдэн ажлын хэсэг байгуулсан тухайн ажлын хэсгүүд нь өөр өөрийн гэсэн чиг үүрэгтэй. Үүнд: Цахим хэлцлээс үүсэх асуудлууд \эрх зүй, худалдааны, санхүүгийн, аюулгүй байдал, сургалтын г.м\ мөн хорооны зөвлөмжүүдийг боловсруулах ба эдгээр нь бүгд засгийн газарт тайлан танилцуулдаг.

Перу Улс: Экспортыг урамшуулах Перугийн Зөвлөл \Promrex\-ийн санаачлагаар Перугийн цахим худалдааны Институт байгуулагдсан. Уг байгууллага нь их олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Үүнд: Үндэсний болон олон улсын хэмжээний төслүүдэд оролцогч байх, олон улсын болон бусад адил төстэй байгууллагуудтай хамтран ажиллаж явуулж буй үйл ажиллагааг дэмжих, хууль эрх зүйн болон бусад зохицуулалтыг бий болгох хэрхэн хэрэглэх талаар бүхий л зөвлөмж мэдээллийг өгөх, Цахим хэрэглээг нийтэд зөв зохистойгоор түгээх талаар сурталчилгаа болон холбогдох бусад зүйлсийг зохион байгуулж төрөлжүүлж бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллаж түүнийхээ мэдээллийг нийтэд түгээх, цахим Испани хэлийг цахим худалдаанд нэвтрүүлэх, цахим хэрэглээг урамшуулах зэрэг үүргийг хэрэгжүүлнэ. IPCE нь хагас төрлийн байгууллага бөгөөд хувийн аж ахуй нэгжүүд, орон нутгийн засаг захиргаа, олон улсын шинжээчид энд оролцож ажилладаг.

Шри Ланка улс: 1995 онд Шри Ланкын Худалдаа мэдээллийн сүлжээ /TrandenetSL/ байгуулагдаж, Дотоод болон гадаад худалдаа, хүнсний яамтай хамтран

⁴ Олон улсын цахим эрх зүйг зохицуулсан гэрээг WWW.ZAKON.ORG сайтаас [сүүлд үзсэн: 2020.12.15]

Шри Ланкын экспортын хөгжлийн зөвлөлийн дор үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Уг байгууллагын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Cyber trader-ийн веб серверээр дамжуулан хэрэгцээтэй мэдээллийг “Нэг цэгийн үйлчилгээ”-ний хэлтсээр дамжуулна. Тухайн серверт 350 гаруй Шри Ланкын бүтээгдэхүүний талаарх мэдээ, худалдааны статистик, үзэсгэлэн худалдааны мэдээлэл, олон улсын болон бараа бүтээгдэхүүний стандартууд, импортлогч орнуудын хэрэглэдэг зохицуулалтыг үзэж болохуйц байдгаараа бусдаас онцлогтой.

Өмнөд Африк: Бизнесийн байгууллагууд интернетийг өргөнөөр хэрэглэж байна. CO.ZA домайн дор 40,000 гаран корпорацийн хаягууд бүртгэгдсэн, мөн 20 төрлийн сэтгүүл онлайн хэлбэртэй байдаг. Цахим хэлбэрээр өөрт хэрэгцээтэй зүйлийг авах \гасалбар захиалах, бүтээгдэхүүний захиалга онлайнгаар өгөх, орон нутгийн үйлчилгээ\, Өмнөд Африкийн засгийн газар, шуудан, харилцаа холбоо, дамжуулалтын яамны Харилцаа холбооны газраас үндэсний хэмжээний мэдээлэл холбооны технологийн талаар баримтлах стратегийн боловсруулж 1998 оны 03 дугаар сарын мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаар баримтлах анхны баримт бичгийг гаргасан. Мөн Харилцаа холбооны газар өөрийн хийсэн төслүүдээ нэгтгэж, татвар дижитал гарын үсэг баталгаажуулах, хувийн мэдээллийн нууцлал, оюуны өмч нууцлалын зэрэг асуудлыг шийдвэрлэх суурь бүтэц, зохицуулалтыг бий болгох нь гол зорилго нь байсан.

Зарим улс орон цахим орчин, хувийн эрх зүйн харилцаанд төр өөрийн хүсэл зоригийг шууд тулган хүлээлгэж, эрх зүйн мөн чанарыг алдагдуулах хандлага гаргадаг. Тухайлбал: Канад улсад хуулийн этгээдийн бүртгэлтэй, өөрийн үйл ажиллагааг АНУ-ын Техас мужид интернетээр хэрэгжүүлдэг компанид холбогдох хэрэг нь АНУ, Канадын эрх зүйн тогтолцоонд нэлээдгүй маргааныг үүсгэсэн байна. Уг маргааныг Канадын давж заалдах шүүхээс 1999 оны намар шийдвэрлэхдээ Канад улсын мэдээллийн орон зайд үүсэж байгаа харилцаанд АНУ-ын эрх зүйн тогтолцоо хамааралгүй хэмээн үзсэн байна.⁵

Оросын эрдэмтэн М.М.Карелина “Интернет ба эрх зүй” өгүүлэлдээ “Интернетийн харилцаанд дүн шинжилгээ хийж үзвэл уг харилцаанд онцгойрох ямар ч шинж байхгүй” хэмээн үзсэн.⁶ Тухайн эрдэмтэн нь энэ эрх зүйг бусад эрх зүйгээс онцгойроод байх зүйлгүй гэж үзсэнтэй миний бие санал нийлэхгүй байна, хэлцлийн төрлүүдийн адил цахим харилцаанд гарч буй маргаануудыг шийдвэрлэх боломжтой. Шийдвэрлэх гарц нь нийтийн болон хувийн эрх зүйг хослуулан, эсхүл тухайн салбар эрх зүйг хэрэглэхдээ одоогоор ашиглаж буй гэрээ конвенцод нийцүүлж, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага үүсжээ. Илүү боловсронгуй болох тусам дотоодын хууль тогтоомж нь олон улсын гэрээ, конвенцод нийцнэ.

Эрх зүйн туйлын зорилго бол өөрийн зохицуулах зүйл болсон нийгмийн харилцааг эрх зүйн ямар ч хийдэлгүй зохицуулахад оршдог. Гэтэл интернетийн сүлжээнд үүсэж байгаа маргаантай харилцааг шийдвэрлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зөвшилцөл, заншил, үндэсний хууль тогтоомжууд хангалттай бус байна.

3.Монгол улсын цахим сүлжээний үүсэл хөгжил, эрх зүйн зохицуулалт

“Хэлцэл” гэж иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно гэж тайлбарлажээ.⁷

ИХ-ийн 8.1.1-д зааснаар хэлцэл хийснээр иргэний эрх зүйн харилцаа үүснэ. Хэлцэл гэдэгт эрх зүйн үр дагавар гаргахад чиглэсэн хүсэл зоригийн илэрхийллийг ойлгох бол энэ нь ихэвчлэн гэрээ, хэлцэл байгуулах замаар илэрнэ, ИХ-ийн 39.1. Түүнчлэн зарим нөхцөлд нэг талын хүсэл зоригийн илэрхийлэл нь мөн нэг талын хэлцэл хэмээх ухагдахуунд

⁵ Л.Очирбат, Интернет ба эрх зүй, УБ, 2009 он.

⁶ М.М.Карелина, “Интернет ба эрх зүй” өгүүлэл, “орч”, Т.Туяа, Гэмт явдал судлал, 2016 он.

⁷ Б.Болортогос нар, Хууль зүйн нэр томъёоны тайлбар толь, УБ, 2012 он, 139 дэх тал

хамаардаг, ИХ-ийн 39.2. Хэлцлийг дотор нь өмчийн ба үүргийн хэлцэл гэж ангилах ба үүргийн хэлцлийн тусламжтай үүргийн харилцаа үүснэ.⁸

Хэлцэл ба хүсэл зоригийн илэрхийлэл гэх мэт ухагдахуун нь өндөр хийсвэрлэлийн дүнд бүтсэн эрх зүйн ойлголтууд бөгөөд бүрэлдэхүүнийг шинжлэх ухааны тайлбар хийх замаар тодорхойлно. Хэлцэл нь холбогдох этгээдийн хүссэн үр дагаврыг бий болгох үндэслэл болдог бүхий л үйл хөдлөлийг хамрах бөгөөд үүний гол цөмийг хүсэл зоригийн илэрхийлэл бүрдүүлнэ. ...Тиймээс хэлцэл гэдгийг дор хаяж нэг этгээдийн хүсэл зоригийн илэрхийллээс бүрдэж байдаг, эрх зүйн үр дагавар нь энэхүү илэрхийллийн агуулгаас шууд хамаарах үйлдэл, эс үйдэхүй хэмээн тодорхойлдог гэжээ.⁹

Иргэний хуульд ... Хэлцлийг хуульд заасан хэлбэрээр, хуульд заагаагүй бол талууд хэлэлцэн тохиролцож амаар буюу бичгээр хийнэ. Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Талууд гол нөхцөлийн хувьд өөрийн хүсэл зоригоо бодит үйлдлээр илэрхийлж хэлцэл хийж болно¹⁰ гэж зохицуулжээ.

Иргэний хуульд /42.1./ Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно. Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр хэлцэл хийх бол /43.2.4/ талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан. /43.4/. Хэлцлийн агуулгыг тодорхойлох боломжгүй бол уг хэлцлийг хийгдээгүйд тооцно¹¹ гэжээ.

Монгол Улс, тэр дундаа иргэний эрх зүйн харилцаанд оролцогч цахим хэлцлийг хийх боломж 1994 оноос эхэлж бүрдсэн байна. “Мэдээллийн харилцаа” ББХК (Датаком) анх удаа интернетийн үйлчилгээг явуулж эхэлсэн бөгөөд Монгол улсын интернетэд холбогдох цорын ганц гарц нь байжээ. 1996 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол улсад интернет нэвтэрснийг албан ёсоор зарлаж нээлтийн ажиллагаанд тухайн үеийн ерөнхийлөгч асан Пунсалмаагийн Очирбат оролцож байжээ.

1996 онд интернет хэрэглэгчдийн тоо Монголд ердөө 500 гаруй байсан бол одоо албан газар, өрх бүр шахуу интернетэд холбогдож хувийн болоод албаны бүхий л ажил хэрэг үүгээр өрнөдөг болжээ. Интернетийг тогтмол хэрэглэгчдийн тоо 30 гаруй хувьд хүрч 2007 оноос хойш интернет хэрэглэгчийн тоо даруй 2.5 дахин өсжээ. Монгол дахь интернет хэрэглэгчдийн судалгааг харвал: 1996 онд интернет сүлжээ хэрэглэгчийн тоо 500 гаруй байсан бол 2020 онд интернет хэрэглэгчдийн тоо 2,910,000 боллоо өссөн, Монгол Улсад 2019 оны нэгдүгээр сарын байдлаар фэйсбүүк идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2.2 сая байна.

Үүнээс гар утсаараа нийгмийн сүлжээд холбогддог хэрэглэгчид 2.1 сая байгаа нь улсын нийт хүн амтай харьцуулахад маш өндөр тоо. Нийгмийн сүлжээний хэрэглээний үзүүлэлтээс авч үзэхэд нэг сард дунджаар манай улсын нэг иргэн 5 сэтгэгдэл бичиж, 16 пост дээр like дарж, 3 пост share хийж, 12 сурталчилгааны мэдээлэл үзэж сонирхдог. Бас нэгэн сонирхолтой баримт дурдахад олон улсын хэмжээнд фэйсбүүкийг өөрт ашиглах хугацаа нь 53 минут байхад Монгол Улсад ашиглах хугацаа нь 77 минут байна. Энэ нь манай улсын фэйсбүүк хэрэглээ олон улсын дунджаас хамаагүй их гэдгийг мэдэж болох юм.

Мөн Монгол улсад 2016 оны эцсийн байдлаар өрхийн суурин интернет хэрэглэгч өрх 226,147 байна гэсэн тооцоог Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргажээ. Харин үүрэн интернет хэрэглэгч буюу гар утсаар интернетэд холбогддог 2,656,330 хүн

⁸ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, Дөрөвдүгээр хэвлэл, УБ, 2015 он, 21 дэх тал

⁹ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, хоёр дахь хэвлэл, УБ, 2014 он, 76 дахь тал

¹⁰ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл сэтгүүл, 2002 он, №7

¹¹ Мөн тэнд

байна. 22 жилийн өмнөх Монгол Улсын цахим хэрэглэгчдийг одоогийн хэрэглэгчийн тоотой харьцуулбал өнөөдөр хүн амын тоотой тэнцэхээр хэмжээнд дөхжээ.¹² Эдгээр тоо баримтууд нь хэрэглэгч цахимаар эрх зүйн харилцаанд оролцож буйг харуулж байна.

Хэрэглэгчийн тоо өсөхийн хэрээр Монгол улсад цахим харилцааг зохицуулах хууль, эрх зүйн ойлголт, зохицуулалт дутагдаж байгааг нотолдог. Манай улсад одоогийн байдлаар энэ харилцааг зохицуулсан, хэрэглэж буй цөөн хэдхэн хууль байдаг ба уг эрх зүйн харилцааг зохицуулахад томоохон дутагдал, алдаа, хийдэл гарч байна.

Хэлцэл нь орчин үед нарийсаж, цахим хэлбэрээр хийгдэх боломжтой буюу цахим хэлцэл технологийн ололт, амжилт, хөгжил дэвшилтэй хамт хөгжсөөр байна. Энэ нь хэлцлийн уламжлалт хэлбэр, хандлага, сэтгэлгээг эвдэж халсан цоо шинэ хэлцлийн хэлбэр, төрөл үүсэж хөгжиж буйг нотлоно.

Цахим хэлцлийн онцлог шинж -/хэлцлийн ерөнхий шинжээс гадна/

1. Техник, технологи ашиглаж баталгаажна.
2. Сүлжээ ашиглана. /2G, 3G, 4G, 5G, + LTE/, байгууллага доторх дотоод сүлжээ /Харилцаа холбооны сүлжээ, хиймэл дагуулын сүлжээ/ гэх мэт /Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, -давтамж ашиглах, Контент
3. Хурд, өргөн тархацтай хөгжинө. жишээлбэл, цахим сүлжээний хурд нь 3.5G үйлчилгээнээс 4G LTE рүү шилжихэд даруй 20 дахин, 4G үйлчилгээний хурдаас 2 дахин илүү хурдаар интернэтэд холбогдох боломжтой болдог байна. Техник дамжуулалтын хурд, хэлцэл хийх цаг хугацаа хурдасна.
4. Мэдээллийн сан үүснэ. Телевиз болон видео, дуу, мультимедиа өгөгдөл, мэдээлэл ашиглаж хэлцэл хийх санал тавьсан байна.
5. Хил хязгаар үл харгалзан, бүрдүүлж болох орон зай, хий-цахим орчин байдаг.
6. 3 дагч этгээдийн систем, үйлчилгээгээр дамжин хэрэгжинэ. Шууд хийгдэхгүй бусдын үйлчилгээгээр дамжина. Нотлох баримтаар ашиглаж болно. /төлбөрийн карт, Төрийн үйлчилгээний машин гэх мэт.
7. Хиймэл оюун ухаан буюу программ өгөгдөл ашиглагдан. 1 талын хэлцэл байж болно-автомат машин. Киоск гэх мэт
8. Аюулгүй байдал хамгаалагдах, урьдчилан сэргийлэх боломжтой-нэвтрэх, гүйлгээ хийх зэрэгт нууц үг, код шаардагдана. -өөрчлөх засварлах, сэргээх гэх мэт

Давуу ба сул тал

Цахимаар гэрээ хэлцлийг хийснээр хил хязгаарт захирагдахгүйгээр зайнаас гэрээ, хэлцэл хийх, тээвэрлэх, түгээх, хүргэх боломж бүрдсэн. Цаг хугацаа хэмнэнэ, хурдан шуурхай, хялбар, тогтсон-найдвартай харилцааг үүснэ, хүмүүс бие биедээ итгэх итгэлийг нэмэгдүүлнэ, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу техник хэрэгслээр шууд хуулбарлан буулгасан гарын үсэг, кодыг түүний эхтэй адилтган үзэх, тодорхой ойлгомжтой бөгөөд олон улсын болон дотоодын орон зайнаас шалтгаалж томоохон хэлцэл хийхэд онгоц, зочид буудлын зардал, зарцуулах цаг хугацаа зэрэг олон хүчин зүйлсээс хамааралтай байсан бол зардал багасах, бэхжүүлэх, баталгаажуулах зэргээр эдийн засгийн ач холбогдолтой.

Иймээс санал болгож буй эрх зүйн харилцаанд оролцох, хэлцэл хийхдээ санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгааны доорх бусдын бичсэн сэтгэгдэл /коммент/-ийг уншиж танилцах замаар дүн шинжилгээ хийж, хэлцлийг хийх эсэхээ шийдвэрлэх, найдвартай харилцагч мөн эсэх, олон улсын зөвшөөрөгдсөн одтой бүтээгдэхүүн үйлчилгээ эсэх аргыг ашиглах, түүний бизнесийн нэр хүнд, туршлага, олонд танигдсан байдлыг судласны үндсэн дээр саналыг хүлээн авах, хүсэл зоригийн илэрхийлэл нэгдэх, баталгаажуулах зэргээр цахим хэлцэл хийх боломжтой.

¹² <http://www.angar.mn/c/440> [сүүлд үзсэн: 2020.01.25]

Хэлцлийн талууд ихэвчлэн биенээ танихгүй, нөгөө талдаа итгэх, бүрэн итгэл найдвар төрөхгүй, залилан мэхлүүлэх, хүссэн зүйлээс өөр хэлбэр, хэмжээтэй байх боломжтой буюу төсөөллөөс нь эсрэг байх, хууртах тохиолдол байна. Мөн хэлцэл хийгч талуудын хүсэл зоригийн илэрхийлэл бүрэн нэгдэх боломж хомс, сэтгэл ханамж өөрчлөгдөх, андуурагдах зэрэг сөрөг талтай.

Тулгамдсан асуудал

Монгол улс дахь интернет-сошиал, цахим орчинд хэрэглэгчдийн тоо, хэрэгцээ шаардлага маш их хэмжээгээр өссөн, энэ нь хэрэглэгчийн тоо судалгаа /ФБ-д 3 сая орчим ... гэх мэт/-гаар харуулах боломжтой. Цахим орчинд цахим эрүүгийн эрх зүй үйлдэл үйлдэгдээд багагүй хугацаа өнгөрч байгаагийн 1-н адил Иргэний эрх зүйн зохих үйлдэл, эрх зүйн харилцаанд оролцогчид бий болсон, тэр дундаа үүгээр ажил, хөдөлмөр эрхэлж орлого олох зэргээр цахим хэлцэл хийж буй Монгол Улсын иргэд байна. Энэ нь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Цахим хэлцлийн талаарх ойлголт, тодорхойлолтгүй. Тодруулбал, иргэд бид дэлгүүр, лангуун дээрээс эд юмс, эрхийг худалдаа хэлцлийн үндсэн дээр өөрт болон бусдад олж авдаг байсан бол өдгөө хилийн чанадаас захиалгаар буюу хэлцлийн үндсэн дээр аливаа эрх, эд хөрөнгийг олж авч байгаа нь Олон улсын төдийгүй, үндэсний эрх зүйн зохицуулалтад үзүүлэх нөлөө нь дээшилж, харилцан хамаарах зүй тогтолтой болохыг харуулж байна.

Эрх зүйн зохицуулалт дутмаг, хангалтгүй. /ИХ-42/ Тухайлбал, Цахим гарын үсгийг томоохон аж ахуйн нэгж хэрэглээд эхэлсэн ба ихэвчлэн тендер сонгон шалгаруулалтад оролцоход хэрэглэж байна. Үүнийг задлаад үзвэл сонгон шалгаруулалт зарлахдаа ИХ-д зааснаар цахим гарын үсэг зурж илгээгээгүй, нийтэд санал болгож цахимаар зарласан, үүний дараа оролцогч талууд баримт материалаа илгээж эцэст нь цахим гарын үсэг зурж хүргүүлдэг байна. Энэ нь дээрх хуулийн зохицуулалттай нийцэхгүй байна.

Нийцүүлэхийн тулд эхлэл нь бас л цахим гарын үсэг зурж санал тавих байсан уу? Үүний дараа цахим гарын үсэг зурж хүргүүлж буюу сонгон шалгаруулалтад оролцох байсан уу? Цахим хэлцлийг зөвхөн цахим гарын үсгээр зохицуулах нь учир дутагдалтай бөгөөд бусад технологийн аргуудыг ашиглах нөхцөлийг эрх зүйн зохицуулалтад тусгах нь зүйтэй санагдана. Энэ нь БАР КОД, зураасан код, сошиал пей ашиглах, QR код үүсгэх, унших зэргээр хүсэл зоригоо илэрхийлэх, санал гаргах, санал нэгдэх, баталгаажуулах гэсэн зохицуулалтуудыг ашиглах боломжтой.

Маргаан хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал тодорхойгүй. Улс орон бүрт тухайн иргэний эрх зүйн харилцааны зохицуулалтын агуулга өөр өөр байна. /Гадаад болон дотоод-аль шүүх шийдвэрлэх вэ?/ одоогоос эрх зүйн маргаан, асуудал гарсаар байна. Тодорхойгүй гэдэг нь ихэнх цахим хэлцэлд оролцож буй талууд эхлээд эрх зүйн зохицуулалтад нийцүүлэх бус хэлцэл оролцохоо урьтал болгож байгаа харагдана. Эцэст нь энэ нөхцөл байдал үүссээр байна.

Иймээс энэхүү өгүүллээр Иргэний хуульд тусгагдсан цахим хэлцлийн талаарх ойлголт, онцлог, тулгамдсан асуудал, харилцаанд оролцож буй этгээдүүдийн өнөөгийн нөхцөл байдал, боломж, хэлцлийг хэрэглэгчийн цахим орчин ашиглаж хийж буй хэрэгцээ, үйлдэл, хариуцлага, түүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хөндөж авч үзсэн болно.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Аливаа хуулиуд ... гэрээ хэлцэл, итгэмжлэлд бичгээр болон тоон гарын үсэг зурснаар хүчинтэй, хүчин төгөлдөр гэж тооцохоор эрх зүйн зохицуулалтаар шаарддаг бол орчин үеийн хувийн эрх зүйн харилцаа, тэр дундаа хэлцлийг цахим хэлбэрээр хийхдээ мэдээллийн харилцаа, холбооны технологи, сүлжээ, техникийн зохицуулалтыг хослуулан ашиглах боломжтой болсон тул уламжлалт эрх зүйн чиг хандлагаа өөрчлөх.

Тухайлбал, нүүрний хэв загвараар таних, гарын хурууны хээ ашиглах, карт уншуулах, шилжүүлэх, тоон өгөгдөл ашиглах, хурууны хээгээр таниулах, бар код, зураасан код, QR код зэргээр санал гаргах, баталгаажуулах хүсэл зоригийн илэрхийлэл нэгдэх боломжтой болсон тул энэ талаар эрх зүйн зохицуулалт оруулах.

- Цахим хэлцлийн ойлголт, тодорхойлолтын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, эрх зүйн маргаан гарахаас урьдчилан сэргийлсэн зохицуулалт, ойлголтыг харилцаанд оролцогчдын ухамсарт өгөх, маргаан гарсан нөхцөлд шүүхийн харьяаллыг хэрхэн тодорхойлох талаар эрх зүйн анхан шатны зохицуулалтыг оруулах саналтай байна.

Дэлхийд цахим хэрэглэгчдийн тоо 1994 онд ердөө 4.000.000 байсан бол 2020 оны байдлаар 4.9 тэрбум болсон байна. Энэ нь дэлхийн хүн амын 63,2 хувийг эзлэх аж. Үүнд: Монгол улс ч мөн багтаж өөрийн гэсэн практикийг бий болгосон. Тухайн сүлжээг анх дэлгэрэх хамгийн их нөлөөлсөн зүйл бол дэлхийн улс орнуудын бизнесийн үйл ажиллагаандаа цахим сүлжээг ашиглаж эхэлснээр цахим сүлжээ маш хурдацтай, өргөн тархацтайгаар хөгжиж ирсэн байна.

Үсрэнгүй буюу асар хурдтай тархаж байгаа шинжлэх ухаан, техник технологи, интернет, цахим хэрэглээ харилцааг ашиглаж хүн төрөлхтөн гэрээ, хэлцлийг байгуулж, эрх зүйн харилцаанд орж эрх үүргийг хэрэгжүүлж байна. Энэ аргаар асар олон, төрөл бүрийн хувийн эрх зүйн гэрээ хэлцэлүүд цахимаар хийгдэх болжээ.

Иргэний хуульд 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар 42¹ дүгээр зүйл буюу Цахим хэлбэрээр хийх хэлцэл гэж нэр томьёо, анхлан энэ хуульд орсон хэдий ч энэ зохицуулалт амьдралд нийцэхгүй, хэрэгжихгүй, тодорхойгүй, тунхаг шинжтэй зохицуулалт болсон байх тул үүнийг цогц байдлаар өнөөгийн эрх зүйн харилцаанд нийцүүлэх, уялдуулах, судлах шаардлагатай. Иймд ... “хуульд зааснаар бүртгүүлэх” гэх зохицуулалтыг дэлгэрүүлэх-ямар ямар хэлцлийг бүртгүүлэхээр зохицуулсанг нэг бүрчлэн тодорхойлж бичихээр нэмж тусгах, түүнчлэн “... цахим баримт бичиг үйлдэж цахим гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал хүлээн зөвшөөрч цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.” гэж хязгаарлах бус “... технологи ашиглаж баталгаажуулж болно” гэж нэмж зохицуулах нь зүйтэй.

Мөн хувийн эрх зүйд нэгэн шинэ ойлголт, тодорхойлолтыг гаргаж ирэх хэрэгтэй. Энэ нь цахим хэлцлийн ойлголт, онол, практик, тусгайлан зохицуулсан хууль тогтоомжийг судалж, эрх зүйн шинэ ойлголт, тодорхойлолтыг бий болгох замаар хэлцлийн хэлбэрийг нэмж илрүүлэхийг судлаачийн зүгээс санал дэвшүүлж байна.

Энэ сэдвийн агуулгыг нэгтгэн дүгнэвэл, Цахим хэлцэл гэдэгт цахим хурд, орчин, сүлжээ, мэдээллийн сан, техникийн ололт, шийдлийг ашиглан тэнд буй мэдээлэл, санал, үйл ажиллагаанд үндэслэн цаг хугацаа, газарзүйн байршил, орон зайнаас үл хамааран сонсох, харах, унших, солилцох, баталгаажуулах замаар иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгож, тодорхойлж болох юм.

ИХ-ийн 42¹-р зөвхөн тоон гарын үсэг зурах бус гэрээний талуудын хүсэл зоригийг нэн түрүүнд харгалзаж тайлбарлах, техник технологийн тал бүрийн боломж, аргуудыг ашиглан эхний удаад Монголын эрх зүйн зохицуулалтад ерөнхийгөөс нарийвчлах буюу эхлээд ерөнхий зохицуулалтыг оруулж, улмаар нарийвчлан зохицуулалт буюу тусгайлан баталгаажуулах техникийн зохицуулалтыг судлаж, эрх зүйн зохицуулалттай уялдуулах аргыг ашиглах нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Иргэний хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2002 он, №7

Монгол хэлээр:

- Л.Очирбат, *Интернет ба эрх зүй*, УБ, 2009 он
- Т.Сэнгэдорж, *Хууль зүйн шинжлэх ухаан*, УБ, 2006.
- Л.Очирбат, *Интернет ба эрх зүй*, УБ, 2009 он.
- Б.Болортогос нар, *Хууль зүйн нэр томъёоны тайлбар толь*, УБ, 2012 он.
- Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн тусгай анги, Дөрөвдүгээр хэвлэл*, УБ, 2015 он.
- Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн удиртгал, хоёрдахь хэвлэл*, УБ, 2014 он.

Гадаад хэлээр:

- М.М.Карелина “Интернет ба эрх зүй” сэтгүүл, Москва, 2017 он.

Цахим эх сурвалж:

- <https://ikon.mn/n/1jed>.
- www.internetworldstats.com.

ORIGIN OF ELECTRONIC NETWORKS AND ELECTRONIC CONTRACT

V.Amartuvshin

Judge of the Civil Court of First Instance of Songinokhairkhan District

ABSTRACT:

Before studying e-transactions and legal regulations, it is necessary to understand the origin, development and regularity of the technology required to use them, how to apply these regulations in civil law and application, and many types of transactions and actions of electronic law in real life. The methodology of coordination is being studied. Although the legal regulation of e-transactions in the Civil Code of Mongolia is very narrow and there are no disputes resolved in practice, there are still e-transactions in practice, and there are not enough legal regulations to interpret and apply them.

KEYWORDS:

Prerequisites for Electronic Contracting, E-Transaction.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГЫН ЗАРЧИМ, ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ



Б.Билгүүн
Өмгөөлөгч

ТОВЧЛОЛ:

Хязгаарлагдмал хариуцлага нь хувьцаа эзэмшигчийг компанийн өр төлбөр, санхүүгийн алдагдалд хувийн хариуцлага хүлээхээс урьдчилан сэргийлсэн хууль, эрх зүйн хамгаалалтын зарчим бөгөөд ерөнхий утгаар тухайн компанид оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр хувьцаа эзэмшигчийн хариуцлага хязгаарлагдана гэсэн утгатай юм. Харин хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг үгүйсгэх зарчим нь шүүхээс хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг хойш тавьж, компанийн хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа эсвэл өр төлбөрт биечлэн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг хэлнэ.

Монгол Улсын хувьд компанийн эрх зүйдээ хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг хүлээн зөвшөөрч шинэчлэн найруулсан Компанийн тухай хууль (2011)-ийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт, тус зарчмыг үгүйсгэх зохицуулалтыг хуулийн 9.4 болон 9.5 дахь хэсэгт тус тус хуульчлан тогтоосон байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Компани, хувьцаа эзэмшигч, хязгаарлагдмал хариуцлага, эд хөрөнгө, өр төлбөр

НЭГ. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ҮНДЭСЛЭЛ, АГУУЛГА, ХЭЛБЭР:

Аливаа бизнес нь хуулийн этгээд хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар болж албан ёсоор бүртгүүлэхэд өмчлөгчөөсөө болон түүний санхүү, эд хөрөнгөөс бүрэн тусгаарлагдаж өөрийн нэрээр эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай болдог. Энэхүү чадвар нь тухайн хуулийн этгээд өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй байж уг хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж, бусдын өмнө үүрэг хүлээх агуулгыг илэрхийлнэ.

Хуулийн этгээдийн гол хэлбэр болох компанийн хувьд мөн өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээд юм.

Компанийг бүрдүүлж, түүнийг хөдөлгөгч нь хүн буюу тус талбар дээр тоглогч сонирхлын хамаарал бүхий этгээдүүд (stakeholder) байдаг. Тэдгээрийг компанитай ашиг сонирхол нэгдсэн этгээдүүд гэж нэрлэх ба эдгээр нь тус бүрдээ өөр өөрийн гэсэн эдийн засгийн сонирхлыг тээж, өөрийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн төлөө ажилладаг¹.

Энэ ч утгаар эрдэмтэн, судлаачид компанийг түүнийг тойрсон сонирхлын хамаарал бүхий этгээдүүд (stakeholder) тус бүрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд бий

¹ Очи-Ай Сэйчи, *Компанийн эрх зүйн үндсэн ойлголт*, орч. Р.Пүрэвбаатар нар, УБ, 2017, 62 дахь тал

болгосон талбар, хэлцлийн төлөөх нэгдэл, олон тооны хэлцлийг зохион байгуулах буюу зохицуулах үүрэгтэй, тэр хэлцлийг хийх “платформ” хэмээн тайлбарладаг².

Иймд компани нь хуулийн этгээдийн эрхтэй гэдэг ойлголт нь түүнийг өмчлөгч буюу хувьцаа эзэмшигчээсээ тусдаа, бие даасан эрх зүйн субъектэд тооцож, түүний оролцох аливаа эрх зүйн харилцааг тодорхой болгож буй болохоос биш сонирхлын хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхлоос тусдаа, бие даасан тухайн компанийн өөрийн нь ашиг сонирхол гэж үгүй³.

Компанийн сонирхлын хамаарал бүхий этгээдүүд дундаас компанийн эсрэг тодорхой шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжтой үүрэг гүйцэтгүүлэгч этгээдүүд байдаг. Тус үүрэг гүйцэтгүүлэгч этгээдэд нэн тэргүүнд компанитай тодорхой төрлийн гэрээний харилцаанд орсон этгээдүүд хамаарна. Тухайлбал, компанитай бизнесийн түншийн харилцаатай этгээдүүд болох компанид зээл олгосон зээлдэгч, хөрөнгө оруулагч, төслийн хүрээнд хамтран ажиллагч, хөрөнгө ашиглуулагч, компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан захиалагч, худалдах, худалдан авах гэрээ байгуулсан худалдагч эсхүл худалдан авагч зэрэг хэн ч байж болно. Мөн хуульд зааснаар үүсэх үүргийн дагуу буюу компанийн гэм буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас гэм хор учирсан этгээд зэрэг хамаарна. Товчхондоо, компанийн эсрэг шаардлага гаргах боломжтой, компанитай ашиг сонирхлын хувьд холбогдсон этгээдийг компанийн үүрэг гүйцэтгүүлэгчид хамааруулна.

Иймээс үүрэг гүйцэтгүүлэгч нь компанитай эрх зүйн харилцаанд орсон тул компанийн эсрэг шаардлага гаргах боломжтой боловч компанийн хувьцаа эзэмшигч рүү тусгайлан шаардлага гаргах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, компанийн хөрөнгө оруулагч болох хувьцаа эзэмшигч нь компанийн үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд үүрэг гүйцэтгэгч нь компани болох тул түүний өмнө шууд хариуцлага хүлээхгүй. Монгол Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимд хянан хэлэлцэгдсэн 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 00382 дугаар тогтоолд “...Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3-т зааснаар Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй, Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээдэг тул хувьцаа эзэмшигч нар нэхэмжлэлийг хариуцахгүй болно” гэж дүгнэсэн практиктай.

Компанийн хариуцлага хүлээх хязгаар нь тус компанийн тайлан тэнцэлд тодорхой тусгагдсан, компанийн өмчлөл эсхүл эзэмшилд байх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр тодорхойлогдох⁴ бөгөөд компани тухайн бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ. Харин компани үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахад түүний хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хариуцлага энэ мөчөөс яригдаж эхэлнэ.

Гэхдээ үүний өмнө компани нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүргийг хүлээн зөвшөөрсөн, улмаар гүйцэтгэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хариуцлага хөндөгдөхгүй бөгөөд аливаа маргаан үүсэхгүй. Харин компани өр төлбөрийн хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй, улмаар гүйцэтгэхгүй байх тохиолдолд компанийн үүрэг гүйцэтгүүлэгчийн зүгээс компанийн өр төлбөрийг шүүхийн шийдвэрээр баталгаажуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд компаниас өр төлбөр барагдуулах ажиллагааг гүйцэтгэнэ.

Иймд хувьцаа эзэмшигчийн хариуцлага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатанд компанийн хөрөнгө түүний өр төлбөрийг төлж хүрэлцэхгүй байх тохиолдолд хэрэгжих юм.

Компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага гэдэг нь компанийн өр төлбөрийн хувьд түүний санхүүгийн хариуцлага хүлээх хэр хэмжээг илэрхийлж буй ойлголт юм. Хувьцаа эзэмшигчийн хариуцлагын дараах хэлбэрүүд байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчийн бүрэн хариуцлага: Уг хариуцлагын хэлбэр нь компани өөрийн хөрөнгөөр үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд компанийн өр төлбөрт хувьцаа эзэмшигч шууд байдлаар компанийн үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө компанид

² Мерлин Арон Эйзенберг “Компани гэдэг бол бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх мөн хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаанд зориулж капиталыг цуглуулан нэгтгэх арга хэрэгсэл юм”, П.Баясан, Компанийн засаглалыг нэвтрүүлсэн олон улсын туршлагауд, УБ, 2006, 18.

³ Мөн тэнд,

⁴ Б.Амарсанаа нар, *Хувьцаа эзэмшигчийн эрх*, гарын авлага (2 дахь хэвлэл), УБ, 2017, 16 дахь тал

оруулсан хөрөнгөөс гадна давхар хувийн хөрөнгөөр бүрэн хариуцлага хүлээх хэлбэр юм. Тус хариуцлагын хэлбэр нь хувьцаат компанийн эрх зүйн зохицуулалтын эхэн үед хэрэгжиж байсан боловч орчин үеийн компанийн эрх зүйд төдийлөн ач холбогдолгүй юм. Учир нь бүрэн хариуцлагын эдийн засгийн үр ашиг нь хязгаарлагдмал хариуцлагын үр ашигтай харьцуулахад харьцангуй бага байдаг. Ийнхүү, бүрэн хариуцлага нь хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хэлбэрийн хүрээнд төдийлөн түгээмэл бус байх бөгөөд онолын хувьд ч нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдөөгүй байна⁵.

Бүрэн хариуцлагын хэлбэр нь хувиараа бизнес эрхлэгч буюу бизнесийнхээ ашиг, алдагдлыг аль алиныг нь өөрөө хариуцдаг хэлбэр, хуулийн этгээдийн эрх зүйн чадвар агуулагдаггүй хамтран ажиллах гэрээний хэлбэр болон төрөөс тусгайлан хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг сонгох сонголтыг хязгаарласан бүрэн хариуцлага хүлээлгэсэн тусгай мэргэжлийн үйл ажиллагаа бүхий хуулийн этгээдийн хэлбэр зэрэг хамаарна.

2. Хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлага: Уг хариуцлагын хэлбэр нь компанийн өр төлбөрт хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөөс гадна өөрийн эзэмшлийн хувьцааны тоонд хувь тэнцүүлэн өөрийн хувийн хөрөнгөөр давхар хариуцлага хүлээх хэлбэр юм. Хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлага нь компанийн эрх зүйн зохицуулалтын хөгжлийн явцад тодорхой хүрээнд хэрэгжиж байсан хариуцлагын хэлбэр юм. Тухайлбал, 1849-1931 оны хооронд Америкийн Калифорни мужид үйл ажиллагаа явуулж байсан компанийн хувьцаа эзэмшигчид хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээж байжээ⁶.

3. Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага: Хязгаарлагдмал хариуцлага бол компанийн эрх зүйн үндсэн зарчим юм⁷. Компани үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлийг зөвхөн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх бөгөөд хувьцаа эзэмшигч нь компанийн өр төлбөрт компанид оруулсан хөрөнгийн хэмжээнээс давсан хариуцлагыг хүлээхгүй буюу оруулсан хөрөнгийн хэмжээгээр түүний хариуцлага хязгаарлагдаж байдаг.

Хязгаарлагдмал хариуцлага бол бизнест хөрөнгө оруулсан этгээдийн тухайн бизнес нь бүтэлгүйтсэн тохиолдолд өөрийн хувийн эд хөрөнгийг эрсдэлд оруулахгүй байхад итгэлтэй байх арга зам юм⁸. Иймээс хувьцаа эзэмшигчийн хамгийн их эрсдэл хүлээх хэмжээ бол түүний компанид оруулсан хөрөнгө буюу эзэмшиж буй хувьцаа юм.

Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчим хүлээн зөвшөөрөгдөхөд хэд хэдэн шалтгаан нөлөөлсөн гэж үздэг. Тухайлбал, хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага үйлчлэх тохиолдолд хөрөнгө оруулагчийн хүлээх хамгийн өндөр эрсдэл нь түүний оруулсан хөрөнгийн хэмжээнээс хэтрэхгүй тул хөрөнгө оруулах хүсэл эрмэлзэл илүү өндөр байдаг тул бизнесийн эрсдэлийг бууруулах нэгэн том хүчин зүйл болдог⁹. Хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг хязгаарлагдмал байлгах аар зохицуулснаар олон тооны хувьцаа эзэмшигчээс хөрөнгө оруулалт татах боломж төдий чинээ ихэсдэг тул эдийн засгийн ихээхэн үр нөлөөтэй гэж үздэг байна¹⁰.

Нөгөөтээгүүр, хувьцаа эзэмшигчийн бүрэн эсхүл хувь тэнцүүлсэн хариуцлага үйлчлэх тохиолдолд эрсдэл төдий чинээ өсөх тул хувьцаа эзэмшигч нь компанийн удирдан зохион байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэр гаргалт бүрт идэвхтэй оролцох, хяналт тавих сонирхол өсөх хирээр бизнесийн үйл ажиллагаа удаашрах нөхцөл үүсдэг.

Харин хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчим үйлчлэх тохиолдолд энэ нь шаардлагагүй болох тул өмчлөх ба удирдан хянах эрх тусгаарлагдсан нээлттэй шинж бүхий компанийн хувьд (хувьцаат компани) илүү тохиромжтой эрсдэлийн хуваарилалтын зохицуулалт болно¹¹.

⁵ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд (хувийн эрх зүйн цуврал), УБ, 2020, 2 дахь тал

⁶ Мөн тэнд

⁷ Frank H. Easterbrook, Daniel R.Fischel, Limited liability and the Corporation, 1

⁸ Paddy Ireland, *Limited Liability, Shareholder rights and the Problem of Corporate irresponsibility*, Cambridge Journal of Economics, Sep 2016. 9.

⁹ https://www.law.cornell.edu/wex/piercing_the_corporate_veil

¹⁰ Очи-Ай Сэйчи, Компанийн эрх зүйн үндсэн ойлголт, орч. Р.Пүрэвбаатар нар, УБ, 2017, 132 дахь тал

¹¹ Мөн тэнд.

Дээрх хүчин зүйлсийн үр дүнд хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага хүлээн зөвшөөрөгдөж, зарчим болон хэвшин тогтсон байдаг.

Компанийн хувьд хязгаарлагдмал хариуцлага үйлчлэх тул үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ, гэдэг асуудал урган гарна. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгч үүргийн зөрчил гаргах эрсдэлийг үнэлж, үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийн байдлыг шалгах, урьдчилан сэргийлэх боломжтой нөхцөлөөр гэрээгээ байгуулсан тохиолдолд гэрээгээр дамжуулан өөрийн эрх ашгийг хамгаалах боломж бүрдэнэ. Хаалттай шинж бүхий компанийн хувьд их хэмжээний хувьцаа эзэмшигч байх тохиолдол олон тул үүрэг гүйцэтгүүлэгч хувьцаа эзэмшигчтэй үүргийн гүйцэтгэлийг хангах тухай гэрээ байгуулах боломжтой.

Тиймээс үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд гэрээний тохиролцоогоор дамжуулан өөрийн эрх ашгийг хамгаалах боломжтой учраас эрх зүйн зохицуулалтын хүрээнд гэрээнээс бусад тусгай эрх зүйн хамгаалалтын механизм шаардлагагүй байж болно. Харин гэм хор учруулснаас үүсэх үүргийн үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд урьдчилан тооцоолж болох эрсдэлээс хамгаалах гэрээний нөхцөлийг тохирох боломжгүй байдгийг анхаарах шаардлагатай юм.

ХОЁР. ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГЫН ЗАРЧМЫГ ҮГҮЙСГЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ:

Хуулийн этгээд нь өмчлөгчөөсөө болон түүний санхүү, эд хөрөнгөөс бүрэн тусгаарлагдаж албан ёсоор бүртгүүлэхэд хуулийн этгээдийн эрх зүйн чадвартай болж өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж, бусдын өмнө үүрэг хүлээдэг тухай өмнөх хэсэгт авч үзсэн билээ.

Тэгвэл хуулийн этгээдийн дээрх эрх зүйн чадвар, цаашилбал хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг зүй бусаар эсхүл урвуулан ашиглаж өөрийн хариуцлагаас үндэслэлгүйгээр зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчид бүрэн хариуцлага ногдуулах тухай ойлголтыг хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг үгүйсгэх зарчим, хязгаарлагдмал хариуцлагын зарчмын хугарал, “Piercing the corporate veil” гэх зэргээр нэрлэдэг.

Энэ тохиолдолд компанийн үүрэг гүйцэтгүүлэгч нь хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмаас үүдэн бий болох эрсдэлийн хуваарилалтыг эсэргүүцэж хувьцаа эзэмшигчийн хувийн хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлээ хангахтай холбоотой харилцаанд хэрэглэгддэг¹². Энэхүү ойлголт нь олон улсад шүүхийн шийдвэрээр нэгэнт хүлээн зөвшөөрч, хэрэглэж тогтсон ойлголт байна.

Шүүхээс хуульчлан тогтоосон хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг хувьцаа эзэмшигч ноцтой зөрчил гаргасан тухайн эрх зүйн харилцааны хувьд үгүйсгэж бүрэн хариуцлага хүлээлгэж байна. Тухайлбал, компанийг хариуцлагаас мултрах зорилгоор хуурамчаар бий болгосон, хувийн болон компанийн хөрөнгийг холилдуулсан, хөрөнгө оруулалтыг дутуу оруулсан, үүргийн гүйцэтгэлийг хангахад компанийн хөрөнгө хүрэлцэхгүйг мэдсээр байж хуурамчаар гэрээ хэлцэл хийсэн, хөрөнгийн бүртгэл хөтлөхгүй байх, компанийн хөрөнгийг үндэслэлгүйгээр хувийн хөрөнгөнд шилжүүлэх зэрэг тохиолдлыг¹³ дурдсан байдаг.

Дээрх хэсэгт дурдсан тохиолдлуудаас нэн тэргүүнд хувийн болон компанийн хөрөнгийг зааглах, хөрөнгө оруулалтыг гүйцэд оруулах зэргийг авч үзвэл:

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт тодорхойлсноор “хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг хэлнэ. Үүнээс үзэхэд тухайлбал, компанийн хувьд тухайн компанийн хувьцааг биет эсхүл биет бус хөрөнгөөр худалдан авч, үүнийг санхүүгийн тайланд тусгасныг хөрөнгө оруулалт гэж тайлбарлахаар байна. Иймд хөрөнгө оруулагчийн шилжүүлэн авсан хувьцаа нь зөвхөн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн

¹² Очин-Ай Сэйчи, *Компанийн эрх зүйн үндсэн ойлголт*, орч. Р.Пүрэвбаатар нар, УБ, 2017, 136 дахь тал

¹³ Erjola Aliaj, PhD Candidate, the principle of shareholders' limited liability and its exception in Albanian company law, *European scientific journal*, 2014, 162

өмчлөлд оролцох эрхийг нотлох болохоос биш компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигч нь компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөхгүй бөгөөд хувь нийлүүлсэн эд хөрөнгийг зөвхөн компани өмчилнө¹⁴.

Тэгвэл хөрөнгө оруулагч болох компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд компанид оруулсан хөрөнгөө өөрийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс салгаж компанид шилжүүлснээр хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын дагуу зөвхөн өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх хүрээ, хязгаар тодорхой болгодог.

ГУРАВ. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГА МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУССАН БАЙДАЛ:

Монгол Улсын хувьд бизнес эрхлэх хэлбэрийг хуулийн төвшинд зохицуулсан баримт бичиг 1987 онд анх батлагдсанаар энэ талаарх эрх зүйн зохицуулалтын орчин үүсэн бөгөөд 1991 оноос Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үед төрийн өмчит улсын үйлдвэр, аж ахуйн нэгжийг өмч хувьчлалаар хувьчлан, 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаар хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, хөрөнгийн зах зээл үүссэн гэж үздэг. Улмаар хувийн өмчит компанид бий болсноор Компанийн эрх зүйн суурь тавигдсан гэж үзэж болно¹⁵.

1991 оны Монгол Улсын Аж ахуйн нэгжийн тухай хуулиар анх компанийн хэлбэрийг зохицуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хэлбэрийг хуульчлан тогтоогоогүй. Мөн 1995 оны Нөхөрлөл, компанийн тухай хуулиар ч мөн уг ойлголт байгаагүй. Харин 1999 оны Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ” хэмээн зохицуулсан нь хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчим Монгол Улсын хууль тогтоомжид анх удаа тусжээ.

Улмаар шинэчлэн найруулсан 2011 оны Компанийн тухай хуулиар хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг хуульчлан тогтоосон буюу тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” хэмээн зохицуулсан нь 1999 оны Компанийн тухай хуулийн 9.3 дахь зохицуулалттай агуулгын хувьд ижил байдаг.

Уг хуулийн зохицуулалтын эхний хэсгийг авч үзвэл хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх аль ч хэлбэрийн үүргийг өөрийн хувийн эд хөрөнгөөр хариуцахгүй талаар зохицуулжээ. Компани бусад гуравдагч этгээдийн өмнө үүрэг хүлээх, ялангуяа эд хөрөнгө, мөнгөн төлбөрийн үүрэг хүлээх тохиолдолд компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр тухайн үүргийг хариуцна.

Нөгөөтээгүүр, компаниар эрх зүйн харилцаанд орсон аливаа гуравдагч этгээд буюу үүрэг гүйцэтгүүлэгч компаниас гадна хувьцаа эзэмшигчид нь холбогдуулж аливаа шаардлага гаргах эрхгүй хэмээн ойлгогдоно. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх яригдахгүй.

Дээрх хуулийн зохицуулалтын хоёр дахь хэсгийг авч үзвэл хувьцаа эзэмшигч ямар хэмжээнд хариуцлага хүлээх талаар зохицуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчийн нэгэнт компанид оруулсан хөрөнгийн хэмжээ буюу эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр түүний хариуцлага хязгаарлагдана. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөөс бусад өөрийн хувийн ямар ч хөрөнгөөр аливаа хариуцлага хүлээхгүй.

Дээрх агуулгаар Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт нь хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг хуульчилсан гэж үзэж болно.

Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу компани нь хуулийн этгээд болохынхоо хувьд өөрийн мэдэлд захиран зарцуулах тусгайлан хөрөнгөтэй, тэрхүү хөрөнгөөрөө хариуцлага хүлээх учиртай. Энэхүү шаардлагыг хангахын тулд Компанийн

¹⁴ М.Мөнхжаргал, Хувьцаа эзэмшигчийн эрхийн зохицуулалт (Дипломын ажил, МУИС-ХЗС, Иргэний эрх зүйн тэнхим), УБ, 2011, 13 дахь тал

¹⁵ О.Мөнхнасан, Монгол Улсын компанийн тухай хууль дахь хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах нь хариуулан судалгаа, 2019, 2 дахь тал.

тухай хуулийн 9.3-т хувьцаа эзэмшигчийн хүлээх хязгаарлагдмал хариуцлагыг хуульчлан тогтоожээ.

Харин Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” хэмээн заасан нь хуулийн этгээдийн эрх зүйн чадвар болон хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг үгүйсгэхэд чиглэсэн зохицуулалт байна¹⁶.

Уг заалтыг задалбал нэгдүгээрт, хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөө өөрийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тусдаа зааглаагүй байх хоёрдугаарт, уг шаардлага хангагдсан тохиолдолд хувьцаа эзэмшигч бүрэн хариуцлага хүлээхээр хуульчилсан байна. Иймд хувьцаа эзэмшигч компанид оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгөө өөрийн хувийн эд хөрөнгөөс тусгаарлан шилжүүлснээр Компанийн тухай хуулийн 9.3-т заасны дагуу зөвхөн хязгаарлагдмал хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын дээд шүүхийн “Компанийн тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 2007 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолын 14 дэх хэсэгт “Мөн зүйлийн 9.5-д заасан “компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэдэг нь компанид оруулсан хувь нийлүүлэгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь компанийн хөрөнгөнд бүртгэгдэн, тайлан тэнцэлд тусгагдаж, түүний хувийн эд хөрөнгөөс зааглагдсан байх ёстой боловч ийнхүү зааглаагүй тохиолдолд компанийн төлбөрийг барагдуулахад хувь нийлүүлэгчийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь компанийн өөрийн хөрөнгөнд тооцогдон түүгээр компанийн хүлээх хариуцлагыг нөхөн төлнө гэж ойлгоно” гэж тайлбарласан байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр “Компанийн тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” дүгнэлтэд “Иргэний хуулийн 25.1-т зааснаас үзвэл хуулийн этгээд нь тусгайлсан хөрөнгөтэй байх, Иргэний хуулийн 34.1-т компани нь өөрийн тусгайлсан хөрөнгөтэй байх ёстойг тус тус хуульчилсан нь ач холбогдлын хувьд тухайн хуулийн этгээд өөрийн хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг байх, хэн нэг этгээд хуулийн этгээдийн хөрөнгийг өөрийн хөрөнгө мэт дураараа ашиглаж, захиран зарцуулахгүй байх гэх зэрэг үр дагаврыг арилгах тул ингэж тусгайлан зааглаагүй тохиолдолд компанид гарах эрсдэлийг хуулийн шаардлагыг биелүүлээгүйн төлөө өөрийн эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээх хуулийн зохицуулалт нь үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн дүгнэлт хийсэн нь үндэслэлтэй гэж үзэж байна” гэж дүгнэсэн.

Монгол Улсын дээд шүүх болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг хувьцаа эзэмшигч хувь хүн компанид оруулсан хөрөнгөө зааглан тусгаарлах хуулийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд өөрийн бүхий л хөрөнгөөр буюу хувьцаа эзэмшигчийн бүрэн хариуцлага хүлээхээр зохицуулсан болохыг дэмжиж тайлбарласан байна.

Түүнчлэн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч...-ийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийг хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна” гэсэн заалт нь мөн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг үгүйсгэхэд чиглэсэн зохицуулалт боловч компанийн үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан хохирлыг бус компанид учирсан хохирлыг хэмээн томьёолсон тул компанийн үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага гаргах зохицуулалт биш юм.

Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд шинэчлэн найруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)-д хуулийн этгээдийн өр төлбөрийг барагдуулахад түүний өмч хөрөнгө нь хүрэлцэхгүй байх тохиолдолд Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсэгтэй хэрхэн холбогдож буйг авч үзвэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь Компанийн өр төлбөрийн хэмжээг тогтоож, гаргуулахаар шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байна.

¹⁶ Г.Давааням, *Хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хүрээнд шаардах эрхийн дарааллыг хойшлуулах онолыг хэрэглэх тухай*” Эрх зүй сэтгүүл №4 (2019), 4 дэх тал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэгт “Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ” хэмээн заасан.

Тодруулбал, Компанийн хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэхийг хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомж буюу Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлахаар ойлгогдож байна.

Иймд Монгол Улсын Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг зохицуулсан тул хувьцаа эзэмшигч компанийн өр төлбөрийг хариуцахгүй тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар компанийн хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа хийгдэхгүй юм. Харин хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т зохицуулсан хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг үгүйсгэх нөхцөл байдал байвал хувьцаа эзэмшигчид бүрэн хариуцлага ногдуулж болно.

ДӨРӨВ. ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төлбөр төлөгч хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэхдээ төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг болон 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн төлбөр төлөгч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн бэлэн мөнгө, бусад хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, төлбөр авагчид шилжүүлэх, хувьцаа эзэмшигчийн түүний банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, битүүмжлэх, дансны зарлагын гүйлгээг хаах, орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих, биет бус үнэт цаасыг битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэх тохиолдол байна. Тухайлбал,

Нэхэмжлэгч “Тавантолгой транс” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд холбогдох “...2016.05.04-ний өдрийн 140/02 тоот эд хөрөнгийг барьцаалан хураан авсан тогтоолыг хүчингүй болгуулах, тус тогтоолоор хураасан “Лексус 570” маркийн суудлын автомашиныг чөлөөлүүлэх тухай”¹⁷ нэхэмжлэлтэй хэрэгт Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас тайлбарлахдаа “Төлбөр төлөгч “Сейсфон” ХХК нь үйл ажиллагаа явуулдаггүй, эд хөрөнгөтэй нь тогтоогдоогүй тул Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу “Сейсфон” ХХК-ийн үүсгэн байгуулагч, 70 хувийн хувьцаа эзэмшигч “Тавантолгой транс” ХХК-ийн хөрөнгөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан... Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т зааснаар хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэж заасан учир “Тавантолгой транс” ХХК-аас “Сейсфон” ХХК-ийн төлөх төлбөрийн 70 хувийг гаргуулах нь хуульд нийцнэ гэж үзэж ажиллагаа явуулсан” гэж тайлбарладаг.

Иймд Компанийн тухай хуулийн 9.3 дахь зохицуулалтыг хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагын хүрээнд авч хэрэглэн төлбөр төлөгч компанийн хувьцаа эзэмшигчийн компанид эзэмшиж буй хувьцааны хэмжээнд өр төлбөрөөс хувь тэнцүүлж хариуцлага хүлээлгэх ажиллагааг зарим тохиолдолд явуулж байна.

Шүүхээс Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын хүрээнд авч хэрэглэн тайлбарладаг ч¹⁸, зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагын үүднээс тайлбарлаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн цөөнгүй тохиолдол байна. Тухайлбал,

¹⁷ https://shuukh.mn/single_case/3210?daterange=2016-08-17%20-%202016-08-17&id=2&court_cat=1&bb=1

¹⁸ Сүхбаатар дүүргийн шүүх, 2016.06.22, №00171, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүх, 2015.10.16, №6929, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүх, 2015.11.04, №7425, Улсын дээд шүүх, 2016.12.09, №001/ХТ2016/011373, Улсын дээд шүүх, 2018.04.17, №001/ХТ2018/00617.

№	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	Хэргийн агуулга	Шийдвэрийн агуулга
1	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013.02.27-ны өдрийн №513 дугаар шийдвэр	<p>Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2010.10.12-ны өдрийн 1989 дугаар шийдвэрээр “ОСАК дөл” ХХК-иас 16,967,950₮ гаргуулж, “Улаанбаатар дулааны сүлжээ” ХК-д олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас “ОСАК дөл” ХХК-ийн өр төлбөрийн хүрээнд тус компанийн 25%-ийн хувьцаа эзэмшигч өөрийн хувьцааны хэмжээнд оногдох 4,252,000₮ төгрөгийн төлсөн тул 40%-ийн хувьцаа эзэмшигч Г.Баяраа, 35%-ийн хувьцаа эзэмшигч Д.Алимаа нарыг төлбөр төлөгч хэмээн тодорхойлж, төлбөрийг хувь тэнцүүлэн оногдуулсантай холбогдуулан Г.Баяраа, Д.Алимаа нар төлбөр барагдуулах үйл ажиллагааг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргасан.</p>	<p>Хариуцагч байгууллага 2012.08.07 болон 2012.08.16-ны өдрүүдэд компанийн хувьцаа эзэмшигч Д.Алимаад төлбөрийн 5,938,782₮-ийг төлөх мэдэгдэл өгсөн буюу компанийн хувьцаа эзэмшигч нараас эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр төлбөр төлөхийг мэдэгдсэн ажиллагааг Компанийн тухай хуулийн 9.3-т заасныг зөрчсөн гэж үзэхгүй гээд “ОСАК дөл” ХХК-ийн өр төлбөрийг 40%-ийн хувьцаа эзэмшигч Г.Баяраа, 35%-ийн хувьцаа эзэмшигч Д.Алимаа нараар тэдгээрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хувь тэнцүүлэн гаргуулахаар шийдвэрлэсэн.</p>
2	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015.09.17-ны өдрийн №6228 дугаар шийдвэр	<p>Шүүхийн шийдвэрийн дагуу “Беринг” ХХК-иас 210,776,965₮ гаргуулж “Нутгийн зам групп” ХХК-нд олгохоор шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигч Л.Болормаагийн үл хөдлөх эд хөрөнгө нь барьцааны бүртгэлтэй. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас “Беринг” ХХК-ийн өр төлбөрийг түүний хувьцааны 49%-ийг эзэмшигч “Волтам” ХХК-нар төлүүлэхээр тус компанийн банкин дахь харилцах данснуудын зарлагын хөдөлгөөнийг зогсоосонтой холбогдуулан төлбөр барагдуулах ажиллагааг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p>	<p>“Волтам” ХХК-ийн эзэмшлийн 49%-ийн хувьцаа нь тус компанийн дүрэмд зааснаар 1 бүрийн үнэ 10 төгрөг, 13,290,025 ширхэг байх бөгөөд энэ нь 132,900,250₮-ийн үнэтэй болно. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2015.05.14-ний өдрийн 2/17657 тоот албан бичгээр “Волтам” ХХК-ийн харилцах дансны зарлагын хөдөлгөөнийг 103,280,713₮-ийн хэмжээнд зогсоосон нь 132,900,250₮-с илүү гараагүй байна. Улмаар Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсгийг үндэслэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, хувьцаа эзэмшигч “Волтам” ХХК-д хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээлгэсэн.</p>

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Компанийн тухай хуулийн 9.5 дахь зохицуулалтыг хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь түүний хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй гэж үзэж хувьцаа эзэмшигчид бүрэн хариуцлага ногдуулах замаар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах арга хэмжээг авах тохиолдол байна.

Ингэхдээ хуулийн этгээдийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын гэрээг шалгадаг боловч манай улсын хувьд хаалттай шинж бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэр давамгайлдаг, хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгийн байдал тодорхой байдаггүйгээс тус газраас хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь түүний хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдсан эсэхийг тогтооход хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байна.

№	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	Хэргийн агуулга	Шийдвэрийн агуулга
1	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2014.06.23-ны өдрийн №2489 дугаар шийдвэр ¹⁹	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь “Туудоор” ХХК-ийн өр төлбөрийг төлүүлэх хүрээнд 100%-ийн хувьцаа эзэмшигч Д.Энхжаргалын орон сууцыг битүүмжилж, захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн.	Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нэг этгээдэд хүлээлгэсэн эд хөрөнгийн хариуцлагыг нөгөө этгээдийн эд хөрөнгөөр хариуцуулж, энэ талаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж болох хуулийн тодорхой үндэслэл бол Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэж тодорхойлсон явдал юм. Иймд Компанийн тухай хуулийн 9.5-д заасны дагуу хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө хувийн хөрөнгөөс тодорхой зааглагдсан эсэхийг нягтлах ёстой гээд орон сууцны битүүмжлэх тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.
2	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.04-ны өдрийн №7425 дугаар шийдвэр ²⁰	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь “Хайсын хүчтэнүүд” ХХК-ийн татварын өрийг төлүүлэх хүрээнд 30%-ийн хувьцаа эзэмшигч Ц.Сайнбилэг өөрийн ээж Л.Сувдаатай хамтран өмчилдөг дундын хөрөнгө болох орон сууцыг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгуулах тухай.	Битүүмжилсэн орон сууц нь Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасан “зааглагдаагүй эд хөрөнгө” гэсэн томьёололд хамаарахгүй. Тодруулбал, тус орон сууц “Хайсын хүчтэнүүд” ХХК-ийн өмчлөлөөс бүрэн тусгаарлагдмал байж, ялган зааглах бүрэн боломжтой байдлаар бүртгэгдэж, ашиглагдаж байсан хэмээн орон сууцны битүүмжлэх тогтоолыг хүчингүй болгосон.
3	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.08.17-ны өдрийн 1448 дугаар магадлал ²¹	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба нь “Сейсфон” ХХК-ийн 70 хувийн хувьцаа эзэмшигч “Тавантолгой транс” ХХК-ийн өмчлөлийн эд хөрөнгөөс 2016.05.04-ний өдрийн 140/02 тоот тогтоолоор төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэсэн тогтоолыг хүчингүй болгуулах тухай.	Компанийн тухай хуулийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан “зааглагдаагүй эд хөрөнгөнд” “Тавантолгой транс” ХХК-ийн өмчлөлийн автомашин хамаарахгүй гэсэн шүүхийн дүгнэлт зөв байна. Өөрөөр хэлбэл, “Тавантолгой транс” ХХК нь “Сейсфон” ХХК-ийн хувьцааны 70 хувийг эзэмшдэг нь тодорхой байх бөгөөд “Тавантолгой транс” ХХК-ийн өмчлөлийн эд хөрөнгийг хувийн эд хөрөнгө гэж үзэхгүй юм. Учир нь хувийн гэх тодотголтой эд хөрөнгө нь хувь хүний эд хөрөнгө болно.

ДҮГНЭЛТ, САНАЛ:

Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага нь олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм. Монгол Улсын хувьд ч компанийн эрх зүйдээ хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг хүлээн зөвшөөрч Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт хуульчлан тогтоосон нь ихээхэн ач холбогдолтой юм.

Харин хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг үгүйсгэх зарчим нь компанийн үүрэг гүйцэтгүүлэгч тухайн компанийн хувьцаа эзэмшигчид бүрэн хариуцлага хүлээлгэх чухал эрх зүйн механизм гэж үзэж болно. Уг ойлголтын нэг хэсгийг Компанийн тухай хуулийн 9 дүгээр 9.5 дахь хэсэгт зохицуулсан. Олон улсын төвшинд хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг үгүйсгэх зарчим буюу “Piercing the corporate veil” хэрэгжих тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүрэн хариуцлага үйлчилж байгаа тул хариуцлагын хувьд оновчтой гэж үзэж байна.

¹⁹ Сүхбаатар дүүргийн шүүх, 2014.06.23, №2489 https://shuukh.mn/single_case/32117?daterange=2014-06-23%20-%202014-06-23&id=1&court_cat=1&bb=1;

²⁰ https://shuukh.mn/single_case/8926?daterange=2015-11-04%20-%202015-11-04&id=1&court_cat=1&bb=1

²¹ https://shuukh.mn/single_case/3210?daterange=2016-08-17%20-%202016-08-17&id=2&court_cat=1&bb=1

Дээрх зүйл заалтуудыг хэрэглэх практик шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон тус ажиллагааг хянаж буй шүүхийн практикаар илэрч байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төлбөр төлөгч хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэхдээ төлбөр төлөгч хуулийн этгээдийн хөрөнгө гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсгийг баримтлан Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг үндэслэхдээ “Хувьцаа эзэмшигч...гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэснийг хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагын үүднээс тайлбарлан хэрэглэх тохиолдол байгаа тул энэхүү байдлыг засаж хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг баримталсан тохиолдолд үүнтэй холбоотой хувьцаа эзэмшигчийн зүгээс компанийн өр төлбөрийг өөрийн хувийн эд хөрөнгөөр хувь тэнцүүлэн хариуцсантай холбоотой шүүхийн маргаан үүсэхгүй юм.

Харин хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус байгууллагаас хэрэглэхдээ хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шалгах ажиллагааг хэрхэн гүйцэтгэж байгаа нь тодорхойгүйгээр хувьцаа эзэмшигчийн хувийн эд хөрөнгөнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах арга хэмжээг авч байгаа нь оновчгүй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн байдлыг эцэслэн шийдвэрлэдэг байгууллага биш тул хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хөрөнгө оруулалтын болон холбогдох гэрээнд тодорхой биш, хэрхэн зааглагдсан нь ойлгомжгүй, тус хөрөнгө нь компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг зүй бусаар эсхүл урвуулан ашиглаж хувьцаа эзэмшигч нь өөрийн хариуцлагаас үндэслэлгүйгээр зайлсхийсэн гэж үзвэл төлбөр авагч болох компанийн үүрэг гүйцэтгүүлэгч хувьцаа эзэмшигчийг хариуцагчаар татаж уг нөхцөл байдлыг тогтоолгохоор шүүхэд хандах боломжтой юм.

ЭХ СУРВАЛЖ

Шүүхийн шийдвэр:

- Сүхбаатар дүүргийн шүүх, 2013.02.27, №513;
- Сүхбаатар дүүргийн шүүх, 2014.06.23, №2489;
- Чингэлтэй дүүргийн шүүх, 2015.09.17, №6228;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, 2015.10.16, №6929;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, 2015.11.04, №7425;
- Сүхбаатар дүүргийн шүүх, 2016.06.22, №00171;
- Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, 2016.08.17, №1448;
- Улсын Дээд шүүх, 2016.12.09, 001/ХТ2016/011373;
- Улсын дээд шүүх, 2018.04.17, №001/ХТ2018/00617;
- Улсын Дээд шүүх, 2020.07.09, №001/ХТ2020/00382;

Монгол хэлээр:

- Очи-Ай Сэйчи, *Компанийн эрх зүйн үндсэн ойлголт*, орч. Р.Пүрэвбаатар нар, УБ, 2017 он;
- Б.Амарсанаа, *Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал*, УБ, 2012 он;
- Г.Давааням, *Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд* (хувийн эрх зүйн цуврал), УБ, 2020 он;
- Б.Амарсанаа нар, *Хувьцаа эзэмшигчийн эрх, гарын авлага* (2 дахь хэвлэл), УБ, 2017 он;
- Г.Давааням, *Хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хүрээнд шаардах эрхийн дарааллыг хойшлуулах онолыг хэрэглэх тухай. Эрх зүй сэтгүүл №4* (2019);

- П.Баясан, *Компанийн засаглалыг нэвтрүүлсэн олон улсын туршлагауд*, УБ, 2006 он;
- М.Мөнхжаргал, *Хувьцаа эзэмшигчийн эрхийн зохицуулалт* (Дипломын ажил, МУИС-ХЗС, Иргэний эрх зүйн тэнхим), УБ, 2011 он;
- О.Мөнхнасан, *Монгол Улсын компанийн тухай хууль дахь хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах нь: харьцуулсан судалгаа*, 2019 он;
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, “*Компанийн тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай*” дүгнэлт, 2012.10.10, №04;
- Монгол Улсын Дээд шүүх, “*Компанийн тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*” тогтоол, 2007.06.18, №27;

Гадаад эх сурвалж:

- Frank H. Easterbrook, Daniel R. Fischel, *Limited liability and the Corporation*;
- Erjola Aliaj, PhD Candidate, *The principle of shareholders' limited liability and its exception in Albanian company law*, European scientific journal, 2014
- Paddy Ireland, *Limited Liability, Shareholder rights and the Problem of Corporate irresponsibility*, Cambridge Journal of Economics, Sep 2016

Цахим эх сурвалж:

- <https://www.law.cornell.edu/>;
- <file:///Users/bilguun/Downloads/3912-Article%20Text-11359-1-10-20140829.pdf>;
- file:///C:/Users/5589/Downloads/Limited_Liability_Shareholder_Rights_and_the_Probl.pdf

THE PRINCIPLE OF SHAREHOLDERS' LIMITED LIABILITY OF COMPANY IN MONGOLIA AND PRACTICAL USE

Bilguun.B
Advocate

ABSTRACT:

Limited liability is a principle of legal protection for shareholders that prevents individuals from being held personally responsible for their company's debts or financial losses, and in general means that the liability of a shareholder is limited to the amount that the owner has invested in the company. “Piercing the corporate veil” refers to a situation in which courts put aside limited liability principle and hold a company shareholders personally liable for the company actions or debts.

In the case of Mongolia, Article 9.3 of the Company Law (2011), which recognized and legislated respectively the principle of limited liability of shareholders in corporate law, provides for the piercing the corporate veil in Article 9.4 and 9.5 of the Law.

KEYWORDS:

Company, Shareholder, Limited liability, Property, Company Debt;

МОНГОЛ УЛСАД ЦАХИМ ХУДАЛДААНЫ БИЕ ДААСАН ХУУЛЬ БАТЛАХ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛЖ, ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ АЖИЛД ХЭРЭГЦЭЭТ САНАЛ ГАРГАХ НЬ



Б.Гунзаяа

МУИС-ийн ХЗС-ийн магистрант

ТОВЧЛОЛ:

Монгол Улсад интернет хэрэглэгчдийн тоо жилээс жилд өсөж байгаагай холбоотойгоор иргэд нийгмийн сүлжээ (Фейсбүүк, инстаграм... г.м.) ашиглан худалдааны харилцаанд оролцох нь түгээмэл болсон. Энэхүү өгүүллээр цахим худалдааны хууль батлах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болсныг хүлээн зөвшөөрч тус харилцааг зохицуулах хууль боловсруулах ажилд хэрэгцээт санал гаргахыг зорилоо. Юун түүрүүн манай улсад түгээмэл болон хөгжиж буй “Бизнесийн байгууллага-хэрэглэгч” болон “Хэрэглэгч-хэрэглэгч” загварын цахим худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь хүн ам болон улс орны эдийн засгийг сайжруулах, бэхжүүлэх нэгэн том түлхэц болох юм. Ийнхүү хууль боловсруулах ажилд олон улсын гэрээ, НҮБ-ын Олон Улсын худалдааны эрх зүйн хорооноос 1996 онд боловсруулагдсан “Цахим худалдааны загвар хууль” болон БНХАУ-ын цахим худалдааны хуулийн ач холбогдолтой зохицуулалтуудыг өөрийн орны онцлогт тохируулан жишиг болгон хэрэглэх боломжтой юм.

ТҮЛХҮҮР ҮГС:

Цахим худалдаа, цахим худалдааны тухай хууль, интернет хэрэглэгч, Монгол Улсын онцлог, дэлхий нийтийн түгээмэл хандлага.

УДИРТГАЛ

Монгол Улсад хүн амын дунд интернет хэрэглээ нэмэгдэх тусам интернетийг ашиглах арга нь улам боловсронгуй, үр өгөөжтэй хэлбэрт шилжиж байна. Манай улсад интернет ашиглан худалдаа эрхлэгчдийн тоо хэд байгаа болон тэдгээр нь ямар бараа, бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчид үзүүлж буй талаар албан ёсны мэдээлэл байхгүй байна. Гэвч зах зээлд маш олон интернет хаяг ашиглан худалдаа эрхлэгчид үйл ажиллагаа явуулж ашиг олсоор байгаа юм. Энэхүү салбарт энэ байдлаар анхаарал хандуулахгүй байх нь хэрэглэгчид болон нийгэмд сөрөг үр дагавар бий болгох боломжтой бөгөөд энэ салбарыг эмх журамд оруулан нэгдсэн хууль дүрмээр зохион байгуулах нь аль нэг этгээд хохирохоос сэргийлж чадах юм.

Цахим худалдааны “Бизнесийн байгууллага- хэрэглэгч” (Business to Consumer, B2C), “Хэрэглэгч- Хэрэглэгч” (Consumer to Consumer, C2C) загварууд нь манай улсад өргөнөөр ашиглагдаж байна. Ялангуяа бизнесийн байгууллагаас худалдаж авсан бүтээгдэхүүнээ гуравдагч этгээдэд дамжуулан худалддаг “Хэрэглэгч- Хэрэглэгч” загвар маш хурдацтай хөгжих хандлагатай байна. Эдгээр харилцаа нь хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдсанаар улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөхөөс гадна хэрэглэгч болоод аж ахуй эрхлэгчийн аль алинд таатай нөхцөл бүрдэх юм.

Цахим худалдааны талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бодлогын судалгаа хийгдсэн нь энэхүү салбар дахь ач холбогдол бүхий цөөхөн судалгааны нэг юм. Монгол Улс дахь цахим худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход судлаачдын санаа, бодол тун их хэрэгцээтэй байх бөгөөд цаашид судалгааны бүтээлийн тоо өснө гэдэгт найдаж байна. Ямартай ч энэ салбарт хийгдсэн судалгаанууд нь цахим худалдааны хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг чухалчлаад л өнгөрсөн байдаг. Харин энэхүү судалгааны ажил нь цахим худалдааны хуулийг батлахдаа юуг анхаарвал зохих талаар олон улсын гэрээ, Цахим худалдааны загвар хууль, гадаад орны хууль тогтоомжийг судалсан дүгнэлтдээ тулгуурлан санал гаргасан шинэлэг талтай юм. Мөн түүнчлэн энэхүү судалгааны ажил нь бид аливаа тоон үзүүлэлт хүлээн суухгүйгээр зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг мэдрэх нь зүйтэй гэсэн агуулгыг гол болгож, Монгол Улсын өнөөгийн эрх зүйн хөгжлийн түвшинд хүлээн зөвшөөрч чаддаггүй чухал ойлголтуудыг шинэ тутам хөгжиж буй салбарт оруулахад хувь нэмрээ оруулах зорилготой болно.

А. ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Өгүүллийн энэхүү хэсэгт цахим худалдааны тухай ойлголтыг тодорхойлсон тайлбаруудтай танилцана. Мөн түүнчлэн цахим худалдааны олон хэлбэрүүдийг нээн илрүүлж оновчтой нэршлээр нэрлэх, уншигчид судалгааны ажлаар гарах нэр томъёог ойлгоход туслах юм. Цаашлаад цахим худалдааны харилцаан дахь талууд, тэдгээрийн үүрэг оролцоо, ирээдүйд давамгайлах чиг хандлагыг харуулахыг зорилоо.

“Цахим худалдаа гэдэг нь ерөнхийдөө текст, дуу, дүрс зэрэг цахим өгөгдлийг боловсруулж дамжуулах ажиллагаан дээр үндэслэсэн байгууллага, хувь хүмүүс хоорондын бизнесийн арилжааны бүх хэлбэр юм.”¹ Мөн түүнчлэн Олон улсын худалдааны байгууллагаас “Интернет худалдаа гэдэг нь телехолбооны сүлжээний тусламжтайгаар барааны үйлдвэрлэл, зар сурталчилгаа, худалдаа, түгээлтийн тухай ойлголт юм”² гэж тодорхойлсон байдаг. Эдгээр тодорхойлолтоос дүгнэвэл, цахим худалдаа нь хүний бүтээсэн аливаа өгөгдлийг дамжуулж, түүгээр ашиг олох боломжийг олгож байдаг өвөрмөц онцлог бүхий арилжааны нэг хэлбэр юм.

Хувь хүн, хуулийн этгээд, Засгийн газар гэсэн 3 төрлийн этгээд цахим худалдааны оролцогч болдог. Цахим худалдаа үүссэн хөгжлийн эхний үед хуулийн этгээд, тэр дундаа компани болон хувь хүмүүсийн хооронд интернет ашигласан харилцаа үүсэж байжээ. Үүнээс хойш цахим худалдаа нь түүнд оролцогчдын онцлогоос хамаарч олон төрөл болон хөгжсөн байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн “Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт” судалгааны ажлын тайланд цахим худалдааны “Засгийн газар- Бизнесийн байгууллага” /G2B/, “Бизнесийн байгууллага-Бизнесийн байгууллага” /B2B/, “Бизнесийн байгууллага- хэрэглэгч” /B2C/, “Хэрэглэгч-Хэрэглэгч” /C2C/, Бизнесийн бус (их дээд сургууль, төрийн байгууллага) гэсэн 5 төрлийн хэлбэр байгааг дурджээ. “Засгийн газар-Бизнесийн байгууллага” ангиллын хувьд засгийн газрын үйлчилгээ, үйл ажиллагаа

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт, судалгааны ажлын тайлан, УБ., ХЗҮХ, 2012 он, 11 дэх тал (Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолт) <https://nli.gov.mn/?p=1980> [Сүүлд үзсэн: 2020.11.02]

² Ц.Оюунаа, *Олон улсын хувийн эрх зүй*, УБ, Соёмбо принтинг, 2015, 144-146 дахь тал

нь гагцхүү бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчид бус бүх этгээдийг хамарсан байдгийг тодотгох нь зүйтэй болов уу. Энэхүү судалгааны ажлаар “*бизнес эрхлэгчээс/хувь хүн, бизнесийн байгууллага/ хэрэглэгчид чиглэсэн*” загварын харилцаанд хэрэглэгдэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлагыг бусад загвар ангилалуудыг илүү өргөн хүрээнд авч үзнэ.

Өдгөө дэлхийд ноёрхож буй Alipay.com, amazon.com, EBay.com зэрэг компаниудаас хэрэглэгчид шууд хандсан хэлбэр бол бизнес-хэрэглэгч (Business to Consumer, B2C) загварын жишээ юм. Үүнээс гадна үйлдвэрлэгч болон тэдгээрийн дэд гэрээлэгч хоорондын үйл ажиллагаа болох бизнес-бизнес(Business to Business, B2B) загвар бол худалдааны түгээмэл хэлбэр байсаар ирсэн. Мөн түүнчлэн, нэг талаас Засгийн газар, төрийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг худалдан авахад зориулан бүтээсэн “засгийн газар-хэрэглэгч” загвар ч нийтэд үр өгөөжөө өгсөөр байна. Цахим худалдааны хурдацтай хөгжиж буй дараагийн нэгэн төрөл нь хэрэглэгч бизнесийн байгууллагаас худалдан авсан бүтээгдэхүүнээ гуравдагч этгээдэд дамжуулан худалддаг “хэрэглэгч- хэрэглэгч” (Consumer to Consumer, C2C)³ загвар юм. “Хэрэглэгч- Хэрэглэгч” загварын цахим худалдаа өдгөө манай улсад түгээмэл болсон бөгөөд хэрэглэгчийн эрхийн зөрчил хамгийн ихээр гарч буй орчин юм.

В. В2С, С2С ЗАГВАРЫН ЦАХИМ ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Өгүүллийн энэ хэсэгт интернет, үүрэн утас хэрэглэгчдийн тоог тогтоосон байдал, монгол банкнаас хийсэн судалгааны тоон мэдээлэлд тулгуурлан маш олон цахим худалдаа эрхлэгч байх боломжтойг юун түрүүнд харуулахыг зорилгоо. Ийнхүү бүртгэлгүй худалдаа эрхлэгчид бизнесийн харилцаанд оролцох нь төр татвар авч чадахгүй байх, хэрэглэгчид хохирох, бизнесүүд баталгаагүйн улмаас үйл ажиллагаа нь ашиггүй байх зэргээр цахим худалдааны эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээг бий болгож байна гэсэн санааг илэрхийлэх юм. Мөн түүнчлэн ХБНГУ-ын хэрэглэгчийн эрхийг хамгаалж буй эрх зүйн орчныг Монгол Улсын хууль, дүрэм журамтай харьцуулан судална. Хамгийн сүүлд нь МУ-ын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025)” баримт бичгийн энэхүү судалгаанд ач холбогдол бүхий зорилтуудын талаар дүгнэлт хийнэ.

Үндэсний статистикийн хорооноос 2017 онд гаргасан судалгаагаар интернет хэрэглэгчдийн тоо 2,656.3 мянга, үүрэн утас идэвхтэй хэрэглэгчдийн тоо 3,371,600 гэж гарчээ.⁴ Харин тус хорооноос 2020 оны 11 дүгээр сарын 09-нд шинэчилсэн нийт интернет хэрэглэгчдийн тоо 2020 оны 1 дүгээр улиралд 3,701.76, 2 дугаар улиралд 3,838.62, 3 дугаар улиралд 3,941.7 байна гэсэн тооцоолол гарчээ.⁵ Энэхүү тоон мэдээнээс харахад 2017 оноос хойш Монгол Улсад интернет хэрэглэгчдийн тоо, интернет бүхий төхөөрөмжийн тоо хурдтай нэмэгдсэн байна. Facebook хаяг, Instagram хаяг бүр цахим худалдааны оператор байх боломжтой гэж үзэхэд худалдаа эрхлэгчдийн тоо хэчнээн олон байж болохыг харж болох юм.

³ C2C represents a market environment where one customer purchases goods from another customer using a third-party business or platform to facilitate the transaction. C2C companies are a type of business model that emerged with e-commerce technology and the sharing economy <https://www.investopedia.com/terms/c/ctoc.asp#:~:text=C2C%20represents%20a%20market%20environment,technology%20and%20the%20sharing%20economy>. [Сүүлд үзсэн: 2020.11.02]

⁴ http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L13 [Сүүлд үзсэн: 2020.11.11]

⁵ http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_1300_012V1&13999001_select_all=0&13999001SingleSelect= t7&SOUm_select_all=1&SOUmSingleSelect=&YearO_select_all=0&YearQSingleSelect= 202003_202002_202001&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2019&viewtype=table [Сүүлд үзсэн: 2020.11.11]

2020 оны 6 дугаар сард Монгол банкнаас гаргасан “Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ”⁶ судалгаагаар 2019 онд манай улсын иргэд 71.5 сая ам. долларын цахим худалдан авалт хийсэн (үүнээс 70.2 сая ам.доллар нь барааны, 1.4 сая ам.доллар нь үйлчилгээний зориулалттай) бөгөөд барааны худалдан авалтын 64.7 сая ам.доллар нь гадаад худалдааны статистик бүртгэлд тусгагдаагүй байдаг байна гэжээ. Ерөнхийдөө цахим худалдаанд оролцогчид нь хувийн хэрэгцээнд болон худалдан борлуулах зорилготой байдгийг түүврийн аргаар хийсэн судалгаагаар тогтоосон. Мөн түүнчлэн, худалдаанд оролцсон 3,331 (судалгаанд сайн дураар оролцсон) хүнээс хувийн хэрэгцээндээ бараа худалдан авсан 3,142 иргэдийн 43% нь Фейсбүүк, 35% нь цахим хуудас(үүнээс 22% нь Amazon, 41% нь БНХАУ-ын Taobao, Alibaba, eBay, Aliexpress, Tmall зэрэг), 6 хувь нь инстаграмм сүлжээ ашиглан, үлдсэн 16% нь аль аль хэлбэрийг хослуулан авдаг байна. Эдгээрээс харахад цахим худалдаа хийж буй дийлэнх иргэд нийгмийн сүлжээ ашигладаг нь харагдаж байна.

С2С хэлбэрээр хийж буй цахим худалдааны хувьд огт бүртгэлгүй байгаа нь олон судалгаа, мэдээллээс харагддаг. Монгол улсад интернетийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй интернет кафе зэрэг үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээлэл байхаас, интернет хэрэглэгч иргэд цахим сүлжээг ашиглан хэдий хэмжээний орлого олж байгаа нь тодорхойгүй байна. Хувийн хэрэгцээндээ зориулан бараа, үйлчилгээ худалдан авахдаа олонхийн ашигладаг хэлбэр нь нийгмийн сүлжээ буюу фэйсбүүк, инстаграм зэрэг байгаа нь энэхүү арга монгол улсад түгээмэл болсныг баталж байна.

Эдийн засгийн хэрэгцээгээ хангах хүсэлтэй олон мянган хүмүүс интернетийн хөгжлийг ашиглан худалдаа эрхэлж эхэлж байна. Чанар, баталгаат байдлын хувьд ялгаатай, бүртгэлгүй зэрэг маш олон хувь хүн, бизнесийн байгууллага энэ салбарт үйл ажиллагаа явуулж байдаг. Захиалсан барааны мэдээллийг дутуу танилцуулах, өнгө үзэмжээр бусдыг хуурах, хэрэглэгчийн мөнгийг авсан ч бараа, бүтээгдэхүүнээ өгөхгүй байх зэрэг маш олон асуудал энэ салбарт гардаг. Энэхүү цахим худалдаа эрхлэх үйл ажиллагаа нь бүртгэл, хяналт, мэдээллийн технологийн хөгжил зэрэг маш олон шийдвэрлэх шаардлагатай асуудлыг хамарна. Гэтэл дээр дурдсанчлан Монгол Улсад цахим худалдаа эрхлэгчдийг бүхэлд нь бүртгэх, хянах тогтолцоо байхгүйгээс нийт хэчнээн этгээд оролцож буйг нь тогтоох боломжгүй байгаагаас судлаачид ч мэдээлэл хомс байгаа юм.

Цахим худалдааны эрх зүйн тогтолцоог боловсонгүй болгох хэрэгцээ шаардлага нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, улс нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилгод чиглэсэн байх ёстой. Улс орнуудын хувьд Цахим худалдааны хуулиасаа гадна иргэний хууль, худалдааны хууль болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиараа цахим худалдааны харилцааг зохицуулсан байдаг. Иргэний хуульдаа цахим худалдаатай холбогдох эрх зүйн зохицуулалтыг тусгасан улсын нэг төлөөлөгч бол ХБНГУ юм. ХБНГУ-ын Иргэний хууль⁷-н “Хэрэглэгчийн гэрээ болон борлуулалтын онцгой хэлбэрүүд” гэсэн гарчгийн 3-р хэсэгт “Электрон хэрэгслээр дамжуулан бизнес эрхлэх ба гэрээ хэлцэл” гэсэн ойлголтыг зохицуулжээ.

Электрон хэрэгслээр бизнес эрхлэх үйл ажиллагаанд аж ахуй эрхлэгч, хэрэглэгч гэсэн 2 субъектыг багтаасан байна. Тус улсын иргэний хуулийн 13 дугаар зүйлд Хэрэглэгч гэх ойлголтыг аливаа хэлцлийг хийхдээ аж ахуйн үйл ажиллагаа голлон эрхлэх эсвэл бие даан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зорилго агуулаагүй иргэн, хуулийн этгээд байна гэж тодорхойлсон. Харин 14 дүгээр зүйлд “Аж ахуй эрхлэгч гэдэгт аливаа хэлцлийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эсвэл бие даан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хийж

⁶ Монгол банк, Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ, судалгааны тайлан УБ, Монгол банк, 2020 он, 19 дахь тал <https://www.mongolbank.mn/documents/sudalгаа/%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC%20%D1%85%D1%83%D0%B4%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B%20%D1%81%D1%82%D0%B0%D1%82%D0%B8%D1%81%D1%82%D0%B8%20%D0%B1%D2%AF%D1%80%D1%82%D0%B3%D1%8D%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%88%D0%B8%D0%BD%D0%B6%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D.pdf> [Сүүлд үзсэн: 2021.03.09]

⁷ ХБНГУ-ын ИРГЭНИЙ ХУУЛЬ (кодификацийн бүрэн эх), орч. Б.Буянхшиг, УБ, Соёмбо принтинг, 2017, 12, 71-72 дахь тал

буй иргэн, хуулийн этгээд болон эрх зүйн чадамжтай хувь хүмүүсийн нэгдлийг ойлгоно” гэж заажээ. Ийнхүү ХБНГУ-ын Иргэний хуульд хэрэглэгч гэх ойлголтыг тодорхойлж өгсөн нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбарын хөгжилд нэгэн том түлхэц болж байгаа юм.

Манай улсын Иргэний хууль⁸-д “хэрэглэгч”, “хэрэглэгчийн гэрээ” зэрэг ойлголтыг тусгаагүй бөгөөд нийтлэг байдлаар гэрээ байгуулагч талуудын харилцаанд иргэний хууль үйлчилдэг. Иргэний хуулийн 42¹ дүгээр зүйл (цахим хэлбэрээр хийх хэлцэл) нь тус хууль дахь “цахим” гэсэн үг бүхий цорын ганц зохицуулалт юм. Гэвч “Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно” гэж заасан. Хуулийн энэхүү заалт нь тодорхой гэрээ, хэлцлийг цахим хэлбэрээр хийх нөхцөлд ямар шаардлагыг баримтлах ёстой талаар зохицуулсан хэм хэмжээ гэж ойлгогдож байна.

Мөн манай улсад бараа, бүтээгдэхүүн худалдах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль⁹ -р зохицуулдаг. Энэхүү хуулиар хэрэглэгчийн эдлэх эрх, гомдлын шаардлага гаргах хугацаа, шүүхээр хамгаалуулах нөхцөл зэрэг харилцааг зохицуулсан. Гэвч тус хуульд интернет сүлжээ ашиглан худалдаа эрхлэгч, хэрэглэгчийн хооронд хийгддэг цахим худалдаа эрхлэхтэй холбогдсон харилцааг тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй юм. Дэлхийн өндөр хөгжилтэй топ 10 орны цахим худалдааны туршлагаас харахад дэд бүтэц; аюулгүй байдал, хамгаалалт; хууль, эрх зүй; төлбөрийн систем гэсэн үндсэн 4 хэсэг дээр¹⁰ анхаарлаа хандуулдаг байна. Эдгээрээс манай улсын хувьд нэн тэргүүнд цахим худалдааны хууль, эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай бөгөөд хууль тогтоогчид цахим худалдааны салбарт тэр бүр анхаарал хандуулахгүй байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/”¹¹-ыг баталсан. Энэхүү бичигт манай улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар, иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэвшилтэт технологи нэвтэрч, өдөр тутмын хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааных нь салшгүй хэсэг болсныг тодотгосон байна. Энэхүү баримт бичгээр мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, дэд бүтэц, мэдээллийн аюулгүй аюулгүй байдлыг сайжруулах зэрэг зайлшгүй хэрэгцээт ажлыг төлөвлөжээ. Тодруулбал, харилцаа холбооны салбарын эрх зүйн орчныг сайжруулах, улс хоорондын болон улс доторх өндөр хурдны сүлжээний мэдээллийн урсгалын хэмжээ, интернет хэрэглэдэг хүн амын нэвтрэлтийн түвшин зэрэг үзүүлэлтүүдийн 2025 онд хүрэх үр дүнг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, интернет орчны чанарт анхаарч тус салбарыг илүү хялбар, баталгаатай болгох зорилгод чиглэж байна гэж харж болно.

Төрөөс мэдээлэл, харилцаа холбоог хөгжүүлэх замаар хувь хүний хөгжлийг дэмжиж, нийгэм эдийн засгийн бүх салбар, бүс нутаг, иргэн бүрд хүртээмжтэй байх зарчмыг удирдлага болгох ёстой. Энэхүү бодлогын баримт бичигт төлөвлөгдсөн ажлууд биеллээ олбол 2025 он гэхэд Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарт тодорхой дэвшил гарч, хууль эрх зүйн таатай орчин бий болох боломжтой байна. Ийнхүү төрийн бодлого, цаашдын үйл ажиллагааны чиглэл нь болж тусгагдсанаараа дэлхий дахины цахим худалдааны салбарын хөгжилтэй Монгол улс хөл нийлүүлэн орших шаардлага тулгарсныг мэдэрч хүлээн авсныг харуулж байна. Цахим худалдааны салбар нь дээр дурдсанчлан шийдвэрлэх шаардлагатай олон асуудлыг хамардаг тул Монгол Улсад өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бүрэн зохицуулах боломжгүй салбар юм. Тиймээс цахим худалдааны бие даасан хууль боловсруулж, батлах нь зүйтэй.

⁸ “төрийн мэдээлэл” эмхтгэл, 2002 он, №7, Монгол Улсын Иргэний хууль

⁹ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, 2004 он, №3, Монгол Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль

¹⁰ С.Долгөөн “Монгол Улсад цахим худалдааг хөгжүүлэхэд олон улсын туршлагыг харгалзах нь” сэдэвт магистрын зэрэг горилсон судалгааны ажил, УБ., 2016 он

¹¹ <https://www.legalinfo.mn/annex/details/7633?lawid=12496> (Сүүлд үзсэн: 2020.11.20)

С. ЦАХИМ ХУДАЛДААНЫ ХУУЛИЙГ ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН СУУРЬ ЗАРЧИМ, ЗАГВАРТ НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛАХ НЬ

Манай улс цахим худалдааны эрх зүйн зохицуулалтыг анхнаас нь зөв зүйтэйгээр зохицуулж, боловсруулах нь нэн тэргүүний шаардлага болоод байна. Тодруулбал, олон улсын гэрээ, бусад орны хууль тогтоомжийг шууд хуулбарлан хэрэгжүүлэхээс зайлсхийж бодит үнэлэлт дүгнэлт хийн өөрийн улсын онцлогийг таньсан байвал зохино. Бид бүхэн олон улсын -байгууллагаас гаргасан загвар хууль, бусад улс орнуудын цахим худалдааны хуулиудтай танилцаж сайн туршлага бий болгон өөрсдийн орны онцлогт тохирсон хууль батлах нь зүйтэй. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцууд болон загвар хууль нь дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хэрэглэгдэх нэн тэргүүний эх сурвалж байх ёстой юм.

Цахим худалдаанд шууд хамаарах ач холбогдол бүхий конвенцуудыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гаргасан “Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт” судалгааны ажлын тайланд авч үзсэн байдаг. Жишээ нь: “Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай” 1980 оны Венийн конвенц, “Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай” Брюсселийн конвенц, “Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай” Гаагийн конвенц ... гэх мэт. Эдгээр конвенцуудаас “Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай” Брюсселийн конвенцод онлайн худалдааны харилцаанд оролцож буй хэрэглэгч нь гэрээ байгуулж буй нөгөө талынхаа хувьд “сул, дорой” тал байдаг тул эрх зүйн хамгаалалтад орох шаардлагатай гэсэн агуулгыг тодотгож байжээ. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь 1980 оны Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ (Венийн)-ын конвенц юм. Харин Гаагийн конвенц хүчин төгөлдөр үйлчилж эхлээгүй, мөн түүнчлэн Брюсселийн конвенцод Европын холбооны улсууд нэгдэн орсон байдаг ч хууль батлах ажилд тус баримт бичгүүдийг судлагдахуун болгох нь зүйтэй юм.

1996 онд “Цахим худалдааны загвар хууль”¹² НҮБ-ын Олон Улсын худалдааны эрх зүйн хорооноос боловсруулагдсан байдаг. Хууль нь 2 хэсэг, 17 зүйлтэй ба 1-р хэсэгт Ерөнхий цахим худалдаанд хамаарах зохицуулалтууд, 2 дахь хэсэгт тусгай хүрээнд хэрэглэгдэх (бараа тээвэрлэлт) цахим худалдааны зохицуулалтуудыг багтаасан. ЮНСИТРАЛ-ын Цахим худалдааны загвар хууль батлагдсаны дараагаар 1999 онд Австрали, Солонгос, 2000 онд Франц, Энэтхэг, Ирланд, Филиппин, Мексик, 2004 онд БНХАУ зэрэг орнууд загвар хуулийн дагуу цахим худалдааны хуулиа баталж байжээ.¹³ Загвар хуулийн гол зорилго нь цахим худалдааг зохицуулах явдлыг хялбар болгоход чиглэгдэж, одоогийн үйлчилж байгаа хууль зүйн шаардлагуудад нийцүүлэх, эрх зүйн тодорхой байдлыг бий болгох зорилготой юм. Энэ загвар хуулиар дараах чиг үүргийн шинжтэй шаардлагуудыг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр шаардлагуудыг тус бүрд нь дараах хэлбэрээр ангилсан байгааг авч үзье:¹⁴

Эх бичиг баримтыг “бичгээр” шаардах. Ихэнх улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд тодорхой нэг арилжаа худалдааг хийхдээ эх бичиг баримтаар баталгаажуулахыг шаарддаг. ...Цаасан дээр бичигдсэн/буулгасан болон цахим хэлбэрийн хэлцэлд адилхан хандах ёстой бөгөөд харилцаа холбооны ялгаатай хэрэгслүүдийг адилтган авч үзэх нь чухал. Мэдээлэл нь бичмэл хэлбэртэй байна гэж хуульд хэлбэрийн шаардлага

¹² UNCITRAL Model Law on Electronic Commerce with Guide to Enactment 1996 https://www.uncitral.org/pdf/english/texts/elect-com/05-89450_Ebook.pdf [Сүүлд үзсэн: 2020.11.24]

¹³ laws and contracts in an e-commerce environment, information economy report 2006 https://unctad.org/system/files/official-document/sdteceb20061ch8_en.pdf [Сүүлд үзсэн: 2020.11.24]

¹⁴ НҮБХХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан “Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд” сэдэвт баримт бичиг, 91-179 дүгээр параграф. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт, судалгааны ажлын тайлангаас дам эшлэв. УБ., ХЗҮХ, 2012 он (Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолт) <https://nli.gov.mn/?p=1980> [Сүүлд үзсэн: 2020.11.24]

тавьсан нөхцөлд хэрэв агуулагдаж буй мэдээлэл нь хэрэглэж болохуйц мөн тухайн холбогдох баримт бичгийн хувьд ашиглагдахуйц зурвас мэдээлэл нь энэхүү шаардлагыг хангасан гэж үзнэ хэмээн хуулийн 6 дугаар зүйл заасан.

Эх “гарын үсэг” шаардах. Бичиг баримтад гарын үсэг зурах эсхүл үүнтэй тэнцэх бусад төрлийн нотолгоо нь тухайн баримтад гарын үсэг зурсан этгээд уг баримтын агуулгад тусгагдсан эрхийг эдлэх, үүргийг хүлээх нотолгоо болдог. Хууль ёсны дагуу бичиг баримтын нотолгоонд эх гарын үсгийг тооцдог. Сүүлийн үеийн дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд нотолгоог гарын үсгээс гадна бусад төрлийн тухайлбал, тамга, цоолбор, факс эсхүл цахим хэлбэрээр гаргахыг хүлээн зөвшөөрөх болсон. Зурвас мэдээлэл нь гарын үсэг гэдгийг илэрхийлэх ямар нэг аргыг хэрэглэсэн бөгөөд зурвас мэдээлэл дэх мэдээллийн агуулгыг хүлээн зөвшөөрч буйг илтгэн харуулж байгаа бол хүлээн зөвшөөрөгдөхүйц байна гэж үзэж болно. Мөн тухайн арга нь зурвас мэдээлэл дэх харилцаа холбооны зорилгод нийцсэн тохиромжтой, найдвартай байвал гарын үсгийн хууль зүйн шаардлагуудыг хангаж байна гэж үзэх тухай загвар хуулийн 7 дугаар зүйлээр зохицуулжээ.

“Эх” бичиг баримт буюу “Эх хувь”-ийг шаардах. Тодорхой бичиг баримтыг эх хувиар нь байхыг шаардах нь мөн л цахим худалдааны хөгжилд ихээхэн саад тотгор учруулж байна гэж тооцогддог. “Бичгээр”, “гарын үсэг”, “эх” гэсэн гэсэн ойлголтууд нь харилцан уялдаа холбоотой тул ихэнх тохиолдолд бичиг баримтанд гарын үсэг бүхий эх бичиг баримтыг бичгээр баталгаажуулсан байх шаардлагыг тавьдаг юм. Эх бичиг баримтыг шаардах нь тухайн бичиг баримтыг хуурамч бус, хууль ёсны дагуу хийгдсэн гэдгийг нотлох зорилготой юм. Загвар хуулийн 8 дугаар зүйлээр зурвас мэдээлэл байдлаар эцсийн хэлбэр болгон анх удаа ерөнхийлөгдсөн тэр цаг мөчид уг мэдээлэл нэгдмэл цогц нэг зүйл боллоо гэдгийг найдвартай батлах нотолгоо байгаа нөхцөлд, эсвэл уг мэдээлэл нь хүлээн авч буй хүнд очихдоо жижиг хэсгүүд болон задрахгүйгээр харагдах боломжтой байгаа нөхцөлд уг зурвас мэдээллийг эх хувийн хувьд тавигдах хууль зүйн шаардлагыг хангасан гэж үзнэ.

Нотлох баримт, нотолгоо болох. Мэдээллийн аюулгүй байдал болон цахим илгээмж (electronic message) бүхий нотолгоо нь цахим худалдаанд амин чухал ач холбогдолтой байдаг. Цахим ертөнцөд цаасан дээр бичсэн бичиг баримт болон гараар бичсэн баримтыг ашиглах боломжгүй байдаг нь цахим илгээмжийг хуурамчаас ялгахад саад учруулдаг. Интернет сүлжээ гэх мэт цахим харилцаа холбооны нээлттэй системийн өнөө үед аюулгүй байдлыг хангах асуудал нь ихээхэн дарамт, хүнд сорилт болж байна. Ийм ч учраас загвар хуулийн 9 дүгээр зүйлээр аливаа эрх зүйн ажиллагаанд зурвас мэдээллийг нотлох баримтын хэмжээнд авч үзэхээс татгалзахгүй байх эсвэл нотлох баримттай холбоотой аливаа дүрэм журам үйлчлэхгүй байх ёсгүй хэмээн зохицуулсан байна.

Гэрээ хэлцэл байгуулах, хүчинтэй болох. Амаар байгуулсан гэрээ хэлцлийг ихэнх эрх зүйн тогтолцоонд хүчинтэй гэрээ хэлцэлд тооцдог хэдий ч цахим хэлбэрээр хийгдсэн гэрээ хэлцэлтэй холбогдуулан олон хүндрэлтэй асуудал, тодорхой бус нөхцөл байдал үүсдэг. Эдгээр асуудал нь гэрээ хэлцэл хүчинтэй болох нөхцөлүүд тухайлбал, бичгээр, гарын үсэг, гэрээ хэлцэл байгуулсан хугацаа ба байршил, шүүх маргааны үед гэрээ хэлцлийн нөхцөлийг баталгаажуулах нотолгоо зэрэгтэй холбоотой юм. Гэрээ хэлцэл байгуулах үед өмч шилжүүлэх, бараа бүтээгдэхүүнийг борлуулснаас үүсэх алдагдал, эрсдэлийг хэрхэн шилжүүлэхийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Анх зурвас мэдээллийг бэлтгэсэн этгээд (originator)–ийн хяналтаас гарч мэдээллийн системд нэвтрэн орсон тохиолдолд зурвас мэдээлэл илгээгдсэн гэж үзэх бөгөөд Загвар хуульд дараах байдлаар тусгасан байдаг. Жишээ нь: а/ хэрэв хариуцсан системд мэдээлэл нэвтрэч орсон үед мессеж мэдээллийг хаяглагч буюу мэдээлэл хүлээн авагч шинээр сонгогдсон мэдээллийн системээр зурвасыг хүлээн авсан гэж, б/хэрэв мессеж мэдээллийг хаяглагч буцаан хүлээн авсан үед хариуцсан системээс өөр мэдээллийн системд мессеж мэдээлэл илгээгдсэн бол зурвас мэдээллийг хүлээн авсан гэж тус тус тооцно.

Цахим худалдааны харилцаа бол гэрээний эрх зүйн харилцаа юм гэдгийг бид ойлгох нь зүйтэй. Цахимаар хийсэн худалдааг хэдийд хүчин төгөлдөр гэрээ болсон гэж үзэх вэ гэдэг нь төвөгтэй асуудал байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, интернет худалдааны гол асуудал нь төрийн байгууллагууд электрон хэлбэрээр байгаа баримт бичгүүдийг хууль зүйн хүчин чадлынх нь хувьд хүлээн зөвшөөрдөггүй явдал юм.¹⁵ Цахим гэрээ хэлцэл нь заавал иргэний хуулийн 42¹ дүгээр зүйлийн 42^{1.2}¹⁶ дахь хэсэгт заагдсан шаардлагыг хангасан байх ёстой юу?. Цахим худалдааны орчинд маргаан гарахад иргэд ямар үндэслэл, нотлох баримтыг гаргаснаар шаардлагаа барагдуулж болох вэ? гэдэг нь манай улсад тун төвөгтэй асуудал юм. Тиймээс бид Загвар хуульд заагдсан интернет орчин дахь өгөгдөл мэдээлэл, талуудын тохиролцоо нь хэдийд хүчин төгөлдөр гэрээ болж агуулга нь нотлох баримтын түвшинд үнэлэгдэж байгааг зохицуулсан хэм хэмжээг анхаарч үзэх шаардлагатай юм.

ЯВЦЫН ДҮГНЭЛТ: Монгол Улс нэгдэн орсон болон нэгдэн ороогүй олон улсын гэрээнүүд нь бүгд хууль боловсруулах ажилд эх сурвалж болох боломжтой. ЮНСИТРАЛ-ын Цахим худалдааны загвар хууль нь өөрийн онцлог бүхий зохицуулалтыг багтаасан. Жишээ нь: Энэхүү загвар хууль нь интернет сүлжээнд бий болсон өгөгдөл мэдээллийг нотлох баримтын хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц байдалд хүргэхэд чиглэсэн гэж үзэж болно. Үүгээрээ шинээр цахим худалдааны хууль баталж буй улс орнуудад сайн жишиг болох юм. Гэвч тус загвар хуулийг бүхэлд нь хуулбарлан авч батлах боломжгүй. Учир нь энэхүү загвар хууль нь дан ганц материаллаг агуулгыг тусгасан эрх зүйн баримт бичиг юм. Манай улсад шүүхийн ачаалал их байдгийн улмаас цахим худалдаатай холбоотой маргааныг дахин шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй. Иймд цахим худалдаанд холбогдон үүсэж болох бүхий л асуудлыг шүүхийн өмнөх шатанд зохицуулах боломжтой байдлаар эсвэл тусгай цахим худалдааны асуудлыг хариуцсан шүүх бий болгох замаар хуулийг батлах нь зүйтэй гэж үзэж байна.

D. ЦАХИМ ХУДАЛДААНЫ ХУУЛИЙГ ГАДААД ОРНЫ ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛАХ НЬ: БНХАУ-ын цахим худалдааны тухай хууль

Олон улсын гэрээ конвенц, цахим худалдааны талаарх загвар хуулиудаас гадна бусад орны тус харилцааг зохицуулсан, амжилттай хэрэгжүүлж буй хууль, дүрмүүд аливаа хуулийг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн батлахад ач холбогдолтой эх сурвалж болно. БНХАУ-ын эдийн засаг, цахим засаглал, нийгмийн хөгжил нь Монгол улсыг ирээдүйн хөгжилд нэгтгэх дээрх зорилгод нийцэж буй тул тус улсын цахим худалдааны хуулийг энэхүү хэсэгт танилцуулж байна.

БНХАУ-ын Цахим худалдааны тухай хууль нь 2018 оны 8-р сарын 31-ний өдөр батлагдсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.¹⁷ Энэхүү хууль нь интернет, мэдээллийн хэрэгсэл ашиглан бараа бүтээгдэхүүн худалдах болон үйлчилгээ үзүүлдэг бүхий л бизнесийн үйл ажиллагааг багтаасан байна. Харин энэ хуулийн хүрээнд мэдээллийн хэрэгслээр явуулж буй санхүүгийн бүтээгдэхүүн-үйлчилгээ, дуу, дүрсний программ, хэвлэл мэдээлэл, соёлын үнэт зүйлстэй холбогдсон харилцаа хамаарахгүй юм.

Хуульд 3 төрлийн “цахим худалдааны оператор”-ыг тодорхойлсон. Цахим худалдааны оператор (e-commerce operators) гэдэгт интернет болон бусад мэдээллийн сүлжээгээр бүтээгдэхүүн борлуулаж, үйлчилгээ үзүүлдэг бодгаль этгээд(хувь хүн), хуулийн этгээд,

¹⁵ Ц.Оюунаа, *Олон улсын хувийн эрх зүй*, УБ, Соёмбо принтинг, 2015, 144-146 дахь тал

¹⁶ “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хусэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно”-Монгол Улсын иргэний хууль, 2002 он

¹⁷ <https://loc.gov/law/foreign-news/article/china-e-commerce-law-passed/> [Сүүлд үзсэн: 2021.02.09]

үүсгэн байгуулагдаагүй этгээдүүд орно. Мөн түүнчлэн, цахим худалдааны платформын операторууд, платформ дахь операторууд зэрэг худалдаа, үйлчилгээг өөрсдийн бүтээсэн вэбсайт эсвэл бусад вэб сүлжээгээр дамжуулан эрхэлж буй этгээдүүд ч ордог байна.

БНХАУ-ын цахим худалдааны тухай хууль нь 7 бүлэг 89 зүйлээс бүрддэг.¹⁸ Цахим худалдааны операторуудын эрх, үүрэг; цахим худалдааны гэрээ хүчин төгөлдөр болох; маргаан шийдвэрлэлт, хуулийн хариуцлага зэрэг агуулгыг багтаасан байна. Энэхүү хуульд зааснаар цахим худалдаа эрхлэгчид нь заавал бүртгүүлэх шаардлагатай бөгөөд үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээгээ өөрийн цахим хуудсандаа нийтэлсэн байх ёстой байдаг. Мөн тэдгээр операторууд заавал бүртгэлийн байгууллагад хандахгүйгээр анх татвараа төлснөөр бүртгэл үүсэж болдог нь цаг хугацаа хэмнэсэн сайн арга байна. /e-commerce law, article 11/ Мөн татвар төлөх үүргээ биелүүлснээр татварын таатай нөхцөл эдлэх, үр ашгийг нь хүртэх боломжийг ч нээж өгчээ./e-commerce law, article 11/

Цахим худалдааны гэрээ

БНХАУ-ын цахим худалдааны тухай хуулийн 47 дугаар зүйлд “Цахим худалдааны талуудын хооронд байгуулагдсан гэрээнд энэхүү хуулийн 3 дугаар бүлэг хамаарахаас гадна БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий зарчим, гэрээний хууль, болон электрон гарын үсгийн тухай хууль хэрэглэгдэнэ” гэж заасан байдаг. Цахим худалдаа эрхлэгчээс гаргасан бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай мэдээллээс хэрэглэгч өөрийн сонголтыг хийн захиалга өгснөөр захиалгыг баталгаажсан буюу гэрээ байгуулагдсан гэж үздэг.

Хариуцлага хүлээлгэх

Хэрвээ цахим худалдааны операторууд нь хууль, гэрээгээр хүлээсэн чанарын шаардлагыг хангаагүй болон үүргээ биелүүлээгүйгээс хэрэглэгчийн амьдрал, эрүүл мэндэд хохирол учирсан бол иргэний хариуцлага оногдуулдаг байна. Энэ нь 50,000-2,000,000 юанийн хооронд торгууль ногдуулах үндэслэл болно. /цахим худалдааны тухай хууль, 83 дугаар зүйл/

Маргаан шийдвэрлэлт

Тус хуулиар маргаан шийдвэрлэх сонголтот аргууд (alternative dispute resolution)-ыг бий болгосон нь харагдаж байна. Тодруулбал, цахим худалдааны маргааныг хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага, үйлдвэрчний эвлэл, хуулийн дагуу байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах байгууллага, арбитр болон шүүхээр шийдвэрлүүлж болохоор заажээ. /цахим худалдааны тухай хууль, 60 дугаар зүйл/ Мөн цахим худалдааны хуулийн 63 дугаар зүйлд цахим худалдааны платформын операторууд өөрсдөө онлайн маргаан шийдвэрлэх механизм, дүрэм журмыг бий болгож болохыг заасан байна.

ЯВЦЫН ДҮГНЭЛТ: БНХАУ-ын цахим худалдааны тухай хууль нь интернет хэрэглэн худалдаа эрхлэгчдийг (бизнесийн байгууллага, хувь хүн) бүртгэх, эрх үүргийг нь тодорхойлох, хэрэглэгчид хохирол учруулсан бол хариуцлага хүлээлгэх, маргааныг шийдвэрлэх аргыг тодорхойлсон байна. Ийнхүү цахим худалдаа эрхлэгчдийг бүртгэж, үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээ олгосноор хэрэглэгчдийн итгэл нэмэгдэх, хууран мэхлэгдэхээс хамгаалагдаж буй ач холбогдолтой юм. Тус хуульд цахим худалдааны харилцааг нэгэн цогц хэлбэрээр журамлан зохицуулж буй нь энэ салбар хурдацтай хөгжих гол нөхцөл болох юм. БНХАУ-ын хувьд эдийн засаг, хүн амын боловсрол, интернетийн хөгжлөөр манай улсаас ялгаатай учраас цахим худалдааны харилцаан дахь маргаан шийдвэрлэх сонголтот аргууд нь асуудалгүй хэрэгжих боломжтой гэж харж байна. Мөн түүнчлэн цахим шүүхийн үйл ажиллагаа тус улсад нэгэнт жигдэрсэн байдлаар явагддаг нь ийнхүү цогц байдлаар баталсан хуулийг хэрэгжүүлэх тал дээр Монгол Улсаас давуу талтай байх юм.

¹⁸ БНХАУ-ын Цахим худалдааны тухай хууль, https://ipkey.eu/sites/default/files/documents/resources/PRC_E-Commerce_Law.pdf [Сүүлд үзсэн: 2020.11.22]

ДУГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсад цахим худалдааны харилцааг зохицуулсан бие даасан хууль батлах хэрэгцээ, шаардлага нь олон хүчин зүйлээр тодорхойлогддог. Юун түрүүнд нийгэмд цахим худалдааны харилцаанд оролцож буй иргэд олон болж буй нь тус хуулийг боловсруулах, батлах ажлыг эхлүүлэх шаардлагыг бий болгож байна. Цаашилбал, Монгол Улсын Иргэний хууль болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиудад цахим худалдааны харилцаанд оролцож буй субъектүүдийн эрх, ашиг сонирхлыг тусгайлан хамгаалсан зохицуулалт тусгагдаагүй байдаг. Харин ХБНГУ-ын Иргэний хуульд цахим худалдааны харилцааг зохицуулсан, мөн түүнчлэн хэрэглэгчийн гэрээ зэрэг хэрэглэгчийн эрх, үүргийг тодорхойлсон агуулгыг тусгасан байгаа нь Монгол Улс дэлхий нийтийн хөгжлөөс хоцорч байгааг харуулж буй нэгэн жишээ юм. Мөн түүнчлэн цахим худалдааны харилцаа нь олон салбарын үйл ажиллагааг хамарч байдаг учир өдгөө манай улсад үйлчилж буй аливаа хуулийн тодорхой нэг бүлэгт зохицуулагдах боломжгүй. Тиймээс нийгмийн хэрэгцээ шаардлагыг хүлээн авч цахим худалдааны харилцааг зохицуулах бие даасан хууль батлах нь нийгэм-эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Иймд Монгол Улс цахим худалдааны хуулийг боловсруулах, батлах ажлын хүрээнд олон улсын гэрээ, загвар хууль болон БНХАУ зэрэг орнуудын тус харилцаанд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайтар судлан, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн нутагшуулах шаардлагатай. Энэхүү судалгааны ажлаар цахимаар хийсэн гэрээг хүлээн зөвшөөрөх, аливаа нэг эрх зүйн харилцаа нь бие даасан процедуртай (бүртгэл, хяналтын асуудлаас эхлээд тухайн харилцаанаас үүдсэн маргааныг хэлэлцэн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагыг шүүхээс ангид байгуулах хүртэлх) байх зэрэг манай улсын хууль тогтоомжид тэр бүр заагдаагүй асуудлыг шийдвэрлэхэд тус болох санааг гаргасан боловч энд судлагдаагүй олон зүйл үлдсэн гэдгийг дурдах нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Иргэний хууль, 2002 он
- ХБНГУ-ын Иргэний хууль, 2002 он
- Монгол Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2003
- БНХАУ-ын Цахим худалдааны тухай хууль, 2018 он

Монгол хэлээр:

- *Төрийн мэдээлэл* эмхэтгэл, 2002 он, №7
- *Төрийн мэдээлэл* эмхэтгэл, 2004 он, №3
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. *Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт*. судалгааны ажлын тайлан, УБ., 2012 он
- Ц.Оюунаа. *Олон улсын хувийн эрх зүй*, УБ., 2015 он
- С.Дөлгөөн. *Монгол Улсад цахим худалдааг хөгжүүлэхэд олон улсын туршлагыг харгалзах нь*. сэдэвт магистрын зэрэг горилсон судалгааны ажил, УБ., 2016 он
- Б.Буянхшиг. *ХБНГУ-ын ИРГЭНИЙ ХУУЛЬ (кодификацийн бүрэн эх)*, УБ., 2017 он
- НҮБХХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар. *Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд* сэдэвт баримт бичиг

Гадаад хэлээр:

- UNCITRAL E-commerce Model Law

Цахим эх сурвалж:

- www.legalinfo.mn
- <https://nli.gov.mn/?p=1980>
- <https://www.investopedia.com/terms/c/ctoc.asp#:~:text=C2C%20represents%20a%20market%20environment,technology%20and%20the%20sharing%20economy>
- http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L13
- <https://www.legalinfo.mn/annex/details/7633?lawid=12496>
- https://www.uncitral.org/pdf/english/texts/electcom/05-89450_Ebook.pdf
- https://unctad.org/system/files/official-document/sdteecb20061ch8_en.pdf
- <https://loc.gov/law/foreign-news/article/china-e-commerce-law-passed/>
- https://ipkey.eu/sites/default/files/documents/resources/PRC_E-Commerce_Law.pdf

IDENTIFY THE NEED FOR AN INDEPENDENT E-COMMERCE LAW IN MONGOLIA AND MAKE THE NECESSARY PROPOSALS FOR LAWMAKING

B. Gunzaya

LL.M. Candidate, School of law, NUM

ABSTRACT:

Mongolian citizens have become common to engage in commercial relationships using social networks (Facebook, Instagram, etc.) due to the increasing numbers of internet users. This article acknowledges the need for an e-commerce law and seeks to make important proposals on legislation to regulate it. First of all, more popular and well-developed models of e-commerce law regulations, such as ‘Business to Consumer’ (B2C) and ‘Consumer to Consumer’ (C2C), are needed to be improved for the sake of the country and its citizens. Therefore, this paper proposes that in Mongolian e-commerce lawmaking process, we are available to consider the essential regulations of the International treaties, Model Law on e-Commerce developed by the United Nations Committee on International Trade Law and Law on e-commerce of the People’s Republic of China and use those provisions in accordance with the features of own country.

KEY WORDS:

E-commerce, E-commerce law, Internet user, National features, Global trends

ИРГЭНИЙ ХУУЛИЙН 498-Р ЗҮЙЛИЙН ТАЛААР СУДЛАХ НЬ: ХАРЬЦУУЛАЛТ, ДҮГНЭЛТ



Р.Пүрэвбаатар

МУИС-Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, магистр

ТОВЧЛОЛ:

Тус өгүүллийн хүрээнд судлаач Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар хэвтээ /гадаад орнуудтай харьцуулах/ болон босоо /түүхчилсэн харьцуулалт/ харьцуулалтыг хийх замаар уг зохицуулалтын онцлогийг тодорхойлж, судлаачдын өөр хоорондоо ялгаатай байр суурьт дүгнэлт өгч, 498-р зүйлийн хэрэглээний талаар шүүхийн онцлох шийдвэрт тулгуурлан дүгнэлт хийж өөрийн тодорхой саналыг дэвшүүлэхийг зорьсон болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Ажил олгогч, гэм буруу, ажилтан, хамтран үүрэг гүйцэтгэгч

УДИРТГАЛ

Өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 онд батлагдсан Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар судлаачид хоорондоо ялгаатай байр суурийг илэрхийлсэн нь бий. Жишээ нь судлаач Б.Буянхишиг “Ажил олгогч нь ажилтны учруулсан гэм хорыг хариуцахад юуны өмнө ажилтан Иргэний хуулийн 497-р зүйлийн объектив талыг хангасан, хууль бус үйлдэл хийсэн эсэхийг тогтоох нь чухал байдаг. ...Харин гэм бурууг тогтоох шаардлагагүй. Учир нь ажил олгогч өөрөө ажилтнаа зохих ёсоор хянаагүй гэм буруугаас хариуцлага хүлээх гэж буй тул энэхүү субъектив нөхцөлийн хувьд зөвхөн ажил олгогчийг авч үзнэ”¹ хэмээн тайлбарлажээ.

Харин зарим судлаачид “Байгууллага нь ажиллагсдын хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорыг арилгаж байгаа нь тухайн ажиллагсдын гэм буруугийн төлөө биш өөрийн гэм буруугийн төлөө хариуцлага хүлээж байна гэсэн үг юм” хэмээн тайлбарлаад байгууллага нь 498-р зүйлийн 498.3 дахь хэсэгт заасан нөхцөл /хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан гэх мэт/ хангагдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө гэж үзжээ². Түүнчлэн Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхимаас гаргасан шинжлэх ухааны тайлбарт “Ажилтны учруулсан гэм хорыг арилгах үүргийг ажил олгогчид хуулиар ногдуулсан байгаа нь ажил олгогч нь ажилтныхаа хөдөлмөрлөх явцыг холбогдох хууль тогтоомж, заавар журмын үндсэн дээр хянах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутай гэж үзэж байгаатай холбоотой юм” хэмээн дүгнэсэн

¹ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (анхны хэвлэл), УБ, Соёмбо принтинг, 2010, 360 дахь тал

² Т.Мөнхжаргал нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, УБ, Сутай дээд сургууль, 2005, 36-42 дахь талыг үзнэ үү.

байна³.

Эхний хандлагаар бол ажил олгогч нь өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсон тохиолдолд хариуцлага хүлээхгүй /хариуцлагаас чөлөөлөх бус хариуцлага хүлээхгүй/ гэх эрх зүйн үр дагавартай /497-р зүйлтэй харьцуулахад гэм бурууг нотлох үүргийн хувьд ялгаатай гэж тайлбарлах боломжтой боловч, практикт 497.2 дахь хэсгийн дагуу хариуцагч өөрийгөө гэм буруугүй болохыг нотлох үүрэг хүлээдэг гэж тайлбарлах нь түгээмэл. Энэ нь хариуцлага хүлээхгүй, хариуцлагаас чөлөөлөх гэсэн ихээхэн ялгаатай хоёр эрх зүйн үр дагаврыг төдийлөн ялгаж тайлбарладаггүйтэй холбоотой⁴/ хэмээн үзэж байх бол удаах хандлагын дагуу ажил олгогч өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсон тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх боломжийг хуулиар олгоогүй гэж үзжээ.

Иймд миний бие тус өгүүллийн хүрээнд Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар түүхчилсэн болоод шүүхийн шийдвэрийн төдийгүй харьцуулсан эрх зүйн товч судалгаа /хэвтээ болон босоо (түүхчилсэн) харьцуулалт/-г хийх замаар тухайн зохицуулалтын онцлогийг тодорхойлох, уг зохицуулалтын талаарх өөр хоорондоо ялгаатай байр суурьт дүгнэлт өгөх, өөрийн тодорхой саналыг дэвшүүлэхийг зорьсон болно.

I. ТҮҮХЧИЛСЭН СУДАЛГАА /1963, 1994 ОНЫ ИРГЭНИЙ ХУУЛЬ/

Аливаа хуулийн зохицуулалтыг сайтар ойлгож хэрэглэхийн тулд хэлзүйн /үгчилсэн/, системийн, түүхчилсэн, телеологийн тайлбарыг боловсруулах, энэ талаар судалгаа явуулах зайлшгүй шаардлагатай байдаг билээ. Хэд хэдэн орны зохицуулалтыг судалж, өөрийн орны хууль тогтоомждоо шууд болоод шууд бус байдлаар тусгах явдал түгээмэл болсон өнөө үед эдгээр хууль зүйн тайлбарт холбогдох судалгааг өргөн хүрээнд гүйцэтгэх нь нэн чухал юм. Иймийн тул юун түрүүнд Иргэний хуулийн 498-р зүйлийн онцлогийг тодруулах зорилгоор түүхчилсэн судалгааг хийх нь зүйтэй хэмээн үзлээ.

Эхлээд 1994 оны Иргэний хууль дахь холбогдох зохицуулалтыг харьцуулан үзье. Уг хуулийн 378-р зүйлд “Хуулийн этгээд бусдад гэм хор учруулсны хариуцлага” гэх байдлаар томьёолсон байна. Тус 378-р зүйлийн 378.1 дэх хэсэгт “Ажиллагсдаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд хүлээнэ” хэмээн зохицуулсан бөгөөд одоогийн Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн зохицуулалттай харьцуулахад “гэм буруутай үйлдлээрээ” гэх хэсэг хуульчлагдаагүй байсан байна. Түүнчлэн 498.3 болон 498.5 дахь хэсгийн зохицуулалттай адил агуулга бүхий хэм хэмжээ тусгагдаагүй байна⁵.

Харин 1963 оны Иргэний хуулийн хувьд 319-р зүйлд “Албан байгууллага гэм хор учруулсны хариуцлага” гэх байдлаар томьёолон хуульчилсан байна. Уг хуулийн 319-р зүйлийн 319.1 дэх хэсэгт “Албан байгууллагын ажилчин, албан хаагчид үүргээ гүйцэтгэж байгаад өөрийн буруугаас бусдад учруулсан гэм хорыг уул байгууллага хариуцах үүрэгтэй” хэмээн зохицуулсан бөгөөд одоогийн Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн зохицуулалтын бүтэц нь уг зохицуулалт болон 1994 оны Иргэний хуулийн 378-р зүйлийн аль алины нь агуулгыг холимог байдлаар тусгасан гэж дүгнэх боломжтой байна.

Дээр дурдсан хоёр хууль (1963, 1994 оны Иргэний хууль⁶)-ийн талаарх албан ёсны тайлбарт “ямар нэг албан байгууллагын ажилчин, албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа тэр үүрэгтэйгээ шууд холбоотойгоор өөрийн буруугаас бусдад гэм хор учруулсан бол иргэний хуулийн 319-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар уг этгээдийн ажиллаж байгаа албан байгууллага уул гэм хорын хохирлыг хариуцан төлөх бөгөөд энэ байгууллага нь хохирлоо гэм буруутай этгээдээс хөдөлмөрийн хууль тогтоомжидаад зааснаар жич нэхэмжлэх эрхтэйг тайлбарласугай” гэж, мөн “ажилчин, албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад бусдад гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй нь тогтоогдвол иргэний хуулийн 318-р зүйлийн 2-р хэсэгт заасан журмын дагуу ажилчин албан хаагч ба байгууллага гэм

³ Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхим, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг) IV, УБ, 2016, 58 дахь тал

⁴ Р.Пүрэвбаатар, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийг нотлох үүргийн онолын үүднээс тайлбарлах нь, Шүүх эрх мэдэл сэтгүүл №3 (2018), 126 дахь тал

⁵ “Төрийн мэдээлэл”, 1995 он, №1-т нийтлэгдсэн.

⁶ 1994 оны Иргэний хуулийн 378-р зүйлийн талаар Монгол Улсын Дээд Шүүхийн 1997 оны 12-р сарын 12-ны өдрийн 473-р тогтоол бий. Гэвч өмнөх хуулийн холбогдох зохицуулалтын талаарх тайлбараас төдийлөн ялгаагүй агуулгатай болно.

хорын хариуцлагаас чөлөөлөгдөнө” гэж тус тус тодорхойлжээ⁷.

Улмаар “Байгууллага энэ журмаар хариуцсан гэм хор буюу өөрт учирсан материалын хохирлыг буруутай ажилчин, албан хаагчдаар хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу /126-130 дугаар зүйл/ төлүүлэн авах ёстой” хэмээн тайлбарласан байна⁸.

Эндээс дүгнэн үзвэл 1963 болон 1994 оны холбогдох зохицуулалтын хувьд ажилчин, албан хаагчийн талаар Иргэний хуулийн 318-р зүйл /377-р зүйл/-ийн дагуу шийдвэрлэх бөгөөд эдгээр зохицуулалтын хувьд гэм хор учруулсан этгээд өөрийгөө гэм буруугүй болохыг нотлох үүрэгтэй юм. Үүнтэй холбогдуулан гэм хор учруулсан этгээд /ажилчин, албан хаагч/ нь өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсон тохиолдолд тухайн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байгууллага, хуулийн этгээдийг нэгэн адил хариуцлагаас чөлөөлөхөөр байна. Харин одоогийн Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар судлаачид ажилтны гэм бурууг бус ажил олгогч өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсон тохиолдолд эсхүл 498.3 дахь хэсэгт заасан нөхцөлд ажил олгогчийг хариуцлагаас чөлөөлнө гэсэн ялгаатай байр суурийг илэрхийлээд байна. Гэхдээ 2002 оны Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.2 дахь хэсгийн зохицуулалтыг “хариуцлагаас чөлөөлөх” шатанд бус “хариуцлагыг хүлээлгэх” шатанд хэрэглэгдэнэ гэж үзвэл өмнө дурдсантай нэгэн адил байдлаар ажилчин, албан хаагч нь өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсноор ажил олгогч хариуцлага хүлээхгүй гэж тайлбарлах боломжтой нь мэдээж.

Өмнө дурдсан зохицуулалтын талаарх түүхэн нөхцөл байдлыг дахин лавшруулан үзвэл 1961 оны 12-р сарын 8-ны өдөр Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөл /Президиума Верховного Совета СССР/-өөс баталсан “ЗСБНХУ болон холбооны улсуудын иргэний хуулийн талаарх үндсэн зарчим”-ын зохицуулалтыг харьцуулан судлах зайлшгүй шаардлагатай болдог. Учир нь зарим судлаачид жишээ нь судлаач Вилльям Э.Батлер /William E.Butler/ БНМАУ-ын 1963 оны Иргэний хуулийн талаар “Энэхүү 1963 оны Иргэний хууль нь 1963-1964 оны хооронд ЗХУ-ын Иргэний хуульд үндэслэн боловсруулагдсан бусад улсын иргэний хуультай маш төстэй” гээд 1963 оны Иргэний хуулийг анх Орос хэл дээр боловсруулаад дараа нь Монгол хэл рүү хөрвүүлсэн тухай тайлбарласан байна⁹.

Уг 1961 оны “ЗСБНХУ болон холбооны улсуудын иргэний хуулийн талаарх үндсэн зарчим”-ын 88-р зүйлийн 88.3 дахь хэсэгт “Ажиллагсад нь өөрсдийн ажил, албан үүргээ гүйцэтгэж байгаад өөрийн буруугаас бусдад учруулсан гэм хорыг байгууллага нь хариуцан барагдуулах үүрэгтэй” гэж зохицуулсан бөгөөд гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаар зохицуулсан ерөнхий зохицуулалтын 3 дахь хэсэгт хуульчилсан нь ажиллагсдын зүгээс тухайн гэм хор нь өөрсдийн нь гэм буруугаас болоогүй гэдгийг нотолсон тохиолдолд байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй гэх бүтэцтэй нь холбоотой хэмээн дүгнэж болох юм. ЗХУ-ын 1964 оны Иргэний хуулийн 445-р зүйлд “Ажиллагсад нь өөрсдийн ажил, албан үүргээ гүйцэтгэж байгаад өөрийн буруугаас бусдад учруулсан гэм хорыг байгууллага нь хариуцан барагдуулах үүрэгтэй” гэх байдлаар буюу 1961 оны үндсэн зарчмын зохицуулалтыг ямар нэгэн өөрчлөлт оруулалгүй хуульчилсан байдаг онцлогтой. Мөн 1991 онд батлагдсан Иргэний хуулийн талаарх үндсэн зарчмын 126-р зүйлийн 126.2 дахь хэсгийн хувьд мөн нэгэн адил агуулгатай болно¹⁰. Өөрөөр хэлбэл уг тогтолцоо нь 1961 оноос хойш ОХУ байгуулагдах хүртэл уламжлагдан ирсэн бөгөөд манай улсын Иргэний хуулийн зохицуулалтын хувьд мөн нэгэн адил үйл явц өрнөсөн гэж дүгнэж болох юм.

Түүнчлэн одоогийн Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.2 болон 498.4 дэх хэсэгт холбогдох зохицуулалтын хувьд 1963 болон 1994 оны Иргэний хуульд “Төр, захиргааны байгууллага, түүний албан тушаалтан”, “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагын албан тушаалтан”, “Улсын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан”, “Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын албан тушаалтан” гэх

⁷ БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1974 оны 12-р сарын 25-ны өдрийн 11/32-р тогтоол, Гэм хор учруулснаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практикийн зарим асуудлын тухай

⁸ БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1989 оны 12-р сарын 22-ны өдрийн 42-р тогтоол, Гэм хор учруулснаас үүссэн маргааныг шийдвэрлэж байгаа шүүхийн практикийн тухай

⁹ WILLIAM E.BUTLER, THE MONGOLIAN LEGAL SYSTEM: CONTEMPORARY LEGISLATION AND DOCUMENTATION, 266-267 (1982)

¹⁰ Основы гражданского законодательства Союза ССР и союзных республик от 31 мая 1991г.

байдлаар нэгэн адил хоёр хэсэгт хуваан зохицуулж иржээ. Энэ талаар судлан үзвэл ОХУ болон хуучнаар ЗХУ-ын зохицуулалттай түүхэн талаасаа холбоотой болох нь тодорхой байдаг. ОХУ-ын судлаачдын хувьд дүгнэхдээ зарим судлаачид захиргааны үйл ажиллагаа болон хууль сахиулах, шүүх, прокурорын үйл ажиллагаа гэсэн хоёр түвшинд төрийн албаны хариуцлагын асуудлыг судлах нь зохистой гэж үзэж байхад нөгөө хэсэг нь эдгээр хоёр түвшингээр хязгаарлалгүй илүү өргөн хүрээнд төрийн үйл ажиллагааны ихэнх хэсгийг хамарч судлах нь зохистой гэж үздэг гэжээ¹¹. Одоогийн Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.2 дахь хэсэгт өмнөх Иргэний хуулиудаас ялгаатай нь “төр хариуцан арилгана” гэх байдлаар хуульчилсан нь илүү өргөн хүрээтэй зохицуулалтыг бий болгосон гэж дүгнэх боломжтой байж болох юм.

Төрийн албан хаагчийн албан үүргийн хэрэгжилттэй холбогдох төрийн хариуцлагын хувьд өмнө дурдсанчлан “ЗСБНХУ болон холбооны улсуудын иргэний хуулийн талаарх үндсэн зарчим”-ын 89-р зүйлд “Төр, төрийн байгууллага болон тэдгээрийн албан тушаалтнаас захиргааны үйл ажиллагаанд хамаарах албан үүргээ буруу явуулснаас болж иргэдэд гэм хор учруулсан бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ерөнхий зохицуулалт /Тус үндсэн зарчмын 88-р зүйл/-ын дагуу хариуцан арилгана” гэж заасан байсан бөгөөд 1963 оны Иргэний хуулийн 319-р зүйлийн 319.2 дахь хэсгийн хувьд “нийтийн нэгэн адил хариуцна” гэж, 1994 оны Иргэний хуулийн 378-р зүйлийн 378.2 дахь хэсгийн хувьд “377 дугаар зүйлд заасан журмаар арилгана” гэж тус тус зохицуулсан нь 1961 оны уг үндсэн зарчим гэх баримт бичигт тулгуурласан болохыг нь тодорхой илтгэж байгаа болно¹². ЗХУ-ын 1964 оны Иргэний хуулийн 446-р зүйлийн зохицуулалт нь уг 1961 оны үндсэн зарчмын 89-р зүйлийн зохицуулалтыг төдийлөн өөрчлөлгүй уламжлан хуульчилсан байдаг онцлогтой. Түүнчлэн өмнө дурдсан 1991 оны үндсэн зарчмын 127-р зүйлд мөн нэгэн адил агуулгыг хуульчилсан байдаг.

Гэхдээ тухайн үеийн ЗХУ-ын зарим судлаачид “ажиллагсдын гэм буруутай үйлдлийн улмаас ажил олгогч нь хариуцлага хүлээх явдлыг хүлээн зөвшөөрөхгүйгээр үл барам байгууллагын хувьд зөвхөн ажилтныг сонгон шалгаруулахдаа хайнга хандсан, эсхүл хянаж, удирдахдаа алдаа гаргасан зэрэг өөрийнхөө гэм буруутай үйлдлийн улмаас л хариуцлага хүлээх” боломжтой гэсэн саналыг илэрхийлж байжээ¹³. Түүнчлэн ажил олгогчийн зүгээс хохирлыг гуравдагч этгээдийн өмнө хариуцаж төлсөн тохиолдолд тухайн гэм хор учруулсан ажилтны эсрэг хохирлоо нэхэмжлэх боломжтой эсэх асуудал мөн хөндөгдсөн байдаг. Энэ талаар ЗХУ-ын үед хөдөлмөрийн хуулийн зохицуулалтын дагуу тодорхой хүрээнд хязгаарлах /жишээ нь цалин, хөлсний нь гуравны нэг гэх мэт/ нь зохистой гэсэн байр суурийг баримталж байжээ¹⁴. Эндээс үзвэл 1963 болон 1994 оны Иргэний хуулийн хувьд үүнтэй адил агуулгатай байсан болохыг тухайн үеийн дээд шүүхийн бүгд хурлын тогтоол буюу албан ёсны хуулийн тайлбараас тодорхойлох боломжтой байна.

II. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН СУДАЛГАА

Тус судалгаагаар өмнө дурдсанчлан Иргэний хуулийн 498-р зүйлийн онцлогийг тодорхойлох, судлаачдын өөр хоорондоо ялгаатай байр суурьт дүгнэлт өгөх зорилго дэвшүүлсэн тул үүнтэй уялдуулан дараах шүүхийн шийдвэрийг сонгон судлахаар шийдвэрлэлээ.

Хэргийн товч агуулга:

Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 407 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Y1-ийг 2009 оны 05 сарын 11-ний өдөр жижүүр эмчээр ажиллаж байхдаа 4 сартай А-д мэс ажилбар хийснээс хойш 8 цагийн дараа үзлэг хийхдээ ажилбараас гарсан хүндрэлийг эрт оношлоогүй буюу хяналтгүй удаан хугацаанд орхисноос өвчтөн А-ийн бие махбодод хүнд гэмтэл учруулж, эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэж, мөн

¹¹ Ярошенко К. Б. Обязательства вследствие причинения вреда, Гражданское право России. Часть вторая. Обязательственное право: курс лекций. отв. ред. О. Н. Садиков. М., 1997. С. 87

¹² Основы гражданского законодательства Союза ССР и союзных республик от 8 декабря 1961г.

¹³ Whitmore Gray, *Soviet Tort Law: The New Principles Annotated*. U.ILL. L.REV, 190 (1964)

¹⁴ *Ibid*

шүүгдэгч Ү2-ийг тус өдөр өвчтөн А-д мэс ажилбар /баруун эгэмний доорх венийн судсыг Сельдингерийн аргаар хаймсуурдах/ хийх үедээ уушгийг хатган гэмтээж улмаар хяналтгүй орхисноос өвчтөний бие махбодод хүнд гэмтэл учирч, эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэж тогтоосон.

Улмаар шүүхээс Ү1 болон Ү2 нар нь иргэний хариуцагч Х-ийн ажилтан болох нь Х-ийн зүгээс ирүүлсэн тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр нотлогдож байна хэмээн дүгнэж, Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн дагуу нийтдээ 17,702,200 төгрөгийг ажил олгогч байгууллага болох Х-ээс гаргуулахаар шийдвэрлэсэн.

Түүнчлэн шүүхээс ажил олгогч байгууллага Х-ийн зүгээс хяналт хангалттай тавиагүй, шаардлагатай багаж хэрэгслээр хангаагүй /зориулалтын аппарат, зүү зэрэг байгаагүй/ нь уг гэмт хэрэг гарахад нөлөөлсөн болохыг тодорхойлсон байна.

Улмаар Х-ийн зүгээс хохирогч В /А-ийн эх/-д дээр дурдсан 17,702,200 төгрөгийн хохирлыг төлж барагдуулсан тул Иргэний хэргийн шүүхэд хандаж, Иргэний хуулийн 498.5 дахь хэсгийн дагуу Ү1 болон Ү2 нараас өөрт учирсан хохирлоо нэхэмжилсэн. Х нь тухайн нэхэмжлэлийг гаргахаасаа өмнө Ү1-ээс 3,207,000 төгрөгийг, Ү2-оос 5,441,970 төгрөгийг тус тус цалингаас нь суутган авсан байсан.

Шүүхийн шийдвэр:

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэгт заасныг баримтлан Ү2-оос 764.030 төгрөг, Ү1-ээс 2,999.200 төгрөгийг тус тус гаргуулж шийдвэрлэсэн¹⁵.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс магадлал гаргаж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн¹⁶. Нэхэмжлэгчийн зүгээс хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан.

Улсын Дээд шүүхийн зүгээс тогтоол гаргаж, шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Үндэслэлийг дурдахдаа “шүүхийн 2012 оны 407 дугаар шийтгэх тогтоолд 17,702,000 төгрөгийн хохирол учрахад Х өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг хангалттай гүйцэтгээгүйгээс гадна эмнэлгийн зүгээс эмч нарыг эмчилгээний зориулалтын багаж хэрэгслээр хангаагүй нөхцөл байдал нөлөөлсөн талаар дурдсан тул эмнэлгийн зарим үйл ажиллагааны улмаас А-д хохирол учирсан гэж үзнэ. Хохирогчид гэм хор учирсан нь эмнэлгийн буруугаас болоогүй гэдгийг нэхэмжлэгч нотолж чадаагүй тул хохирогчид учирсан хохирлыг зохигчид хамтран хариуцна. В-д учирсан 17,702,000 төгрөгийн хохирлын 50 хувь буюу 8,851,000 төгрөгийг эмнэлэгт, үлдэх 50 хувь буюу 8,851,000 төгрөгийг эмч нарт хариуцуулах нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийг зөрчихгүй тул Х-ийн нэхэмжлэлээс 8,851,000 төгрөгийн шаардлага үндэслэлгүй байна” гээд Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.3, 498.5 дахь хэсгийг баримтлан Ү1-ээс 1,218,500 төгрөг, Ү2-ын зүгээс гаргасан сөрөг нэхэмжлэлээс 1,016,470 төгрөгийг гаргуулж шийдвэрлэсэн байна¹⁷.

Шүүхийн шийдвэрийн талаар:

Тус шийдвэрийн хувьд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилладаг ажиллагсдынхаа гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад учирсан гэм хорын хохирлыг ажил олгогч байгууллагын зүгээс Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн дагуу хариуцан нөхөн төлсөн тохиолдолд Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.5 дахь хэсгийн дагуу тухайн гэм буруутай ажиллагсдаас өөрт учирсан хохирлыг шаардсантай холбогдох маргааны талаар шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэрийн хувьд Улсын дээд шүүхийн зүгээс ажил олгогч болон ажилтны аль аль нь тухайн хохирол учрахад оролцоотой байсан буюу гэм буруутай болохыг эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт үндэслэн тодорхойлж, ийм тохиолдолд Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.3 дахь хэсгийн дагуу аль аль нь

¹⁵ Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2015 он 10 сарын 20-ны өдөр, Дугаар 102/ПШП2015/06461

¹⁶ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2016 он 02 сарын 05-ны өдөр Дугаар 250

¹⁷ Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2016 он 04 сарын 19-ны өдөр, Дугаар 001/ХТ2016/00385

хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй болохыг тайлбарласнаараа ихээхэн онцлог бүхий шийдвэр болно.

Харин 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн хувьд ажил олгогчийн өөрийн нь гэм бурууг зайлшгүй шалган тогтоох шаардлагагүй болохыг уг шийдвэрээс болон бусад холбогдох шийдвэрээс тодорхойлох бүрэн боломжтой байна¹⁸. Өөрөөр хэлбэл ажил олгогч нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн дагуу хариуцлага хүлээдэггүй бөгөөд ажил олгогч нь бусдын үйлдэл /эс үйлдэхүй/-ийн өмнөөс хариуцлага / vicarious liability, liability for the acts of others/ хүлээдэг гэж тайлбарлах боломжтой байна. Энэ нь Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн зохицуулалтыг гэм буруу гэх урьдчилсан нөхцөлийг ашиглажгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд суурилсан хэм хэмжээ болохыг нь бүрэн илтгэнэ. Гэхдээ яагаад заавал ажил олгогч нь ажиллагсдынхаа гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусад учирсан гэм хорын хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй болохыг тайлбарлах шаардлага бий. Мэдээж хэрэг гэм бурууг үндэслэхгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмын хүрээнд авч үзвэл ажил олгогч /байгууллага/ нь тухайн ажилтны үйл ажиллагааны үр дүнд ашиг олж байгаа учраас хариуцлага хүлээх шаардлагатай гэх үндэслэл, эсхүл ажил олгогч /байгууллага/ нь ажиллагсадтай харьцуулахад хохирлыг нөхөн төлөх боломж, бололцоо ихтэй гэх үндэслэл, гэм бурууг үндэслэхгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд тулгуурласан нь хохирогчийн хувьд нотолгооны хувьд илүү хялбар нөхцөл байдлыг бий болгодог гэх бодлогын шинжтэй үндэслэл зэргийг энд дурдаж болно¹⁹.

Иргэний хуулийн 497-р зүйлийн 497.3 дахь хэсгийн хувьд гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон тохиолдолд тэдгээр нь хамтран үүрэг гүйцэтгэгчийн хувиар хохирлыг нөхөн төлөх асуудлыг зохицуулдаг. 497-р зүйлийн 497.1 /497.2/ дэх хэсгийн хувьд аквиваленцийн онолоор буюу “үйлдэл байгаагүй бол үр дагавар үүсэхгүй байх байсан уу” гэх шалгуур /нөхцөлт шалгуур/-аар шийдвэрлэдэг бол 497-р зүйлийн 497.3 дахь хэсгийн хувьд хэд хэдэн этгээдийн үйлдэл байх тул нэг үйлдлийн хувьд ашиглагддаг аквиваленцийн онолыг шалгуур болгон хэрэглэх боломжгүй хэмээн тайлбарлах боломжтой. Тиймээс гэм хор учруулахад оролцсон хэд хэдэн этгээдийн үйлдлийн талаар субъектив болон объектив харилцан хамаарал бий эсэхийг тогтоох шаардлага үүсдэг. Тус шүүхийн шийдвэрийн хувьд ажил олгогч эмнэлгийн хувьд шаардлагатай багаж хэрэгслээр хангаагүй, хяналт тавиагүй харин ажилтан болох эмч нар нь үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй болохыг хоорондоо объектив харилцан хамаарал бүхий үйлдэл гэж дүгнэсэн байх боломжтой байна.

III. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА /2002 ОНЫ ИРГЭНИЙ ХУУЛЬ/

Тус хэсэгт эхлээд өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 оны Иргэний хуулийн 498-р зүйлийн зохицуулалтын онцлогийг харьцуулалт /босоо/ хийх замаар тодорхойлохыг оролдох болно. Дараагаар нь зарим улсын зохицуулалт болон онолын тайлбар, судлаачдын үзэл баримтлалыг өөрийн орны зохицуулалттай харьцуулан /хэвтээ харьцуулалт/ судална.

Одоогийн 2002 оны Иргэний хуулийн 498-р зүйлийн хувьд өмнөх буюу 1963 болон 1994 оны Иргэний хуулийн зохицуулалтаас ялгаатай хэд хэдэн онцлогтой. Жишээ нь 498-р зүйлийн 498.3 дахь хэсэг, 498-р зүйлийн 498.5 дахь хэсгийн зохицуулалтыг энд дурдаж болно. Тэгвэл эдгээр шинээр хуульчлагдсан хэм хэмжээний талаар 2002 оны Иргэний хуулийг батлах үед тодорхой хэмжээнд судалгааны зорилгоор ашиглагдаж байсан бусад орны хуулийн зохицуулалттай харьцуулан үзье.

ОХУ-ын Иргэний хуулийн 1068-р зүйлийн 1068.1 дэх хэсэгт “Хуулийн этгээд эсхүл хувь хүн нь тэдгээрийн ажилтан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг хүлээнэ. Тус бүлгийн зохицуулалтын хүрээнд хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуульд заасан гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа хувь хүн нь тухайн ажиллаж байгаа хуулийн этгээд эсхүл хувь хүний удирдлага, аюулгүй ажиллагааны журмын дагуу ажил үүргээ гүйцэтгэх шаардлагатай бол ажилтанд тооцогдоно” гэж зохицуулсан байна. Урьдчилсан нөхцөлийн хувьд юун түрүүнд бусдад гэм хор учруулсан тухайн этгээд нь ажил олгогч этгээдийн ажилтан нь байх, хоёрдугаарт

¹⁸ Жишээ нь Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018 он 12 сарын 13-ны өдөр, Дугаар 01837-г энд дурдаж болно.

¹⁹ PAULA GILIKER, VICARIOUS LIABILITY IN TORT: A COMPARATIVE PERSPECTIVE, CAMBRIDGE, 228 (2010)

гэм хор учруулахдаа ажил үүргээ гүйцэтгэж байсан байх, гуравдугаарт ажилтан нь ерөнхий зохицуулалтын хүрээнд хариуцлага хүлээхээр байх гэсэн нөхцөлийг хангасан байх шаардлагатай²⁰. ОХУ-ын хувьд ажил олгогч этгээд нь эдгээр нөхцөл хангагдсан тохиолдолд өөрийн гэм буруугүй болохыг нотлох замаар хариуцлага хүлээхгүй байх боломжгүй буюу гэм бурууг үндэслэхгүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим /strict liability/-д суурилсан хэм хэмжээг хуульчилсан онцлогтой бөгөөд ажил олгогч нь Иргэний хуулийн 1081-р зүйлийн дагуу ажилтнаасаа өөрт учирсан хохирлоо шаардах боломжтой²¹. Гэвч ОХУ-ын Иргэний хуулийн хувьд санаатай болон илт болгоомжгүй гэх байдлаар уг шаардах эрхийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт тогтоогоогүй байна. Өмнө дурдсанчлан энэ нь 1961 оны ЗСБНХУ болон холбооны улсуудын иргэний хуулийн талаарх үндсэн зарчмын 88-р зүйлийн 88.3 дахь хэсгийн зохицуулалтаас улбаатай. Тиймээс 2002 оны Иргэний хууль батлагдсанаар 1961 оноос уламжлагдсан тогтолцооноос өөр агуулга бүхий хэм хэмжээг анхлан хуульчилсан гэж дүгнэх боломжтой байна.

Тэгвэл ямар орны хуулийн зохицуулалт манай улсын 2002 оны Иргэний хуулийн 498-р зүйлийн зохицуулалтад тодорхой нөлөөг үзүүлсэн бэ гэдгийг судлах шаардлагатай байна. Иймд тус зорилгоор Гүрж улсын Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг харьцуулж үзье. Гүрж улсын Иргэний хуулийн 997-р зүйлд “Аливаа этгээд нь түүний ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа өөрийн хууль бус үйлдлээр бусдад гэм хор учруулсан бол нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Ажилтан нь гэм буруугүй тохиолдолд уг хариуцлага үүсэхгүй” гэж, 1005-р зүйлийн 1005.1 дэх хэсэгт “Аливаа албан тушаалтан өөрийн албаны үүргийг зөрчиж, санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр бусдад гэм хор учруулсан бол төр, тухайн албан тушаалтны харьяалагдах төрийн байгууллага нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Хэрэв санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хорыг учруулсан бол албан тушаалтан болон төр нь хохирлыг нөхөн төлөх үүргийг хамтран хариуцна” гэж, 1005.2 дахь хэсэгт “Хэрэв хохирогч нь санаатай буюу илтэд болгоомжгүй хандаж хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагааны дагуу хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүй бол хохирлыг нөхөн төлөх хариуцлага үүсэхгүй” гэж тус тус хуульчилжээ²².

Гүржийн Иргэний хуулийн 997-р зүйл дэх “аливаа этгээд” гэдэгт хуулийн этгээд төдийгүй хувь хүн хамаарах бөгөөд “бусдад” гэдэгт тухайн ажил олгогч этгээдийн ажилтан бус бусад бүх этгээдийг хамааруулан ойлгодог байна²³. Түүнчлэн тус улсын Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарт дурдсанаар бол хохирогч нь тухайн тохиолдолд ажил олгогчийн эсрэг шаардах эрхтэй бөгөөд ажил олгогч хохирлыг нөхөн төлсөн бол гэм буруутай ажилтнаас өөрт учирсан хохирлоо шаардах эрхийг ерөнхий зохицуулалтын хүрээнд олгосон байна²⁴. Урьдчилсан нөхцөлийн хувьд 1. Хохирол, 2. Хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/, 3. Хохирол болон хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/ хоорондын шалтгаант холбоо, 4. Ажилтны гэм буруу, 5. Ажил олгогч болон гэм хор учруулсан ажилтан хоорондын хөдөлмөрийн харилцаа гэх нөхцөлтэй байна²⁵.

Монгол улсын Иргэний хуулийн 498-р зүйлийн зохицуулалттай харьцуулахад Гүрж улсын Иргэний хуулийн 997-р зүйлд ажилтан нь гэм буруугүй болох нь нотлогдвол хариуцлага хүлээхгүй байх бөгөөд 498.5 дахь хэсэгтэй адил агуулга бүхий хязгаарлалтыг тогтоогоогүй байна. Гэвч Гүрж улсын Иргэний хуулийн 1005-р зүйлийн 1005.1 дэх хэсэгт “санаатай буюу илтэд болгоомжгүй” үйлдлээр бусдад гэм хор учруулсан тохиолдолд л зөвхөн төр, төрийн байгууллага өөрийн албан хаагчийн бусдад учруулсан гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээх боловч, хамтран үүрэг гүйцэтгэгч болохоор хуульчилсан нь ихээхэн онцлогтой байна. Манай улсын хувьд 498-р зүйлийн 498.2, 498.4 төдийгүй, 498-р зүйлийн 498.1 дэх хэсгийн хувьд ажил олгогч нь гэм буруутай ажилтнаас өөрт учирсан хохирлоо шаардах тохиолдолд “шууд санаатай буюу илтэд болгоомжгүй” гэх байдлаар

²⁰ CHRISTOPHER OSAKWE, RUSSIAN CIVIL CODE PARTS 1-3: TEXT AND ANALYSIS TRANSLATION AND COMMENTARY, 240 (2008)

²¹ *Ibid*

²² <https://www.matsne.gov.ge/en/document/view/31702?impose=original&publication=110> [Сүүлд үзсэн: 2021.02.10]

²³ Avtandil Natsvaladze, *Characteristic of Vicarious Liability*, EUROPEAN SCIENTIFIC JOURNAL, 81 (2016)

²⁴ *Ibid*

²⁵ *Ibid*

хязгаарлалтыг тогтоож өгсөн бөгөөд яагаад, ямар зорилгоор ийм хязгаарлалтыг төрийн албан хаагч төдийгүй бусад бүхий л ажилтны хувьд тогтоосон нь тодорхойгүй байна.

498-р зүйлийн 498.5 дахь хэсгийн талаар судлаачид “хуульд заасан өөрт учирсан хохирол түүний хэмжээг тухайн байгууллагын бусдад нөхөн төлсөн төлбөрийн дүнгээр тодорхойлогдох бөгөөд гэм хор учруулсан этгээдийн гэм буруугийн хэлбэр нь хохирлын хэмжээнд хамаарахгүй” гэж²⁶, “нэгэнт илт болгоомжгүй гэм буруугийн хэлбэрийг хууль тогтоогч тусгасан болохоор шууд бус санаатай хэлбэр мөн адил албан хаагчийн нөхөх хариуцлагыг үндэслэнэ” гэж²⁷ тус тус тайлбарласан байна.

ХБНГУ-ын хувьд Иргэний хуулийн 831-р зүйлийн 831.1 дэх хэсэгт “Бусдыг өөрийн ажил үүргийг гүйцэтгэхэд хөлсөлсөн этгээд нь тухайн ажилтан өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцад бусдад хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Ажил олгогч нь ажилтныг сонгон томилох болон ажил олгогч нь тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлтгэх, ажил үүргийн гүйцэтгэлийг удирдан хянах үүрэгтэй тохиолдолд тухайн бэлтгэх болон удирдан хянахдаа зохих анхаарал болгоомжтой байсан эсхүл зохих анхаарал болгоомжтой хандсан ч хохирол учрах байсан бол хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэхгүй” гэж зохицуулсан байна. Харин 839-р зүйлийн 839.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч нь гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан тушаалын үүргээ санаатай буюу болгоомжгүй гэм буруутайгаар зөрчсөн тохиолдолд төрийн албан хаагч нь гуравдагч этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Төрийн албан хаагч нь болгоомжгүй гэм буруутайн улмаас хариуцлага хүлээх тохиолдолд хохирогч нь зөвхөн бусад аргаар хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй тохиолдолд л төрийн албан хаагч нь хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ” гэж зохицуулсан бөгөөд төрийн албан хаагчийн хувьд 831-р зүйлд заасантай адил өөрийн анхаарал болгоомжтой байсан эсэхийг нотлох замаар хариуцлага хүлээхгүй байх боломж олгогдоогүйгээрээ онцлогтой.

Гэхдээ ХБНГУ-ын Иргэний хуулийн 839-р зүйлийн хувьд зөвхөн төрийн албан хаагч (Beamter)-ийн талаар зохицуулсан хэм хэмжээ бөгөөд 839-р зүйлийн 839.1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэрээр дамжин төр хохирлыг хохирогчийн өмнө хариуцан арилгах үүрэг хүлээх боломжтой байдаг. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 34-р зүйлд “Аливаа этгээд нь өөрт нь шилжүүлсэн нийтийн эрх зүйн эрхийг хэрэгжүүлэх явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албаны үүргээ зөрчсөн тохиолдолд зарчим ёсоор тухайн этгээдийг ажиллуулдаг төр эсхүл байгууллага хариуцлага хүлээнэ. Санаатай эсхүл илт болгоомжгүй гэм буруутай тохиолдолд өөрт учирсан хохирлоо тухайн этгээдээс шаардах явдлыг хориглохгүй. Хохирол нөхөн төлүүлэхээр болон өөрт учирсан хохирлоо тухайн этгээдээс шаардах тохиолдолд ердийн шүүхэд нэхэмжлэл гаргах явдлыг хориглож болохгүй” гэж зохицуулсан нь уг 839-р зүйлийн зохицуулалттай хамтатган хэрэглэгддэг. Гэхдээ Үндсэн хуулийн 34-р зүйлийн зохицуулалт төр болоод төрийн байгууллага нь өөрт учирсан хохирлоо тухайн төрийн албан хаагчаас шаардах эрхийг үндэслэсэн хэм хэмжээнд тооцогддоггүй²⁸. Заавал өөр бусад хуулийн зохицуулалттай хамтатган хэрэглэх шаардлагатай. Үндсэн хуулийн 34-р зүйлийн хувьд “аливаа этгээд” гэх нэр томъёог ашигласан нь төрийн албан хаагчаар хязгаарлалгүй субъектийн хүрээг илүү өргөн хүрээтэй хуульчилсан онцлогтой²⁹. Үүнтэй холбоотойгоор эрх шилжүүлэн авсан этгээдийн хувьд хариуцлагыг хэрхэн шийдвэрлэх вэ гэсэн асуулт судлаачдын дунд үүссэн байдаг. Өмнө дурдсанчлан Үндсэн хуулийн 34-р зүйлийн зохицуулалт нь бие даасан шаардах эрхийн үндэслэлд тооцогдохгүй бөгөөд холбооны төрийн албан хаагчийн хувьд жишээ нь Холбооны төрийн албан хаагчийн тухай хууль (Bundesbeamtenengesetz, BBG)-ийн 75-р зүйлийг хамтатган хэрэглэх шаардлагатай³⁰.

Харин Япон улсын хувьд Иргэний хуулийн 715-р зүйлд дараах байдлаар зохицуулсан байдаг.

²⁶ Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхим, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг) IV, УБ, 2016, 61 дэх тал

²⁷ Б.Буянхшиг, Иргэний эрх зүйн тусгай анги (анхны хэвлэл), УБ, Соёмбо принтинг, 2010, 369 дэх тал

²⁸ Michael Ahrens. Staatshaftungsrecht. 3 Aufl. C.F.Müller, 2018. S.7

²⁹ Ebd.

³⁰ Ebd.

715.1. Тодорхой аж ахуйн үйл ажиллагааны төлөө бусдыг ажиллуулж байгаа этгээдийн хувьд ажилтан нь тухайн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд ажил үүргээ гүйцэтгэхдээ гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол түүний хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Гэвч ажил олгогч нь ажилтныг сонгон томилох болон аж ахуйн үйл ажиллагааг хянан удирдах талаар тодорхой анхаарал болгоомжтой байсан бол эсхүл тодорхой анхаарал болгоомжтой байсан хэдий ч хохирол учрах байсан бол хариуцлага хүлээхгүй.

715.2. Ажил олгогчийн оронд аж ахуйн үйл ажиллагааг хянан удирдах этгээд ч мөн адил өмнөх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

715.3. Өмнөх 2 дахь хэсгийн зохицуулалт нь ажил олгогч эсхүл хянан удирдах эрхтэй этгээд нь ажилтны эсрэг өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах явдлыг хориглохгүй.

Энэхүү 715-р зүйлийн хувьд 1. Ажил олгогч, ажилтны харилцаа, 2. Ажил үүргээ гүйцэтгэхдээ, 3. Ажилтны хохирол учруулсан үйлдэл, 4. Хариуцлагыг үгүйсгэх нөхцөл хангагдахгүй байх гэсэн урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд хохирогч нь ажил олгогчоос хохирлоо шаардах эрхтэй болдог³¹. Япон улсын хууль тогтоогчдын хувьд энэхүү зохицуулалт нь ажил олгогч нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас хариуцлага хүлээх тохиолдол /自己責任/ гэж үзэж байсан боловч, дараагаар нь бусдын үйлдлийн өмнөөс хариуцлага хүлээх тохиолдол /代位責任/ гэж тайлбарлах хандлага хүчтэй дэмжигдэж, практикт 715-р зүйлийн 715.1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн дагуу хариуцлагыг үгүйсгэж шийдвэрлэх нь бараг үгүй болсон гэж судлаачид дүгнэдэг³².

Харин төрийн албаны хариуцлагын хувьд Төрийн албаны хариуцлагын тухай хууль /国家賠償法/-ийн дагуу шийдвэрлэдэг бөгөөд уг хуулийн 1-р зүйлийн 1.1 дэх хэсэгт “Төр болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн нийтийн эрх зүйн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг төрийн албан хаагч нь өөрийн албан үүргээ гүйцэтгэх явцдаа санаатай эсхүл болгоомжгүй гэм буруутайгаар хууль бусаар бусдад хохирол учруулсан тохиолдолд төр болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ” гэж, тус хуулийн 1.2 дахь хэсэгт “Өмнөх хэсэгт заасан тохиолдлын хувьд төрийн албан хаагч нь санаатай эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай байсан бол төр болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь тухайн төрийн албан хаагчаас өөрт учирсан хохирлоо шаардах эрхтэй” гэж тус тус зохицуулжээ. Уг хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт төр болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн зүгээс гэм буруутай төрийн албан хаагчийн эсрэг өөрт учирсан хохирлоо шаардах эрхийг “санаатай эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай”-аар бусдад хохирол учруулсан тохиолдлоор хязгаарласан шалтгаан, үндэслэлийн талаар судлаачид анх хуулийг батлах үед болгоомжгүй гэм буруутай бүхий л тохиолдолд төрийн албан хаагч нь өөрийн бусдад учруулсан хохирлоо төр болон харьяалах нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хандан нөхөн төлөх болбол өөрийн албан үүргээ гүйцэтгэхэд маш хүнд дарамт учруулах бөгөөд энэ нь албан үүргээ бүрэн гүйцэтгэхэд саад учруулна гэж үзэж байсантай холбоотой хэмээн тайлбарласан нь бий³³. Мөн зарим судлаачийн хувьд “төрийн албан хаагчийн зүгээс бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах зохицуулалт байх нь зүйтэй. Учир нь санаатай буюу илтэд болгоомжгүй гэм буруутай тохиолдолд хүртэл хохирлыг хуваарилах чиг үүргийг шийтгэх, хууль бус үйлдлийг таслан зогсоох чиг үүргээс тэргүүнд тавих шаардлагагүй юм” хэмээн саналаа илэрхийлсэн нь бий³⁴.

IV. Дүгнэлт, санал

Тус өгүүллээр Монгол улсын Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар түүхчилсэн болон харьцуулсан эрх зүйн товч судалгааг хийлээ. Судалгааны хүрээнд 1963 болон 1994 оны Иргэний хуулийн 319, 378-р зүйлийн талаар хуучнаар ЗХУ-ын холбогдох хуулийн зохицуулалттай, улмаар 2002 оны Иргэний хуулийн 498-р зүйлийн талаар Гүрж улсын Иргэний хуулийн холбогдох зохицуулалт, ОХУ болон ХБНГУ, Япон улсын Иргэний хуулийн зохицуулалттай тус тус харьцуулан судаллаа. Түүхчилсэн болон харьцуулсан эрх

³¹ 内田貴、民法II債権各論（第3版）、東京大学出版会、2014年、483頁。

³² 同書、484頁。

³³ 古崎慶長、国家賠償法、有斐閣、1971年、202頁。

³⁴ 宇賀克也、国家補償法、有斐閣、1997年、88頁。

зүйн судалгааг хийх улсыг сонгоходоо Монгол улсын 2002 оны Иргэний хуулийн 498-р зүйлийн зохицуулалтыг боловсруулахад тодорхой хэмжээнд нөлөө үзүүлсэн эсэхийг гол шалгуур болголоо.

Уг судалгааны хүрээнд манай улсын 1963 болон 1994 оны Иргэний хуулийн зохицуулалт нь хуучнаар ЗХУ-ын 1961 оны ЗСБНХУ болон холбооны улсуудын иргэний хуулийн талаарх үндсэн зарчим, 1964 оны Иргэний хуульд тулгуурлан боловсруулагдсан болохыг тодорхойллоо. Гэвч тухайн үеийн зохицуулалтын хувьд одоогийн Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.3 болон 498.5 дахь хэсэгтэй адил агуулга бүхий хэм хэмжээг хуульчлаагүй байна. Харин Гүрж, ХБНГУ, Япон улсын Иргэний хууль, Үндсэн хууль, Төрийн албаны хариуцлагын тухай хууль, Холбооны төрийн албан хаагчийн тухай хуулийг харьцуулан үзэхэд зөвхөн төр болон төрийн байгууллагын хувьд өөрийн төрийн албан хаагчийн бусдад учруулсан гэм хорын хохирлыг нөхөн төлсөн бол тухайн гэм буруутай төрийн албан хаагчаас өөрт учирсан хохирлоо шаардах тохиолдолд л “санаатай буюу илтэд болгоомжгүй” гэх байдлаар хязгаарлалт тогтоосон байна. Гүрж улсын хувьд ялгаатай нь төр, төрийн байгууллага нь төрийн албан хаагч санаатай буюу илтэд болгоомжгүй гэм буруутай үйлдлээрээ бусдад гэм хор учруулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээхээр зохицуулсан бөгөөд төр болон төрийн байгууллага, төрийн албан хаагч нь хамтран үүрэг гүйцэтгэгч байхаар хуульчилжээ. Энэ нь төрийн албан хаагчийн зүгээс албан үүргээ гүйцэтгэхдээ ямар нэгэн дарамт, хариуцлага хүлээх болов уу гэж эмээх явдлаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар хязгаарлах нөлөө /chilling effect/ үзүүлэхээс зайлсхийх зорилготой гэж дүгнэх боломжтой байна.

Гэвч манай улсын Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.5 дахь хэсэгт хувийн эрх зүйн субъект төдийгүй нийтийн эрх зүйн субъектийн хувьд нэгэн адил байдлаар зөвхөн “шууд санаатай буюу илтэд болгоомжгүй” үйлдлээр ажилтан, албан хаагч нь бусдад гэм хор учруулсан тохиолдолд ажил олгогч, төрийн зүгээс өөрт учирсан хохирлоо шаардах боломжийг олгохоор хуульчилсан бэ гэдэг нь тодорхойгүй байна. Жишээ нь ажил олгогч этгээдийн хувьд тухайн гэм хор учирсан явдалд огт гэм буруугүй нөхцөлд ч гэсэн тухайн гэм буруутай ажилтан нь зөвхөн “шууд санаатай буюу илтэд болгоомжгүй” байсан тохиолдолд л өөрт учирсан хохирлоо түүнээс шаардах боломж олгогдож байна. Яг ийм шалтгааныг үндэслэвэл ХБНГУ, Япон улстай адил байдлаар буюу ажил олгогч нь өөрийгөө гэм буруугүй болохыг нотолсон тохиолдолд ажилтныхаа өмнөөс хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээхгүй байх, эсрэгээрээ нотолж чадаагүй тохиолдолд ажилтныхаа бусдад учруулсан гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээх байдлаар шийдвэрлэх нь илүү зохистой зохицуулалт гэж дүгнэх боломжтой байна.

Үүний сацуу тус өгүүллийн хүрээнд судалсан шүүхийн шийдвэрийн хувьд ажил олгогч болон ажилтны хувьд 497-р зүйлийн 497.3 дахь хэсгийг хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Хэрвээ 498-р зүйлийн зохицуулалт нь ажил олгогч /төр/-ийн хувьд өөрийн ажилтны гэм буруутай үйлдлийн улмаас бусдад учирсан гэм хорыг түүний оронд нөхөн төлөх үүрэг хүлээх /vicarious liability/ буюу өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас бус бусдын гэм буруутай үйлдлийн улмаас оронд нь хариуцлага хүлээж буй тохиолдолд хамаарна гэж тайлбарлавал тухайн гэм буруутай ажилтнаасаа өөрт учирсан хохирол /бусдад нөхөн төлсөн хохирол/-оо бүхэлд нь шаардах эрхтэй байх нь мэдээжийн хэрэг. Гэвч 498-р зүйлийн зохицуулалт нь бусдын гэм буруутай үйлдлийн улмаас учирсан гэм хорыг оронд нь хариуцах зарчимд тулгуурласан боловч, тус зохицуулалтын дагуу тэрээр өөрийн гэм буруугаас үүдэлтэй гэм хорыг мөн нэгэн адил нөхөн төлөхийг хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэх боломжтой байна.

Тиймээс ажил олгогч болон ажилтан хоорондын дотоод харилцаан дахь хохирлыг хуваарилах асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь маш чухал асуудал болно. Манай улсын хувьд шүүхийн практикт энэ тохиолдолд 497-р зүйлийн 497.3 дахь хэсгийг хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэх боломжтой. Гэвч бүхий л тохиолдолд “шууд санаатай буюу илтэд болгоомжгүй” гэх байдлаар ажил олгогч ажилтнаасаа өөрт учирсан хохирлоо шаардах эрхийг хязгаарлах нь хохирлыг шударгаар хуваарилах боломжийг үгүйсгэх эрсдэлтэй гэж миний бие үзэж байна. Иймд ямар тохиолдолд буюу ямар ажил үүрэг, албан үүрэг

гүйцэтгэж буй тохиолдолд, ямар салбарын хувьд хязгаарлалтыг тогтоох, хэрхэн, ямар шалгуураар тогтоох талаар нарийвчлан судлах зайлшгүй шаардлагатай байна. Магадгүй бусад ажил үүрэг, албан үүрэгтэй харьцуулахад илүү их аюул дагуулдаг буюу эрсдэл ихтэй салбарын хувьд хязгаарлалтыг тодорхой шалгуураар тогтоох нь зохистой болов уу. Харин бусад салбарын хувьд хохирлыг шударгаар хуваарилах зорилгын хүрээнд гэм хор учрахад ажил олгогч болон ажилтан тус бүрийн оролцоо ямар түвшинд байсныг тогтоох замаар буюу ерөнхий, хийсвэр нөхцөлөөр дамжуулан шийдвэрлэх нь зохистой биз ээ.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэлээр:

- Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн тусгай анги (анхны хэвлэл)*, УБ, Соёмбо принтинг, 2010
- Т.Мөнхжаргал нар, *Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй*, УБ, Сутай дээд сургууль, 2005
- Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхим, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг) IV, УБ, 2016
- Р.Пүрэвбаатар, *Иргэний хуулийн 497 дугаар зүйлийг нотлох үүргийн онолын үүднээс тайлбарлах нь*, Шүүх эрх мэдэл сэтгүүл №3 (2018)
- БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1974 оны 12-р сарын 25-ны өдрийн 11/32-р тогтоол, Гэм хор учруулснаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практикийн зарим асуудлын тухай
- БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1989 оны 12-р сарын 22-ны өдрийн 42-р тогтоол, Гэм хор учруулснаас үүссэн маргааныг шийдвэрлэж байгаа шүүхийн практикийн тухай
- Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2015 он 10 сарын 20-ны өдөр, Дугаар 102/ШШ2015/06461
- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2016 он 02 сарын 05-ны өдөр Дугаар 250
- Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2016 он 04 сарын 19-ны өдөр, Дугаар 001/ХТ2016/00385
- Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018 он 12 сарын 13-ны өдөр, Дугаар 01837

Гадаад хэлээр:

- Основы гражданского законодательства Союза ССР и союзных республик от 8 декабря 1961г.
- Основы гражданского законодательства Союза ССР и союзных республик от 31 мая 1991г.
- Ярошенко К. Б. *Обязательства вследствие причинения вреда*, Гражданское право России.
- Часть вторая. *Обязательственное право: курс лекций*. отв. ред. О. Н. Садигов. М., 1997.
- WILLIAM E.BUTLER, *THE MONGOLIAN LEGAL SYSTEM: CONTEMPORARY LEGISLATION AND DOCUMENTATION*, (1982)
- Whitmore Gray, *Soviet Tort Law: The New Principles Annotated*. U.ILL. L.REV, (1964)
- PAULA GILIKER, *VICARIOUS LIABILITY IN TORT: A COMPARATIVE PERSPECTIVE*, CAMBRIDGE, (2010)
- CHRISTOPHER OSAKWE, *RUSSIAN CIVIL CODE PARTS 1-3: TEXT AND ANALYSIS TRANSLATION AND COMMENTARY*, (2008)
- Avtandil Natsvaladze, *Characteristic of Vicarious Liability*, EUROPEAN SCIENTIFIC

JOURNAL, (2016)

- *Michael Ahrens*. Staatshaftungsrecht. 3 Aufl. C.F.Müller, 2018.
- 内田貴、民法II債権各論（第3版）、東京大学出版会、2014年
- 古崎慶長、国家賠償法、有斐閣、1971年
- 宇賀克也、国家補償法、有斐閣、1997年

ARTICLE 498 OF THE CIVIL CODE: COMPARISON AND ANALYSIS

R.PUREVBAATAR

LL.M, Lecturer of Private Law Department, School of Law, NUM

ABSTRACT:

In this article author aims to identify the characteristics of article 498 of the Civil code by conducting horizontal comparison /with foreign countries/ and vertical comparison /historical comparison/, to discuss different opinions of researchers, and to express opinion by analyzing landmark court decision on the application of article 498 of the Civil code.

KEYWORDS:

Employer, Fault, Employee, Joint tortfeasor

НИЙТИЙН ДЭГ ЖУРАМ ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, БИЕЛҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛОХ НЬ: ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА



Н.Энхицэг

МУИС-ийн ХЗС-ийн докторант

ТОВЧЛОЛ:

Нийтийн дэг журам (*ordre public*) нь олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах түгээмэл үндэслэлүүдийн нэг юм. Өнөөг хүртэл энэ асуудал маргаантай, эдрээтэй асуудал байсаар иржээ. Учир нь олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд улс орнуудын шүүхүүд нийтийн дэг журмын талаар янз бүрийн хандлага баримталж ирсэнтэй холбоотой. Шүүхийн шийдвэрийн нийтлэг жишгээс үзвэл эрх зүйн системийн гол үнэт зүйлсээс гажсан тохиолдолд Нью Йоркийн конвенцын V (2)(b) заалтын дагуу нийтийн дэг журмын үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах хандлагатай байна. Энэ өгүүлэлд нийтийн дэг журмын тухай ойлголтын талаар товч авч үзэж, улс орнуудын шүүхийн практикт давамгайлж буй тайлбар, хандлагыг онцлох жишээнд үндэслэн толилуулна. Мөн олон улсын нийтийн дэг журам болон дотоодын нийтийн дэг журмын ялгаа буюу гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхэд дотоодын нийтийн дэг журмыг илүү явцуу утгаар түлхүү хэрэглэж буй талаар нэртэй эрдэмтэнд судлаачид, комментаторуудын бүтээлд үндэслэн өгүүлнэ. Улмаар Монгол Улсын хууль, тогтоомжид нийтийн дэг журам арбитрын шийдвэрийг биелүүлэх агуулгын үүднээс хэрхэн туссан хийгээд, уг асуудлын талаар эрдэмтэн, судлаачид хэрхэн үзэж буй талаар танилцуулна. Цаашид тус агуулгын хүрээнд Монгол Улс нийтийн дэг журмын талаарх ойлголт, баримтлах хандлагыг судалгаа шинжилгээний хүрээнд хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа талаар асуудал дэвшүүлнэ.

ТҮЛХҮҮР ҮГС:

Гадаадын арбитрын шийдвэр, Хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх, Нийтийн дэг журам, ойлголт, Олон улсын нийтийн дэг журам, Ёс суртахуун ба шударга ёсны үндсэн зарчим, Явцуу утгаар ойлгох нь

УДИРТГАЛ

Олон улсын арилжааны гэрээ, хэлэлцээр хийж буй талууд маргаантай асуудал гарвал арбитраар шийдвэрлүүлэх талаар хэлэлцэн тохирч, өөрсдийн сонгосон аль нэг олон улсын арбитрын байгууллага эсвэл түр арбитраар маргаанаа шийдвэрлүүлдэг нь олон улсад

тогтсон практик юм¹. Гэвч хэрэв арбитрын шийдвэрийг биелүүлэх үр дүнтэй механизм үгүй бол олон улсын арбитрын ач холбогдол юунд орших билээ. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх харилцааг зохицуулахаар Нэгдсэн Үндэстний Байгууллага (“НҮБ”) 1958 онд “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц”-ыг (цаашид “Конвенц” эсвэл “Нью Йоркийн конвенц” гэх)² баталсан нь олон улсын арилжааны эрх зүйд гарсан дэвшил болсон бөгөөд өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн олон талт хэлэлцээр юм. 1958 оны Нью-Йоркийн конвенц гэж олон улсад нэрлэгдэж хэвшсэн тус хэлэлцээр нь олон улсын бизнесийн хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтын дүнд бий болсон бөгөөд “олон улсын арбитрын тулгын чулуунд” тооцогддог³. Өдгөө 167⁴ улс нэгдэн ороод байна.

Нью Йоркийн конвенцын хэлэлцэн тохирогч улсуудад гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх ажиллагаа шууд автоматаар хэрэгжих үү гэвэл хараахан тийм биш. Учир нь Нью Йоркийн конвенцын V зүйлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзаж болох хэд хэдэн үндэслэлийг заасан⁵. Тэдгээр үндэслэлүүдээс хамгийн эдрээтэй гэж болох нэг үндэслэл бол “*public policy (англиар), ordre public (францаар), публичный порядок (оросоор)*” буюу “нийтийн дэг журам” юм. Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх улсын шүүх нь арбитрын шийдвэрийг нийтийн дэг журам зөрчсөн гэж үзсэн бол тухайн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болохоор Нью Йоркийн конвенцын V (2)(b) заалтад заасан. Эл үндэслэл НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссын (“ЮНСИТРАЛ”) Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн (“Загвар хууль”) 36 дугаар зүйлд⁶ тусгалаа олсон.

Дээр эдрээтэй гэсний учир нь олон улсын арбитрын ажиллагааны практикт “нийтийн дэг журам” гэсэн ойлголттой холбоотой ялгаатай чиг хандлагыг үндэсний шүүхүүд баримталж ирсэн явдал, энэ хэрээр арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах үндэслэл болох нийтийн дэг журам нь онол, практикийн хүрээнд судалгааны сэдэв байсаар иржээ. Хэдийгээр улс, орнууд нийтийн дэг журмыг өөр өөрөөр

¹ Лондонгийн Queen Mary их сургуулийн Олон улсын арбитрын сургуулийн 2006-2020 онд хийсэн судалгаанд олон улсын арилжааны олон төрлийн үйл ажиллагаатай холбоотой маргааныг шүүхээс илүүтэй арбитраар илүү их шийдвэрлүүлсэн тухай эмпирик судалгаа харуулжээ. Тус судалгаатай <http://www.arbitration.qmul.ac.uk/> цахим хуудаснаас танилцаж болно. Энэхүү нийтлэлийн судалгааны хүрээнд 2021 оны 01 сарын 28-нд хамгийн сүүлд нэвтэрсэн.

² “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц” (1958 оны 06 сарын 10-нд батлагдаж, 1959 оны 07 сарын 07-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.) 330 UNTS 38, Бүртгэлийн №. 4739.

³ Guide to the Convention on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards, United Nations Commission on International Trade Law (UNCITRAL) Secretariat (2016), x 1; https://www.uncitral.org/pdf/english/texts/arbitration/NY-conv/2016_Guide_on_the_Convention.pdf.

⁴ 2018 онд Судан, Кабо Верде, 2019 онд Мальдив, 2020 онд Сиерра Леон, Сизэллис, Тонга, дөнгөж саяхан буюу 2021 оны 3 дугаар сарын 04-нд Малави улс 167 дахь орноор нэгдэн ороод байна. UNCITRAL-ын дараах вебсайтаас харна уу: https://uncitral.un.org/en/texts/arbitration/conventions/foreign_arbitral_awards/status2

⁵ Конвенцын V зүйл хоёр хэсэгт хуваагддаг. Эхний хэсэг буюу V (1) дэх хэсэгт шуларга ёсны үндсэн зарчмууд болон талуудын чөлөөт байдлын зарчмыг (*party autonomy*) хамгаалахтай холбоотойгоор шийдвэрийг биелүүлэхээс татгалзах таван үндэслэлийг тодорхойлсон. Үүнд: а) арбитрын хэлэлцээр байгуулсан талууд эрх зүйн чадамжгүй байх, эсхүл талууд арбитрын хэлэлцээр байгуулахдаа баримталсан буюу хэрэв үүнийг заах боломжгүй бол арбитрын шийдвэр гаргасан улсын хуулийн дагуу арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус байх, б) арбитрын томилох буюу хэргийг арбитраар хянан шийдвэрлэх талаар хариуцагч талд зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл хариуцагч тал нь бусад шалтгаанаар тайлбараа гаргаж өгч чадаагүй, (с) арбитрын хэлэлцээр буюу гэрээнд оруулсан арбитрын заалтын нөхцөлд тусгаагүй буюу түүнд заасан хэмжээнээс хэтэрсэн асуудлаар шийдвэр гаргасан, d) арбитрын ажиллагааны журам болон арбитрын бүрэлдэхүүнийг томилох ажиллагаа нь талуудын харилцан тохиролцсон хэлэлцээрийн дагуу яагаагүй, эсхүл ийм хэлэлцээр байгуулаагүй бол арбитрын шийдвэр гаргасан орны хуулийг зөрчсөн e) арбитрын шийдвэр талуудын хувьд заавал биелүүлэх хүчинтэй болоогүй эсхүл арбитрын шийдвэр гарсан улсад эсвэл тус улсын хуулийн дагуу эрх бүхий байгууллага арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон буюу үндэслэлийг гагцхүү шийдвэр биелүүлэхээс татгалзуулах хүсэлтэй талын хүсэлт, нотолгоонд үндэслэх ба шүүх өөрийн санаачилгаар ийм үндэслэл бий эсэхийг хянаагүй юм. Конвенцын V (2) зүйлд хэлэлцэн тохирогч улсуудад арбитрын шийдвэрийг нийтийн дэг журмыг зөрчсөн гэсэн үндэслэлээр хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзаж болох нэмэлт хоёр үндэслэлийг заасан. Тэрээр шийдвэр биелүүлэх улсын эрх бүхий байгууллага өөрийн санаачилгаар а) маргааны зүйл нь арбитраар шийдвэрлүүлэх зүйл байж болохгүй эсхүл б) арбитрын шийдвэр нь тухайн улсын нийтийн дэг журмыг зөрчиж байна гэж үзвэл татгалзах эрхтэй.

⁶ UNCITRAL Model Law on International Commercial Arbitration 1985 with amendments as adopted in 2006 (Model Law). Тус загвар хууль 1985 оны 06 сарын 21-нд батлагдаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей гишүүн улсууддаа 1985 оны 12 сарын 11-нд №40/72 тоот шийдвэрээр зөвлөмж болгосон.

тодорхойлж ирсэн хэдий ч шүүхийн нийтлэг жишиг эрх зүйн системийн гол үнэт зүйлээс хазайсан үед Нью Йоркийн Конвенцын V (2)(b)-д заасны дагуу нийтийн дэг журмын үндэслэлээр шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах хандлагатай байгаа ажээ (ЮНСИТРАЛ-ны Нарийн бичгийн дарга нарын газар). Тэрээр нийтийн дэг журмыг үндэслэх нь тухайн улсын эрх зүйн системийн хувьд хамгийн гол үндэс суурь болсон үнэт зүйлийг орхихгүйгээр арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх боломжгүй онцгой нөхцөлд ашиглах “хамгаалалтын хавхлага” хэмээн түгээмэл үздэг.

Энэхүү судалгааны өгүүлэлд Нью Йоркийн конвенцын хүрээнд нийтийн дэг журам зөрчсөн гэдэг үндэслэлээр гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах талаарх ерөнхий ойлголт болон тус үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзсан гадаад улс орнуудын шүүхийн практикийн зарим асуудлыг хөндөнө.

Олон улсын болон бүс нутгийн эрх зүйн баримт бичгүүд

Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхэд нийтийн дэг журмыг харгалзах эсэх талаар дараах олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон загвар хуульд тусгалаа олсон байна. Үүнд:

Нью Йоркийн конвенц

Нью Йоркийн конвенцод “нийтийн дэг журам” гэсэн үгийг дараах байдлаар V (2)(b) заалтад шууд заасан:

2. *Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх улсын эрх бүхий байгууллага дараах тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болно:*

(a) ...

(b) *арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх явдал нь тухайн орны “нийтийн дэг журамд”-д харшилж байвал.*

Панамын Конвенц

Олон Улсын Арилжааны Арбитрын Америкийн Улсуудын Конвенцыг (“Панамын Конвенц”) 1975 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Латин Америкийн улс орнууд болон АНУ зэрэг 19 улс орон гарын үсэг зурж нэгджээ. Тус конвенц нь Нью Йоркийн Конвенцын үзэл санааг дагаж мөрдсөн бөгөөд бүс нутгийн хүрээнд хэрэгжинэ. Панамын Конвенцын V(2) (b)-д Нью Йоркийн конвенцын V(2)(b) заалттай адил боловч нийтийн дэг журам гэсэн үгийн дараа “(*ordre public*)” гэж оруулсан байдаг⁷.

Шүүхийн хамтын ажиллагааны Арабын конвенц (Эр-Риад)

1983 оны Шүүхийн хамтын ажиллагааны Арабын конвенцын 37 дугаар зүйлд хэрэв арбитрчдын шийдвэр “тухайн шийдвэрийг биелүүлэх улсын Шариатын хууль, нийтийн дэг журам эсхүл ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн” бол арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзаж болно гэж заасан байна⁸.

Аммань Конвенц

1987 оны Арилжааны Арбитрын тухай Арабын Конвенцын 35 дугаар зүйлд зааснаар хэлэлцэн тохирогч улсын дээд шүүх арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд арбитрын шийдвэр нь гагцхүү нийтийн дэг журамтай (*public order*) зөрчилдсөн тохиолдолд татгалзаж болно гэж заажээ⁹.

Африкийн улсуудын бизнесийн эрх зүйг уялдуулах байгууллагын (OHADA) Арбитрын хуулийн нэгдсэн акт

2017 онд батлагдаж 2018 онд хүчин төгөлдөр болсон Африкийн улсуудын бизнесийн эрх зүйг уялдуулах байгууллагын Арбитрын хуулийн нэгдсэн актын 31 дүгээр зүйлд

⁷ Inter-American Convention on International Commercial Arbitration (B-35), Article 5.2.b. <https://treaties.un.org/doc/Publication/UNTS/Volume%201438/volume-1438-I-24384-English.pdf>

⁸ Riyadh Arab Agreement for Judicial Cooperation, 1983, Article 37.e. <https://www.refworld.org/docid/3ae6b38d8.html>

⁹ Arab Convention on Commercial Arbitration, 1987, хүчин төгөлдөр болсон огноо: 1992 оны 06 дугаар сарын 25. <https://www.jus.uio.no/english/services/library/treaties/11/11-05/arab-commercial-arbitration.xml>

арбитрын шийдвэр нь холбогдох тал-Улсын олон улсын нийтийн дэг журмыг илт зөрчсөн тохиолдолд л арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзана гэж заажээ.

ЮНСИТРАЛ-ын Загвар хууль

ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн 36(2)(b) заалтад Нью Йоркийн конвенцын зохицуулалттай ижил төстэйгөөр буюу арбитрын шийдвэрийг “тухайн улсын нийтийн дэг журамтай зөрчилдсөн” гэдэг үндэслэлээр хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзаж болох тухай заажээ¹⁰. ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийг баримталсан улс орнуудын хууль тогтоомжуудад мөн нийтийн дэг журмын үндэслэлээр татгалзах зохицуулалт агуулагдаж байдаг.

Мөн Загвар хуулийн 34(2)(b)(ii)-т нийтийн дэг журамд харшилж байна гэж үзвэл шүүх өөрийн санаачилгаар арбитрын шийдвэрийг хүчингүй болгож болох тухай туссан.

Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц (ICSID)

1965 оны Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц (“Вашингтоны конвенц”)–д шийдвэрийг биелүүлэхтэй холбоотойгоор нийтийн дэг журмыг эш татаагүй¹¹ бөгөөд хүчин төгөлдөр болсон Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхэд нийтийн дэг журмын үндэслэлээр хянан үзэхгүй ажээ¹². Францын Хяналтын шатны шүүх Societe “Ouest Africaine des Betons Industriels v. State of Senegal” хэрэгт “нийтийн дэг журам нь, олон улсын буюу аль нь ч байлаа, ICSID-ийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой ажиллагаанд шүүгч авч үзэх асуудал биш хэмээн ойлгомжтойгоор баталгаажуулжээ¹³. Гэхдээ, Вашингтоны конвенцын дагуу шийдвэрийг бүх тал заавал биелүүлэх үүрэгтэй боловч (Вашингтоны конвенцын 53.1 зүйл), улсын дархан эрхтэй холбоотой асуудал тухайн улсын хууль шийдвэрийг биелүүлэхэд хамаарна (Вашингтоны конвенцын 55 зүйл).

Талуудын чөлөөт байдлын зарчим ба нийтийн дэг журам

Талууд хэдийгээр олон улсын арилжааны арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцсон ч эцэст нь арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх асуудлаар холбогдох шүүхэд хандахад нийтийн дэг журмыг зөрчсөн гэдэг үндэслэлээр арбитрын шийдвэр биелэгдэхгүй байх асуудалтай тулгарч болно.

Нью Йоркийн конвенцын V(2) зүйлийн дагуу олон улсын арилжааны арбитрын практикт гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх үед тухайн шийдвэрийг биелүүлэх улсын нийтийн дэг журам зөрчигдөхөөр байвал эрх бүхий байгууллага буюу шүүх өөрийн санаачилгаар нийтийн дэг журмыг үндэслэн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах боломжтой юм.

Олон улсын арилжааны арбитра талууд арбитрын хэлэлцээрээр байнгын эсхүл түр арбитраар шийдвэрлүүлэх эсэх, арбитрадын тоо, арбитрын ажиллагааны журам, арбитрын хэлэлцээрт хэрэглэх хууль зэргээ харилцан тохиролцох эрхтэй. Энэхүү талуудын чөлөөт байдлын зарчмыг (*party autonomy*) баталгаажуулж Нью Йоркийн Конвенцын V(1) зүйлд талуудын арбитрын хэлэлцээрээр тохиролцсон тохиролцоог баримтлаагүйгээс үүдсэн үндэслэлээр арбитрын шийдвэрийн биелэлтийг татгалзуулах хүсэлт гаргах эрхийг заасан. Гэхдээ хэрэв арбитрын шийдвэр уг шийдвэрийг биелүүлэх улсын нийтийн дэг журмыг

¹⁰ ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн 36(2)(b) заалт.

¹¹ Улс Болон Гадаад Улсын Иргэний Хооронд Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх тухай Конвенц, <https://www.legalinfo.mn/law/details/1268>. Конвенцын хүрээнд 52 дугаар зүйлд шүүх нь эрх мэдлээ хэтрүүлсэн, шүүхийн гишүүн авлига авсан, хянан шийдвэрлэх ажиллагааны дэг ноцтойгоор зөрчигдсэн эсхүл шүүх шийдвэрээ шаардлагын хэмжээнд үндэслээгүй зэрэг шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг заасан байдаг ба эдгээр нь олон улсын нийтийн дэг журмын үндэслэл болдог.

¹² United Nations Conference on Trade and Development (UNCTAD), International Centre for Settlement of Investment Disputes, 2.9 Binding Force and Enforcement, training course modules, p.12; Christoph Schreuer, Interaction of International Tribunals and Domestic Courts in Investment Law in Contemporary Issues in International Arbitration and Mediation, p.85.

¹³ Cour de cassation, 11 June 1991, 2 ICSID Reports 337, 341; 29 ILM 1341 (1990)

зөрчсөн бол шүүх түүнийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах боломжтой байдаг нь талуудын эрх чөлөө хязгааргүй хэрэгжих зүйл биш болох нь харагдана. Өөрөөр хэлбэл, Нью Йоркийн конвенцын V зүйлийг бүхэлд нь харвал V(1) зүйлээр талуудын чөлөөт байдлын зарчмыг баримталсан байдаг бол¹⁴ V(2)(b) заалтад шүүх өөрийн санаачилгаар арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзаж болох нөхцөл заасан нь талуудын чөлөөт байдлын зарчмын хүрээ хязгаарыг илэрхийлж байна.

Ойлголт, ухагдахуун

Нийтийн дэг журам нь Нью Йоркийн конвенцод ганц хамаатай ойлголт биш бөгөөд олон улсын хувийн эрх зүйн зөрчилдөөний эрх зүйн хүрээнд судлаачдын хөнддөг нэг судлагдахуун юм¹⁵. Нийтлэг эрх зүйн системт улс орнуудын эрх зүйн үүднээс *public policy* буюу нийтийн дэг журмын тухай үзэл баримтлал Английн эрх зүйн системд арвантавдугаар зуунаас хүлээн зөвшөөрөгдөж, арваннаймдугаар зуунаас хэрэг маргаан шийдвэрлэхэд одооны хэрэглэж буй утга агуулгаар тайлбарлагдаж иржээ¹⁶. *Mitchel v. Reynolds* хэрэгт нийтийн дэг журмын талаарх үзэл баримтлалыг анх дурдсан бөгөөд нийтийн дэг журмыг тусдаа зарчим гэж үзжээ¹⁷. Мөн Английн шүүхийн 1853 онд гаргасан шийдвэрээр Английн Лордын танхим нийтийн дэг журмыг тодорхойлохдоо “нэг ч субъект олон нийтэд хор уршигтай, эсвэл нийтийн сайн сайхны эсрэг чиглэсэн үйлдлийг хуулийн хүрээнд хийж болохгүй гэсэн эрх зүйн зарчим” гэж үзсэн байна¹⁸. Иргэнлэг эрх зүйн системт улс орнуудын эрх зүйн системд *ordre public* -н тухай ойлголтын талаар арванесдүгээр зуунаас Савиньи (Savigny), Манчини Mancini (Mancini) зэрэг олон улсын хувийн эрх зүйн судлаачид хөндөж бичиж, улмаар Франц, Герман зэрэг улсуудын иргэний эрх зүйн хууль тогтоомж боловсруулах үед эрх зүйн системд *ordre public* судлагдахууны нэг сэдэв болж хөгжиж иржээ¹⁹. Тэрчлэн, нийтийн дэг журам нь тогтсон нэг ойлголт гэхээс илүүтэй эрх зүйн системийн хөгжил болон эрх зүйн сэтгэлгээний болон нийгмийн хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой, цагийн аясаар уялдан хувьсан өөрчлөгдөж болох ойлголт болохыг ч мөн судлаачид гарган тавьсан ажээ²⁰.

Нийтийн дэг журмыг арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх контекстийн хүрээнд гаргаж ирсэн нь 1927 оны Гадаадын арбитрын шийдвэрийг гүйцэтгэх Женевийн конвенц юм. Тус конвенцын I(e) дэх хэсэгт арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх хүсэлтийг ханган шийдвэрлэхийн тулд уг шийдвэрийг биелүүлэх нь тухайн улсын нийтийн дэг журам эсвэл эрх зүйн зарчимтай харшлахгүй байх ёстой гэсэн нөхцөлийг тусгасан байжээ. Женевийн конвенцын энэхүү зохицуулалт Нью Йоркийн конвенцод тусгалаа олохдоо “эрх зүйн зарчимтай харшлах” гэсэн хэсгийг хасаж, харин нийтийн дэг журамтай зөрчилдөхгүй байх гэсэн нөхцөлийг хэвээр авч үлдсэн байна.

Нью Йоркийн Конвенцын V (2)(b) заалтын англи хэлээрх бичвэрт нийтийн дэг журмыг “*public policy*”, орос хэлээрх бичвэрт “*публичный порядок*”, франц хэлээрх бичвэрт “*ordre public*” хэмээн заажээ²¹. Нью Йоркийн Конвенцын дээрх хэлээрх бичвэрүүдээс харахад

¹⁴ Конвенцын II (1) зүйлд гэрээний талууд гарч болзошгүй маргаантай асуудлаа арбитраар шийдвэрлүүлэх талаар чөлөөтэй тохиролдож болох, мөн V(1) зүйлд арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээх тал холбогдох нотолгоог эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн нөхцөлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзаж болохыг зааж талуудын чөлөөт байдлын зарчмыг хүлээн зөвшөөрсөн.

¹⁵ Олон улсын хувийн эрх зүйд гадаад улсын хууль хэрэглэх тохиолдолд зөрчилдөөний хэм хэмжээний үндсэн дээр агуулгыг зөв тогтоох, улмаар гарч болох үр дагавар, шийдвэр нь дотоодын эрх зүйн зарчим, нийтийн дэг журамтай нийцэж байгаа эсхийг шалгахад хэрэглэгдэнэ. Ж.Амарсанаа – ред, Т.Мэндсайхан, Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, ХЗДХЯ, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төсөл, 64-65 тал, 2011; Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй: Орчин үеийн чиг хандлага, 144-145 тал, 2019.

¹⁶ Kent Murphy, *The Traditional View of Public Policy and Ordre Public in Private International Law*, Georgia Journal of International & Comparative Law 591 (1981), <https://digitalcommons.law.uga.edu/gjic/vol11/iss3/9/>

¹⁷ Michel v. Reynolds (1711). Тус хэрэгт өрсөлдөөнийг хорьсон нь нийтийн ашиг сонирхолд харшилна гэж шүүх үзсэн ажээ.

¹⁸ Egerton v Earl of Brownlow: HL 1853, Maxi Scherer, England, IBA report, 20 October 2014

¹⁹ Kent Murphy, эшлэл 16, адил хуудас.

²⁰ Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, 2019, х. 145.

²¹ НҮБ-ын албан ёсны зургаан хэл дээрх бичвэр: http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/NYConvention.html

“*public policy*” гэж англи нэршил болон “*ordre public*” гэсэн франц нэршлийн хувьд олон улсын арилжааны арбитрын хүрээнд нэг ижил утга агуулгаар хэрэглэгдэж байна. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид “нийтийн дэг журам”-ын талаарх ойлголтыг хэд хэдэн нэр томъёогоор илэрхийлсэн байна. Нью Йоркийн конвенцын монгол хэлээрх хөрвүүлэгд “нийтийн дэг журам”²² гэж хөрвүүлсэн бол Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2.б болон 49 дүгээр зүйлийн 49.1.2.б заалтад “... Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол” гэж томъёолжээ.

Нью Йоркийн Конвенцод “нийтийн дэг журам” гэж юуг ойлгохыг тодорхойлоогүй орхисон нь тус үндэслэлээр гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах ээдрээтэй сорилтын нэг болжээ. Нийтийн дэг журмыг яг таг тодорхойлох нь төвөгтэй асуудал болохыг нэртэй судлаачид хүлээн зөвшөөрчээ²³. ЮНСИТРАЛ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас 2016 онд гаргасан тайлбар²⁴ болон Олон Улсын Хуульчдын Холбооноос (IBA) 2014-2015 онд хийсэн судалгаанд 48 орон хамрагдсан ба тус судалгааны тайлангаас²⁵ олон улсын арилжааны арбитрын практикт улс орнуудын шүүхүүд нийтийн дэг журамд үндэслэн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзсан янз бүрийн тайлбар, тодорхойлолт, үндэслэлийг гаргаж тавьсныг харж болно.

Олон Улсын Эрх Зүйн Ассоциацийн (“ОУЭЗА”) Арилжааны арбитрын хорооноос гаргасан “Нийтийн дэг журам нь олон улсын арбитрын шийдвэрийн биелүүлэхээс татгалзах үндэслэл болох талаарх ОУЭЗА-ын завсрын тайлан”-д нийтийн дэг журмыг ёс суртахуун, шударга ёсны үндсэн суурь болох тухай, олон улсын нийтийн дэг журам, улс дамнасан нийтийн дэг журмыг эш татан тайлбарлажээ²⁶.

Нью Йоркийн конвенцыг хэрэглэх хүрээнд арбитрын ажиллагаа дахь нийтийн дэг журмыг олон улс орны нэр бүхий шүүгчид хэрэг хянан шийдвэрлэхдээ тайлбарлаж, тодорхойлж ирсэн бөгөөд зарим шийдвэрүүд өнөө хэр бусад шүүхийн шийдвэрт эш татагдаж, судалгаа шинжилгээнд голлох байр суурьтай байна.

Дотоодын ба олон улсын/улс дамнасан нийтийн дэг журмын ялгаа

Гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх нь тухайн улсын нийтийн дэг журмыг зөрчиж байна гэж шийдвэр биелүүлэх улсын шүүх үзэхдээ дотоодын арбитрын шийдвэрт мөрддөгтэй ижил жишиг, стандартыг баримтлах уу гэсэн асуулт зүй ёсоор тавигддаг байна. Мөн тэрчлэн, үндэсний хууль тогтоомжид энэ зорилгоор “олон улсын нийтийн дэг журам” (*ordre public international*) болон “дотоодын нийтийн дэг журмын” (*ordre public interne*) хоорондын ялгааг гаргасан эсэх тухай асуулт ч байж болно. Нийтлэг хандлагаас харвал дотоодын шийдвэрт мөрддөг жишиг, стандартыг гадаадын арбитрын шийдвэрт нэгэн адил хэрэглэх нь үгүй бөгөөд²⁷, олон улсын арилжааны арбитрын шийдвэрийг биелүүлэхэд ихэнхдээ Нью Йоркийн конвенцын зорилгыг тууштай баримтлан явцуу утгаар тайлбарлан

²² Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц, 5 дугаар зүйлийн 2(b):

²³ Pierre Mayer, Audley Sheppard, Final ILA Report on Public Policy as a Bar to Enforcement of International Arbitral Awards, Arbitration International (“Final ILA Report”), Volume 19, Issue 2, 1 June 2003. 252. Luke Villiers, Breaking in the ‘Unruly Horse’: The Status of Mandatory Rules of Law as a Public Policy Basis for the Non-Enforcement of Arbitral Awards, at, 161, Australian International Law Journal;

²⁴ Эшлэл 3, V(2)(b) заалтын тайлбар; Тус тайлбарт дурдагдсан шүүхийн шийдвэрүүд ЮНСИТРАЛ-ын албан ёсны дараах цахим хуудсанд бий. <https://newyorkconvention1958.org>;

²⁵ IBA Subcommittee on Recognition and Enforcement of Arbitral Awards Report on The Public Policy Exception in The New York Convention, October 2015 (IBA Report); Улс орон бүрээр тайланг дараах цахим хуудаснаас харж болно. [https://www.ibanet.org/LPD/Dispute Resolution Section/Arbitration/Recognm Enfrcemnt Arbitl Awd/publicpolicy15.aspx](https://www.ibanet.org/LPD/Dispute%20Resolution%20Section/Arbitration/Recognm%20Enfrcemnt%20Arbitl%20Awd/publicpolicy15.aspx)

²⁶ Audley Sheppard, ILA Committee on International Commercial Arbitration, ‘Interim Report on Public Policy as A Bar to Enforcement of International Arbitral Award’ in Arbitration International (ILA Interim Report), vol. 19, No.2, at 219-220. LCIA, 2003.

²⁷ UNCITRAL Secretariat Guide, V (2)(b) тайлбар; Albert Jan van den Berg, “New York Convention 1058: Refusals of Enforcement” in ICC International Court of Arbitration Bulletin, at 64, 2007, Vol. 18/No.2; Pierre Mayer, Audley Sheppard, эшлэл 23, х 251; IBA Report, эшлэл 25.

хэрэглэж иржээ²⁸.

Нью Йоркийн конвенцын V (2)(b)-д "... тухайн орны нийтийн дэг журамтай харшилсан бол ..." гэж заасан нь шийдвэр биелүүлэх улсын нийтийн дэг журмыг хэлж байгаа нь тодорхой. Улс орнуудын шүүхийн практик, тэргүүлэх комментаторууд, судлаачдын тайлбараас харвал гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхэд (i) дотоодын нийтийн дэг журмын ойлголтыг явцуу утгаар хэрэглэх; болон (ii) "ёс суртахуун, шударга ёсны талаарх үндсэн ойлголтыг зөрчсөн" гэсэн хоёр хандлага давамгайлж байна.

ОУЭЗА-ийн Арилжааны Арбитрын Хорооноос гаргасан "Нийтийн дэг журам нь олон улсын арбитрын шийдвэрийн биелүүлэхээс татгалзах үндэслэл болох талаарх ОУЭЗА-ын эцсийн тайлан"-д "олон улсын нийтийн дэг журам"-ыг олон улсын хувийн эрх зүйн хүрээнд ойлгох буюу тухайн улсын нийтийн дэг журам зөрчигдөхөд аль нэг талын хувьд гадаадын эрх зүй, гадаадын шүүхийн шийдвэр эсвэл гадаадын арбитрын шийдвэрийг үндэслэх боломжгүй болох нөхцөл байдлыг ойлгоно гэж заасан байна²⁹.

Тус тайлангаар олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах үндэслэл бий эсэхийг шалгах шалгуур нь "олон улсын нийтийн дэг журам" байвал зохино гэж зөвлөсөн бөгөөд аливаа улсын олон нийтийн нийтийн дэг журамд (i) тухайн улс шууд хамааралгүй байсан ч хамгаалах хүсэл эрмэлзэлтэй шударга ёс эсвэл ёс суртахууныг илэрхийлэх үндсэн зарчим, (ii) "*lois de police*" буюу "нийтийн дэг журмын хэм хэмжээ" гэдгээр танигдсан, тухайн улсын улс төр, нийгэм эсвэл эдийн засгийн суурь эрх ашигт үйлчлэх хэм хэмжээ, (iii) бусад улс орнууд буюу олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ чандлан биелүүлэх тухайн улсын үүргээс бүрдэнэ гэж тодорхойлжээ³⁰. Mayer, Shepard нар зөвлөхдөө шийдвэр биелүүлэх шүүх арбитрын шийдвэр эцсийн шийдвэр байх нөхцөл болон шударга ёсны хоорондын тэнцвэрийг хангах ёстой гээд ОУЭЗА-ын эцсийн тайланд өгсөн зөвлөмжөө зөвхөн гадаад улсад гарсан арбитрын шийдвэрт төдийгүй мөн тэрчлэн гадаад элемент тодорхой хэмжээгээр оролцсон (ө.х, шийдвэр биелүүлэх улсын нутагт гарсан) арбитрын шийдвэрт мөн адил зориулжээ.

'Олон улсын нийтийн дэг журам' гэсэн ойлголтыг хуульд тодорхой дурдсан жишээгээр Франц зүй ёсоор нэрлэгддэг ба өөр хэд хэдэн орон³¹ хуульдаа олон улсын нийтийн дэг журам гэж тусгасан. Францын Иргэний процессын хуулийн 1514-д зааснаар арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах хязгаарлагдмал үндэслэлийн нэг нь "*ordre public international*" – д харшлах явдал³² байна. Францын хуулийн энэ заалтыг (өмнөх хуулийн 1502.5 зүйл) Fouchard Gaillard, Goldman нар тайлбарлахдаа "энэ нь зөвхөн олон улсын дэг журмын талаарх Францын ойлголтыг илэрхийлэх буюу өөрөөр хэлбэл, Францын эрх зүйн дэг журмаар зөрчигдөхийг тэвчиж боломгүй үнэт зүйлийн цогц юм" гэжээ³³. Улмаар, Францын давж заалдах шатны шүүх дотоодын болон олон улсын нийтийн дэг журмын хоорондын ялгааны зарчмыг "дотоодын нийтийн дэг журмын зөрчил гэж үзсэн үндэслэлийг Францад гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхээр гаргасан шийдвэрийг давж заалдах үндэслэл болохгүй, учир нь 1502.5 (хуучин заалт) зүйл нь гагцхүү олон улсын нийтийн дэг журамтай зөрчилдсөн шийдвэрийг хэлж байгаа юм" гэж үзжээ.

²⁸ Alan Redfern & Martin Hunter, *Law and Practice of International Commercial Arbitration* 541, 543 (4th ed. 2004); Luke Villiers, эшлэл 23, at, 162, 165, 180; Moses, M. (2017). *Enforcement of the Award. In the Principles and Practice of International Commercial Arbitration: Third Edition* (243). Cambridge: Cambridge University Press; Parsons & Whittemore Overseas Co., Inc. v. Société Gynière de l'Industrie du Papier, 508 F.2d 969 (2d Cir. 1974). АНУ-ын хоёрдугаар тойргийн давж заалдах шатны шүүх Америкийн компанийн эсрэг гарсан арбитрын шийдвэрийг баталгаажуулахдаа "Конвенцын нийтийн дэг журмын үндэслэлийг явцуу утгаар тайлбарлах ёстой" гэж дурдсан. Dr Stefan M. Kroell, *Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards in Germany*, at 166, 2002, International A.L.R., Sweet & Maxwell.

²⁹ Pierre Mayer, Audley Sheppard, эшлэл 23, 251 дэх тал.

³⁰ Pierre Mayer, Audley Sheppard, эшлэл 23, 255 дахь тал.

³¹ IBA Report, эшлэл 25, at 5, (Ливан, Португаль, Перу, Парагвай улсууд хуульдаа заасан)

³² Code de Procédure Civile: Titre II, L'arbitrage international, chapitre III: La reconnaissance et l'exécution des sentences arbitrales rendues a l'étranger ou en matière d'arbitrage international. Article 1514. <https://www.legifrance.gouv.fr/codes/id/LEGISC-TA000006089134/2021-01-27/>

³³ Fouchard, Gaillard and Goldman on International Commercial Arbitration (Gaillard and Savage (ed.), Kluwer, 1999), paras. 1648.

Зарим улс орнуудын хувьд дотоодын болон олон улсын нийтийн дэг журмын ялгааг шүүхүүд шийдвэрээрээ ялгаж тодорхойлсон байна. Тухайлбал, Милан хотын давж заалдах шатны шүүх нэгэн шийдвэртээ Нью Йоркийн конвенцын V (2)(b) зүйлд дурдсан нийтийн дэг журам нь олон улсын нийтийн дэг журам юм” гэж үзжээ³⁴.

Дотоодын нийтийн дэг журам нь улс орон бүрийн хувьд өөр өөр байж болох ч үндсэндээ тухайн улсын хувьд дотоодын маргааныг хянан шийдвэрлэхэд баримталдаг хамгийн чухал суурь зарчим, шударга ёс, ёс суртахууны хэм хэмжээ болон үнэт зүйлээс тогтсон ойлголт юм. Олон улсын нийтийн дэг журам нь дотоодын нийтийн дэг журмаас илүү явцуу утгаар тайлбарлагддаг.

Нийтийн дэг журмыг өргөн хүрээтэйгээр буюу үндэсний ашиг сонирхол, улсын бүрэн эрхт байдалтай (*national sovereignty*) холбон тайлбарласан жишээ байдаг ажээ. Бразилийн дээд шүүх авч хэлэлцсэн асуудал нь улсын бүрэн эрхт байдалтай холбоогүй тул нийтийн дэг журмын шинж чанар агуулаагүй байна гэж нэгэн шийдвэртээ³⁵ дурдсан бол үүнтэй төстэйгөөр Энэтхэг улс хэд хэдэн шийдвэртээ³⁶ “арбитрын шийдвэр нь Энэтхэг Улсын ашиг сонирхолд харш бол нийтийн дэг журамтай харшилсан болно” гэж дүгнэжээ.

Харин проф. Alan Redfern, Martin Hunter нар тайлбарлахдаа Нью Йоркийн конвенцын V(2)(b) заалт нь нийтийн дэг журмын талаар өргөн хүрээнд ойлгогдох дотоодын дэг журам болон улс дамнасан нийтийн дэг журмын аль алиныг нь агуулаагүй гэж үзжээ³⁷.

Олон улсын нийтийн дэг журмаас гадна улс дамнасан нийтийн дэг журмын тухай ойлголт бий. Энэ нь нийтийн дэг журмын ойлголт нь универсал/түгээмэл буюу улс дамнасан мөн чанар агуулж буй эсэх тухай³⁸ бөгөөд үүнийг хэрэглэсэн цөөн хэдэн жишээ өөр өөр чиг хандлага баримталсан байна.

Улс дамнасан нийтийн дэг журмын тухай ойлголтын талаар П.Лалив (*P.Lalive*) 1986 онд Олон улсын арилжааны арбитрын зөвлөлийн илтгэлдээ гаргаж тавьж байжээ³⁹. Улс дамнасан нийтийн дэг журам нь аль нэг улсын нийтийн дэг журам биш харин олон улсын нийтийн эрх зүйгээс эхтэй улс орнуудын хил дамнасан нийтийн дэг журмыг голчлон ойлгох ба мөн тэрчлэн зарим талаар улс дамнасан олон улсын хувийн эрх зүйн зарчим буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хамарч болно. Тухайлбал, хээл хахуультай холбоотой асуудал нэг улсын дотоодын нийтийн дэг журмын асуудал төдийгүй олон улсын нийтийн дэг журамд⁴⁰ хамаарах ба улс дамнасан нийтийн дэг журам олон улсын нийтийн дэг журмаас ялгаатай нь тухайн дүрэм журам, бодлогыг аль нэг улсын өнцгөөс бус харин олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс тодорхойлж буй нийтийн дэг журмыг хамаарч буй юм⁴¹. Өөрөөр хэлбэл олон улсын нийтийн дэг журам нь тодорхой улс орнуудын хууль тогтоомжид үндэслэгдэх бол улс дамнасан нийтийн дэг журам нь олон улсын хамтын нийгэмлэгийн нэгдсэн стандартыг илэрхийлэх ажээ.

Нью Йоркийн конвенцын V(2)(b) дахь заалтад “тухайн улсын нийтийн дэг журам” хэмээн заасан байгаагаас харахад тус конвенцын хүрээнд “улс дамнасан нийтийн дэг журам” буюу хэд хэдэн улсыг хамарсан нийтийн дэг журмыг хамруулаагүй. Гэхдээ өмнө дурдсанчлан цөөн хэдэн улс орнуудад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхэд “улс дамнасан нийтийн дэг журмыг” хэрэглэсэн байна. Миланы давж заалдах шатны

³⁴ *Allsop Automatic Inc. v. Tecnoski snc*, Court of Appeal of Milan, Italy, 4 December 1992, XXII Y.B. Com. Arb. 725.

³⁵ *Grain Partners S.p.A. v. Cooperativa dos Produtores Trabalhadores Rurais de Sorriso Ltda.*, https://newyorkconvention1958.org/doc_num_data.php?explnum_id=1682

³⁶ *Renusagar Power Co. Ltd. v. General Electric Company & anor.*, Supreme Court, India, 7 October 1993, 1994 AIR 860; *Penn Racquet Sports v. Mayor International Ltd.*, High Court of Delhi, India, 11 January 2011;

³⁷ Alan Redfern & Martin Hunter, *Law and Practice of International Commercial Arbitration* 541, 543 (4th ed. 2004).

³⁸ Julian D. M. Lew, *Transnational Public Policy: Its Application and Effect by International Arbitration Tribunals*, De la ediciyn, 2018, Fundaciyn Universitaria San Pablo CEU.

³⁹ Pierre Lalive, *Transnational (or Truly International) Public Policy and International Arbitration in Pieter Sanders (ed), Comparative Arbitration Practice and Public Policy in Arbitration*, ICCA Congress Series, 1986 New York Volume 3, Kluwer Law International (1987);

⁴⁰ Pierre Lalive, дээрх эшлэл, х. 291, ICC-ийн нэгэн хэргийн жишээг харж болно.

⁴¹ Julian D. M. Lew, эшлэл 39..

шүүх олон улсын нийтийн дэг журмыг тодорхойлохдоо “нийтийн дэг журам гэдэг нь олон улсын гэрээ, конвенцод тусгалаа олдог хүний үндсэн эрхийг хамгаалах зорилготой, соёл иргэншлийн хувьд ижил улс үндэстэн бүрд хамаатай түгээмэл зарчмуудыг хэлж байгаа”⁴² гэж *Allsup Automatic Inc. v. Tecnoski snc*-ийн хэрэгт тодорхойлсон нь улс дамнасан нийтийн дэг журмын ойлголтод илүү хамаарна гэж тэргүүлэх судлаачид үздэг⁴³. Үүнтэй адилхан Швейцарын Холбооны Улсын Шүүх нийтийн дэг журмыг “хэрэв арбитрын шийдвэр нь бүхий л соёл иргэншилт улс орнуудад сайтар танигдсан ёс суртахуун болон шударга ёсны суурь зарчмыг зөрчсөн бол уг шийдвэр тухайн улсын нийтийн дэг журмыг зөрчиж байна” гэж үзжээ⁴⁴.

Энэтхэгийн дээд шүүх “нийтийн дэг журмын ойлголтын талаар улс дамнасан гэж тодорхойлох нь хэрэгжих боломжгүй гээд Нью Йоркийн конвенцын V(2)(b) заалтын нийтийн дэг журмыг шийдвэр биелүүлэх улсын нийтийн дэг журмын утгаар авч үзэх ёстой гэсэн зарчмыг зөвшөөрчээ”⁴⁵.

Нийтийн дэг журмыг тодорхойлж тайлбарласан зарим шүүхийн шийдвэр

Нью Йоркийн конвенцод нэгдэн орсон, ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийг баримталсан улс орнуудын хувьд гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх ажиллагааг саадгүй явуулах, арбитраг ээлтэй бодлогыг баримталж байгаа тул “нийтийн дэг журам”-ыг явцуу байдлаар тайлбарлах чиг хандлагатай байна.

Мөн тэрчлэн Нью Йоркийн конвенцын V(1) болон V(2) заалтад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзаж “болно” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, “татгалзана”, “татгалзах үүрэгтэй” зэрэг үүрэг болгосон үг биш харин шүүхэд “татгалзахгүй ч байж болох” эрхийг үлдээсэн байна. Иймд шүүхүүд тухайн улсын нийтийн дэг журмыг зөрчсөн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх эсэхээ өөрийн санаачилгаар шийдвэрлэх эрхтэй юм.

Английн шүүхүүд арбитрын ажиллагааны хүрээнд нийтийн дэг журмыг явцуу байдлаар тайлбарлах байр суурийг баримталж буй нь сүүлийн үеийн шийдэгдсэн хэргүүдээс харагдана. Тухайлбал арбитрын шийдвэрийг биелүүлэх агуулгын хүрээнд Английн давж заалдах шатны шүүхийн шүүгч *D.S.T v Rakoil*⁴⁶ хэргийг шийдвэрлэхдээ “*нийтийн дэг журмыг бүхэлд нь хамарч тодорхойлох боломжгүй ч үүнд маш болгоомжтой хандах хэрэгтэй. ... Тухайн хэрэгт хууль бус зарим элемент байгаа нь мэдэгдэж байх буюу арбитрын шийдвэрийг биелүүлэх нь нийтийн сайн сайханд хор хохиролтой болох нь илт, магадгүй эсвэл, ийнхүү биелүүлэх нь ... ‘нийгмийн хэвийн ухамсарт’ гишүүнийг гутаан доромжилсон болохоор байгаа нь тодорхой байх хэрэгтэй*” гэж дурдсан байна. Үүнтэй төстэйгөөр *BRG Trading (UK) Ltd v Sinocore International Co Ltd* хэрэгт Английн давж заалдах шатны шүүх дээр дурдсан *D.S.T v Rakoil* хэргийг эш татан “нийтийн дэг журмыг явцуу байдлаар тайлбарлах явдлыг өргөнөөр хүлээн зөвшөөрсөн билээ” гэж тэмдэглэжээ⁴⁷.

Америкийн шүүгч Кардозо (*Benjamin N. Cardozo*) нийтийн дэг журам нь “шударга ёсны зарим үндсэн зарчим, ёс суртахууны талаарх зонхилох ухагдахуун, болон зан заншлын хэвшин тогтсон уламжлалыг зөрчих явдал” гэж тодорхойлсон нь өнөө хэр эш татагдаж буй хэллэг юм⁴⁸.

Нийтийн дэг журмын талаар хамгийн их эшлэгддэг тодорхойлолт бол АНУ-ын хоёрдугаар тойргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Joseph Smith-ийн “*Parsons*

⁴² *Allsup Automatic Inc. v. Tecnoski snc*, Court of Appeal of Milan, Italy, 4 December 1992, XXII Y.B. Com. Arb. 725.

⁴³ ILA Interim Report, эшлэл 27, 220 дахь тал.

⁴⁴ *W v F and V* (1994) Switzerland Court of Appeal.

⁴⁵ *Renusagar Power Co. Ltd. v. General Electric Company & anor.*, Supreme Court, India, 7 October 1993, www.newyorkconvention1958.org сайтаас харах боломжтой.

⁴⁶ *Deutsche Schachtbau-und Tiefbohrsgesellschaft m.b.H. v. Shell International Petroleum Co. Ltd.*, Court of Appeal, England and Wales, 24 March 1987, [1990] 1 A.C. 295. www.newyorkconvention1958.org сайтаас харах боломжтой.

⁴⁷ Дээрхтэй адил.

⁴⁸ Monrad Paulsen and Michael Sovern, ‘Public Policy in the Conflict of Laws’ (1956) 56 Colum L Rev 969, 970.

& *Whittemorff*”-ийн хэргийг шийдвэрлэхдээ “гадаадын арбитрын шийдвэрийг нийтийн дэг журмын үндэслэлээр ‘гагцхүү тийнхүү биелүүлэх нь шийдвэр биелүүлэх улсын ёс суртахуун, шударга ёсны талаарх үндсэн ойлголтыг зөрчсөн’ бол биелүүлэхээс тагталзаж болох юм” гэж үзсэн тайлбар юм. Тэрээр цааш нь “нийтийн дэг журмын үндэслэлийг дотоодын улс төрийн ашиг сонирхлыг хамгаалах явцуу арга хэрэгсэл болгон ашиглах нь Конвенцын хэрэглээг ноцтой дордуулсан хэрэг болно” гэж дүгнэсэн⁴⁹. Өөрөөр хэлбэл, нийтийн дэг журмыг улс төрийн зорилгоор ашиглахгүй байхыг онцолсон шийдвэр болсон.

Хонг Конгийн Давж заалдах эцсийн шатны шүүх арбитрын шийдвэрийг нийтийн дэг журмыг зөрчсөн шийдвэр хэмээн тодорхойлоод, уг шийдвэр нь “шийдвэрийг биелүүлэх улсын шударга ёсны ойлголтыг үндсээр нь гутаан доромжилсон шийдвэр тул хэдийгээр Хонг Конг Нью Йоркийн конвенцод нэгдэн орсон боловч хүлээн зөвшөөрөх үндэслэл байхгүй байна” гэжээ.⁵⁰

Германы Холбооны дээд шүүх (Bundesgerichtshof) нийтийн дэг журмыг шударга ёсны үндсэн дүрэм, ойлголтын үүднээс дараах байдлаар тайлбарлажээ⁵¹: “Хэрэв гагцхүү арбитрын шийдвэр нийтийн эсвэл эдийн засгийн амьдралын суурь болсон журмыг зөрчсөн, эсвэл Германы шударга ёсны үзэл баримтлалтай үндсээрээ зөрчилдсөн тохиолдолд Германы эрх зүйн суурь зарчмыг (*ordre public*) зөрчсөн зөрчил болно. Арбитрын бүрэлдэхүүний хэрэглэсэн материаллаг эсвэл процедурын хуулийн үл ялих зөрчил нь нийтийн дэг журмыг зөрчсөнд тооцогдохгүй”.

ОХУ-ын Арбитрын дээд шүүх нийтийн дэг журам гэдэг нь “нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны болон ёс зүйн дүрэмд харшилсан, эсвэл иргэдийн амь нас, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд хор хөнөөлтэй”⁵² буюу “Улсын эдийн засаг, улс төр, эрх зүйн тогтолцооны үндэс суурийг бүрдүүлж буй нийгмийн болон төр/олон нийтийн онцгой ач холбогдол бүхий императив мөн чанартай суурь, түгээмэл эрх зүйн зарчмууд” юм гэж үзсэн байна” юм гэж үзсэн байна⁵³. ОХУ-ын шүүхүүд мөн дараах үзэл бодлыг баримталсан байна. ОХУ-ын Арбитрын дээд шүүх арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлсэн тохиолдолд “нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны болон ёс зүйн дүрэмд харшилсан, эсвэл иргэдийн амь нас, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн” үр дүнд хүргэх шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх хүсэлтийг нийтийн дэг журмын ойлголтод үндэслэн үл ханган шийдвэрлэжээ⁵⁴.

Олон улсын хуульчдын холбооны арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх дэд хороонд Хятадын Дээд Шүүхийн ахлах шүүгч Гао Сиаолигийн гаргаж өгсөн тайланд⁵⁵ дурдсанаар Хятадын шүүхийн практикийн хувьд нийтийн дэг журмыг “Хуулийн зарчим, нийгмийн суурь эрх ашиг, улс орны аюулгүй байдал, бүрэн эрхт байдал болон нийгмийн сайн сайхан зан заншил” гэж ерөнхийдөө үзэж байна гэжээ⁵⁶.

⁴⁹ *Parsons & Whittemore Overseas v. Société Générale de L'Industrie du Papier (RAKTA)*, Дээрх дүгнэлтийг тус шүүх АНУ, Египетийн хоорондын дипломат харилцааг таслахад хүргэсэн гэж үзсэн шийдвэр биелүүлэхийг эсэргүүцсэн талын гаргасан аргументийг шийдэхдээ гаргасан. www.newyorkconvention1958.org сайтаас харах боломжтой. Энэ шийдвэрийг мөн *National Oil Corp. v. Libyan Sun Oil Co.*, хэрэгт АНУ-ын Делаваре -ийн Дүүргийн шүүх хэрэглэсэн.

⁵⁰ *Hebei Import & Export Corp. v. Polytek Engineering Co. Ltd.*, Hong Kong Court of Appeal, [1999] 2 HKC 205 www.newyorkconvention1958.org сайтаас харах боломжтой.

⁵¹ BGH, 12 July 1990 - III ZR 174/89, NJW 1990 at p. 3210.

⁵² *Ansell S.A. v. OOO MedBusinessService-2000*, Высший Арбитражный Суд Российской Федерации, Определения № ВАС-8786/10, 2010.08.03 www.newyorkconvention1958.org сайтаас харах боломжтой.

⁵³ Арбитражный Апелляционный Суд, Постановление, от 04 Июля 2013 Года Дело N А56-156/2013

⁵⁴ *Эшлэл 53.*

⁵⁵ Report of the People's Republic of China on Public Policy as a Ground for Refusal of Enforcement of Arbitral Awards under the New York Convention, by Gao Xiaoli (Senior Judge of the Supreme People's Court of P.R.China) www.ibanet.org сайтаас харах боломжтой.

⁵⁶ Дээрхтэй адил.

Taizhou Haopu Investment Co. Ltd v Wicor Holding AG хэрэгт⁵⁷ Хятадын Тайжоугийн дунд шатны шүүх Олон улсын худалдааны танхимын арбитрын шийдвэрийг нийтийн дэг журам дээр үндэслэн биелүүлэхээс таггалжээ. Тус хэрэгт арбитрын шийдвэр гарахаас өмнө Жиансүгийн Ардын дээд шүүх арбитрын хэлэлцээр хүчингүй гэсэн шийдвэр гаргасан байсан ба Тайжоугийн шүүх арбитрын шийдвэрийг биелүүлэх хүсэлтийг хүлээж аваад, Жиансүгийн Ардын дээд шүүхийн шийдвэр аль хэдийн гарсан байтал арбитрын хэлэлцээр хүчинтэй мэтээр арбитрын шийдвэр гарсан байгаа нь Жиансүгийн Ардын дээд шүүхийн шийдвэртэй шууд зөрчилдөж байгаа тул Хятадын нийтийн дэг журмыг зөрчиж байна гэж үзжээ. Гэтэл үүнтэй төстэй хэрэг өмнө нь гарч байсан бөгөөд Хятадын Дээд Шүүхээс арбитрын хэлэлцээрийн талаарх арбитрын бүрэлдэхүүн болон шүүхийн шийдвэр зөрөөтэй байсан ч энэ нь Хятадын нийтийн дэг журмыг зөрчсөнд тооцогдохгүй гэж шийдсэн байжээ⁵⁸. Тус хэрэгт арбитрын ажиллагааны явцад нэг тал нь Жоншаны дунд шатны шүүхэд арбитрын заалтыг хүчингүй болгуулахаар хандсан бөгөөд шүүхээс арбитрын заалт хүчингүй гэж үзжээ. Уг хэргийн арбитрын шийдвэрийг Хятад хүлээн зөвшөөрч биелүүлэх хүсэлтийг Жоншаны дунд шатны шүүх хүлээн аваад Хятадын шүүхийн гаргасан шийдвэртэй арбитрын шийдвэрийн харьяалал зөрчилдөж байх тул Хятадын нийтийн дэг журмыг зөрчиж байна гэж үзэн Гундоны Ардын дээд шүүхэд мэдээлжээ. Гундоны Ардын дээд шүүх энэ талаарх дүгнэлтээ Улсын дээд шүүхэд танилцуулсан. Улсын дээд шүүх нь нийтийн дэг журмын үзэл баримтлалыг Нью Йоркийн Конвенцын V(2)(b) заалтыг нийтийн ашиг сонирхол илэрхий хөндөгдөх Хятадын суурь зарчим, бүрэн эрхт байдал, нийгмийн аюулгүй байдал, эсхүл нийгмийн сайн сайхан зан заншлыг гагцхүү агуулна гэж үзсэн ба дээрх хэрэгт арбитрын шийдвэр нь арбитрын заалтын хүчинтэй байдалтай холбоотой шүүхийн шийдвэрээс өмнө гарсан байх бөгөөд Хятадын нийтийн дэг журмыг зөрчөөгүй гэж үзжээ⁵⁹.

Дээр өгүүлсэн шүүхийн шийдвэрүүд болон тэргүүлэх эрдэмтэн, судлаачид, комментаторууд, олон улсын байгууллагын судалгаа зэргээс үзвэл хэрэв тухайн шийдвэр биелүүлэх орны суурь үнэт зүйл, зарчмыг “илэрхий” зөрчсөн бол гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхээс таггалзах боломжтой ажээ. Үүнийг гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд дотоодын нийтийн дэг журмын талаарх ойлголтыг илүү явцуу утгаар хэрэглэх замаар хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна. Нийтийн дэг журмыг өргөн утгаар тайлбарлах үндэслэл болох *loi de police*, эрх зүйн суурь зарчим, нийгмийн хэв журам, үндэсний ашиг сонирхол, гадаад харилцаа⁶⁰ зэргийн талаар дараагийн өгүүлэлд авч үзнэ.

Зарим орны хууль тогтоомж дахь нийтийн дэг журам

Улс орнууд ч арбитрын ажиллагаанд нийтийн дэг журмыг өөр өөрийн үндэсний эрх зүйн системийн хүрээнд тодорхойлж, тайлбарлаж иржээ. Ихэнх улсууд Нью Йоркийн конвенц болон ЮНСИТРАЛ-ын Загвар хуульд заасан “нийтийн дэг журам” гэх үгийг шууд хэрэглэх эсвэл Нью Йоркийн конвенцын дагуу гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээр уг конвенцыг эшлэх байдлаар хууль тогтоомждоо заасан байна.

Дан Нью Йоркийн конвенц бус олон улсын гэрээний нөхцөлийг эш татах байдлаар гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээр заасан зохицуулалттай улсын нэг нь тухайлбал ОХУ байна. ОХУ-ын Арбитрын процессын тухай хуулийн 244

⁵⁷ Taizhou Intermediate People’s Court refuses recognition and enforcement of ICC award on basis of public policy by Jessica Fei (Partner), May Tai (Partner) and Mark Chu (Associate), Herbert Smith Freehills, [https://uk.practicallaw.thomsonreuters.com/w-003-4682?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true](https://uk.practicallaw.thomsonreuters.com/w-003-4682?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true); <https://hsfnotes.com/arbitration/2016/09/13/taizhou-intermediate-peoples-court-refuses-recognition-and-enforcement-of-icc-award-on-basis-of-public-policy/>

⁵⁸ Castel Electronic Pty Ltd. v. TCL Air Conditioner (Zhongshan) Company Ltd. China, Gao Xiaoli, Senior Judge of the Supreme People’s Court of P.R.China, https://www.ibanet.org/LPD/Dispute_Resolution_Section/Arbitration/Recognntn_Enfrncmnt_Arbitl_AwrD/publicpolicy15.aspx

⁵⁹ Дээрхээс харна уу.

⁶⁰ Sheppard, IIA Interim Report, эшлэл 27, 228 дахь тал.

дугаар зүйлийн 3 дахь хэсэгт ОХУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Арбитрын шүүх гадаадын арбитраын шийдвэр нь тус улсын нийтийн дэг журамтай (публичныйный порядок) зөрчилдөж байвал Арилжааны арбитраын тухай хуульд заасан үндэслэлээр бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс таггалзаж болно гэж заажээ.

Мөн нийтийн дэг журмыг хууль тогтоомждоо тодорхойлох, тайлбарлах буюу нэмэлт нөхцөл оруулж заасан зарим нэг улсууд бий. Тухайлбал, нийтийн дэг журмыг хуулиараа тодорхой заасан улс орны нэг нь Австрали юм. Австрали нийтийн дэг журмыг Арбитрын хуульдаа дараах байдлаар шууд тодорхойлсон байна: [...] түр арга хэмжээ эсвэл арбитраын шийдвэр хэрэв (а) түр арбитраын арга хэмжээ эсвэл арбитраын шийдвэрийг гаргахад авилгал эсвэл залилан нөлөөлсөн эсвэл түлхэц болсон эсхүл (б) түр арга хэмжээ авах эсвэл арбитраын шийдвэр гаргахтай холбоотойгоор жам ёсны шударга ёсны хэм хэмжээг зөрчсөн бол нийтийн дэг журмын эсрэг байна гэж үзнэ гэжээ⁶¹.

Нью Йоркийн конвенцын хэлэлцэн тохирогч зарим улсууд ийнхүү дотоодын хууль тогтоомждоо нийтийн дэг журмыг ёс суртахуун (*good morals*) эсхүл нийтлэг ашиг сонирхол (*public interests*) зэрэгтэй холбож тайлбарласан байна. Тухайлбал, Солонгосын Арбитрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36(2)(b) дэх заалтад зааснаар арбитраын шийдвэр Бүгд Найрамдах Солонгос Улсын ёс суртахуун болон нийгмийн дэг журмын бусад хэлбэртэй зөрчилдсөн бол хүчингүй болох үндэслэл байхаар заажээ. Гэхдээ энэхүү үндэслэл нь дотоодын арбитраын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхэд хамаарах бөгөөд гадаадын арбитраын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тохиолдолд Нью Йоркийн конвенцын дагуу зохицуулахаар заасан байна⁶². Японы Арбитрын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45(2)(9) дэх заалтад зааснаар арбитраын шийдвэрийн агуулга нь Японы ёс суртахуун, нийтийн дэг журамтай зөрчилдсөн бол арбитраын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс таггалзаж болно гэж заажээ⁶³.

Нийтийн дэг журмыг нийтлэг ашиг сонирхолтой холбож үздэг улсын нэг жишээ нь Хятад байна. Хятадын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шүүх арбитраын шийдвэрийг биелүүлэх нь тус улсын нийтлэг ашиг сонирхолтой зөрчилдөхөөр бол биелүүлэхгүй байхаар тогтоол гаргана гэж заасан байдаг байна⁶⁴. Мөн Хятадын Арбитрын тухай хуулийн 58 дугаар зүйлд зааснаар арбитраын шийдвэр нийгэм, нийтлэг ашиг сонирхолтой зөрчилдөх бол арбитраын шийдвэрийг хүчингүй болгоно гэж заажээ.

Монгол Улсын хууль тогтоомж дахь нийтийн дэг журам, ойлголт

Манай улс 1994 онд Нью Йоркийн конвенцод нэгдэн орсон бөгөөд ингэснээр тус конвенцын гишүүн улс орнуудын арбитраын шийдвэр Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөж биелэгдэхээс гадна Монгол Улсад гарсан арбитраын шийдвэр ч уг конвенцын гишүүн улсуудад хүлээн зөвшөөрөгдөж биелэгдэх боломжтой болсон. Тэрчлэн орчин үеийн арбитраын хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн, олон улсын стандартад нийцсэн арбитраын системийг хөгжүүлэхээр Арбитрын тухай хуулийг ЮНСИТРАЛ-ын Загвар хуультай нийцүүлэн 2017 онд шинэчлэн найруулж баталсан бөгөөд Арбитрын тухай хуулийн зорилтыг “эрх зүйн маргааныг арбитраын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино⁶⁵” хэмээн заасан билээ. Тус шинэчилсэн найруулгаар гадаадын арбитраын шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх, биелүүлэх явдлыг баталгаажуулж, үүнтэй холбоотойгоор Нью Йоркийн конвенцод заасан журмын дагуу арбитраын үндсэн шийдвэрийг гүйцэтгэнэ гэж

⁶¹ Австралийн Арбитрын хууль, 8(7A), <https://www.legislation.gov.au/Details/C2018C00439>

⁶² Солонгосын Арбитрын тухай хууль, 39 дүгээр зүйл, https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=38889&lang=ENG

⁶³ Японы Арбитрын тухай хууль, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=415AC0000000138>

⁶⁴ Хятадын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <http://cicc.court.gov.cn/html/1/219/199/200/644.html>

⁶⁵ Арбитрын тухай хуулийн 1.1 дэх заалт

заажээ⁶⁶.

Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн үндэслэлээр арбитрын үндсэн шийдвэрийг эс хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болох тухай⁶⁷ зохицуулалт Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлд ийнхүү туссан.

49.1.Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг үл хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхээс доор дурдсан үндэслэлээр татгалзаж болно:

[...]

49.1.2.б.арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх нь Монгол Улсын **“нийтлэг ашиг сонирхлыг”** [зөрчсөн].

Мөн Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2-т арбитрын үндсэн шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн нөхцөл, байдлыг шүүх тогтоосон бол хүчингүй болгох тухай заасан нь гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд хамааралгүй, харин арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс байх арбитрын үндсэн шийдвэрт хамаарах юм.

Өмнөх 2003 оны Арбитрын тухай хуульд “... Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол, **үндэсний аюулгүй байдалд** харшлахаар ...” нөхцөл байдал тогтоогдсон бол шүүх арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх хуудас бичихээс татгалзах эрхтэй зохицуулалт үйлчилж байв⁶⁸. Тус хууль анх 2003 батлагдахад тийнхүү татгалзах эрх давж заалдах шатны шүүхийн эрхэд хамаарч байгаад 2007 оны нэмэлт, өөрчлөлтөөр анхан шатны шүүх болон өөрчлөгдөж байжээ⁶⁹. Тус 2003 оны хуульд “Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол” болон “үндэсний аюулгүй байдал” гэж хоёр нөхцөлийг заасан нь энэхүү хоёр ухагдахуун тусдаа ойлголтууд байхаар ойлгогдож байна.

2003, 2017 оны Арбитрын тухай хуулиудад аль алинд нь “Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол” гэсэн томъёолол хэрэглэж ирсэн байна. Харин энэхүү ойлголт нь Нью Йоркийн конвенцын нийтийн дэг журам буюу “*public policy/ordre public*” гэсэн ойлголтыг илэрхийлэх эсэх нь цаашдын судлагдахуун юм⁷⁰. Тэрчлэн эдгээр хуульд Монгол Улсын нийтлэг ашиг сонирхолд юуг ойлгох талаар заагаагүй байна. “Нийтийн эрх ашиг”, “нийтлэг ашиг сонирхол”, “нийтийн ашиг сонирхол” гэсэн ижил буюу төсөөтэй ойлголт, томъёолол Монгол Улсын бусад хуулиудад заалтууд бий. Тухайлбал, Концессын тухай хуульд “үндэсний аюулгүй байдал ... **нийтийн эрх ашгийн** үүднээс концессын гэрээг цуцлахаар Засгийн газар шийдвэрлэсэн тохиолдолд эрх бүхий этгээдийн санаачилгаар цуцлах” тухай⁷¹, ИХШХШТХ-д “... Монгол Улсын **нийтлэг ашиг сонирхолд** харшлахгүй гэж шүүх үзсэн бол шүүхийн ажиллагааг ... хаалттай явуулахаар шийдвэрлэж болох” тухай⁷², Захиргааны ерөнхий хуульд “**нийтийн ашиг сонирхол**”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд⁷³ “**үндэсний нийтлэг ашиг сонирхол**” гэж гэсэн томъёолол эш татан хэрэглэсэн байна. Эдгээр хуулиудад ч тухайн хэрэглэсэн нэр томъёо, ойлголтыг тодорхойлоогүй байна.

⁶⁶ Арбитрын тухай хуулийн 48.1-д “аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харьяалах шүүхэд бичгээр өргөдөл гаргаснаар энэ хуулийн 48, 49 дүгээр зүйл болон Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью Йоркийн конвенцэд заасан журмын дагуу арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэнэ” гэж заажээ.

⁶⁷ Арбитрын тухай хууль 2017, 49.1, 49.1.2.б заалт

⁶⁸ Арбитрын тухай хууль 2003 (2017 оны 01 сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон), 43.1, 43.1.1 заалт, 40.2.6 заалт;

⁶⁹ Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, 2007 оны 8 дугаар сарын 3, 1 дүгээр зүйл.

⁷⁰ М.Уянга, Монгол Улсад Гадаадын Худалдааны Арбитрын Шийдвэрийг Хүлээн Зөвшөөрөх ба Биелүүлэх Эрх Зүйн Асуудал, 2016; С.Должин, Монгол Улсын Арбитрын Процессын Эрх зүй, УБ, 2017, 129дахь тал.

⁷¹ Концессын тухай хуулийн 24.2, 24.2.4.

⁷² ИХШХШТХууль, 160^б.1.

⁷³ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. 3.3.1.2.-т “нутаг дэвсгэрийн хуваарь, сонгуулийн тогтолцоог **үндэсний нийтлэг ашиг сонирхол** ... д нийцүүлэх” тухай; 3.3.3.5.2-д “төв, орон нутгийн бүх түвшинд **үндэсний нийтлэг ашиг сонирхол**, төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг дээдэлнэ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд (2010) үндэсний ашиг сонирхол, үндэсний нийтлэг ашиг сонирхол гэсэн томъёоллыг хэрэглэсэн ч яг ямар утгатай болох талаар нарийн заагаагүй. Харин тус баримт бичгийн 1 дүгээр зүйлийн 1.1.2-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд” Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана” хэмээн тодорхойлжээ. Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох”-оос бусад хэллэг ижил байдлаар тодорхойлсон байна. Онцлон тэмдэглэвэл зохих нэг зүйл бол 1994 оны Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын Үндсэн хууль нь Монгол Улсын ард иргэд, нийгмийн бүх хэсэг бүлгийн **нийтлэг ашиг сонирхлын** цогцолсон илэрхийлэл мөн” хэмээн томъёолж байжээ. Гавьяат хуульч Б.Чимэд гуай Монголын ард түмний язгуур ашиг сонирхол, ард түмний туйлын хүслэнг Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгалд томъёолон бататгасан гэжээ⁷⁴. Монгол Улсын Үндсэн хууль хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эдийн засаг, нийгэм, төрийн байгууламж, тогтолцоо зэрэг нийгмийн үндсэн суурь зарчмыг тодорхойлсон билээ. Монгол Улсын Үндсэн Хуулийн зарчим, үзэл баримтлал нь гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзах Монгол Улсын нийтийн дэг журмын үндэслэл байх боломжтой юм.

Олон улсын хувийн эрх зүй болон арбитрын эрх зүйн хүрээнд Монголын судлаачдын судалгаа шинжилгээний бүтээлүүдэд “нийтийн дэг журам”, “нийтийн эрх ашиг”, “нийгмийн дэг журам⁷⁵”, “нийтийн ашиг сонирхол⁷⁶” зэрэг ойлголтыг тус тусын судлагдахууны хүрээндээ авч үзсэн жишээ тохиолдоно. Арбитрын шийдвэрийг биелүүлэх контекстийн хүрээнд судлаачид ерөнхийдөө нийтийн дэг журам гэсэн томъёоллыг илүүтэй хэрэглэжээ⁷⁷. Олон улсын хувийн эрх зүйн үүднээс Б.Тамирын судалгаанд зөрчилдөөний хэм хэмжээний үүднээс гадаад улсын хуулийг хэрэглэхэд нийтийн дэг журмыг зөрчихөөр байвал хэрэглэхгүй бөгөөд нийтийн дэг журам нь гадаадын хуулийг хэрэглэснээр гарах үр дагаврыг хянан хэмээн тайлбарлажээ⁷⁸. Проф. Ж.Амарсанаа, проф. Т.Мэндсайхан, Б.Тамир нар “Олон улсын хувийн эрх зүй” гарын авлагад “арбитрын шийдвэр нийтийн эрх ашигт харшилж байвал шүүх өөрийн санаачилгаар татгалзах” үндэслэл бий гэсэн байна⁷⁹.

Хуульч Д.Дүгэржав нийтийн дэг журам гэдэг ойлголтыг нэг мөр томъёолон тодорхойлох боломжгүй гэдгийг зөвшөөрөөд тухайн харьяалах улсын үндэсний шалгуураар, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, тухайн маргааны нөхцөл байдлыг харгалзан шүүх тогтооно гэж тайлбарласан нь⁸⁰ Нью Йоркийн конвенцын дагуу гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд олон улсын болон улс дамнасан нийтийн дэг журмын үүднээс хэрэглэх учиртай болохыг илэрхийлжээ. Доктор М.Уянга нийтийн дэг журам буюу нийтлэг ашиг сонирхлын талаар Монгол Улсын хууль тогтоомжид юуг хэлдэг талаар нарийн зааж өгөөгүй болохыг дурдаад нийтлэг ашиг сонирхол болон нийтийн дэг журам нь ялгаатай ойлголт болохыг илэрхийлсэн болох нь түүний дүгнэлтээс харагдаж

⁷⁴ Бяраагийн Чимэд, Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийтлэг асуудал, нэгдүгээр дэвтэр, УБ, 2004, х. 178.

⁷⁵ М.Болор-Эрдэнэ, Гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах үндэслэл болох нийгмийн дэг журмын тухай, Хууль дээдлэх ёс сэтгүүл №76, (2020).

⁷⁶ Б.Сүндэрьяа, ХБНГУ-ын Үндсэн хууль болон Монгол Улсын холбогдох хуулиуд дахь “нийтийн ашиг сонирхол” болон “төр”-ийн талаарх нэр томъёоны зохицуулалт, УБ, Хууль дээдлэх ёс сэтгүүл №72, (2019)

⁷⁷ М.Уянга, Монгол Улсад Гадаадын Худалдааны Арбитрын Шийдвэрийг Хүлээн Зөвшөөрөх ба Биелүүлэх Эрх Зүйн Асуудал, 2016; С.Долижин, Монгол Улсын Арбитрын Процессын Эрх зүй, УБ, 2017, 137 дахь тал; Э.Байгал, Олон улсын хувийн эрх зүй, УБ, 2012, 109 дэх тал; С.Энхцэцэг, Арбитр ба Нийтийн дэг журам, УБ, Хууль Хууль дээдлэх ёс сэтгүүл №77, (2020).

⁷⁸ Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй: Орчин үеийн чиг хандлага, 144-145 дахь тал, (2019)

⁷⁹ Т.Мэндсайхан, Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, ХЗДХЯ, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төсөл, 140 дэх тал, (2011)

⁸⁰ Д.Дүгэржав, Арбитрын тухай хуулийн товч тайлбар, 119 дэх тал, (2017).

байна⁸¹. Судлаач С.Энхцэцэг “гөрөөс хараат бус, нийтийн эрх ашгийг хамгаалсан эрх зүйн тогтолцоог бий болгоход “нийтийн дэг журам” гэсэн заалтыг тайлбарлах ба хэрэглэх тохиолдолд тухайн улсын дотоодын харилцаанд хамаарах “үндэсний нийтийн дэг журам” гэсэн ойлголтын үйлчлэх хүрээ, түүнээс үүсэх үр дагаврыг анхаарах цаг болсныг онцолжээ⁸². Судлаач М.Болор-Эрдэнэ “нийгмийн дэг журам” гэсэн томъёоллыг хэрэглэж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 11.1-т заасан “... нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, болон Хоринтавдугаар зүйлийн 25.2.2-т заасан “Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход ...” заалтуудыг дурдаад, Үндсэн хуульд заасан нийгмийн дэг журам гэдэг ойлголт нь *ordre public* гэдэг ойлголтыг илэрхийлж байх тул цаашид уг нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэж санал дэвшүүлжээ⁸³.

Арбитрын тухай хуульд “нийтлэг ашиг сонирхол” гэж томъёолсон ойлголт нь хувийн эрх зүйн судлаачдын давамгайлан хэрэглэсэн нийтийн дэг журам гэсэн томъёоллоор илэрхийлэгдсэн Нью Йоркийн конвенцын *ordre public* ойлголтыг илэрхийлж буй эсэх талаар нэгдсэн ойлголтыг бий болгох нь нэр томъёоны хувьд төдийгүй ойлголтын хувьд цаашдын онол практикийн судалгаа, хэрэглээнд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, нийтийн дэг журмын томъёоллын хувьд төдийгүй ойлголт талаас нь нарийвчлан судлах шаардлагатай болохыг тус судалгаа харуулж байна. Мөн тэрчлэн гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх ажиллагаанд Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.2.б-д заасан Монгол Улсын “нийтлэг ашиг сонирхол” болон Нью Йоркийн конвенцын V(2)(b) заалтын “нийтийн дэг журам”-ыг хэрэглэхдээ явцуу хүрээнд тайлбарлах байр суурийг баримтлах нь олон улсын арилжааны арбитра ээлтэй системийг бүрдүүлэх, Нью Йоркийн конвенцын зорилгод нийцсэн алхам болох юм.

Гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх талаарх шүүхийн шийдвэр ба Монгол Улс

Монгол улсын арбитрын байгууллагын гаргасан арбитрын шийдвэрийг гадаад улсад биелүүлэхтэй холбоотойгоор энэ судалгааны хүрээнд олж мэдсэн цөөн хэдэн шийдэгдсэн хэрэг байгаагийн дотор нийтийн дэг журмыг зөрчсөн үндэслэлээр татгалзсан тохиолдол үгүй байна. Тухайлбал, нийтийн дэг журмын үндэслэлээр биш боловч Нью Йоркийн Конвенцын V(2)(a)-д заасан арбитраар шийдвэрлүүлэх маргаан биш гэсэн үндэслэлээр Монголын Үндэсний Арбитрын гаргасан арбитрын шийдвэрийг БНХАУ-ын Дээд шүүх хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзсан байна. Тус хэрэгт нас барсан нөхрийнхөө компани дахь хувьцааг эхнэр нь өвлөн авахтай холбоотой арбитрын шийдвэрийг БНХАУ-ын Дээд шүүх өв залгамжлалтай холбоотой асуудлыг арбитрын журмаар шийдвэрлүүлэх боломжгүй гэж үзжээ⁸⁴. Мөн Алтайн хүдэр компани *IMC Mining Inc.*, болон болон түүний хамаарал бүхий Австралийн *IMC Aviation Solutions Pty. Ltd.* (IMCS) компанитай холбогдуулан Монгол улсад гарсан арбитрын шийдвэрийг Австрали улсад биелүүлэх хүсэлт гаргасан ба IMCS компанийг арбитрын хэлэлцээрийн тал биш гэсэн үндэслэлээр [Нью Йоркийн Конвенцын V(1)(a) заалтын дагуу] арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан шийдвэр гарсан байна⁸⁵. Өөр нэг хэрэг нь *Aiduoladuo* (Монгол) *Co. Ltd. v. Zhejiang*

⁸¹ М.Уянга, Монгол Улсад Гадаадын Худалдааны Арбитрын Шийдвэрийг Хүлээн Зөвшөөрөх ба Биелүүлэх Эрх Зүйн Асуудал, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2016 №3, 129 – 130 дахь тал. Тэрээр 2003 оны Арбитрын тухай хуулийн зарим зүйл, заалттай холбогдуулан Загвар хуул болон Нью Йоркийн конвенцтэй нийцүүлэх шаардлагатай болохыг зөвлөмж болгож байсан нь 2017 оны Арбитрын хуулиар биелэлээ олсон, гэхдээ нийтлэг ашиг сонирхол гэсэн томъёолол хэвээр хэрэглэгдсэн тул энэ өгүүлэлд дэвшүүлсэн түүний нийтийн дэг журмын талаарх санал, дүгнэлт ач холбогдолтой хэвээр байна.

⁸² С.Энхцэцэг, эшлэл 77, 84 дэх тал.

⁸³ М.Болор-Эрдэнэ, эшлэл 75, 233, 236 дахь тал.

⁸⁴ *Wu Chunying v. Zhang Guiwen*, Хятадын Ардын дээд шүүх, 2009 оны 9-р сарын 2, www.newyorkconvention1958.org сайтаас товчоог харах боломжтой.

⁸⁵ *Altain Khuder LLC v. IMC Mining Inc., et al. and IMC Aviation Solutions Pty. Ltd. v. Altain Khuder LLC*, Австралийн дээд шүүх, арилжааны шүүхийн шийдвэр 2011 оны 1 дүгээр сарын 28, Австралийн Викториа-н дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн шийдвэр 2011 оны 8 дугаар сарын 22, XXXVI Y.B. Com. Arb. 242 (2011); www.newyorkconvention1958.org сайтаас харах боломжтой.

Zhancheng Construction Group Co. Ltd. хэрэгт Zhejiang Zhancheng “арбитрын ажиллагааны журам болон арбитрын хурал болох өдрийн” талаар зохих ёсоор мэдэгдэл аваагүйн улмаас хуралд оролцож чадаагүй Монголын Үндэсний Арбитрын шүүх гэж маргасан бөгөөд Нью Йоркийн конвенцын V(1)(b)-д заасан үндэслэлээр Хятадын Шаошингийн ардын шүүх Монголын Үндэсний Арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан байна⁸⁶. Шаошингийн шүүх дүгнэлтээ Жэжиангийн дээд шатны шүүхэд хүргүүлсэн бөгөөд Жэжиангийн шүүх тус шүүхийн дүгнэлтийг зөвшөөрөхийн зэрэгцээ арбитрын хэлэлцээрт талууд маргаанаа БНХАУ-ын шүүх ба арбитрт гаргахаар заасан байгаа нь Хятадын хуулиар хүчингүй гэж үзсэн. Жэжиангийн шүүх дүгнэлтээ Дээд шүүхэд хүргүүлсэн ба Дээд шүүх арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг баталгаажуулсан. Дээд шүүх Zhejiang Zhancheng-ыг арбитрын ажиллагааны мэдэгдэл аваагүй гэж дүгнэсэн. Гэхдээ арбитрын хэлэлцээрийг хүчинтэй тул Конвенцыг V (1)(a) заалтын дагуу татгалзах үндэслэлгүй гэж үзжээ.

Энэхүү судалгааны явцад гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбоотойгоор нийтийн дэг журмын үндэслэлээр татгалзсан шүүхийн шийдвэр бий эсэхийг судалж байгаа бөгөөд шүүхийн шийдвэр, тайлбар, байр суурийг дараагийн судалгаанд хамруулна.

ДҮГНЭЛТ

Өнөөдөр Монгол Улсын хууль, тогтоомжид “Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол”, “нийтийн дэг журам”-ын талаарх ойлголт тодорхойгүй байна. Арбитрын тухай хуульд “Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол” гэж томъёолсон ойлголт нь Нью Йоркийн конвенцын *ordre public* ойлголтыг илэрхийлж буй эсэх талаар нэгдсэн ойлголтыг нэр томъёоны хувьд төдийгүй ойлголтын хувьд нарийвчлан судлах нь онол практикийн судалгаа, хэрэглээнд чухал ач холбогдолтой юм.

Улс, орнууд нийтийн дэг журмыг өөр өөрөөр тодорхойлж ирсэн хэдий ч шүүхийн нийтлэг жишиг эрх зүйн системийн гол үнэт зүйлээс хазайсан үед Нью Йоркийн Конвенцын V (2)(b)-д заасны дагуу нийтийн дэг журмын үндэслэлээр шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах хандлагатай байгаа ба, улс орнуудын шүүхийн практик, тэргүүлэх комментаторууд, судлаачдын тайлбарт үндэслэн гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхэд (i) дотоодын нийтийн дэг журмын ойлголтыг явцуу утгаар хэрэглэх; болон (ii) “ёс суртахуун, шударга ёсны талаарх үндсэн ойлголтыг зөрчсөн” гэсэн байх хоёр хандлага давамгайлж байна.

Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх ажиллагаанд Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.2.6-т заасан “нийтлэг ашиг сонирхол” болон Нью Йоркийн конвенцын V(2)(b) заалтын “нийтийн дэг журам”-ыг хэрэглэхдээ явцуу хүрээнд тайлбарлах байр суурийг баримтлах нь олон улсын арилжааны арбитрт ээлтэй системийг бүрдүүлэх, Нью Йоркийн конвенцын зорилгод нийцсэн алхам болно гэж үзэж байна. Үүний тулд дотоодын нийтийн дэг журамд юуг ойлгох талаар мөн анхаарч үзэх учиртай.

Нью Йоркийн конвенцод нэгдэн орсон болон ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийг нутагшуулсан улсын хувьд Монгол Улс эдгээр баримт бичгийн зорилго, үзэл санаанд нийцүүлэн нэр томъёо, ойлголтын талаар олон улсын дэвшилтэт байр суурийг баримтлах нь зүйтэй юм. Ингэснээр Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд, ардчилсан улсын хувь бизнес, эдийн засгийн шударга, таатай орчныг бүрдүүлэх, бататгах үндэс болох юм.

⁸⁶ China / 08 December 2009 / China, 中华人民共和国最高人民法院 (Supreme People's Court) / Aiduoladuo (Mongolia) Co., Ltd. v. Zhejiang Zhancheng Construction Group Co., Ltd. / [2009] Min Si Ta Zi No. 46 ([2009] 民四他字第46号), www.newyorkconvention1958.org сайтаас товчоог харах боломжтой. Мөн дараахаас харах боломжтой: https://www.uncitral.org/clout/clout/data/chn/clout_case_1688_081209.html

ЭХ СУРВАЛЖ**Хууль тогтоомж:**

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал, 2010
- Арбитрын тухай Монгол Улсын хууль, 2017
- Арбитрын тухай Монгол Улсын хууль, 2003
- Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью Йоркийн конвенц (1958 оны 6 сарын 10-нд батлагдаж, 1959 оны 7 сарын 07-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.) 330 UNTS 38, Бүртгэлийн №. 4739.
- Улс Болон Гадаад Улсын Иргэний Хооронд Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх тухай Конвенц 1965
- НҮБ-ын Олон Улсын Худалдааны Комиссын 1985 оны Олон Улсын Арилжааны Арбитрын Тухай Загвар Хууль, 2006 оны нэмэлт өөрчлөлтийн хамт (UNCITRAL Model Law on International Commercial Arbitration 1985 with amendments as adopted in 2006)
- Inter-American Convention on international commercial arbitration, 1975
- Riyadh Arab Agreement for Judicial Cooperation, 1983
- Arab Convention on Commercial Arbitration, 1992
- Австралийн Арбитрын тухай хууль
- Солонгосын Арбитрын тухай хууль
- Хятадын Арбитрын тухай хууль
- Японы Арбитрын тухай хууль
- Францын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Монгол хэлээр:

- Бяраагийн Чимэд, *Үндсэн хуулийн үзэл баримтлал*, нийтлэг асуудал, нэгдүгээр дэвтэр, УБ, 2004
- Ж.Амарсанаа – ред, Т.Мэндсайхан, Б.Тамир, *Олон улсын хувийн эрх зүй*, ХЗДХЯ, 2011
- С.Должин, *Монгол Улсын Арбитрын Процессын Эрх зүй*, УБ, 2017
- Э.Байгал, *Олон улсын хувийн эрх зүй*, УБ, 2012
- Д.Дүгэржав, *Арбитрын тухай хуулийн товч тайлбар*, 2017
- Б.Тамир, *Олон улсын хувийн эрх зүй: Орчин үеийн чиг хандлага*, 2019.

Гадаад хэлээр:

- Alan Redfern and Martin Hunter, *Law and Practice of International Commercial Arbitration*, Sweet & Maxwell, 2004
- Moses, M. (2017). Enforcement of the Award. *In the Principles and Practice of International Commercial Arbitration: Third Edition*. Cambridge: Cambridge University Press
- Julian D. M. Lew, *Transnational Public Policy: Its Application and Effect by International Arbitration Tribunals*, De la ediciyn, 2018, Fundaciyn Universitaria San Pablo CEU
- Fouchard, Gaillard, *Goldman on International Commercial Arbitration*, Kluwer Law International B.V., 1999

Өгүүлэл:

- М.Болор-Эрдэнэ, *Гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах үндэслэл болох нийгмийн дэг журмын тухай*, Хууль дээдлэх ёс сэтгүүл №76, (2020).
- Б.Сүндэрьяа, *ХБНГУ-ын Үндсэн хууль болон Монгол Улсын холбогдох хуулиуд дахь “нийтийн ашиг сонирхол” болон “төр”-ийн талаарх нэр томъёоны зохицуулалт*, УБ, Хууль дээдлэх ёс сэтгүүл №72, (2019)
- С.Энхцэцэг, *Арбитр ба Нийтийн дэг журам*, УБ, Хууль Хууль дээдлэх ёс сэтгүүл №77, (2020)
- Albert Jan van den Berg, *New York Convention 1058: Refusals of Enforcement*, 2007, ICC International Court of Arbitration Bulletin, Vol. 18/No.2.
- Christoph Schreuer, *Interaction of International Tribunals and Domestic Courts in Investment Law in Contemporary Issues in International Arbitration and Mediation*,
- Kent Murphy, *The Traditional View of Public Policy and Ordre Public in Private International Law*, 1981
- Monrad Paulsen and Michael Soevern, *Public Policy in the Conflict of Laws* (1956) 56 ColumL Rev.
- Dr Stefan M. Kroell, *Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards in Germany*, 2002, International A.L.R
- Luke Villiers, *Breaking in the ‘Unruly Horse’: The Status of Mandatory Rules of Law as a Public Policy Basis for the Non-Enforcement of Arbitral Awards*, at 180, *Australian International Law Journal*;
- Julian D. M. Lew, *Transnational Public Policy: Its Application and Effect by International Arbitration Tribunals, De la ediciyn*, 2018, Fundaciyn Universitaria San Pablo CEU;
- Pierre Lalive, *Transnational (or Truly International) Public Policy and International Arbitration in Pieter Sanders (ed), Comparative Arbitration Practice and Public Policy in Arbitration, ICCA Congress Series*, 1986 New York Volume 3, Kluwer Law International (1987);
- *Taizhou Intermediate People’s Court refuses recognition and enforcement of ICC award on basis of public policy*, by Jessica Fei (Partner), May Tai (Partner) and Mark Chu (Associate), Herbert Smith Freehills.

Судалгааны тайлан:

- United Nations Conference on Trade and Development (UNCTAD), *International Centre for Settlement of Investment Disputes, 2.9 Binding Force and Enforcement, training course modules*
- *IBA Subcommittee on Recognition and Enforcement of Arbitral Awards Report on The Public Policy Exception in The New York Convention*, October 2015
- Audley Sheppard, *ILA Committee on International Commercial Arbitration, ‘Interim Report on Public Policy as A Bar to Enforcement of International Arbitral Award’* in *Arbitration International*, vol. 19, No.2, at 219-220. LCIA, 2003.
- Pierre Mayer, Audley Sheppard, *Final ILA Report on Public Policy as a Bar to Enforcement of International Arbitral Awards, Arbitration International*, Volume 19, Issue 2, 1 June 2003. 252.
- *Report of the People’s Republic of China on Public Policy as a Ground for Refusal of Enforcement of Arbitral Awards under the New York Convention*, by Gao Xiaoli (Senior Judge of the Supreme People’s Court of P.R.China)
- *Guide to the Convention on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards, UNCITRAL Secretariat* (2016)

Шүүхийн кейс:

- Cour de Cassation Societe Ouest Africaine des Betons Industriels v. State of Senegal
- Allsop Automatic Inc. v. Tecnoski snc, Court of Appeal of Milan, Italy, 4 December 1992,
- Арбитражный Апелляционный Суд, Постановление, от 04 Июля 2013 Года Дело N A56-156/2013
- Hebei Import & Export Corp. v. Polytek Engineering Co. Ltd.,
- Ansell S.A. v. ООО MedBusinessService-2000, Высший Арбитражный Суд Российской Федерации, Определения № ВАС-8786/10, 2010.08.03
- Grain Partners S.p.A. v. Cooperativa dos Produtores Trabalhadores Rurais de Sorriso Ltda.,
- Renusagar Power Co. Ltd. v. General Electric Company & anor., Supreme Court, India, 7 October 1993,
- Castel Electronic Pty Ltd. v. TCL Air Conditioner (Zhongshan) Company Ltd. China, Gao Xiaoli, Senior Judge of the Supreme People's Court of P.R.China,
- Parsons & Whittemore Overseas v. Sociйтй Гйййrale de L'Industrie du Papier (RAKTA),
- Deutsche Schachtbau-und Tiefbohrgesellschaft m.b.H. v. Shell International Petroleum Co. Ltd., Court of Appeal, England and Wales, 24 March 1987, [1990] 1 A.C. 295.
- W v F and V (1994) Switzerland Court of Appeal.
- BGN, 12 July 1990 - III ZR 174/89, NJW 1990 at p. 3210.
- Egerton v Earl of Brownlow: HL 1853, Maxi Scherer, England, IBA report, 20 October 2014

Цахим эх сурвалж:

- Лондонгийн Queen Mary их сургуулийн Олон улсын арбитрын сургуулийн судалгааны сан
- <http://www.arbitration.qmul.ac.uk/research/>
- www.newyorkconvention1958.org
- http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/NYConvention_status.html
- <https://unctad.org/>

PUBLIC POLICY AS A GROUND FOR REFUSAL OF RECOGNITION AND ENFORCEMENT OF FOREIGN ARBITRAL AWARD: CONCEPT AND APPROACHES

N.ENKHTSETSEG

Ph.D candidate, School of Law, NUM

ABSTRACT:

Ordre public/public policy is one of the most popular grounds to refuse the enforcement of foreign arbitral award. To date, it remains highly debated, complex, and controversial subject. This is because national courts have been taking diverse approach in relation to the concept of ordre public when recognizing and enforcing foreign arbitral award. In analysing the case laws of various countries, there is a tendency to refer to an ordre public basis for refusing recognition and enforcement of an award under article V (2)(b) of the New York Convention when it deviates from the core values of a legal system of a country. This article provides a brief overview of the concept

of public policy and presents the prevailing interpretations and approaches in court practices of a various countries based on the landmark cases. It also draws on the work of prominent scholars and commentators on the distinctions between international public policy and domestic public policy, or on the narrower use of domestic public policy in recognizing and enforcing foreign arbitral awards. It then introduces the public policy under Mongolian relevant laws in terms of the recognition and enforcement of arbitral awards, and leading scholars and researchers view on the subject. In this context, author finally concludes the article by highlighting few recommendations as to the needs of scholastic development on the concept of public policy in Mongolia.

KEYWORDS:

Foreign Arbitral Award, Recognition and Enforcement, Public Policy, Concept, International Public Policy, Fundamental Principle of Morality and Justice, Narrow Concept of Public Policy.

---o0o---

ИРГЭДЭД ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГ ОЛГОХ “ХУУЛЬЧДЫН ПОДКАСТ” СТУДИЙГ БАЙГУУЛЛАА




Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, зөвлөгөө мэдээллийг илүү ойроос шуурхай хүрэх зорилгоор ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “Хуульчдын подкаст” студийг байгууллаа.

Уг студи нь сүүлийн үеийн техник, технологиор тохижуулсан бөгөөд Монголын хуульчид болон иргэдэд зориулсан хууль зүйн сургалт, сурталчилгаа, мэдээ, мэдээллийг аудио болон видео хэлбэрээр шууд хүргэх юм.

“Хуульчдын подкаст” студийн нээлтийн ажиллагаанд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор Х.Эрдэм-Ундрах, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, гавьяат хуульч Ц.Сарантуяа, Эрх зүйн боловсрол академийн захирал А.Энхтуяа нар оролцов. Энэ үеэр “Хуульчдын подкаст” студийг байгуулахад дэмжлэг үзүүлсэн ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын хамт олонд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зүгээс талархал илэрхийлж, дурсгалын зүйлсийг гардууллаа.

Энэхүү студийн үүд хаалга Монголын бүх хуульчид болон хуулийн байгууллагуудын өмнө үргэлж нээлттэй байх тул Та бүхнийг урьж байна.

ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙН ХЯЗГААРЛАЛТ БА ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ХАРААТ БУС БАЙДАЛ



Г.Билгүүн
МУИС-ийн ХЗС-ийн магистрант

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээрээ би Үндсэн хууль төрийн эрх мэдлийн байгууллага болон төрийн өндөр албан тушаалтны эрх мэдлийг хязгаарлаж, төрийн аль ч эрх мэдэлтэн Үндсэн хуулийг зөрчих эрх байхгүй талаар болон Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэц гэсэн биеэ даасан институт үүсэн байгуулагдсанаар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний хэм хэмжээг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага бий болж төрийн эрх мэдлийн байгууллага болон түүний эрх бүхий албан тушаалтны шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол маргааныг магадлан шийдвэрлэж дүгнэлт гаргаж байгаа нь зарим эрх мэдэлтэнд таалагдахгүй байх тохиолдол байдаг учир Цэцийн гишүүний бие даасан, хараат бус байдлын баталгааг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай байгаа тухай бичихийг зорьсон юм.

ТҮЛХҮҮР ҮГ:

Үндсэн хууль, төрийн эрх мэдлийн хуваарилалт, Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал.

ОРШИЛ

Үндсэн хууль бол аливаа орны гол буюу тулгуур хууль төдийгүй төрийн эрх мэдлийг хязгаарладаг, хүний эрхийг хамгаалдаг дээд хүчин чадалтай эрх зүйн акт билээ. Манай улсын хувьд 1992 онд баталсан шинэ Үндсэн хууль бол анхны ардчилсан үндсэн хууль юм. Энэ хуулийн үзэл баримтлалд үндсэн хуулийн эрх зүйн онолын нэн чухал үнэт зүйлийн нэг болох төрийн эрх мэдэл хуваарилах онол буюу ухагдахуун орсон явдал юм. Түүнчлэн шинэ Үндсэн хуульд Монгол Улсын төр-хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, иргэний нийгэмд үйлчилдэг нийтлэг хуульд захирагдахыг тунхаглаад, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, түүний гүйцэтгэлийг хангах /гүйцэтгэх/, хамгаалах /шүүх/ гэсэн гурван салаа бүхий бүтцэд тэнцвэржүүлэн хуваарилах тухай баталгаажуулан заасан бөгөөд биеэ даасан салбаруудын нэг болох шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд ажиллах үүрэгтэйгээр төрийн тогтолцоонд Үндсэн хуулийн Тавдугаар бүлэгт тусгагдсаны дагуу цоо шинээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /шүүх/ бий болсноор анх удаа хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, төрийн өндөр албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах эрх бүхий бие даасан, хараат бус институт бүрэлдэн тогтсон юм.

Иймд дээрх агуулгын хүрээнд миний бие энэхүү бичвэрээрээ өөрийн судалсан судалгааны хэмжээнд дараах хоёр сэдэвт багтааж товчхон бичихээр оролдсоныг дурдах нь зүйтэй.

Нэгд. Үндсэн хууль төрийн эрх мэдлийг хязгаарлах нь
Хоёрт. Үндсэн хуулийн цэц /шүүх/ болон Цэцийн гишүүний хараат бус байдал

Нэг. Үндсэн хууль төрийн эрх мэдлийг хязгаарлах нь

Төрийн байгууллагууд болон тэдний үүргийг зааглах үзэл санааг анх эртний сэтгэгч Платон, Аристотель, Полибий нар дэвшүүлсэн байдаг. Эдгээр Грек, Ромын сэтгэгчдийн төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл, сургаалыг гүнзгийрүүлж орчин үеийн үзэл баримтлалыг бий болгоход Английн улс төрийн гүн ухаантан Ж.Локк, Францын нэрт сэтгэгч, хуульч Ш.Л.Монтескье нар XVII-XVIII зуунд жинтэй хувь нэмэр оруулсныг дурдах нь зүйтэй. Ж.Локкын үзсэнээр төрийн эрх мэдлийг хүний үндсэн эрхийг хангах зорилгоор хязгаарлах, тодорхой хүрээнд оруулах нь зайлшгүй бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг нийт иргэдээс сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлнэ гэсэн байна. Мөн ард түмэн хувь хүн, байгууллагад эрх мэдлийг олгодог төдийгүй бас эргүүлж авдаг юм гэсэн үзэл санаа нь ардчилсан дэвшилттэй байв.¹ Харин Ш.Л.Монтескье төрийн эрх мэдэл хуваарилах үзэл санааг цэгцтэй онол болгон хөгжүүлсэн төдийгүй түүний эл үзэл Франц, АНУ-ын Үндсэн хуулиуд болон 1789 оны “Хүн болон иргэний эрхийн тунхаглал”-д тусгагдсан аж. Тухайлбал, тунхаглалын 16 дугаар зүйлд “Эрхийн баталгаа, хуулиа дагаж мөрдөх явдлыг баталгаажуулаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилаагүй аливаа нийгэмд Үндсэн хууль гэж байдаггүй”² хэмээн заасан байна.

Дээрх үзэл, сургаал болон онолоос авч үзвэл Үндсэн хуулийн амин гол сүнс бол төрийн эрх мэдэл хуваарилах асуудал байна. Төрийн эрх мэдлийг хуваарилах үндсэн санааг “хязгаарлах” гэсэн агуулгаар үзэж болно. Учир нь төрийн эрх мэдлийг төрийн аль нэгэн байгууллага дээр төвлөрүүлэхийг хязгаарлах, эрх мэдлийг хяналтгүйгээр хэтрүүлэн ашиглахаас сэргийлэх утга үүнд агуулагдаж байдаг. Түүнчлэн төрийн эрх мэдэл хуваарилах тухай ойлголт нь төрийн чиг үүрэг хуваарилах явдлаас ялгаатай ойлголт юм. Тухайлбал, эрх мэдлийг тодорхой нэг субъектийн буюу эзэн хаан, ерөнхийлөгч, нэг намын тогтолцоо гэх мэт эрхийн асуудал биш, харин эрх мэдлийг гагцхүү Үндсэн хуулиар зохицуулах ёстой байдагт мөн чанар нь оршино. Төрийн эрх мэдлийг хуваарилах гэдгийг хамгийн энгийнээр ойлгоход эрх мэдлүүд бие даасан байдалтай байх бөгөөд бие даасан байдал нь хязгаартай байх ёстой. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох эрх мэдлээс хуулийг тогтооно, гүйцэтгэх эрх мэдлээс зөвхөн хэрэгжүүлнэ, шүүх эрх мэдлээс түүнийг хэрэглэнэ гэсэн үг юм.³ Мөн хууль тогтоогчид бодлого боловсруулж, хэм хэмжээ тогтоон хуульчлахдаа тодорхой хүрээ хязгаартай байх учиртай. Энэ нь эрх мэдэл хуваарилах, эрх мэдэлтнийг хязгаарлаж байх онолоос үүдэлтэй бөгөөд уг онолыг боловсруулагчид, тухайлбал, Шарль Монтескье, Кант, Болл нар эрх мэдлийг хянаж байхгүй бол аюултайг үндэслээд, эрх мэдэл хуваах тогтолцоо нь төр, эрх мэдэлтний дур зоргын үйлдлийг хязгаарлахаас гадна шүүх хяналтын тусгай механизм шаардлагатайг авч үзсэн байдаг⁴ байна. Иймээс Үндсэн хуулийг зөрчих эрх төрийн аль ч эрх мэдэлд байх ёсгүй хэмээн үздэг бөгөөд Үндсэн хуулийг хууль тогтоогч болон төрийн бусад эрх мэдлээс дээгүүрт тооцох ёстой юм.

Монгол Улсын тухайд, 1992 оны Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэг “Монгол Улсын төрийн байгуулал” нэртэй бөгөөд уг бүлэг нь дотроо: 1. Монгол Улсын Их Хурал; 2. Монгол Улсын Ерөнхийлөгч; 3. Монгол Улсын Засгийн газар; 4. Шүүх эрх мэдэл гэсэн дөрвөн хэсэгтэй. Энэхүү бүлэгт хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал, гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч, Засгийн газар, түүний байгууллагуудад, шүүх эрх мэдлийг шүүх, Цэцийн хүрээнд, байцаан шийтгэх ажиллагааны янз бүрийн талыг эрхэлдэг байгууллагын

¹ Д.Лүндэжанцан, “Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт”, УБ., 2014 он, 35 дахь тал

² Declaration of the Rights of Man and of the Citizen of 26 august 1789

³ Ц.Сарантуяа, “Төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим ба Үндсэн хуулийн хяналт”, МУҮХЦ (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), УБ., 2007 он, 81 дэх тал

⁴ Шарль Монтескье. Хуулийн амин сүнс. УБ, 2008 он

оролцоотойгоор хэрэгжүүлэхээр тусгасан юм.⁵ Харин Үндсэн хуулийн цэц /шүүх/ бие даасан Тавдугаар бүлэгт багтсан нь Цэц парламент, Засгийн газрын үйл ажиллагаа, хууль, шийдвэрт Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс хянаж, төрийн эрх мэдлүүдийн хооронд зохицуулагчийн үүрэгтэй байхаар хуульчилж өгчээ.

Гэсэн хэдий ч манай улс шинэ ардчилсан Үндсэн хуультай болоод 28 жилийн нүүр үзэж байгаа хэдий ч пост социалист орны зовлон бэрхшээлээс үүдэн Үндсэн хуулийн төрийн эрхийг хязгаарлах, хүний эрхийг хамгаалах гэсэн хоёр том чиг үүргийн суурь асуудал бүрэн шийдэгдээгүй, түүнчлэн төрийн эрх мэдэл бүрэн хуваарилагдаж, хяналт, тэнцвэр хангагдаагүй байна гэж профессор Н.Лүндэндорж үзжээ. Мөн тэрээр хүний үндсэн эрхийг олон улсын түвшинд дөхүүлж хуульчилсан хэдий ч хамгаалах ёстой шүүхийн хамгаалалтад оруулаагүй байна гэж өөрийн бүтээлдээ бичсэн байдаг.⁶

Дээрх асуудалтай уялдуулж Үндсэн хуулийн цэцийг авч үзвэл Цэц нь парламент, Засгийн газар, Ерөнхийлөгчийн шийдвэрийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах бөгөөд төрийн гурван бус, харин хоёр эрх мэдлийн шийдвэрийг хянадаг нь бусад улс орны Үндсэн хуулийн шүүхүүдээс ялгагдах онцлог юм. Мөн түүнчлэн Монгол Улсад иргэн хүн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгайлан заасан объектуудтай адил өөрийнх нь Үндсэн эрх зөрчигдөөгүй байхад ханддаг байхаар хуульд туссан боловч хүний үндсэн эрх бодит байдал дээр зөрчигдсөн тохиолдолд Цэц шүүхийн журмаар Үндсэн хуулийг хэрэглэн сэргээх боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл, зөрчигдсөн эрхийг ердийн шүүх сэргээдэг, харин үндсэн эрх зөрчигдвөл түүнийг Цэц Үндсэн хуулийн нэрийн өмнөөс сэргээх боломж бүрдээгүй байгаатай холбоотой юм. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд мөн хэсгийн 3 дахь заалтад “хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, ... -ээс шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;” гэж заасан нь Монгол Улсын иргэн, манай улсад оршин суугаа гадаадын иргэн, аль ч улсын харьяалалгүй этгээд эрхээ зөрчигдсөн гэдэг үндэслэлээр Үндсэн хуулийн цэцэд хандсан тохиолдолд хэрэг маргааны харьяаллаар гарсан маргааныг Улсын дээд шүүхээр шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргасан бол Улсын дээд шүүх өөрт нь шилжүүлсэн асуудлыг заавал зохих журмын дагуу хянан шийдвэрлэх замаар хүний эрхийг хамгаалах үүргээ хэрэгжүүлэхийг⁷ тодорхойлж өгчээ. Мөн түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... . Гагцхүү Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл тогтоогдсон бол Цэцийн шийдвэрийг баримтлан хэргийг зохих хууль тогтоомжийн дагуу дахин хянаж болно.” гэж хуульчилсан байна.

Хоёрт. Үндсэн хуулийн цэц болон Цэцийн гишүүний хараат бус байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасан нь Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн шинжтэй байгууллага бөгөөд төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхэд Үндсэн хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд эрх тэгш оролцдог⁸ бие даасан байгууллага болохыг баталгаажуулсан байна.

Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлын зайлшгүй байх шинж нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын үзэл санаатай шууд холбоотой. Учир нь Үндсэн хуулийн шүүх нь төрийн эрх мэдлийн байгууллага, төрийн өндөр албан тушаалтны гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх, мөн эрх мэдлийн байгууллага хоорондын маргааныг шийдвэрлэдэг⁹

⁵ Б.Чимид, “Үндсэн хуулийн үзэл баримтлал”, УБ., 2017 он, 57 дахь тал

⁶ Н.Лүндэндорж, “Шүүх эрх мэдэл”, УБ., 2017 он, 37 дахь тал

⁷ Г.Совд, Н.Жанцан ... нар, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, УБ., 2000 он, 217 дахь тал

⁸ Ц.Сантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал”, УБ., 2005 он, 59 дэх тал

⁹ В.К.Бобровка, М.А.Митюков, А.А.Подалов. Конституционное правосудие в странах СНГ и Балтии. Москва, Зерцало, 1998 г. стр 46

онцлогтой.

Дэлхийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарын 2 дугаар чуулганд Австрийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Кристоф Грабенвартер тавьсан илтгэлдээ “Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоомжийг хүчингүй болгох эрх мэдэлтэй учир хууль зүйн онолд тэднийг “сөрөг хууль тогтоогч” гэж тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү онол нь 20 дугаар зууны эхэн үеэс хойш гарсан. Гэхдээ энэ нь хууль тогтоох эрх мэдэлд Үндсэн хуулийн шүүхээс нөлөөлөх зөвхөн нэг хэлбэр юм: Үндсэн хуулийн шүүгч нь “эерэг” утгаараа хууль тогтоогчийн эрх мэдэлтэй байнгын холбоотой байх ёстой. ... Түүнчлэн Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын үзэл санаатай объектив утгаараа хамааралтай учир эрх мэдлийн хуваарилалтын хэрэгжилтэд Үндсэн хуулийн шүүх нь үр дүн бүхий хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй”¹⁰ гэж үзсэн байна.

Гадаад улс орны Үндсэн хуулийн шүүхүүдийн нэгэн адил Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулиар баталгаажсан бие даасан, хараат бус байгууллага болохын хувьд өөрийн гэсэн нийгэмд эзлэх өндөр, дээд байр суурьт тохирсон улс төр, хууль зүй, эдийн засаг, зохион байгуулалт, аюулгүй байдлын баталгаагаар хангагдах ёстой ба эдгээр нь Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын гол шалгуур юм. Тиймээс Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг баталгаажуулсан байдаг.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын 40 нас хүрсэн иргэн байх бөгөөд нийт 9 гишүүнээс бүрдэнэ. Цэцийн гишүүдийг Үндсэн хуулийн эрх мэдлийн байгууллагуудаас /Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Дээд шүүх тус бүрээс гурвыг/ тэнцвэрт тоогоор санал болгож байгаа нь уг байгууллагын бие даасан байдлыг хангахад чиглэгддэг байна. Гэхдээ эрх мэдлийн байгууллагуудаас санал болгож Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэн Улсын Их Хурлаас томилдог нь “эрх мэдлийн тэнцвэрийг хангах, аль нэг эрх мэдлээс хараат байх явдлаас сэргийлэх агуулгатай ба харин гишүүд тэдгээр байгууллагын төлөөлөл гэсэн үг биш бөгөөд гишүүний үйл ажиллагаа ямар нэгэн байгууллага, албан тушаалтны хяналтад байдаггүй.”¹¹ Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн даргыг Цэцийн есөн гишүүн дундаас хэн нэгийгээ сонгодог явдал бол Үндсэн хуулийн цэцийн бие даасан, хараат биш байх бас нэг давхар баталгаа болдог. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг хөндлөнгөөс аль нэг байгууллага, албан тушаалтны томилсон буюу сонгосон хүн удирддаггүй Цэцийн гишүүдийн өөрсдийнх нь чөлөөт хүсэл зоригийн дагуу сонгогдсон хүн удирддаг юм.¹² Мөн Цэцийн дарга Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд сонгогдсон учраас Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих, Цэцэд харьяалагдах асуудлаар дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд Цэцийн бусад гишүүдтэй адил, тэгш эрх, үүрэгтэй оролцдог. Өөрөөр хэлбэл, Цэцийн шийдвэр гаргах үед даргын хувьд тусгайлан илүү эрх хэмжээ эдлэхгүй.¹³

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын эцсийн үр дүн нь тодорхой хэрэг, маргааныг Үндсэн хуулийн цэц хуралдаанаараа хянан хэлэлцэж Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан шийдвэр гаргах байдлаар илэрдэг. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн агуулгаас үзвэл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь Цэцийн бие даасан байдал нь Цэцийн гишүүний хараат бус байдлаас шууд хамаарах нь тодорхой байна. Түүнчлэн Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд аливаа байгууллага, албан тушаалтан, иргэнээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан, өөрийн мэргэшлийн мэдлэг, чадвар, хууль дээдлэх зарчим, ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон дотоод итгэл үнэмшлээрээ асуудалд хандаж чадвал Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бие даасан

¹⁰ Christoph Grabenwarter “Separation of powers and the Independence of Constitutional Courts and Equivalent Bodies”, keynote speech Jan 2011, 2nd Congress of the World Conference on Constitutional Justice, Rio de Janeiro

¹¹ Д.Наранчимэг, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт, 2017 он, 226 дахь тал

¹² Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай тайлбар, 2000 он, 256 дахь тал.

¹³ Н.Жанцан, “Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлыг хангах зохион байгуулалтын болон материаллаг баталгаа”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), 2007 он, 159 дэх тал.

байдал хангагдана.

Дээрх агуулгатай уялдуулан Үндсэн хуулийн шүүхийн активизмыг товчхон авч үзвэл Үндсэн хуулийн шүүхийн активизм нь Үндсэн хууль болон улс төр хоёрыг салгаж ойлгож болохгүй гэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл, төрийн дээд эрх мэдэл бүхий байгууллага болон өндөр албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчсөн хууль болон шийдвэр гаргах, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, улс төрийн маргаан, эсхүл иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөнд шууд болон шууд бусаар халдах тохиолдолд Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүнийг чандлан сахин биелүүлэхэд аль ч улс төрийн нам, эрх мэдэл бүхий албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар хянан шийдвэрлэх ажиллагаа юм. Мөн түүнчлэн шүүхийн активизм буюу шүүх эрх мэдлийн шийдвэр гаргах философи нь шүүгч нар өөрсдийн шийдвэр гаргахад чиглэсэн төрийн бодлого, бусад хүчин зүйлсийн дунд өөрийн үзэл бодол, дотоод итгэл үнэмшлээрээ тайлбар хийж илэрхийлэх боломж юм. Энэхүү философийн чиг хандлага нь үндсэн хуулийн зөрчлийг олж илрүүлэх байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий субъект гэдэг угтаараа Үндсэн хуулийн албан ёсны тайлбар гаргах эрхтэй гэж зарим судлаачид үздэг байна.¹⁴

Манай улс 1992 оны Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлтийг хоёр удаа оруулсан. Сүүлд 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлсэн байна. Энэхүү төсөлд орсон нэг зүйл бол Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор томилгооны сонголт хийж Улсын Их Хурал нийт гишүүний олонхийн саналаар есөн жилийн хугацаатай томилно. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилохыг хориглоно.” гэж; мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арван таваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно.” гэж тусгасан байсан хэдий ч 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-аас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа тус хэсгийг хуучин хэвээр үлдээсэн байна.

Дээрх нэмэлт, өөрчлөлтийн төслийн Үндсэн хуулийн цэцтэй хамааралтай хэсгийг холбогдуулж гадаадын зарим улс орны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлага, томилох хугацааг харьцуулан харвал, Австри, Солонгос, Польш зэрэг улс орны хувьд Үндсэн хуулийн шүүхийн шүүгч 40-өөс дээш настай байх, хууль зүйн өндөр мэргэшилтэй /үүнд: Солонгос Улсын хувьд шүүгч, прокурор болон өмгөөлөгч, Төрийн байгууллага, төрийн өмчит буюу улсын үйлдвэрийн газар, засгийн газрын хөрөнгө оруулалттай байгууллага, эсхүл бусад корпорац зэрэгт хууль зүйн асуудал эрхэлсэн албанд ажиллаж байсан; магадлан итгэмжлэгдсэн хуулийн коллежийн дэд профессор, түүнтэй эн тэнцүү буюу түүнээс өндөр албан тушаал эрхэлж байсан. Харин Австри Улсын хувьд төрийн өндөр албан тушаалтан, улс төр, хууль, эрх зүйн профессор, багш, шүүгч нар дундаас сонгодог бол Польш Улсын хувьд Дээд шүүхийн шүүгч, эсхүл Захиргааны дээд шүүхийн шүүгчид тавигдах шаардлагыг хангасан эрх зүй, хуулийн мэдлэг, туршлагаараа танигдаж шалгарсан хуульч байхыг шаарддаг/, мэргэжлээрээ 10 болон 15-аас дээш жил ажилласан байх, 70 нас хүртлээ шүүгчийн /гишүүний/ албан тушаалыг хашна гэж Үндсэн хууль, Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульдаа баталгаажуулж өгсөн байна. Дахин томилох тухайд Солонгос Улсын хувьд шүүгчийн 6 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд дахин томилогдох эрх нь нээлттэй байна. Австри Улсын хувьд тэтгэвэрт гарах хүртэл бол, Польш Улсын хувьд шүүгчийг 9 жилийн хугацаатай томилдог байна.

Харин ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшигч нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйн салбарт өндөр мэргэшсэн, нэр хүндтэй, 40 нас хүрсэн ОХУ-ын иргэн байх, шүүгчээр ажиллах насны дээд хязгаар 70 нас байна гэж хуульчилжээ.

Эдгээр улс орнуудаас харахад, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлагад хууль зүйн өндөр мэргэшилтэй байх талаар хуульчилж өгсөн байна. Мөн түүнчлэн Үндсэн

¹⁴ Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй, төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, УБ., 2016 он, 132 дахь тал.

хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд тусгагдсан холбогдох зүйл, заалт нь ОХУ-ын хуулийн зохицуулалттай нэлээд төстэй байна.

Гэхдээ дээрх төсөлд тусгагдсан холбогдох зүйл, заалтын “... Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилохыг хориглоно.” гэсэн нь Цэцийн гишүүнийг дахин томилох нь Цэцийн гишүүний нэр дэвших эрхийг хязгаарлаж байгаа ухагдахуун бөгөөд дахин томилогдсоноор Цэцийн гишүүний хараат бус байдал алдагдана гэж төслийн ажлын хэсэг үзсэн бололтой. Зарим улс орны жишгийг үзэхэд нэг бол тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэх, аль эсвэл дахин томилогдох эрх нь нээлттэй байхаар хуульчилсан нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, аливаа улс төрийн хүчнээс хамааралгүй, туршлагатай шүүгчийг дахин томилох, эс томилох асуудлыг эрх бүхий субъектэд үлдээсэн байна.

Үндсэн хуулийн шүүхэд хэлэлцэж буй маргааны эцэст Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоодог. Нөгөө талаас Үндсэн хуулийн шүүхийг шударга бус, тухайлбал тодорхой нам улс төрийн байр сууринаас хандсан гэх мэтээр буруутгах, шүүмжлэх зэрэг байдал ажиглагддаг. Үүнээс гадна, Цэц дунд суудлын хуралдаанаараа маргааныг хянан шийдвэрлээд Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гарган Улсын Их Хуралд хариу ирүүлэхийг уламжилдаг. Тухайлбал, 1992 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд иргэд болон эрх бүхий байгууллагаас Үндсэн хуулийн цэцэд хандаж нийт 2970 гаруй өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдол ирүүлснийг Цэц шийдвэрлэсэн байна. Эдгээр шийдвэрээс Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж дунд, их суудлын хуралдаанаар нийт 209 маргааныг хянан хэлэлцэж дүгнэлт гаргасны 116 шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн гэж гарсан байна. Энэхүү Үндсэн хууль зөрчсөн гэж гарсан нийт 116 шийдвэрээс 74 шийдвэрийг Улсын Их Хурал хүлээж аваагүй байна.¹⁵ Үндсэн хууль зөрчсөн нь илт тодорхой байхад Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авахгүй байдал түгээмэл бөгөөд Цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй тохиолдолд үндэслэл, шалтгааныг заахгүй тогтоол гаргах явдал өнөөг хүртэл байсаар иржээ.

Эндээс үзэхэд хууль тогтоогч баталсан хуулиа Үндсэн хууль зөрчсөн гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй, Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй зөрүүтэй санаатай байх тохиолдол их байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан төрийн дээд зарим байгууллага албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх, эсхүл тэдгээрийг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхийг Цэцээс хянан үзэж гаргасан дүгнэлтийг хэдийгээр Улсын Их Хуралд оруулдаг ч түүнийг Улсын Их Хурал зөвхөн хүлээж авах ёстой атал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6.13-т “Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороодын болон Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу хэлэлцдэг ташаа практик байна. Учир нь төрийн өндөр албан тушаалтныг Үндсэн хууль зөрчсөн эсэх, огцруулах болон эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхийг гагцхүү хараат бус шүүх (Цэц) шийдвэрлэх эрхтэй¹⁶ юм.

Харин Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших хугацаанд Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлтэй маргааныг хянан хэлэлцэж, шийдвэр гаргасан хэд хэдэн тохиолдол гарч байжээ. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүнтэй холбоотой гарсан 7 маргааны 3-т нь Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлтийг Цэц гаргасан байна.¹⁷ Эдгээр гарсан шийдвэрээс төрийн өндөр албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулсан шийдвэрийг гаргаж байсан байна.

Жишээ нь: Цэц нэр бүхий иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж 2007 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Их суудлын хуралдаанаараа хэлэлцэн 03 дугаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд уламжилсан байна. Уг дүгнэлтэд “Авилгын эсрэг хууль, Ашигт

¹⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвийн статистик мэдээ, УБ., 2020 он

¹⁶ Ц.Сарантуяа, “Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал”, УБ., 2005 он, 65 дахь тал

¹⁷ Эрдэмтдийн судалгааны тайлан, “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ, УБ., 2015 он, 58 дахь тал

малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засвар, өөрчлөлтийг хийснээрээ Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн байна.” гэж үзэн Улсын Их Хурлын хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай гэсэн байна. Энэ нь Улсын Их Хурал болон Цэц Үндсэн хуулиар оноогдсон бүрэн эрхээ харилцан итгэлцлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлэхэд, Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг хэрхэн биелүүлэхэд чиглэсэн маш чухал тайлбар байсан бөгөөд Үндсэн хууль зөрчсөн Улсын Их Хурлын даргын үйл ажиллагааг залруулах бололцоог Улсын Их Хуралд олгосон шийдвэр байсан юм. Гэвч Төрийн байгуулалтын байнгын хорооноос Улсын Их Хуралд оруулах санал байхгүй болсон гэх зэргээр маргалдсаар “зөрчлийг арилгуулах” үйлдэл хийгдээгүй үлдсэн байна.

Энэ тохиолдлоос харахад Улсын Их Хурал мөн л Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй санал нийлэхгүй Үндсэн хуулийн зөрчлийг арилгуулах үйлдэл хийхгүй байсныг олж харж болно.

Үүний дараахан дахин ижил агуулгатай мэдээлэл нэр бүхий иргэдээс Цэцэд хандаж ирүүлсэн байна. Уг мэдээллийн дагуу Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Их суудлын хуралдаанаар хэлэлцэн 06 дугаар дүгнэлт гаргасан байдаг. Энэхүү дүгнэлтэд “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засварыг хийснээрээ Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн байна. ... Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын бүрэн эрхэд удаа дараа халдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн үйлдэл нь түүнийг Улсын Их Хурлын даргын албан тушаалаас огцруулах үндэслэл болно.”¹⁸ гэжээ.

Цаашдаа Цэц төрийн өндөр албан тушаалтныг огцруулах, эсхүл эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх, мөн Улсын Их Хурлаас баталсан хууль Үндсэн хуульд нийцээгүй эсэх талаар Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу маргаан үүсгэн хянан хэлэлцэж Үндсэн хууль зөрчсөн хэмээн шийдвэр гаргаж байх нь мэдээж хууль санаачлагч болон Улсын Их Хурлын гишүүдэд таатай санагдахгүй нь дамжиггүй юм.

Эндээс хууль тогтоогч болон Үндсэн хуулийн шүүх хоёр “зөрчилдөөн бүхий харилцаа” байдаг гэдэг нь нотлогдож байна. Энэхүү зөрчилдөөн нь эргээд Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлөх ямар нэгэн оролдлого болох боломжтой байгаа юм.

Тухайлбал, 2016 онд Улсын Их Хурлын нэгэн гишүүн хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль санаачлан Цэцийн гишүүний хараат бус байдлыг дордуулсан байдлаар хуулийн төсөл өргөн барьж Улсын Их Хурлаар батлуулсан байна. Энэхүү хуулийг нэр бүхий иргэдийн мэдээллээр Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн дунд, их суудлын хуралдаанаараа хэлэлцэн дээрх хуулийн холбогдох заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэж үзэж дүгнэлт, тогтоол гарган хүчингүй болгосон байна.¹⁹

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын нэг чухал баталгаа нь гишүүний хараат бус байдал байдаг бөгөөд Цэцийн гишүүний эрх зүйн байдлын хэм хэмжээ нь түүний халдашгүй байдал, гишүүний бүрэн эрхийн баталгаа байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.” гэсэн байна. Цэцийн гишүүнийг Цэцийн зөвшөөрөлгүйгээр /түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчлахаас бусад

¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 06, 2007.05.23-ны өдөр

¹⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоол.

тохиолдолд/ баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хуулиар хориглодог нь гишүүний халдашгүй байдлын баталгаа болдог. Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг Цэц хэлэлцэж шийдвэрлэхээр Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд тус тус хуульчилсан байна. Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах асуудлаар Цэц шийдвэр гаргаж, уг шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно. Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, түүнийг эгүүлэн татахад Үндсэн хуулийн цэц онцгой эрхтэй байгаа нь тухайн байгууллагын бие даасан байдлыг илэрхийлээд зогсохгүй гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгаа болдог онцлогтой.

Гэтэл “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” 2016 оны хуулиар “Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.” гэсэн өөрчлөлт оруулснаар хууль зөрчсөн эсэхийг шүүх тогтоох бус дурын байгууллага, тухайлбал, Улсын Их Хурлын Тамгын газар хууль зөрчсөн хэмээн үзэж, Улсын Их Хурал түүнийг нь эрх бүхий байгууллага мөн гээд Цэцийн гишүүнийг эгүүлэн татсан явдал гарсан нь нэгд, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим, хоёрт, эрх зүйт төрд аливаа этгээдийн гэм буруутай эсэхийг шалган тогтоох эрхийг гагцхүү шүүхийн байгууллага тогтоох эрхийг хэрэгжүүлдэг байтал Улсын Их Хурал дүгнэлт гаргасан нь Цэцийн гишүүний хараат бус байдалд төдийгүй Цэцийн бие даасан байдлын баталгааг алдагдуулахад хүргэсэн жишээ болсон юм.

Түүнчлэн Улсын Их Хурал Цэцийн гишүүнийг ийнхүү эгүүлэн татахдаа хэд хэдэн хууль зөрчсөн төдийгүй Үндсэн хуулийн цэцээс үйлчлэлийг нь түдгэлзүүлсэн байсан хуулийн заалтыг үндэслэсэн байдаг.²⁰

Ийм байдлаар хууль тогтоогч байгууллага нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл хүч түрж шийдвэрлэх боломжтой гэдэг нь практикаас харагдаж байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын нэг болох хууль дээдлэх зарчим буюу Үндсэн хууль дээдлэх ёс мөн яригдана. Манай улс Үндсэн хуульдаа Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж хуульчилсан нь аль ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хууль болон бусад хуульд захирагдах бөгөөд хуулиас дээгүүр эрх мэдэл хэнд ч байхгүй гэдэг ойлголт юм. Дээрх хүч түрсэн хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох эрх нь Үндсэн хуулийн цэцэд бий.

Иймд Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал, гишүүний хараат бус байдлын үндсэн баталгааг Үндсэн хуульд хөдөлбөргүй нарийвчлан тогтоож өгөх нь Цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүхтэй ихэнх улс орнууд Үндсэн хуулийн шүүхийн шүүгч /Цэцийн гишүүн/-д нэр дэвшигчийн шалгуурыг Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульдаа нарийвчлан тодорхойлж хуульчилжээ, мөн Цэцийн гишүүний томилооны хугацаа буюу бүрэн эрхийн хугацаа нь 9-15 жил байхаар эсвэл Цэцийн гишүүнээр томилогдсоноос хойш ажиллах хугацаа нь Цэцийн гишүүний ажиллах насны дээд хязгаар буюу 65-70 нас байхаар хязгаарлан хуульчилсан байгаа нь дахин томилогдох зохицуулалтаас аль болох татгалзсан нь ажиглагдаж байгаа юм. Энэ нь гишүүний хараат бус байдлыг хангах бас нэг баталгаа болж байна гэж үзэхээр байна. Манай улсын хувьд Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил байхаар хуульчилсан бөгөөд гишүүний дахин томилогдох боломжийг хязгаарлаагүй байдаг. Энэ нь нэг талаасаа улс төрчид Цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал юм.

²⁰ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Уб., 2016 он, 183-188 дахь тал

ДҮГНЭЛТ

Эцэст нь дүгнэхэд, Дэлхийн улс орнуудад Үндсэн хуулийн хяналтыг аль ч хэлбэрээр хамгаалах нь Үндсэн хуулиар тунхагласан нийгэм болон улс төрийн тогтвортой тогтолцоог бий болгох маш чухал баталгаа болдог бөгөөд Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлэх нь тухайн субъектийн бие даасан, хараат бус байдлын баталгаа хамгийн чухал байдаг.

Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлын баталгааг бүрэн дүүрэн хангах эрх зүйн орчныг Үндсэн хууль болон тусгайлан гаргасан хуульд нарийвчлан зохицуулалт хийж баталгаажуулахгүй бол Цэцийн шийдвэр эрх мэдэлтнээс Үндсэн хуулийг, Монголын ард түмний язгуур эрх ашгийг хамгаалж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан албан тушаалтнуудын эрх мэдлийг хязгаарласнаар зарим нэг эрх мэдэл бүхий албан тушаалтанд таалагдахгүй юм. Мөн түүнчлэн Улсын Их Хурал нь хууль тогтоох онцгой бүрэн эрхийнхээ дагуу хэн нэгэн Улсын Их Хурлын гишүүний санаачилга, аль нэг улс төрийн хүчний захиалгаар Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд дурын өөрчлөлт оруулж Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдалд халдах нөхцөл дахин давтагдахгүй гэх баталгаа үгүй юм.

Иймд Үндсэн хуульдаа Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлын үндсэн баталгааг нарийвчлан тогтоож өгөх, мөн Цэцийн тухай хуульд гишүүний эрх зүйн байдлыг илүү нарийвчлан тодорхойлж, онцгой журам тогтоож өгөх нь Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүдийн хараат бус байдлын баталгааг бэхжүүлэх зорилгоор дээр дурдсан холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэхээр байна.

ЭХ СУРВАЛЖ**Хууль тогтоомж:**

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль

Монгол хэлээр:

- Д.Лүндээжанцан, *Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт*, УБ. 2014 он
- Ц.Сарантуяа, *Төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим ба Үндсэн хуулийн хяналт*, МУҮХЦ (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), УБ. 2007 он
- Шарль Монтескье. *Хуулийн амин сүнс*. УБ. 2008 он
- Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал*, УБ. 2017 он
- Н.Лүндэндорж, *Шүүх эрх мэдэл*, УБ. 2017 он
- Ц.Сарантуяа, *Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал*, УБ. 2005 он
- Д.Наранчимэг, *Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт* УБ. 2017 он
- Г.Совд нар, *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай тайлбар*, 2000 он
- Н.Жанцан, *Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлыг хангах зохион байгуулалтын болон материаллаг баталгаа*, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), 2007 он
- Г.Совд, Н.Жанцан ... нар, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, УБ. 2000 он, 217 дахь тал
- Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй, төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, УБ. 2016 он
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний газар, *Судалгааны төвийн статистик мэдээ*, УБ. 2018 он

- Эрдэмтдийн судалгааны тайлан, *Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дун шинжилгээ*, УБ. 2015 он, 58 дахь тал
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 03, 2007.03.02-ны өдөр
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 06, 2007.05.23-ны өдөр
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоол.
- Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Уб., 2016 он
- МУИС-ийн Хууль зүйн сургууль, Эрх зүй/NUM Law Review, УБ., 2018 он

Гадаад хэлээр:

- В.К.Бобровка, М.А.Митюков, А.А.Подалов. *Конституционное правосудие в странах СНГ и Балтии. Москва, Зерцало*, 1998 г. стр 46
- Christoph Grabenwarter *Separation of powers and the Independence of Constitutional Courts and Equivalent Bodies*, keynote speech 16 Jan 2011, 2nd Congress of the World Conference on Constitutional Justice, Rio de Janeiro
- Declaration of the Rights of Man and of the Citizen of 26 august 1789

Цахим эх сурвалж:

- <https://www.vfgh.gv.at/index.en.html>
- <https://www.refworld.org/docid/3ae6b53b10.html>
- <http://www.ksrf.ru/en/Info/Pages/default.aspx>

RISTRICIONS ON STATE POWER AND INDEPENDENCE OF JUSTICES OF THE CONSTITUTIONAL COURT OF MONGOLIA

G.Bilguun

LL.M. Candidate, School of Law, NUM.

ABSTRACT:

In this article, it notes that the Constitution restricts the powers of public authorities and high-ranking public officials, that no public official has the right to violate the Constitution, and that the 1992 Constitution of Mongolia established an independent institution called the Constitutional Tsets /Court/ with authority to review and decide whether a decision has breached the Constitution. Some authorities do not like the Constitutional Court's ruling on disputes that breach the Constitution. Therefore, I am writing to emphasize the importance of the independence of justices of the Constitutional Court and how it should be guaranteed and defined in detail in the relevant legislation.

KEY WORDS:

Constitution, Separation of powers, The Constitutional Court of Mongolia, independence of justice of the Constitutional Court.

“ХОРИН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ БА БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ ХАНДЛАГА” ХАВСАРГА СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Б.Өнормаа

УЕПГ-ын хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор

НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын хүн амын тодорхой бүлгүүдийн дундах бэлгийн замын халдварт өвчний тархалт буурахгүй байгаа талаар эрүүл мэндийн байгууллагаас гаргаж буй статистик мэдээллээс харагдаж байна.

Дээрх өвчний тархалтын нэг шалтгаан нь хувь хүний бэлгийн зан үйл, бэлгийн замын халдварт өвчин болон түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг байдаг тул 25 хүртэлх насны, Улаанбаатар хотод оршин суудаг мянган залуусын¹ дунд судалгааг явууллаа.

Энэхүү судалгаагаар залуучуудын бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг, ойлголт, үүнээс урьдчилан сэргийлэх мэдлэгийн түвшинг тодорхойллоо.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгаанд зан үйлийн асуулгын аргыг² хэрэглэн эрх бүхий байгууллагаас баримт, тоон мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээ, материал, тоон үзүүлэлтийг боловсруулах, нэгтгэж дүгнэх, судалгааны нэгдсэн тайланг боловсруулах гэсэн үе шаттайгаар явууллаа.

Судалгаанд хамрагдсан хүмүүсээр 42 төрлийн асуулга бөглүүлж, Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн хороо, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс³ ирүүлсэн тоон мэдээллийг ашиглав.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ

Судалгааны үр дүнд үндэслэн хүн амын тодорхой бүлгийн дундах бэлгийн замын халдварт өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад нөлөөллийн шинжтэй санал гаргаж улмаар хүн амын удмын сан, нөхөн үржихүйд сөргөөр нөлөөлөх

¹ Хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах зорилгоор судалгаанд хамрагдсан хүмүүсийн нэр, эрхэлсэн ажил, сургуулийн нэрийг дурьдаагүй болно.

² “Бэлгийн замын халдварт өвчин болон бэлгийн зан үйлийг тодорхойлох” асуулгыг судлаач О.Баасантогтох, Ж.Батжаргал нартай хамтран боловсруулсан.

³ Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны төв нь тоон мэдээллээ нууцын зэрэглэлтэй ирүүлсэн тул тухайн өвчний тархалт өндөр байгаа засаг захиргааны нэгжийн нэрийг судалгаанд дурьдаагүй болно.

өвчний шинж чанар, хор хөнөөлийн талаар залуучуудын мэдлэгийг дээшлүүлэхэд ач холбогдолтой сургалт, мэдээлэл боловсруулахад ашиглана.

ДӨРӨВ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ⁴

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн тоон мэдээгээр 2017 онд 2017 онд бэлгийн замын халдварт өвчний 24243 тохиолдол 2018 онд 24564 тохиолдол бүртгэгдэж зонхилон тохиолдох халдвар 16130 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 766 буюу 5.0 хувиар өсжээ.

Зонхилон тохиолдох халдвар буюу тэмбүү нийт өвчлөлийн 38,2 хувь, заг хүйтэн 33.9 хувь, трихомониаз 27.8 хувь, ХДХВ/ДОХ 0,1 хувийг тус тус эзэлж байна.

2018 онд тэмбүүгийн өвчлөл 6163 бүртгэгдэж өнгөрсөн онтой харьцуулахад 507 тохиолдлоор буурч, заг хүйтэн 5461 бүртгэгдэж өнгөрсөн оноос 1039 тохиолдлоор өссөн бөгөөд трихомониаз 4488 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оноос 241 тохиолдлоор өссөн байна.

Арван мянган хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөлөөр Хөвсгөл 46.5, Говьсүмбэр 33.4, Сүхбаатар 32.1, Баянхонгор 29.6, Дорнод 29.0, Говь-Алтай 28.5, Хэнтий 22.2, Сэлэнгэ 20.5, Налайх 27, Багануур 27.4 хувьтай улсын дунджаас өндөр байна.

Заг хүйтэн өвчлөлөөр Хөвсгөл 66.7, Говьсүмбэр 23.0, Дорнод 13.2, Дорноговь 28.2, Сүхбаатар 17.3, Баянхонгор 37.9, Багануур 30.5 хувиар улсын дунджаас өндөр байна.

Трихомониазийн өвчлөлөөр Дорнод 52.1, Сэлэнгэ 20.3, Баянхонгор 53.8, Налайх дүүрэг 16.6 хувьтай улсын дунджаас дээгүүр байна.

2018 онд төрөлхийн тэмбүүгийн 49 тохиолдол бүртгэгдэж, төрөлхийн тэмбүү оноштой 11 нярай нас барж 14 амьгүй ураг бүртгэгджээ.

2014 онд Эрүүл мэнд, спортын яам (тухайн үеийн нэр)-наас “Хүний дархлал олдмол хомстол, Бэлгийн замаар дамжих халдварын тандалт”-ын судалгааг хийсэн бөгөөд уг судалгаагаар эрэгтэйчүүдтэй бэлгийн хавтгалд анх орсон эрэгтэйчүүдийн нас залуужиж, эрэгтэй эмэгтэй бэлгийн хавьтагчийн тоо болон тэмбүүгийн тархалт нэмэгдсэн байгаа нь цаашид нийт хүн амын дунд халдвар тарах эрсдэлийг нэмэгдүүлж байна гэж дүгнэжээ.

ТАВ. ЗАЛУУЧУУДЫН БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ БА БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА

Судалгаанд нийт 16-26 насны 1000 залуучууд хамрагдсан болно. Судалгаанд оролцогчид нь нас, хүйс, боловсрол, нийгмийн гарал, одоо оршин суугаа газар, харьяа оршин суугаа газрын хувьд өөр хоорондоо ялгаатай бөгөөд энэхүү судалгаагаар Монгол Улсын залуучуудын дундах бэлгийн зан үйл, бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэгийг тогтоох, энэ төрлийн өвчний гаралтыг судлахыг зорьсон болно.

5.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- 16-18 насныхан нь 267 буюу 26.7 хувийг,
- 19-22 насныхан 682 буюу 68.2 хувийг,
- 23-26 насныхан нь 51 буюу 5.1 хувийг тус тус эзэлж байна.

5.2 Судалгаанд оролцогчдын хүйсийн байдал

Судалгаанд оролцогчдын 52.3 хувь нь эмэгтэй, 47.7 хувь нь эрэгтэй байна.

Энэ нь Монгол Улсын нийт хүн амын тоо 2017 оны байдлаар 3.177.899 байснаас эрэгтэй 1.562.370, эмэгтэй 1.615.529 байна.⁵ Өөрөөр хэлбэл, нийт хүн амын 50.8 хувийн эмэгтэйчүүд, үлдсэн 49.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд тиймээс судалгаанд оролцогчдын 52.3 хувь нь эмэгтэй байгаа нь Монгол Улсын хүн амын хүйсийн харьцаатай дүйж байна хэмээн үзэж болох юм.

⁴ Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн хороо, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс ирүүлсэн мэдээлэл.

⁵ Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас. Дэлгэрэнгүйг http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L03 үзнэ үү. Сүүлд үзсэн огноо: 2019.3.17.

5.3 Судалгаанд оролцогчдын одоо оршин суугаа газар

Улаанбаатар хотод ажиллаж, амьдарч суралцаж буй нийт 1000 залуучуудаас энэхүү судалгаар авсан бөгөөд судалгаанд оролцогчдын 57.2 хувь нь хотын төвд, 17.6 хувь нь хотын төвийн ойролцоо, 25.2 хувь нь хотын захын хороололд амьдардаг байна.

5.4 Судалгаанд оролцогчийн харьяалал

- Улаанбаатар хотын харьяалалтай оролцогч 410 буюу 41 хувийг,
- Дархан, Эрдэнэтийн харьяалалтай оролцогч 97 буюу 9.7 хувийг,
- Аймгийн төвд харьяалалтай оролцогч 333 буюу 33.3 хувийг,
- Сумын төвд харьяалалтай оролцогч 137 буюу 13.7 хувийг,
- Хөдөө /багт/ харьяалалтай оролцогч 23 буюу 2.3 хувийг эзэлж байна.

5.5 Судалгаанд оролцогчдын амьдардаг сууцны нөхцөл

- 537 буюу 53.7 хувь нь орон сууцад,
- 183 буюу 18.3 хувь нь оюутны байранд,
- 77 буюу 7.7 хувь нь галладаг байшинд,
- 62 буюу 6.2 хувь нь хувийн байр, сууцанд,
- 59 буюу 5.9 хувь нь байр хөлсөлдөг,
- 34 буюу 3.4 хувь нь нийтийн байранд,
- 24 буюу 2.4 хувь нь айлын хажуу өрөөнд,
- 24 буюу 2.4 хувь нь гэрт амьдардаг байна.

5.6 Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

- 891 буюу 89.1 хувь нь бүрэн дунд боловсролтой буюу дээд сургуульд элсэн суралцаж байгаа,
- 95 буюу 9.5 хувь нь дээд боловсролтой буюу их дээд сургууль төгсөж, дахин суралцаж байгаа,
- 11 буюу 1.1 хувь нь тусгай дунд боловсролтой,
- 3 буюу 0.3 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байна.

5.7 Судалгаанд оролцогчдын нийгмийн гарал

- 43.7 хувь нь ажилчин,
- 13.4 хувь нь малчин,
- 34.2 хувь нь сэхээтэн,
- 8.7 хувь нь албан хаагч байна.

5.8 Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал

- 752 буюу 75.2 хувь нь гэрлээгүй, тусдаа гэр бүлийн амьдрал зохиогоогүй,
- 73 буюу 7.3 хувь нь гэрлэлтээ батлуулан хамт амьдарч байгаа,
- 77 буюу 7.7 хувь нь гэрлэлтийн баталгаагүй ч хамтран амьдардаг хүнтэй,
- 13 буюу 1.3 хувь нь гэрлэсэн ч одоогоор тусдаа амьдарч байгаа,
- 5 буюу 0.5 хувь нь гэрлэсэн ч гэрлэлтээ цуцлуулсан,
- 80 буюу 8 хувь нь бусад буюу ганц бие гэж хариулсан байна.

5.9 Судалгаанд оролцогчдын бэлгийн харьцаа

- 43.8 хувь нь тогтвортой нэг бэлгийн хамтрагчтай,
- 35.7 хувь нь бэлгийн харьцаанд ороогүй,
- 18.7 хувь нь бэлгийн харьцаа тогтворгүй өөр өөр хавьгагчтай,
- 1.8 хувь нь бэлгийн харьцааны 2 хамтрагчтай байна.

5.10 Судалгаанд оролцогчид хэнтэйгээ амьдардаг

- Нөхөр /эхнэр/ хүүхдийн хамт амьдардаг 28 буюу 2.8 хувь,
- Аав, ээжтэйгээ хамт амьдардаг 416 буюу 41.6 хувь,
- Өвөө, эмээгийн хамт амьдардаг 44 буюу 4.4 хувь,
- Ганцаараа амьдардаг 77 буюу 7.7 хувь,
- Найз нартайгаа хамт амьдардаг 173 буюу 17.3 хувь,

- Найз залуу/бүсгүйн/ хамт амьдардаг 60 буюу 6 хувь,
- Бусад гэсэн нээлттэй хариултыг 202 оролцогч сонссон байх бөгөөд тэд ах эгч, хамаатны төрөл садантайгаа хамт амьдардаг байна.

5.11 Судалгаанд оролцогчдын амьдарч буй газар

Судалгаанд оролцогчдын 215 буюу 21.5 нь оюутны байранд, 155 буюу 15.5 хувь нь айлд /хамаатан танил, найз нөхөд/, 23 буюу 2.3 хувь нь айлын хажуу өрөө түрээсэлж амьдардаг, 122 буюу 12.2 хувь нь байр түрээсэлдэг, 4 буюу 0.4 хувь нь хашаа байшин түрээсэлдэг, 481 буюу 48.1 хувь нь амьдардаг байна.

ЗУРГАА. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ БОЛОН БЗХӨ-ИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Энэхүү судалгаагаар сонгох болон нээлттэй хэлбэрээр хариулах боломжтой нийт 42 асуултын хүрээнд залуучуудын бэлгийн зан үйл болон БЗХӨ-ний талаарх мэдлэгийг шалгасан болно.

6.1 Бэлгийн замын халдварт өвчин залуучуудын дунд хэр түгээмэл тохиолддог гэж бодож байна?

Энэхүү асуултад судалгаанд оролцогчдын 337 буюу 33.7 хувь нь их, 248 буюу 24.8 хувь нь дунд зэрэг, 216 буюу 21.6 хувь нь маш их, 150 буюу 15 хувь нь мэдэхгүй, 45 буюу 4.5 хувь бага, 4 буюу 0.4 хувь нь маш бага гэж хариулсан байна.

Дээрхээс дүгнэвэл, бэлгийн замын халдварт өвчин залуучуудын дунд хэр түгээмэл байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу нийт 55.3 хувь нь маш их, их гэсэн хариултыг сонгосон бөгөөд залуучуудын дунд БЗХӨ түгээмэл тохиолддог хэмээн үзэж болох юм.

6.2 Таны бодлоор залуучуудын ямар бүлэгт бэлгийн замын халдварт өвчин илүү их тохиолдох эрсдэл ихтэй гэж бодож байна вэ?

- 56.5 хувь нь шоу цэнгээн хөөцөлддөг залуус,
- 17.3 хувь нь оюутан, залуучууд,
- 15.4 хувь нь боловсролгүй залуучууд,
- 5.1 хувь нь ажилгүй залуучууд,
- 1.9 хувь нь бэлгийн цөөнх (ижил хүйстэн),
- 1.7 хувь нь бусад,
- 1.6 хувь нь хөдөө, гадаа их явдаг ажил эрхэлдэг залуус,
- 0.5 хувь нь малчин залуучууд бэлгийн замын халдварт өвчин тусах эрсдэлтэй хэмээн хариулжээ.

Өөрөөр хэлбэл, шоу цэнгээнд дурлаж, тохиолдлын бэлгийн харьцаанд ордог эсхүл олон бэлгийн хавьтагчтай хүмүүс бэлгийн замын халдварт өвчин тусах хамгийн эрсдэлтэй бүлэгт хамаардаг гэж судалгаанд хамрагдсан оролцогчдын дийлэнх нь үзсэн байна.

6.3 Залуучуудын дунд бэлгийн замын халдварт өвчний тархалт хэр түвшинд байна гэж үзэж байна вэ?

Дээрх асуултад судалгаанд оролцогчдын 474 буюу 47.4 хувь нь өндөр, 325 буюу 32.5 хувь нь дунд зэрэг, 124 буюу 12.4 хувь нь маш өндөр, 66 буюу 6.6 хувь нь бага, 11 буюу 1.1 хувь нь маш бага гэж хариулжээ.

Энэхүү үр дүн нь график 11-д дурдагдсан судалгааны үр дүнг бататгаж байх бөгөөд тиймээс залуучуудын дунд бэлгийн зам халдвар өвчний тархалт маш өндөр, өндөр зэрэглэл хамаарч байна хэмээн судалгаанд оролцогчдын 59.8 хувь нь үзсэн байна.

6.4 Таны бодлоор залуучуудын БЗХӨ-ний түвшин өндөр байхад ямар хүчин зүйл хамгийн их нөлөөлж байна вэ?

- 630 буюу 63 хувь нь бэлгийн замбараагүй харьцаа газар авсан,
- 542 буюу 54.2 хувь архидалт, мансуурал, зугаа цэнгэл их байгаагай холбоотой

хэмээн үзсэн, - 509 буюу 50.9 хувь нь бэлгийн замын өвчний талаар ойлголт мэдлэг тааруу,

- 247 буюу эрт бэлгийн харьцаа,
- 204 буюу тохиолдлын бэлгийн харьцаа,
- 197 буюу халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэггүй,
- 40 буюу хэний юу хийх нь чөлөөтэй болсон гэсэн зүйлүүд нөлөөлж байна гэж үзжээ.

6.5 Та бэлгийн замын өвчний хор хөнөөл, түүнээс хэрхэн сэргийлэх мэдлэгийн түвшнийг хэрхэн үнэлэх вэ?

- 430 буюу 43 хувь нь дунд зэрэг,
- 242 буюу 24.2 хувь нь сайн,
- 166 буюу 17 хувь нь муу,
- 82 буюу 8.2 хувь нь маш сайн,
- 80 буюу 8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

6.6 Та бэлгийн замын өвчний хор хөнөөл, түүнээс хэрхэн сэргийлэх талаарх мэдлэг, мэдээллийг ихэвчлэн ямар эх сурвалжаас авдаг вэ?

- 369 буюу 36.9 хувь нь интернетээс,
- 161 буюу 16.1 хувь нь эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөнөөс,
- 120 буюу 12 хувь нь TV эрүүл мэндийн нэвтрүүлгээс,
- 114 буюу 11.4 хувь нь найз нөхдөөсөө,
- 70 буюу 7 хувь нь сургуулийн эмч, нийгмийн ажилтнаас,
- 61 буюу 6.1 хувь нь аав ээжээсээ,
- 58 буюу 5.8 хувь нь мэдээлэл авч чаддаггүй,
- 29 буюу 2.9 хувь нь ах дүү хамаатан саднаасаа,
- 14 буюу 1.4 хувь нь сонин сэтгүүлээс,
- 4 буюу 0.4 хувь нь эмч эмнэлгийн байгууллагаас мэдээллийг ихэвчлэн авдаг гэж хариулт өгсөн байна.

6.7 БЗХӨ-ний дараах төрлийн өвчнүүдийн дамжих хэлбэр, урьдчилан сэргийлэх, эмчлэх арга замыг хэр зэрэг мэдэх вэ?

Судалгааны үр дүнгээс үзвэл заг хүйтэн өвчний талаар судалгаанд оролцогчдын

- 312 буюу 31.2 хувь нь огт мэдэхгүй,
- 311 буюу 31.1 хувь нь дунд зэрэг,
- 209 буюу 20.9 хувь нь маш муу,
- 112 буюу 11.2 хувь нь сайн,
- 56 буюу 5.6 хувь нь маш сайн мэднэ гэж хариулсан байна.

Тэмбүү өвчний талаар судалгаанд оролцогчдын

- 318 буюу 31.8 хувь нь дунд зэрэг,
- 252 буюу 25.2 хувь нь огт мэдэхгүй,
- 240 буюу 24 хувь нь маш муу,
- 132 буюу 13.2 хувь нь сайн,
- 58 буюу 5.8 хувь нь маш сайн мэднэ гэж хариулжээ.

Трихомониаз өвчний талаар судалгаанд оролцогчдын

- 470 буюу 47 хувь нь огт мэдэхгүй,
- 228 буюу 22.8 хувь нь маш муу,
- 209 буюу 20.9 хувь нь дунд зэрэг,
- 60 буюу 6 хувь нь сайн, 33 буюу 3.3 хувь нь маш сайн мэднэ гэж хариулжээ.

Мөөгөнцөр өвчний талаар судалгаанд оролцогчдын

- 366 буюу 36.6 хувь нь огт мэдэхгүй,
- 265 буюу 26.5 хувь нь дунд зэрэг,

- 214 буюу 21.4 хувь нь маш муу,
- 101 буюу 10.1 хувь нь сайн,
- 54 буюу 5.4 хувь нь сайн мэднэ гэсэн хариултыг сонгосон байна.

Гарднереллез өвчний талаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу

- 51.7 хувь нь огт мэдэхгүй байна.

Хомхой өвчний талаар судалгаанд оролцогчдын

- 461 буюу 46.1 хувь нь огт мэдэхгүй,

Гепатит В өвчний талаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 53.7 хувь нь огт мэдэхгүй байна.

Мөн өнгөний лимфогранулемоз өвчний талаар 589 буюу 58.9 хувь нь огт мэдэхгүй, донованоз өвчний талаар 592 буюу 59.2 хувь нь огт мэдэхгүй, хламидоз өвчний талаар 610 буюу 61 хувь нь огт мэдэхгүй, микоплазмоз өвчний талаар 553 буюу 55.3 хувь нь огт мэдэхгүй, цитомегаловирус өвчний талаар 619 буюу 61.9 хувь нь огт мэдэхгүй, ДОХ өвчний талаар 175 буюу 17.5 хувь нь огт мэдэхгүй байна.

Дээрх үр дүнгээс харвал, залуучуудын дунд БЗХӨ-ний талаарх мэдлэг маш бага байна. Учир нь эдгээр өвчний талаар огт мэддэггүй гэсэн хариулт 17.5 – 61.9 хувийг эзэлж байна.

Түүнчлэн, БЗХӨ-нүүд дундаас хамгийн хор хөнөөлтэй өвчний болох ДОХ-ын талаар мэдлэг бусад БЗХӨ-ний талаарх мэдлэгээс өндөр байгаа хэдий ч бусад өвчний талаар мэдлэг маш доогуур байгаа нь залуучуудын эрүүл мэндийн боловсрол тэр дундаа бэлгийн харьцаа, зан үйл, БЗХӨ-ний талаарх мэдлэг дутмаг байгааг илэрхийлж байна.

6.8 Бэлгийн эрүүл мэндийн шалтгааны улмаас эмч, эмнэлгийн байгууллагад хандаж байсан эсэх

Судалгаанд оролцогчдын 181 буюу 18.1 хувь нь бэлгийн эрүүл мэндийн улмаас эмч, эмнэлгийн байгууллагад хандсан бөгөөд үлдсэн 819 буюу 81.9 хувь нь эмч эмнэлгийн байгууллагад хандаж байгаагүй гэж хариулжээ.

6.9 Эмнэлэгт хандах болсон шалтгаанаа тодруулна уу?

Нийт судалгаанд хамрагдсан 1000 оролцогчоос 181 оролцогч бэлгийн эрүүл мэндийн шалтгааны улмаас эмч, эмнэлгийн байгууллагад хандсан шалтгааныг тодруулахад:

- 11 буюу 6.1 хувь нь тохиолдлын бэлгийн харьцаанаас эхлээд эрсдэлтэй үйлдэл хийсэн,
- 23 буюу 12.7 хувь нь эрсдэлтэй алхам хийж сэтгэл санааны хувьд тайван байж чадахгүй байсан,
- 49 буюу 27.1 хувь нь БЗХӨ-ний шинж тэмдэг, зовуур илэрсэн,
- 96 буюу 53 хувь нь эрсдэл зовуур илэрсэн гэлтгүй сайн дураараа үзлэгт орж байхыг боддог,
- 2 буюу 1.1 хувь нь БЗХӨ-өөс өөр хэлбэрээр хандах болсон гэсэн хариултыг өгсөн байна.

6.10 Бэлгийн замын халдварт өвчин тусаж байсан уу?

Судалгаанд оролцогчдын 891 буюу 89.1 хувь нь бэлгийн замын халдварт өвчин тусаж байгаагүй гэсэн бол 109 буюу 10.9 хувь нь бэлгийн замын халдварт өвчин тусаж байсан гэжээ.

6.11 БЗХӨ хэдэн удаа туссаныг тодруулсан байдал

Нийт судалгаанд оролцогчдоос 109 нь бэлгийн замын халдварт өвчин тусаж байсан гэж хариулсан байх бөгөөд тэдгээр оролцогчдоос

- БЗХӨ нэг удаа тусаж байсан 81 буюу 74.3 хувь,
- олон удаа тусаж байсан 16 буюу 14.7 хувь,
- 13 буюу 12 хувь нь цөөн удаа бэлгийн замын халдварт өвчин тусаж байсан гэж хариулжээ.

6.12 БЗХӨ туссан шалтгааныг тодруулсан байдал

Нийт судалгаанд хамрагдсан 1000 оролцогчийн 109 оролцогч нь БЗХӨ тусаж байсан гэж хариулсан бөгөөд БЗХӨ тусах болсон шалтгааныг тодруулахад:

- 27 буюу 24.8 хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн харьцаанд орсон,
- 52 буюу 47.7 хувь нь хамгаалах хэрэгсэлгүй /бэлгэвчгүй/ тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд орсон,
- 30 буюу 27.5 хувь нь өөрийн найз залуу /найз охиноос/ халдвар авсан гэж тус тус хариулжээ.

6.13 Бэлгийн замын ямар халдварт өвчин туссаныг тодруулсан байдал

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 109 нь бэлгийн замын халдварт өвчин туссан гэж хариулсан:

- 55 буюу 50.4 хувь нь заг хүйтэн,
- 18 буюу 16.5 хувь нь тэмбүү,
- 18 буюу 16.5 хувь нь мөөгөнцөр,
- 10 буюу 9.2 хувь нь трихомониаз,
- 3 буюу 2.8 хувь нь хламидоз,
- 2 буюу 1.8 хувь нь хомхой,
- 2 буюу 1.8 хувь нь өнгөний лимфогранулематоз,
- 1 буюу 0.9 хувь нь гарднереллез,
- 1 буюу 0.9 хувь нь гепатит өвчинг туссан гэж хариулжээ.

Харин донованоз, микоплазмоз, цитомегаловирус, ДОХ зэрэг өвчнийг тусаагүй байна.

6.14 Өвчнөө эмчлүүлэхийн тулд авсан арга хэмжээ

БЗХӨ туссан 109 тохиолдлоос

- 81 буюу 74.3 хувь нь нь эмнэлэгт очиж эмчилгээ хийлгэсэн,
- 21 буюу 19.3 хувь нь эмчээс асууж зөвлөгөө авсан,
- 4 буюу 3.7 хувь нь бусад хүмүүсээс судалж өөрөө эмчилсэн,
- 3 буюу 2.7 хувь нь тэгсгээд гайгүй болохоор орхичихсон гэж хариулжээ.

6.15 Таны бодлоор оюутан залуучуудын бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг ямар түвшинд байна вэ?

Судалгаанаас оролцогчдын бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэгийг дүгнэхдээ

- 38 буюу 3.8 хувь нь сайн,
- 352 буюу 35.2 хувь нь дунд,
- 447 буюу 44.7 хувь нь муу,
- 163 буюу 16.3 хувь нь хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.

6.16 Та өөрийгөө бэлгийн замын өвчлөлөөс сэргийлж чадна гэж боддог уу?

- 223 буюу 22.3 хувь нь бүрэн чадна,
- 479 буюу 47.9 хувь нь чадна,
- 223 буюу 22.3 хувь нь нэг их итгэлтэй байж чадахгүй,
- 75 буюу 7.5 хувь нь итгэлгүй байна гэж хариулт өгсөн байна.

ДОЛОО. ХУВЬ ХҮНИЙ БЭЛГИЙН ХАРЬЦААНЫ ТАЛААР АСУУДАЛ

Судалгаанд оролцогчдоос тухайн хүний бэлгийн харьцааны талаарх асуудлыг тодруулж дүн шинжилгээ хийсэн болно.

7.1 Судалгаанд оролцогчдын анх бэлгийн харьцаанд орсон нас

Судалгаанаас үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын 357 буюу 35.7 хувь нь бэлгийн харьцаанд ороогүй байна.

Түүнчлэн 10-13 настайдаа бэлгийн харьцаанд орсон гэж хариулсан 5 тохиолдол байна. Харин судалгаанд оролцогчдын 319 буюу 31.9 хувь нь 14-16 настайдаа, 282 буюу 28.2 хувь нь 17-19 настайдаа, 37 буюу 3.7 хувь нь 20-23 настайдаа анх бэлгийн харьцаанд орсон гэж хариулсан байна. Дээрхээс үзвэл залуучуудын дунд анх бэлгийн харьцаанд 14-16 насандаа түгээмэл байдлаар ордог нь ажиглагдаж байна.

Монгол Улсын 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар *“Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл”*, мөн 12.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт *“арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж”*, 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт *“... арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн”*, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт *“Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн...”* бэлгийн хүчирхийллийн аливаа үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна.

Өөрөөр хэлбэл, 14 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон тохиолдолд Эрүүгийн хуульд зааснаар хохирогчийн хүсэл зоригоос үл хамааран бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог. Түүнчлэн, 18 насанд хүрсэн хүн тухайн хүнийг 16 насанд хүрээгүйг нь мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон тохиолдолд Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд заасан *“Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох”* гэмт хэрэг үйлдсэнд тооцогдох боломжтой юм.

Гэтэл дээр дурдсан Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой тохиолдлууд нэлээд байсан боловч ямар нэг ямар нэг байдлаар цагдаагийн байгууллагад мэдээлээгүй бөгөөд насанд хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох үзэгдэл нуугдмал, далд хэлбэрт гарсаар байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдсан болно. Тухайлбал, 10-13 насандаа анх бэлгийн харьцаанд орсон 5 тохиолдлыг шалган үзвэл Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан *“Хүчиндэх”* гэмт хэргийн шинжийг агуулж байгаа юм.

7.2 Бэлгийн харьцаанд орох болсон шалтгаан

- Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 414 буюу 64.4 хувь нь өөрийн хүсэл сонирхлоор,
- 62 буюу 9.6 хувь нь найз залуу /найз охин/-гийн шахалтаар,
- 79 буюу 12.3 хувь нь харилцагч маань таалагдсан,
- 77 буюу 12 хувь нь санамсаргүй байдлаар,
- **11 буюу 1.7 хувь нь бусдын хүчинд автсан** гэсэн хариултыг өгсөн байна.

Судалгааны явцад бусдын хүчинд автсан 11 тохиолдол байх бөгөөд үүнээс дүгнэвэл бусдад хүчирхийлүүлсэн буюу Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан *“Хүчиндэх”* гэмт хэргийн хохирогч болсон байхыг үгүйсгэх аргагүй юм.

7.3 Анх бэлгийн харьцаанд хэнтэй орсон талаар

- 479 буюу 74.5 хувь нь найз залуу, найз бүсгүйтэйгээ,
- 144 буюу 22.4 хувь нь тохиолдлын улмаас танилтайгаа,
- 16 буюу 2.5 хувь нь танихгүй хүнтэй,
- 4 буюу 0.6 хувь нь хамаатны хүнтэйгээ гэж хариулсан байна.

7.4 Анхны бэлгийн харьцааны талаарх бодол

Судалгаанд оролцогчдоос бэлгийн харьцаанд орсон 643 хүнээс анхны бэлгийн харьцааны талаарх бодлыг нь асуухад:

- 163 буюу 25.3 хувь нь болох ёстой юм болсон л гэж боддог,
- 95 буюу 14.8 хувь нь харамсаж явдаг,

- 151 буюу 23.5 хувь нь харамсдаг ч үгүй дурсдаг ч үгүй,
- 131 буюу 20.4 хувь таатай сэтгэгдэл төрдөг,
- 103 буюу 16 хувь нь нандин сайхнаар дурсдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Дээрхээс үзвэл, бэлгийн харьцаанд анх орсон сэтгэгдлийн хувьд залуучуудын дунд болох ёстой зүйл болж өнгөрсөн учраас харамсах сэтгэл төрдөггүй гэсэн хариулт давамгайлж байна.

7.5 Бэлгийн хамтрагчтай эсэх

- 685 буюу 68.5 хувь нь одоогоор бэлгийн хамтрагчгүй,
- 248 буюу 24.8 хувь тогтмол нэг хамтрагчтай,
- 67 буюу 6.7 хувь нь хэд хэдэн хамтрагчтай гэж хариулжээ.

7.6 Бэлгийн чиг хандлагаа тодорхойлсон байдал

- 993 буюу 99.3 хувь нь эсрэг хүйсийн хүнээ сонирхдог,
- **3 буюу 0.3** хувь нь ижил хүйсийн хүнээ сонирхдог,
- **4 буюу 0.4** хувь нь аль аль хүйсийн хүнийг сонирхдог гэж хариулт өгсөн байна.

7.6 Тохиолдлын бэлгийн харьцаанд орж байсан эсэх

- 542 буюу 54.2 хувь нь тохиолдлын бэлгийн харьцаанд орж байгаагүй гэж,
- 380 буюу 38 хувь нь ховорхон байдаг гэж,
- 60 буюу 6 хувь нь нэлээд олон удаа тохиолдсон гэж,
- 8 буюу 0.8 хувь нь байнга тохиолддог гэсэн бол
- 10 буюу 0.1 хувь нь энэ асуултад хариулаагүй байна.

7.7 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн харьцаанд орж байсан эсэх

- 748 буюу 74.8 хувь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн харьцаанд орж байгаагүй гэж,
- 203 буюу 20.3 хувь нь цөөн удаа гэж,
- 49 буюу 4.9 хувь нь нэлээд олон удаа гэж хариулсан байна.

7.8 Бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэдэг эсэх

Судалгаанаас авч үзэхэд байнгын хамтрагчтайгаа бэлгийн харьцаанд орохдоо

- бэлгэвч огт хэрэглэдэггүй **637 буюу 63.7 хувь**,
- ихэнхдээ хэрэглэдэг 174 буюу 17.4 хувь,
- тогтмол бэлгэвч хэрэглэдэг 113 буюу 11.3 хувь,
- хааяа бэлгэвч хэрэглэдэг тохиолдол 76 буюу 7.6 хувийг тус тус эзэлж байна. Харин тохиолдлын бэлгийн харьцаанд орох үедээ бэлгэвч хэрэглэдэг эсэхийг тодруулахад **676 буюу 67.6 хувь нь** огт хэрэглэдэггүй гэж, 128 буюу 12.8 хувь нь ихэнхдээ хэрэглэдэг гэж, 125 буюу 12.5 хувь нь тогтмол хэрэглэдэг гэж, 71 буюу 7.1 хувь нь хааяа хэрэглэдэг гэж хариулжээ.

Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглэдэг эсэхийг тодруулахад **698 буюу 69.8 хувь** нь огт хэрэглэдэггүй гэж, 142 буюу 14.2 хувь нь ихэнхдээ хэрэглэдэг гэж, 58 буюу 5.8 хувь нь хааяа хэрэглэдэг гэж, 102 буюу 10 хувь нь тогтмол хэрэглэдэг гэж хариулжээ.

Дээрхээс дүгнэвэл, залуучуудын дунд бэлгэвч хэрэглээний асуудал маш бага байх бөгөөд ялангуяа тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч огт хэрэглэдэггүй тохиолдол **67.6 хувь** байгаа нь энэхүү үйлдлийн улмаас үүсэх цаашдын үр дагавар болох хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчин тусах зэрэг эрсдэлийг бий болгоход гол нөлөө үзүүлж байна.

НАЙМ. БЗХӨ, ДОХ-ООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГЫН ТАЛААРХ МЭДЛЭГ

Судалгаанд оролцогчдын 676 буюу 67.6 хувь нь БЗХӨ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх аргын талаар сайн мэдэхгүй гэж, 151 буюу 15.1 хувь нь хангалттай мэдлэгтэй гэж, 173 буюу 17.3 хувь нь бараг мэдэхгүй гэж хариулжээ.

Дээрхээс дүгнэвэл, ЕБС-д хүүхдүүдэд бэлгийн харьцаа, БЗХӨ-нөөс хэрхэн сэргийлэх талаар мэдлэг дутмаг олгодог, эрүүл мэндийн хичээл ЕБС-ийн хөтөлбөрт тусгагдан, ордог боловч хангалттай мэдлэг мэдээллийг сурагчдад олгож чадахгүй байгаагаас хүүхдүүд энэ талаарх мэдлэг, боловсрол дутмаг байдлаар амьдралд хөл тавьж байна. Их дээд сургуульд залуучуудын бэлгийн зан үйл, БЗХӨ-ний талаар мэдлэг олгох эрүүл мэндийн хичээл огт заагддаггүй нь залуучуудын энэ талаар мэдлэг дутмаг байхад нөлөөлж байна гэж дүгнэж болох юм.

8.1 БЗХӨ, ДОХ-оос хэрхэн урьдчилан сэргийлдэг талаар

Судалгаанд оролцогчдын **453 буюу буюу 45.3 хувь** нь БЗХӨ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй гэж, **83 буюу 8.3 хувь** нь мэдээлэл байнга авч эрсдэлт зан үйлээс сэргийлдэг гэж, **16 буюу 1.6 хувь** нь бэлгийн хамтрагчтайгаа хамт шинжилгээ хийлгэдэг гэж, **28 буюу 2.8 хувь** нь бэлгийн хамтрагчдаа шаардлага тавьдаг гэж, **140 буюу 14 хувь** нь бэлгэвч тогтмол хэрэглэдэг гэж, **37 буюу 3.7 хувь** байнга эмчийн үзлэгт ордог гэсэн хариултыг өгсөн байна.

8.2 Жирэмслэлтээс хэрхэн сэргийлдэг тухай /эмэгтэйчүүдийн хувьд/

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс жирэмслэлтээс хэрхэн сэргийлдэг тухай асуухад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй тохиолдол **51 хувь**, өөрөөсөө шалтгаална гэж боддоггүй тохиолдол **14 хувийг** эзэлж байна. Харин жирэмслэлтээс хамгаалахын тулд бэлгэвч тогтмол хэрэглэдэг гэж **13 хувь** нь хариулсан бол, эм уудаг гэж **8 хувь** нь, тариа тариулдаг гэж **8 хувь** нь, календарь хөтөлдөг гэж **6 хувь** нь хариулсан байна.

Дээрхээс дүгнэхэд судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь буюу **65 хувь** жирэмслэлтээс сэргийлэх ямар нэгэн арга хэмжээ авдаггүй болох нь ажиглагдаж байна. Энэ нь нэг талаасаа хүсээгүй жирэмслэлтэд болж, үр хөндүүлэх цаашлаад эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаагаараа хохирол маш том эрсдэлийг дагуулж буйг дурдах нь зүйтэй.

8.3 БЗХӨ, ДОХ-ын шинжилгээнд ордог эсэх

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдоос БЗХӨ-ний шинжилгээнд хамрагдаж байсан эсэхийг тодруулахад огт хамрагдаж байгаагүй гэж **80.9 хувь** нь хариулсан бол, ганц нэг удаа хамрагдсан гэж **13 хувь** нь, хэд хэдэн удаа хамрагдсан гэж **4.2 хувь** нь, тогтмол хамрагддаг гэж **1.9 хувь** нь хариулжээ.

Харин ХДХВ/ДОХ шинжилгээнд хамрагдсан эсэхийг тодруулахад хамрагдаж байгаагүй гэж **81.4 хувь** нь, ганц нэг удаа хамрагдсан гэж **13.6 хувь** нь, хэд хэдэн удаа хамрагдсан гэж **3.1 хувь** нь, тогтмол хамрагддаг гэж **1.9 хувь** нь хариулжээ.

Судалгаанд оролцогчдын **69.8 хувь** нь эмчийн үзлэгт тогтмол хамрагддаг гэж, хэд хэдэн удаа хамрагдсан гэж **20.8 хувь** нь, ганц нэг удаа хамрагдсан гэж **6.2 хувь** нь, огт хамрагдаж байгаагүй гэж **3.2 хувь** нь хариулсан байна.

Дээрхээс дүгнэвэл, судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу **69.8 хувь** нь эмчийн үзлэгт /БЗХӨ, ДОХ-оос бусад/ тогтмол хамрагддаг гэж хариулсан боловч БЗХӨ болон ДОХ-ын шинжилгээнд ордог эсэхийг асуухад эмчийн үзлэгээс урвуу хамааралтай буюу огт хамрагддаггүй тохиолдол давамгайлж байна.

8.4 Хамтрагчтайгаа бэлгийн харьцаанд орохоосоо өмнө БЗХӨ, ХДХВ/ДОХ-ын шинжилгээ өгч байсан эсэх

Судалгаанаас авч үзэхэд дийлэнх буюу **955 буюу 95.5 хувь** нь хамтрагчтайгаа бэлгийн харьцаанд орохоосоо өмнө БЗХӨ, ХДХВ/ДОХ-ын шинжилгээ өгч байгаагүй байна. Үлдсэн **4.5 хувь** нь энэ төрлийн шинжилгээг өгч байсан байна.

8.5 Судалгаанд оролцогчид нь дараах зүйлсийг хэрэглэдэг эсэх

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу **62.7 хувь** нь тамхи тогтмол татдаг бөгөөд тамхи хааяа татдаг тохиолдол **24.7 хувийг** эзэлж байна. Өөрөөр хэлбэл, нийт судалгаанд оролцогчдын **87.4 хувь** нь тамхи татдаг, үлдсэн **12.6 хувь** нь тамхи огт татдаггүй байна.

Судалгаанд оролцогчдын **59.3 хувь** нь архи согтууруулах ундаа тогтмол хэрэглэдэг байх бөгөөд 37.6 хувь нь архи согтууруулах ундаа хааяа хэрэглэдэг, архи согтууруулах ундаа огт хэрэглэдэг тохиолдол маш бага буюу 3.1 хувийг эзэлж байна.

8.6 БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийлгэдэг эсэх /жилд дунджаар 2 ба түүнээс дээш бол тогтмол гэж үзнэ/

БЗХӨ-нөөс урьдчилан сэргийлэх үзлэгт судалгаанд оролцогчдын **69.1 хувь нь огт хамрагдаж байгаагүй бөгөөд** 26.9 хувь нь өөрийн хүсэлтээр жилд 1 удаа үзлэгт хамрагддаг гэсэн бол 4хувь нь өөрийн хүсэлтээр жилд 2 удаа хийлгэдэг гэж хариулсан байна.

ЕС. ДҮГНЭЛТ

1. Бэлгийн замын халдварт өвчин залуучуудын түгээмэл тохиолдол байх бөгөөд судалгаанд оролцогчдоос БЗХӨ залуучуудын дунд хэр байгааг тодруулахад 55.3 хувь нь маш их, их гэсэн хариултыг сонгосон байна. Өөрөөр хэлбэл, залуучуудын дунд БЗХӨ түгээмэл тохиолддог хэмээн үзэж болох юм.

Энэ нь залуучуудын дунд БЗХӨ, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, бэлгийн зан үйлийн талаарх мэдлэг муу байгаагаас үүдэлтэй гэж үзэж байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 50-аас дээш хувь нь өнгөний лимфогранулемоз, донованоз, хламидоз микоплазмоз, цитомегаловирус зэрэг өвчний талаар огт мэдэхгүй байна.

Харин судалгаанд оролцогчдын хувьд ДОХ талаар маш сайн мэддэг гэсэн хариулт хамгийн олон буюу 17.3 хувийг эзэлж байна. Үүний дараагаар заг хүйтэн өвчнийг маш сайн мэддэг гэж 5.6 хувь нь хариулсан байна.

Гэтэл 17.3 хувь, 5.6 хувь гэдэг үзүүлэлт маш бага үзүүлэлт бөгөөд БЗХӨ-нүүд дундаас хамгийн хор хөнөөлтэй өвчний болох ДОХ-ын талаар мэдлэг бусад БЗХӨ-ний талаарх мэдлэгээс өндөр байгаа хэдий ч бусад өвчний талаар мэдлэг маш доогуур байгаа нь залуучуудын эрүүл мэндийн боловсрол тэр дундаа бэлгийн харьцаа, зан үйл, БЗХӨ-ний талаарх мэдлэг дутмаг байгааг илэрхийлж байна.

Мөн судалгаанд нь оролцогчдын 32.4 хувь нь 10-16 настайдаа буюу ЕБС-д суралцаж байх үедээ бэлгийн харьцаанд анх орсон байна. Иймд залуучуудын дунд БЗХӨ, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, бэлгийн зан үйлийн талаар зохих мэдлэг олгох сургалт зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна. /ЕБС болон Их дээд сургуульд энэ чиглэлийн хичээлийг хөтөлбөрийг боловсронгуй болгон тусгах/

2. Бэлгийн харьцаа тогтворгүй буюу өөр өөр хавьтагчтай, бэлгийн харьцааны 2 хамтрагчтай тохиолдолд цөөнгүй буюу 20.5 хувийг эзэлж байна. Иймд залуучуудыг бэлгийн нэг хамтрагчтай байснаар бэлгийн замын халдварт өвчин болон эрсдэлт зан үйлээс ангид байх боломжтойг мэдүүлэн таниулах. Мөн тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанаас татгалзахыг уриалах. Учир нь судалгаанд оролцогчдын 44.8 хувь тодорхой байдлаар тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд орж байсан бөгөөд энэ нь БЗХӨ тусах эрсдэлийг хамгийн ихээр бий болгож байдаг.

3. Судалгааны үр дүнгээс үзвэл 16-26 насны залуучуудын дунд бэлгийн зан үйл, БЗХӨ-ний талаар мэдлэг, мэдээлэл хомс байх бөгөөд БЗХӨ туссан ч эмчид хандалгүй эдгэрэхийг хүлээдэг хандлага ажиглагдаж байна. Иймд залуучуудын эмчийн үзлэгт хамруулж, БЗХӨ талаар мэдлэг олгох зөвлөгөө өгөх.

Түүнчлэн, бэлгийн харьцааны хэд хэдэн хамтрагчтай тохиолдол цөөнгүй байх бөгөөд тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч хэрэглээгүйгээс бэлгийн замын халдварт өвчин туссан тохиолдол цөөнгүй байна.

Байнгын хамтрагчтайгаа бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч огт хэрэглэддэггүй тохиолдол 63.7 хувийг эзэлж байх бөгөөд тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд орохдоо бэлгэвч огт хэрэглэддэггүй тохиолдол дээрхээс олон буюу 67.6 хувийг эзэлж байгаа нь залуучуудын дунд бэлгэвчний хэрэглээ маш бага байгааг илэрхийлж байна. Иймд

бэлгэвчний хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч БЗХӨ-нөөс урьдчилан сэргийлэх арга замыг олон нийтэд сурталчлах, ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийн боловсронгуй болгох /эрэгтэй, эмэгтэй хөвгүүдэд тус тусад нь эрүүл мэндийн хичээлийг оруулах/.

4. Залуучуудын дунд БЗХӨ туссан тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын дундаас 109 оролцогч нь БЗХӨ тусаж байсан гэж хариулсан бөгөөд БЗХӨ тусах болсон шалтгааныг тодруулахад 24.8 хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн харьцаанд орсон, 47.7 хувь нь хамгаалах хэрэгсэлгүй /бэлгэвчгүй/ тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд орсон, 30 буюу 27.5 хувь нь өөрийн найз залуу /найз охиноос / халдвар авсан гэж тус тус хариулжээ.

Дээрхээс үзвэл тохиолдлын шинжтэй бэлгийн харьцаанд бэлгэвчгүй орсны улмаас БЗХӨ туссан тохиолдол хамгийн түгээмэл байна. Бэлгийн замын ямар халдварт өвчин туссаныг тодруулахад 50.4 хувь нь заг хүйтэн, 16.5 хувь нь тус тус тэмбүү болон мөөгөнцөр өвчин туссан байна.

Ийнхүү БЗХӨ туссан хэдий ч эмнэлгийн байгууллагад ханддаггүй тохиолдол элбэг байна. Түүнчлэн, судалгаанд оролцогчдын хувьд эмнэлгийн байгууллагад ханддаггүй тохиолдол дийлэнх олонх буюу 81.9 хувийг эзэлж байна.

Гэсэн хэдий ч энэ нь өөр хоорондоо ялгамжтай байх судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 69.8 хувь нь эмчийн үзлэгт /БЗХӨ, ДОХ-оос бусад/ тогтмол хамрагддаг гэж хариулсан боловч БЗХӨ болон ДОХ-ын шинжилгээнд ордог эсэхийг асуухад эмчийн үзлэгээс урвуу хамааралтай буюу огт хамрагддаггүй тохиолдол давамгайлж байна. Өөрөөр хэлбэл, залуучууд эмнэлгийн байгууллагад огт ханддаггүй хэрэг биш бөгөөд зөвхөн БЗХӨ, ДОХ-ын шинжилгээ, үзлэг, зөвлөгөө авахаар эмнэлгийн байгууллагад ханддаггүй болохыг илэрхийлж байна.

5. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь буюу 65 хувь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэгэн арга хэмжээ авдаггүй болох нь ажиглагдаж байна. Энэ нь нэг талаасаа хүсээгүй жирэмслэлтэд болж, үр хөндүүлэх цаашлаад эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаагаараа хохирол маш том эрсдэлийг дагуулж буйг дурдах нь зүйтэй.

Иймд эмэгтэйчүүдийн хувьд хүсээгүй жирэмслэлтээс хамгаалахын тулд хэрхэх талаар зөвлөгөө, энэ талын мэдлэг олгох шаардлагатай болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

6. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь интернетээс, эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөнөөс, TV эрүүл мэндийн нэвтрүүлгээс, найз нөхдөөсөө, сургуулийн эмч, нийгмийн ажилтнаасаа БЗХӨ, түүний хор хөнөөл, хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг бэлгийн боловсролыг авдаг бөгөөд тэргүүлэгч эх сурвалж нь интернет байна. Иймд залуучуудын эрүүл мэндийн боловсрол тэр дундаа бэлгийн харьцаа нөхөн үржихүйн боловсролыг сайжруулахын тулд тэдэнд мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор дээрх эх сурвалжийг ашиглах бүрэн боломжтой.

7. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэгт “..эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг хуулиар тогтооно”, гэж заасан байдаг. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

Үндсэн хуульд заасны дагуу иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй бөгөөд төрөөс тэр эрхийг нь хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцдаг. Тэр ч утгаараа манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад иргэний энэ эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан байдаг.

Тухайлбал: Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “*Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх*

хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна” гэж заасан бөгөөд мөн хуулийн 20 дугаар зүйлд “Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг”-ийг тусгаж өгсөн бөгөөд 20.2.5-д “хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах” үүрэгтэй болохыг хуульчилж өгсөн байна.

Мөн Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5-д “иргэнд албан болон албан бус сургалтаар боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, түүний боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохиож байгаа ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах” гэж боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгаж өгсөн байна.

Түүнчлэн, Бага дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудад хувь хүний эрүүл мэндийн боловсрол хийгээд, эмч эмнэлгийн байгууллагад хандах эрх, салбар байгууллагын эрх, үүргийг хуульчилж өгсөн бөгөөд хууль эрх зүйн орчны хувьд зохицуулалтууд байгаа хэдий ч практикт төдийлөн хэрэгжихгүй байна.

АРАВ. САНАЛ

1. Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглан олон нийтэд сурталчлах,

2. Мөн Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5-д “иргэнд албан болон албан бус сургалтаар боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, түүний боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохиож байгаа ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах” гэж заасны дагуу Ерөнхий боловсрол болон их дээд сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт нөхөн үржихүйн болон бэлгийн боловсрол олгох сургалтыг тусгах

3. Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-г “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна” гэж заасны дагуу БЗХӨ-г эрт оношлох үүднээс залуучуудыг энэ төрлийн үзлэг оношилгоонд хамруулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах.

ЭХ СУРВАЛЖ


Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 1992, №1;
- Бага дунд боловсролын тухай хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2002, №19;
- Боловсролын тухай хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2002, №19;
- Дээд боловсролын тухай хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2002, №19;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2015, №8;
- Эрүүл мэндийн тухай хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2011, №11;
- Эрүүгийн хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2002, №5;
- Эрүүгийн хууль, *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2016, №7;
- Арван найманд насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалсан суурь судалгаа, УЕПГ-ССТ-ийн Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах хүрээлэн, 2018 он.

Цахим эх сурвалж:

- Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас, www.1212.mn

НҮБ-ЫН ДҮРЭМ БА УЛС ОРНУУДЫН ХИЛИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ



Ш. Чулуунбат
*ДХИС-ийн дэд профессор,
хурандаа*



М.Баярсайхан
*ДХИС-ын Хил судлалын ухааны
докторант*

ТОВЧЛОЛ:

Өнөөдөр манай дэлхий дээр НҮБ-ын гишүүн 193 улс орон зэрэгцэн оршиж байна. Эдгээр улс орнууд нь НҮБ-ын дүрмийн шаардлага, олон улсын эрх зүйн зарчимд тулгуурлан өөрийн орны төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийг хүлээдэг. Энэхүү судалгааны ажилд Монгол Улс, ОХУ, БНХАУ, Европын Холбооны Улс, БНБелУ-ын төрөөс хилийн талаар баримталж буй бодлогын баримт бичгийн агуулга, үзэл баримтлал, үндсэн чиглэл, онцлогийн талаар харьцуулан судаллаа. Судалгаанд Б.Л.Вульфсоны шинжилгээний аргыг хэрэглэсэн бөгөөд үр дүнд үндэслэн өөрсдийн дүгнэлтийг илэрхийлсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйн зарчим, хилийн аюулгүй байдал, төрөөс хилийн талаар баримтлах бодлого

УДИРТГАЛ

Аливаа улс орон хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа өөрийн орны физик газар зүйн онцлог, улс төр, нийгэм эдийн засаг, хүн ам, тэдний шилжилт хөдөлгөөн, хөрш улс болон бүс нутгийн нөхцөл байдлаас хамаарсан төрөл бүрийн арга хэлбэр, төрийн бодлогыг баримталдаг. Ингэхдээ нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байх зарчмыг олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд бүх нийтээр хүлээн зөвшөөрч хилийн аюулгүй байдлыг харилцан хүндэтгэлтэйгээр хамтран хангахыг чухалчлах болсныг хилийн аюулгүй байдлыг хамтын хүчээр хангах¹, хилийн нэгдмэл менежментийг нэвтрүүлэх², хил хамгаалалтын хамтын систем үүсгэх³, олон улсын эрх зүйн зохицуулалтын⁴ аргаар хангах туршлага болон манай орны улсын хил

¹ James, R.P., Jeffrey, D., Monica, K. (2018). "Border Security", Carolina Academic Press, Durham, 370-373.

² Frontex, European Commission., (2010). "Guidelines for Integrated Border Management in European Commission External Cooperation", EuropeAid Cooperation Office, 13-25.

³ Ганболд,Ц., (2018). "Хилийн аюулгүй байдлаа хангаж буй гадаадын зарим орнуудын туршлага, сургаамж", Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Уб., 87 тал

⁴ OSCE, "Border Security and Management Concept", (2005). Organization for Security and Co-operation in Europe Ministerial Council, Ljubljana, MC.DOC/2/05, osce.org.

хамгаалалтын “нэг хил, хоёр улс” зарчим⁵ зэргээс харж болно.

Монгол Улс нь нэгдэн орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээ тогтоосон гэрээ хэлцлийн дагуу хүлээсэн үүргээ үндэсний хэмжээнд хангах үүргийг олон улсын байгууллагын өмнө хүлээдэг. Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах бодлого”, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын хилийн тухай хууль”, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр⁶, манай улсын нэгдэн орсон НҮБ, түүний төрөлжсөн болон бусад олон улсын байгууллагаас гаргасан конвенцууд⁷ юм.

Энэхүү бүтээлд Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Европын Холбооны Улс, Бүгд Найрамдах Беларусь Улсын төрөөс хилийн талаар баримталж буй бодлогын баримт бичгүүд нь НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйн үндсэн зарчимтай хэрхэн нийцэж байгаа талаар харьцуулан судалсан дүнгийн талаар өгүүлсэн болно.

НҮБ-ын дүрэм ба хилийн аюулгүй байдал

НҮБ-ын Ерөнхий Ассамблей улс орнуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх олон улсын эрх зүйн зарчмын тухай Тунхаглалыг 1970 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, улс хоорондын харилцаанд зайлшгүй баримтлах зарчмын Тунхаглалыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны 1970 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн төгсгөлийн актаар тус тус баталж олон улсын эрх зүйн үндсэн (9) зарчмуудыг хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх; улс орны тэгш бүрэн эрхийг хангах; дотоодын хэрэгт үл оролцох; нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх; улсын хил халдашгүй дархан байх; маргааныг эв зүйгээр шийдвэрлэх; хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх; ард түмэнд тэгш эрхээр өөртөө засан тогтнох; олон улсын үүргээ шударгаар биелүүлэх хэмээн соёрхон баталгаажуулсан байдаг⁸.

Системийн хувьд олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүй нь харилцан адилгүй боловч хоорондоо нягт уялдаа холбоотой бөгөөд улс орнууд өөрийн орны хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд олон улсын эрх зүйн үндсэн зарчим, НҮБ-ын дүрмийн шаардлагыг уялдуулан хангах үүргийг хүлээдэг.

Улс орнуудын хилийн талаар баримталж буй бодлого, эрх зүйн хэм хэмжээ

Монгол Улс нь ОХУ, БНХАУ, Австрали, АНУ, АНЭУ, Казахстан, Канад, Куба, ХБНГУ, БНСУ, Турк, Энэтхэг, Япон зэрэг 36 оронтой найрамдалт хамтын ажиллагааны гэрээ, үүнээс БНХАУ, ОХУ-тай иж бүрэн стратегийн түншлэлийн; АНУ, Япон, БНЭУ-тай стратегийн түншлэлийн; БНСУ, Турк, ХБНГУ-тай иж бүрэн түншлэлийн; Канад, Австрали Улстай өргөн хүрээтэй түншлэлийн харилцаатай бөгөөд НҮБ, түүний төрөлжсөн болон бусад олон улсын байгууллагаас гаргасан 287 конвенцод, үүнээс хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой 100 гаруй конвенцод нэгдэн орсноор олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчноо бүрдүүлжээ⁹.

Түүнчлэн 1921 оноос 2017 онуудад 85 оронтой 1395 хоёр талт хамтын ажиллагааны гэрээ буюу иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар 54, Гаалийн харилцааны асуудлаар 20 оронтой 22, ургамал хорио цээрийн асуудлаар 7 оронтой 11, мал эмнэлэг, хорио цээрийн асуудлаар 15 оронтой 21, агаарын харилцааны асуудлаар 32 оронтой 36, авто тээврийн харилцааны асуудлаар 10 оронтой 17, төмөр замын харилцааны асуудлаар 3 оронтой 24

⁵ Арвай.Ш., (2018). “Үндэсний аюулгүй байдлын үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь”, Хилийн аюулгүй байдал тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, УБ., 27 дахь тал

⁶ Жанцан.Ц., (2012). “Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр дэхдэд бүтэц, нийгэм эдийн засгийн хөгжлийг цогцоор шийдвэрлэх нь хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн”, Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа, ДХИС, УБ., 37 дахь тал

⁷ Нямсүрэн.Ч, Чулуунбат.Ш., (2018). “Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй олон улсын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ”, Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин судалгааны төсөлт ажлын тайлан, УБ., 11 дэх тал

⁸ Муратхан.А., “Хилийн аюулгүй байдлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын хэрэгжилтээр хангах арга замын тухайд”, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, УБ., 232 дох тал

⁹ <https://www.mfa.gov.mn>, 2021.01.06.

гэрээг байгуулан мөрдөн ажиллаж байна.

Монгол Улс нь хилийн асуудлаар ОХУ-тай 1931 оноос хойш 50 гаруй, БНХАУ-тай 1962 оноос 20 гаруй, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 2, Дамжин өнгөрөх журмын тухай Монгол Улс, БНКАУ-ын Засгийн газар хоорондын (1993) гэрээ, хэлэлцээр зэргийг байгуулан ажиллаж байгаа нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх үндсэн зохицуулалт болж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”, аравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж заасан нь НҮБ-ын дүрэмд тодорхойлсон “нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх”, “улсын хил халдашгүй дархан байх”, “олон улсын үүргээ шударгаар биелүүлэх” гэсэн тулгуур зарчимд үндэслэгдсэн Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны олон улсын харилцааг зохицуулах эрх зүйн үндэс болсон байна¹⁰.

Улсын Их Хурлын 2011 оны 10-р тогтоолоор баталсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын нэгдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно”, хоёрдугаар зүйлийн 14.1 дэх хэсэгт “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ” гэж заасан нь Монгол Улс энхийг эрхэмлэсэн, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, аюулгүй байдлаа хангах хүрээнд бусад улстай тэгш харилцах, олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг харилцан хүндэтгэх зарчмыг баримталсан эрх зүйн зохицуулалт¹¹ юм.

Монгол Улсын Их хурлын 2002 оны 20-р тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичигт “Хилийн талаар баримтлах бодлого нь бусад улсын тусгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд тулгуурлана”, “Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдана”; Монгол Улсын Их хурлын 2010 оны 48-р тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал”-ын “Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал” хэмээх 3-р зүйлийн 1.2-т:

- ...улсын хилийн хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна;
- гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна;
- хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн

¹⁰ Жанцан.Ц., (2012). “Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, нийгэм эдийн засгийн хөгжлийг цогцоор шийдвэрлэх нь хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн”, Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа, ДХИС, Уб., 37 дахь тал

¹¹ Алтанхүү.Б., (2012). “Улсын хил хамгаалалт ба гадаад хамтын ажиллагааны зарим асуудал”, Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа, ДХИС, Уб., 82 дахь тал

шинэчлэлийг хэрэгжүүлнэ;

- хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно;
- хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ;
- хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана» гэж тус тус тусгасан нь НҮБ-ын дүрмийн нэгдүгээр бүлгийн 4 дэх хэсэгт заасан “НҮБ-ын бүх гишүүн улс нь олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн НҮБ-ын зорилгод харшлах ямарваа үйлдэл хийхийг хориглоно” гэсэн гишүүн орнуудын хилийн халдашгүй дархан байдлын баталгаажилтын зарчимд үндэслэсэн байна.

ОХУ нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Төрийн цэргийн бодлого болон бусад хууль тогтоомжтой нягт уялдуулсан стратегийн урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд “иргэний эрх, эрх чөлөө, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, тогтвортой хөгжил, улсын баглан хамгаалалт, аюулгүй байдал” нь гадаад, дотоодын аюулаас хамгаалагдсанаар үндэсний аюулгүй байдал хангагдана¹² хэмээн тодорхойлжээ.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 174 тоот зарлигаар баталсан “ОХУ-ын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын бодлогын нэг хэсэг бөгөөд хилийн бүс нутагт үндэсний эрх ашгийг хамгаалах эрх зүй, улс төр, дипломат, эдийн засаг, батлан хамгаалах, хил хамгаалах, гааль, байгаль орчин, эрүүл ахуй, халдвар судлал, экологийн болон бусад арга хэмжээний цогц юм¹³ гэж заасан. Энэхүү бодлогын баримт бичигт улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, хилийн халдашгүй дархан байдлыг хангах; хилийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх; хууль сахиж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх; аливаа хамтын ажиллагаанд үндэсний ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих; хилийн бүс нутагт үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй аюул, заналаас урьдчилан сэргийлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажиллах талаар тусгасан нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний “нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх”, “улсын хил халдашгүй дархан байх”, “маргааныг эв зүйгээр шийдвэрлэх”, “олон улсын үүргээ шударгаар биелүүлэх” гэсэн тулгуур зарчимд үндэслэсэн байна.

БНХАУ нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа сайн хөршийн нөхөрсөг харилцааны (1949-1979) бодлогыг чухалчилж байсан бол нээлттэй, уян хатан (1979 оноос хойш) бодлогыг баримтлах болсон. БНХАУ-ын хилийн бодлого улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахиулах ерөнхий хууль, тогтоомжийг агуулсан суурь бодлого болон төв, орон нутгийн засаг захиргаа, хил хамгаалах байгууллага, хил орчмын нутаг дэвсгэрийн иргэд, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг нэвтрүүлэх, хилийн худалдааны харилцааг зохицуулах тусгай бодлогоос тус тус бүрддэг байна¹⁴.

Мөн улсын хилийн баталгаажилт, хамгаалалтыг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, улсын хилийг агаар, газар, ус, газрын хэвлийд тасралтгүй, найдвартай хамгаалах, хил хамгаалах зориулалттай цэрэг, иргэд хамтран улсын хилийг манаж, хамгаалах зэрэг нийтлэг зарчмуудыг баримталдаг байна¹⁵.

БНХАУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлого (улсын хилийг тодорхойлох, тогтоох, тодотгох, эрх зүйгээр баталгаажуулах, хилийг манах, хамгаалах, түрэмгийллийг няцааж хилээ сэргээх) нь ерөнхийдөө олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмаас онцгойлон ялгардаггүй боловч “хил, хил орчмын нутаг дэвсгэрийн физик газар зүй, хөрш орон

¹² Арвай.Ш “нар”, (2016). “Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал”, ДХИС, УБ, 157 дахь тал

¹³ ОХУ-ын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого.(2018).1.4 зүйл

¹⁴ Шүрхүү.Д., (2018). “Монгол-Хятадын хилийн орон зайд гарч буй өөрчлөлт ба Монгол Улсын өмнөд хилийн аюулгүй байдал”, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, УБ, 102 дахь тал

¹⁵ Арвай.Ш “нар”, (2016). “Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал”, ДХИС, УБ, 156 дахь тал

болон бүс нутгийн нөхцөл байдлаас хамаарсан харилцан адилгүй бодлого, арга хэмжээг хэрэгжүүлдэг¹⁶.

БНХАУ-ын Ардын төлөөлөгчдийн их хурлаар 1949 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталгаажуулж 1988, 1993, 1999, 2004, 2018 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан БНХАУ-ын Үндсэн хуулийн хэд хэдэн зүйл, заалтууд нь (28, 29, 37, 41, 52, 54, 55, 63, 80, 86, 89, 90) хилийн аюулгүй байдлын үйл ажиллагааг хангах үндэсний эрх зүйн зохицуулалтын үндэс болдог байна¹⁷.

Бүгд Найрамдах Беларусь Улс нь дэлхий дээрх далайд гарцгүй 44 улсын нэг¹⁸ бөгөөд ОХУ-ын хувьд стратегийн болон геополитикийн онцгой чухал орон болохын хувьд манай оронтой ижил төстэй юм.

БНБелУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 410 тоот зарлигаар баталсан “Хилийн аюулгүй байдлыг хангах концепц 2018-2022” бодлогын баримт бичигт БНБелУ-ын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоодын аюул заналаас хамгаалахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгасан нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний “нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх”, “улсын хил халдашгүй дархан байх”, “олон улсын үүргээ шударгаар биелүүлэх” гэсэн тулгуур зарчимд үндэслэсэн байна. Уг баримт бичгийн Хилийн орон зайн хөгжлийн чиг хандлага, аюул заналын үндсэн асуудал хэмээх 2 дугаар бүлэгт Гадаад аюул заналыг:

- хөрш орнууд улсын хилийг олон улсын хэмжээнд албан ёсны болгох үйл явцыг хойшлуулах буюу цуцлах;
- хил орчмын нутаг дэвсгэрт цэрэг байрлуулах;
- бүх төрлийн гэмт хэргийн өсөлт;
- зэвсэгт бүлэглэл, олон улсын гэмт хэргийн бүлэг, террорист бүлэг, хэт даврагсад, салан тусгаарлагчдаас гэмт хэрэг үйлдэх зорилгоор зэвсэг, сум, галт хэрэгсэл түүнтэй холбоотой бараа бүтээгдэхүүнийг Бүгд Найрамдах Беларусь Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх;
- дамжин өнгөрөх хууль бус цагаачдын сувгийн тоо нэмэгдэх, урсгал эрчимжих;
- хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг сөргөөр сурталчлах, иргэдийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл тараах;
- хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл гэх мэт улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан болон хориглосон эд зүйл, бараа, түүнчлэн их хэмжээний барааг хууль бусаар нэвтрүүлэх;
- радио цацрагт, хими, биологи болон бусад төрлийн хөнөөлт бодисыг хууль бусаар зөөвөрлөх, дамжуулан тээвэрлэх;
- техникийн туслалцаа үзүүлэх олон улсын хандивлагчдын боломжийг багасгах;
- хил залгаа орны хил орчмын нутаг дэвсгэрт нийтийг хамарсан үймээн, эмх замбараагүй байдал, зэвсэгт мөргөлдөөн, байгаль, техникийн болон бусад төрлийн гамшигт нөхцөл байдал үүсэх гэж тодорхойлсон бол Дотоод аюул заналыг:
- БНБелУ-ын иргэд хилийн тухай хууль, тогтоомжийг зөрчих, хууль сахиулах, хилийн хяналтын байгууллагын албан хаагчдаас авилга авах үйлдэл өсөх;
- нийгэм, улс төр, шашин, үндэстний хэт туйлшрах үзэл, арьс өнгөөр ялгаварлах, шашныг үл тэвчих нөхцөл байдал нь улсын хилийн тухай хуулийг зөрчих, гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлэх;
- хилийн боомтын журмыг зөрчих, албаны үйл ажиллагаанд саад учруулах;
- улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны

¹⁶ Цэргийн нэвтрэхий толь, (2007). БНХАУ-ын Цэргийн шинжлэх ухааны хүрээлэн, baike.baidu.com.

¹⁷ Манцуров.А.Ю., (2018). “Правовые и организационные основы деятельности пограничных органов Китайской Народной Республики по обеспечению национальной безопасности”, ФГКОУ ВПО, Дальневосточный юридический институт МВД России, Право/2.Административное право и финансовое право, rusnauka.com.

¹⁸ Rosenberg, M., (2020). “44 Landlocked Countries Without Direct Ocean Access” ThoughtCo, thoughtco.com/landlocked-countries-1435421.

талаар худал мэдээлэл тараах;

- санаатай болон санамсаргүй байдлаас үүссэн байгаль, техникийн болон бусад төрлийн гамшгаас үүдэн хууль бусаар хил нэвтрэх нөхцөл бүрдэх гэж тусгажээ.

Мөн хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зорилго, зорилт, зарчмууд хэмээх 4 дүгээр бүлэгт хилийн аюулгүй байдлыг хангахад төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг боловсруулах; хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, үр дүнтэй, тогтвортой үйл ажиллагаагаар хангах; хил хамгаалах байгууллагыг хөгжүүлэх зарчмуудыг тэргүүлэх чиглэл болгоно хэмээн тодорхойлсон байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Сайд нарын зөвлөлөөс 2005 онд баталсан “Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлал” нь гишүүн орнуудын хилийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичиг бөгөөд олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд харилцан итгэлцэх, түншлэх, эрх тэгш, нээлттэй, байх зарчмуудыг баримтлан ажиллахыг тунхаглажээ. Энэхүү бодлогын баримт бичигт хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд гишүүн орнуудын хүлээх үүргийг дэлхий, тив, бүс нутгийн болон хоёр талын хэмжээнд хэрхэн уялдуулан зохицуулах талаар нарийвчлан тусгасан. Тухайлбал:

- Дэлхийн хэмжээнд: гишүүн орнууд нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа олон улсын хууль, хүний эрх, дүрвэгсэд, хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж Дэлхийн гаалийн байгууллага, Шилжилт хөдөлгөөний олон улсын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын дүрвэгсдийн дээд хороо болон бусад олон улсын байгууллагуудаас гаргасан үйл ажиллагааны зөвлөмж, стандартыг мөрдлөг болгоно;
- ЕАБХАБ-ын хэмжээнд: гишүүн орнууд нь Хельсинкийн эцсийн тайланд тусгагдсан эрх тэгш, нээлттэй байх зарчим, нийтлэг хэм хэмжээг баримтална. Ингэхдээ Копенгагены баримт бичиг (1990), Хельсинкийн баримт бичиг (1992), Европын аюулгүй байдлын тунхаг бичиг (1999) болон ЕАБХАБ-аас хүлээн зөвшөөрсөн хилийн аюулгүй байдлыг хангах талаар гаргасан бусад эрх зүйн баримт бичгийг удирдлага болгоно;
- Бүсийн болон дэд бүсийн хэмжээнд: гишүүн орнууд нь бүсийн болон дэд бүсийн хэмжээнд хүлээсэн үүрэг, хариуцлагаа бүрэн ухамсарлаж хилийн аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, стандартыг мөрдөн ажиллах бөгөөд үйл ажиллагааны хэрэгжилтэд аливаа давхардал үүсгэхээс татгалзана;
- Хоёр талын хэмжээнд: гишүүн орнууд нь сайн хөршийн харилцааг эрхэмлэх, хилийн асуудлаар байгуулсан хоёр талын гэрээ, хэлэлцээрийг хүндэтгэх, харилцан туршлага хуваалцаж ажиллахыг эрмэлзэнэ гэж тусгажээ.

Энэхүү үзэл баримтлалын хүрээнд хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Хилийн нэгдсэн менежментийн загвар (Integrated Border Management Model)-ыг Европын холбооны гишүүн орнуудын гадаад хил хариуцсан агентлаг Фронтекс (FRONTEX)-ээс нэвтрүүлж гишүүн орнуудын хилийн албадын харилцаа, хамтын ажиллагааг уялдуулах, туслалцаа үзүүлэх, хамтарсан операци, сургалт, судалгаа, мэдээлэл солилцох систем бүрдүүлэх зэрэг олон арга хэмжээг зохион байгуулдаг байна. Үүний үр дүнд Фронтекс нь 2020 оны байдлаар 13170 хүний ам нас, эрүүл мэндийг хил, хил орчмын нутаг дэвсгэрт хамгаалж, хүн худалдаалах гэмт хэргийг зохион байгуулагч 742, хар тамхи мансууруулах бодисын хууль бус эргэлтийг зохион байгуулагч 453 этгээдийг илрүүлэн 147 тонн хар тамхи, мансууруулах бодисыг хураан авсан байна¹⁹.

¹⁹ European Border and Coast Guard Agency, (2021). In Brief 2020, Luxembourg, Publications Office of the European Union.

ДҮГНЭЛТ

НҮБ-ын гишүүн улс орнууд нь хилийн талаар баримталж буй бодлогын баримт бичгээ олон улсын эрх зүйн болон оролцогч улс хоорондын харилцаанд зайлшгүй баримтлах зарчимд тулгуурлан боловсруулж хэрэгжилтийг мөрдөн ажиллах үүргийг хүлээдэг.

Энэхүү судалгаанд Монгол Улс, ОХУ, БНХАУ, Европын Холбооны Улс, БНБелУ-ын төрөөс хилийн талаар баримталж буй бодлогын баримт бичгийн агуулга, үзэл баримтлал, үндсэн чиглэл, онцлогийн талаар харьцуулан судалсан бөгөөд судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

Нэгдүгээрт: Монгол Улс, ОХУ, БНХАУ, Европын Холбооны Улс, БНБелУ-ын төрөөс хилийн талаар баримталж буй бодлогын баримт бичгийн агуулга, үзэл баримтлал, үндсэн чиглэл нь НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчимд нийцэж байна. Жишээлбэл, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг «... байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах» гэж тодорхойлсон нь ОХУ, БНХАУ, Европын Холбооны Улс, БНБелУ-ын төрөөс хилийн талаар баримталж буй бодлого, үзэл баримтлалтай утга агуулгын хувьд нийцэж байна. Монгол Улсын Хил хамгаалах байгууллага нь улсын хэмжээнд хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журмыг сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зэрэг чиг үүргийг Монгол Улсын хилийн тухай хуулиар хүлээдэг. Монгол Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг юм. Монгол Улс нь хилийн маргаангүй бөгөөд улсын хилийг хил залгаа улстай хамтран хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх үндсэн зарчмыг баримталдаг.²⁰

Хоёрдугаарт: Монгол Улс, ОХУ, БНХАУ зэрэг орнууд үндсэн хууль, хилийн аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичиг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцэн гарсан талаар эрх зүйн үндэслэл хэсэгтээ тусгасан байх бол БНБелУ нь бодлогын баримт бичигтээ “БНБелУ-ын нутаг дэвсгэрийн заагийг тодорхойлсон улсын хилийг олон улсын хууль эрх зүйн журмаар бүртгэх”, “улсын хилийн тухай үндэсний хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг дагаж мөрдөх” хэмээн тодорхойлж үндсэн хуулийнхаа талаар ямар нэгэн ишлэл заалт дурдаагүй байна. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Сайд нарын зөвлөлөөс 2005 онд баталсан “Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлал”-д олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд харилцан итгэлцэх, түншлэх, эрх тэгш, нээлттэй байх зарчмуудыг баримтлан ажиллахыг үндэслэл болгон тунхаглажээ.

Гуравдугаарт: судалгаанд хамруулсан улс орнууд нь хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлээ тухайн улс орны физик газар зүй, хүн ам, улс төр, нийгэм эдийн засгийн онцлогоос хамаарч харилцан адилгүй тодорхойлсон байна. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох; хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагаа гэж тусгасан бол ОХУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, агаарын хилийн орон зай, усан хил, эдийн засгийн онцгой бүсэд үндэсний аюулгүй байдлын тогтолцоог хөгжүүлэх, хилийн бүс нутгийн хөгжил, нийгэм, эдийн засгийн таатай нөхцөлийг бий болгох гэсэн байна. БНХАУ нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг хилийн маргаан, сөргөлдөөнтэй, терроризм, салан тусгаарлах аюул занал ихтэй хилийн орон зайн чиглэл, хөдөлгөөн ихтэй, хууль бус худалдаа, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хилийн зөрчилтэй нутаг дэвсгэрийн чиглэл гэж авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээгээр тодорхойлсон (Д.Шүрхүү, 2018) байна. БНБелУ-ын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэл нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, бүс нутгийн эдийн

²⁰ Улсын хил хамгаалалт, bpo.gov.mn

засгийг хөгжүүлэх, бүс нутагт улс төр, нийгмийн тогтвортой байдал, хууль журмыг сахин хэрэгжүүлэх ажлыг дэмжих, хилийн аюулгүй байдлыг хангах зорилтыг шийдвэрлэхэд төрийн байгууллагуудын оролцоо, бүрэн эрх, үүрэг хариуцлагыг сайжруулах хэмээн тусгажээ.

Дөрөвдүгээрт: дээрх улс орнууд нь хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналд хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэт даврагсад, салан тусгаарлагчид, зэвсэгт бүлэглэл, терроризм, улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан болон хориглосон бараа бүтээгдэхүүний хууль бус эргэлт, хууль бус шилжилт хөдөлгөөн, үй олноор хөнөөх зэвсэг түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, маргалдаан, зөрчилтэй хилийн орон зай гэх мэт хүчин зүйлсийг нийтлэгээр багтаасан байна. Харин ОХУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн “Хилийн бүс нутаг дахь үндэсний аюулгүй байдлын төлөв байдал” хэмээх 2 дугаар бүлэгт ОХУ-ын үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй гол хүчин зүйлд “Арктикийн болон Алс дорнодын стратегийн нөөцөд гадаадын орнууд, үндэстэн дамнасан корпорацууд халдах”, “... тэнгисийн орон зайг хязгаарлах асуудлыг дуусгавар болгоогүй байдал» хэмээн тодорхойлсон, мөн усны биологийн нөөцийг хамгаалах, усны биологийн нөөцийг олборлоход тавих хилийн хяналт, шалгалтын асуудлыг тусгасан зэрэг нь онцлог байна. Монгол Улс, БНБелУ болон ЕАБХАБ-аас баталсан хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт далай тэнгис, гол мөрний ус болон усны биологийн нөөцийг ашиглах, хамгаалах талаар тусгайлсан заалт байхгүй бөгөөд нэр томьёоны хувьд “хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал”, “хил орчмын нутаг дэвсгэр”, “бүс нутаг” гэх нийтлэг томьёоллыг ашигласан байна.

Судалгаанаас үзэхэд Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНБелУ, Европын Холбооны Улсын хилийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нь НҮБ-ын дүрэм болон хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх; улс орны тэгш бүрэн эрхийг хангах; дотоодын хэрэгт үл оролцох; нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх; улсын хил халдашгүй дархан байх; маргааныг эв зүйгээр шийдвэрлэх; хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх; ард түмэнд тэгш эрхээр өөртөө засан тогтнох; олон улсын үүргээ шударгаар биелүүлэх тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчимд тулгуурласан байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын үндсэн хууль, *БНМАУ-ын Ардын Их Хурал*, (1992)
- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, (2011). *Улсын Их Хурал*, № 10
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, (2010). *Улсын Их Хурал*, № 48
- Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, (2002). *Улсын Их Хурал*, № 20

Монгол хэлээр:

- Алтанхүү.Б. *Улсын хил хамгаалалт ба гадаад хамтын ажиллагааны зарим асуудал*. Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа, ДХИС, Улаанбаатар. 2012 он
- Арвай.Ш. Наранжамц.Н., Муратхан.А., Нямдорж.Д. *Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал*, ДХИС, Улаанбаатар. 2012 он
- Арвай.Ш. *Үндэсний аюулгүй байдлын үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь*, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Улаанбаатар. 2008 он
- Ганболд.Ц. *Хилийн аюулгүй байдлаа хангаж буй гадаадын зарим орнуудын туршлага, сургамж*, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Улаанбаатар. 2008 он
- Жанцан.Ц. *Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, нийгэм эдийн засгийн хөгжлийг цогцоор шийдвэрлэх нь хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн*, Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа, ДХИС,

Улаанбаатар. 2012 он

- Муратхан.А. *Хилийн аюулгүй байдлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын хэрэгжилтээр хангах арга замын тухайд*, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Улаанбаатар.
- Нямсүрэн.Ч, Чулуунбат.Ш. “Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй олон улсын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ”, Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин судалгааны төсөлт ажлын тайлан. 2018 он
- Шүрхүү.Д. “Монгол-Хятадын хилийн орон зайд гарч буй өөрчлөлт ба Монгол Улсын өмнөд хилийн аюулгүй байдал”, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Улаанбаатар. 2018 он
- Цэргийн нэвтэрхий толь. БНХАУ-ын Цэргийн шинжлэх ухааны хүрээлэн. 2017 он

Гадаад хэлээр:

- *Концепции обеспечения пограничной безопасности Республики Беларусь на 2018–2022 годы*, Указ Президента Республики Беларусь, (2018). № 410, pravo.by.
- Манцуров.А.Ю., (2018). *Правовые и организационные основы деятельности пограничных органов Китайской Народной Республики по обеспечению национальной безопасности*, ФГКОУ ВПО, Дальневосточный юридический институт МВД России, Право/2.Административное право и финансовое право, rusnauka.com.
- *Основ государственной пограничной политики Российской Федерации*. Указ Президента Российской Федерации, (2018). № 174, kremlin.ru
- Frontex, European Commission., (2010). *Guidelines for Integrated Border Management in European Commission External Cooperation*, EuropeAid Cooperation Office, 13-25.
- European Border and Coast Guard Agency, (2021). In Brief 2020, Luxembourg, *Publications Office of the European Union*.
- James, R.P., Jeffrey, D., Monica, K. (2018). *Border Security*, Carolina Academic Press, Durham, 370-373.
- OSCE, *Border Security and Management Concept*, (2005). Organization for Security and Co-operation in Europe Ministerial Council, Ljubljana, MC.DOC/2/05, osce.org.
- Rosenberg, M., (2020). 44 *Landlocked Countries Without Direct Ocean Access*. ThoughtCo, thoughtco.com/landlocked-countries-1435421.
- Vulfson, B. L., (2002). *Methods of Comparative Education Researches*, Pedagogica, Volume 2, 70-80.

Цахим эх сурвалж:

- Улсын хил хамгаалалт, bro.gov.mn
- baike.baidu.com
- Монгол Улсын үндсэн хууль, БНМАУ-ын Ардын Их Хурал, (1992). conscourt.gov.mn.
- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтла, (2011). *Улсын Их Хурал*, № 10, mfa.gov.mn
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, (2010). *Улсын Их Хурал*, № 48, legalinfo.mn.
- Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, (2002). *Улсын Их Хурал*, № 20, legalinfo.mn.

BORDER POLICIES OF THE COUNTRIES AND UN CHARTER

Sh.Chuluunbat

Director, Foreign Language Institute, University of Internal Affairs, PhD, Associate Professor, Colonel

M.Bayarsaikhan

Curriculum Manager, Graduate school, University of Internal Affairs. Graduate student in border studies, Lieutenant Colonel.

ABSTRACT:

Nowadays, in the world 193 sovereign states that are members of the United Nations (UN) who is responsible to develop and implement its state policy on border based on requirements of the Charter of the United Nations and principals of the international legislation. In this comparative study, we aimed to investigate the main objectives and particularity of the state policies on the border of Mongolia, Russian Federation, China, European Union, and Belarus by using Vulfson's methods of comparative research. Summary of result discussed respectively.

KEYWORDS:

Charter of the UN, Principals of The International Legislation, Border Security, State Policy on Border.

ХӨВСГӨЛ АЙМАГТ СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ХУГАЦААНД ГАРСАН АМИА ХОРЛОСОН ТОХИОЛДЛУУДАД ХИЙСЭН СУДАЛГАА, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ



Т.Бүрэнхаан
ДХИС-ийн докторант

ТОВЧЛОЛ:

Амиа хорлох болон амиа хорлохыг завдах тохиолдол өнөөгийн нийгэмд хүүхэд залуучууд болон нийт ард иргэдийн дунд тулгамдаж байгаа асуудлуудын нэг мөн гэдэгт маргах зүйл байхгүй юм. Нийгмийг цочроосон, ард иргэдийн сэтгэлийг эмзэглүүлэх маргаантай, олон янзын шалтгаанаар ард иргэдийг талцуулсан амиа хорлох үйлдэл бүхий хэргүүд өдөр тутам гарч байна. Бид энэ нийгмийн сөрөг үзэгдлийг мэдсээр байдаг ч төдийлөн багасгах, бууруулах, урьдчилан сэргийлэх талаар бодитой ажил хийгдэхгүй байна. Хөвсгөл аймагт 2011-2020 оныг хүртэл 10 жилийн хугацаанд гарсан амиа хорлосон хэргүүдэд суурь судалгааг хийж ажиллав. Хөвсгөл аймагт амиа хорлосон иргэдийн нас залуужиж, амиа хорлосон тохиолдлын тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 2020 онд 63 хүн амиа хорлосон бөгөөд нийт хүн амын 100,000 хүн тутамд 46,6 амиа хорлолт бүртгэгдээд байна. Энэ нь 6 хоног тутамд 1 хүн амиа хорлож байна гэсэн тоо судалгаагаар тогтоогдоод байна. Хөвсгөл аймаг хэрвээ дэлхийн нэг улс гэж үзвэл дэлхийн нийт хүн амын амиа хорлолтын дунджаас 4 дахин их бөгөөд дэлхий дээрх хамгийн их амиа хорлолттой Литв (100,000 хүнд 31,9) улсаас 14,7 амиа хорлолтоор их байна. Энэ нь Монгол улс шиг хүн ам цөөнтэй улсад байж болохгүй үзэгдэл юм. Ийм учраас бид энэ үйлдэлтэй тэмцэх бүхий л арга замыг эрэлхийлэх шаардлагатай байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Амиа хорлолт, Амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, Амиа хорлолтын нийгмийн хүчин зүйл, Амиа хорлох зан үйлийн онол, үзэл баримтлал.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хөвсгөл аймагт 2011-2020 онуудад гарсан амиа хорлосон тохиолдлуудын суурь судалгаа, өнөөгийн нөхцөл байдал

Амиа егүүтгэх гэдэг нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслах төрх үйл юм. Амиа егүүтгэх болон амиа егүүтгэхээр оролдох нь манай улсын хувьд төдийгүй дэлхийн олон оронд нийгэм эдийн засгийн болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа билээ. Амиа егүүтгэж нас барах, амиа егүүтгэх оролдлого

хийх тохиолдол нь анагаах ухаан, философи, нийгэм судлал, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг билээ. Хэвлэл мэдээллээс үзвэл хүн амын дундах дээрх үйлдлүүд нь өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын мэдээлснээр жилд ойролцоогоор 800,000 хүн амь насгаа алддаг бөгөөд үүнээс олон хүн амиа хорлохыг завддаг. Энэ нь 40 секунд тутамд дэлхийн оршин суугчдын нэг нь санаатайгаар амиа хорлож байна. Амиа хорлох үйлдэл нь гэр бүл, олон нийтийн амьдралд удаан хугацаагаар нөлөөлдөг эмгэнэлт явдал юм. Амиа хорлох нь амьдралын мөчлөгийн туршид тохиолддог бөгөөд 2016 онд дэлхийн хэмжээнд 15-29 насны залуучуудын нас баралтын хоёр дахь шалтгаан болжээ.¹

Амиа хорлох нь бүхий л цаг хугацааны туршид дэлхийн өнцөг булан бүрд тохиолддог дэлхийн үзэгдэл юм. Харин түүнийг судлах, шалтгаан нөхцөлийг тогтоох, тэмцэх ажил нь үр дүнд хүрэхгүй байгаа нь гол асуудал юм. Амиа хорлохыг бууруулах чиглэл арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд амиа хорлохоос урьдчилан сэргийлэх цогц, салбар хоорондын стратеги шаардлагатай.²

Дэлхийн хэмжээнд амиа хорлох, амиа хорлохыг завдсан талаарх мэдээллийн хүртээмж, чанар хангалтгүй байна. Зөвхөн 80 гишүүн улс амиа хорлох төвшинг шууд тооцоолоход ашиглаж болох хүн амын судалгааны бүртгэлтэй байдаг. Нас баралтын мэдээллийн энэ асуудал нь зөвхөн амиа хорлохтой холбоотой төдийгүй зарим улс оронд амиа хорлох асуудалд эмзэг байдал, амиа хорлох зан үйлийн хууль бус байдлыг харгалзан мэдээллээ дутуу тайлагнах, буруу ангилах нь бусад шалтгаанаас илүүтэйгээр амиа хорлоход илүү их бэрхшээл учруулж болзошгүй юм. Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх стратегийн үр дүнтэй байдал нь амиа хорлох, амиа хорлох оролдлогыг хянах, сайжруулах хяналтаас хамаарна. Амиа хорлолтын хэв маяг, амиа хорлох шинж чанар, арга хэлбэрийн улс хоорондын ялгаа нь улс орон бүр амиа хорлох мэдээллийн хамрах хүрээ, чанар, цаг тухайд нь сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Эдгээрт амиа хорлох оролдлогын талаарх хүн ам зүйн бүртгэл, эмнэлэгт бүртгэгдсэн амиа хорлох оролдлогын талаарх мэдээллийг цуглуулах үндэсний хэмжээний судалгааг багтаасан болно.³

Амиа егүүтгэх төрх үйлийн талаар Э.Дюркгейм судалснаас хойш дэлхий дахинаа илүүтэй анхаарч судлах болсон гэж үздэг. Дэлхийн амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх олон улсын холбоо нь (International Association for Suicide Prevention- IASP) жил бүрийн 9-р сарын 10-ны өдрийг амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх өдөр болгон, тодорхой уриан дор олон улсын түвшинд тэмдэглэдэг. ДЭМБ-ын 2012 оны судалгаанаас үзэхэд амиа егүүтгэх тохиолдлын дэлхийн дундаж 100 000 хүн амд 11.4 (эрэгтэйд 15, эмэгтэйд 8), харин Номхон далайн баруун эргийн бүсийн орнуудад амиа егүүтгэл хүйсийн хувьд онцгой ялгаагүй 100 000 хүн амд 7.9 тохиолдол байдаг байна. Дэлхий дахинаа амиа егүүтгэх тохиолдол нь хүйсийн хувьд ялгаатай тухайлбал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин илүү амиа егүүтгэдэг. Амиа егүүтгэлийн улмаас нас барах тохиолдол нь дэлхийн хүн амын нас баралтын 1.4%, нас баралтын шалтгааны 15-р байрыг эзэлж байгаа ажээ. Харин Хөвсгөл аймгийн тухайд сүүлийн 10 жилийн дунджаар амиа хорлолт нь тухайн аймгийн нийт нас баралтын 5,13%-ийг амиа хорлолт эзэлж байна.

Амиа егүүтгэхэд ашиглаж буй аргууд нь ихэнхдээ амь насыг нь аврах боломжгүй, шууд үхэлд хүргэх амь насанд аюултай аргууд байдаг хэдий ч энэ аргууд нь улс орны ёс заншил, байгалийн орчин, тогтоц зэрэг онцлогоос хамаардаг. Дээрх тайлангаас үзвэл аль ч улс оронд амиа егүүтгэхэд хамгийн өргөн хэрэглэдэг арга нь өөрийгөө боомилох (50%), галт зэвсгээр өөрийгөө хөнөөх (18%) аргууд байна. Галт зэвсэг хэрэглэн амиа егүүтгэх тохиолдол нь АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад их байдаг бол хөдөө аж ахуй сайн хөгжсөн орнуудад хөдөө аж ахуйд хэрэглэдэг химийн бодисууд ялангуяа пестицид

¹ Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх: Глобал Императив (2014) // Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

² <https://www.who.int/ru/news-room/fact-sheets/detail/suicide>

³ <https://www.who.int/ru/news-room/fact-sheets/detail/suicide>

хэрэглэх, Гонг-Конг, Хятад, Сингапур зэрэг өндөр барилга бүхий улс орнуудад өндрөөс үсрэх, угааргах, химийн бодисын холимог хэрэглэх зэрэг аргуудыг илүүтэй хэрэглэдэг байна.

Судалгааны дүнгээс үзвэл хүн ам амиа егүүтгэхэд ядуурал, дайн байлдаан, ялгаварлан гадуурхал, эмнэлгийн тусламжийн хангалтгүй байдал, хүн хоорондын харилцааны зөрчил, сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хортой хэрэглээ, хүчтэй өвдөлт бүхий архаг өвчнүүд, удамд нь амиа егүүтгэх оролдлого хийж байсан, амиа егүүтгэж байсан тохиолдлууд ихээхэн нөлөөлдөг болохыг тогтоожээ. Амиа егүүтгэхэд хүргэдэг сэтгэцийн өвчнүүдийн дотор сэтгэл хөдлөлийн эмгэг (12%), архины хамааралд орох (7%), шизофрени (5%) зэрэг нь ихэнх хувийг эзэлдэг.

Дэлхий дахинаа амиа егүүтгэх тохиолдлыг бууруулах зорилгоор 2013-2020 он хүртэл Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 2020 он гэхэд амиа егүүтгэх тохиолдлыг 10% бууруулна хэмээн төлөвлөсөн байна. Амиа егүүтгэх тохиолдлыг бууруулах боломжтой хэмээн үзэж байгаа бөгөөд тухайлбал АНУ-д галт зэвсгийн хэрэглээнд хяналт тавих, тээврийн хэрэгсэлд ашигладаг химийн бодист хяналт тогтоох, хүн амд сэтгэл зүй- сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлсний үр дүнд амиа егүүтгэх тохиолдлыг 20%-аар бууруулсан буюу 6000 хүний амь насыг аварсан үр дүнд хүрсэн ажээ (2010). Амиа егүүтгэх тохиолдлыг бууруулахад тусгайлан бодлого, хөтөлбөр шаардлагатай байгаа бөгөөд өнөөгийн байдлаар амиа егүүтгэх үйлдлийг бууруулах асуудлыг тусгасан ямар нэг баримт бичиг боловсруулсан 50 орон байгаагаас 7 улс нь үндэсний хөтөлбөртэй байна.

Монгол улсад амиа егүүтгэх, амиа егүүтгэх оролдлого хийх тохиолдлын тархалтын судалгаа 2 удаа хийгдсэн байна. Үүнд: Ш.Доржжадамба “Амиа егүүтгэхийг завдсан, амиа егүүтгэсэн тохиолдлын тархвар зүйг судалсан нь” сэдэвт судалгааг Улаанбаатар хотын хэмжээнд 2003 онд ДЭМБ-ын тэтгэлгээр хийсэн (Г.Цэцэгдарь, С.Бямбасүрэн, Н.Туяа. 3.Хишигсүрэн... нар) Уг судалгааг 1991-2002 онуудад амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг УБ хотын цагдаагийн газар, Хордлогын төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Наркологийн төв, Гэмтлийн эмнэлэг, Сэтгэцийн клиникийн эмнэлгийн бүртгэл, өвчний түүхэнд эргэж судалгааны аргыг ашиглан хийсэн болно. 1991-2002 онуудад Улаанбаатар хотын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн 5056 тохиолдол бүртгэгдсэнээс 1765 (34.9%) нь амиа егүүтгэсэн байжээ. Амиа егүүтгэсэн нийт тохиолдлын 80.9% нь эрэгтэйчүүд, насны бүлгээр авч үзвэл 31.2% нь 18-29 насныхан байсан. Амиа егүүтгэгчид нь ихэнхдээ өөрийгөө боомилох (60.4%), өндрөөс үсрэх (12.3%), иртэй, үзүүртэй зүйлээр биедээ гэмтэл учруулах (10.8%) аргыг ашиглан хаврын улиралд илүүтэй амиа егүүтгэсэн байлаа. Амиа егүүтгэсэн тохиолдлын дотор сэтгэцийн эмгэгийн улмаас амиа егүүтгэсэн тохиолдлыг тодорхойлох боломжгүй байсан.

2006 онд Хүний аюулгүй байдлын төвөөс “Монголын амиа хорлогсдын талаарх судалгаа”-г (Ц.Эрдэнэчулуун нар) хийсэн байдаг байна. Энэхүү судалгааны гол зорилго нь амиа егүүтгэх тохиолдлын тоог тусгасан тайлан, тоо мэдээнд тулгуурлан дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, тохиолдлын тоог бууруулах талаар зөвлөмж гаргах асуудал байсан байна.

2003-2008 онуудад Монгол улсын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг судалсан билээ (З.Хишигсүрэн, Д.Оюунсүрэн, Г.Цэцэгдарь, С.Бямбасүрэн, Най.Туяа... нар) ДЭМБ-ын 2014 оны тайланд дурдсанаар 2012 оны байдлаар Монгол улсад амиа егүүтгэсэн тохиолдол 100.000 хүн амд 261 тохиолдол буюу 15.5 байгаа бөгөөд хүйсийн хувьд эрэгтэйчүүд 214, эмэгтэйчүүд 47 байсан байна. Үүнээс үзвэл манай улсад амиа егүүтгэх тохиолдлын тоо 100.000 хүн амд 15.5 тохиолдол байгаа нь дэлхийн дунджаас (11.4) дээгүүр байна.

2017 онд Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалт, судалгааны төвөөс судлаач, хяналтын прокурор, хууль зүйн доктор Б.Өнөрмаагаар ажлуулсан судалгааны баг судалгаа хийсэн байдаг ба Монгол Улсад 2012-2016 онуудад нийт амиа хорлосон эрүүгийн хэргийн мэдээллийг цуглуулж нэгтгэсэн байна.

Тухайн судалгаанаас ерөнхий мэдээллийг дурдвал сүүлийн таван жилийн байдлаар буюу 2012 онд 484, 2013 онд 397, 2014 онд 441, 2015 онд 388, 2016 онд 333 хүн амиа хорлосон тохиолдолд хуулийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна. Улсын хэмжээнд 2012-2016 оны хооронд амиа хорлох тохиолдлын тоо буурсан бөгөөд энэ хугацаанд 2055 хүн амиа хорлож, жилд дунджаар 411 амиа хорлосон тохиолдол бүртгэгджээ. Хүйсийн харьцааны хувьд авч үзвэл нийт тохиолдлын 1729 нь эрэгтэй, 326 эмэгтэй хүн амиа хорлосон бөгөөд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс 5.2 дахин их байна. Амиа хорлосон тохиолдлыг насны бүлгээр авч үзвэл 10-89 хүртэлх насны хүмүүс амиа хорлосон ба дундаж нас нь 33 ± 12.9 байна. Насны бүлгийн хувьд авч үзвэл 605 тохиолдол буюу 29.4 хувь нь 10 наснаас 25 нас хүртэлх, 1450 буюу 70.6 хувь нь 29-өөс дээш насны амь хохирогчид байсан. Тэр тусмаа 29 хүртэлх насны хүмүүсийн дундах амиа хорлолт жил бүр өсөх хандлагатай байна. Статистикийн шугаман хандлага тооцох аргачлалаар тооцож үзэхэд амиа хорлолт 2017 онд 332, 2018 онд 312, 2019 онд 293, 2020 онд 275 болж буурахаар байна.⁴ Сүүлийн таван жилд 2012-2016 онд 10-25 насны 605 хүн амиа хорлосон бөгөөд нийт 2055 тохиолдлоос 29.44 хувийг эзэлж байна. Үүнээс 10-14 насны хүүхэд амиа хорлосон нийт 78 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хот хамгийн их 27 буюу 34.6 хувь, хөдөө орон нутгаас Хөвсгөл аймагт 10.2 хувь байна. 15-19 насны нийт 179 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 57 буюу 31.8 хувь, **Хөвсгөл аймагт 17** буюу 9.5 хувь, 20-25 насны амиа хорлосон нийт 348 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 154 буюу 44.25 хувь, **Хөвсгөл аймагт 7.7** хувь нь бүртгэгдсэн байна.

2015 оны байдлаар гаргасан Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тоо баримтад 100,000 хүн тутамд 28.3 амиа хорлолтоор Монгол улс бүс нутагтаа дэд байранд орж байгааг тухайн үед мэдээлсэн юм. Тэгвэл 2017 онд шинэчилсэн тоо баримтаар Монгол улс 100,000 хүн тутамд 28.1 амиа хорлолтоор дэлхийд гуравдугаар байранд орсныг үзүүлсэн байна.⁵

Уг суурь судалгаанаас Хөвсгөл аймагт гарсан 2012-2016 оны хооронд 136 хүн амиа хорлож нас барсан⁶ гэх бөгөөд бидний хийсэн судалгаагаар 2012-2016 онуудад 192 хүн амиа хорлож нас барсан нь 56 хүнээр зөрж байна. Хэрэв нэг аймагт ийнхүү 56 тоогоор дутсан байгаа нь бусад орон нутагт тухайн дүнтэй дүйцэхээр дутсан гэж үзвэл 70,8% дээр суурь судалгаа хийгдсэн гэсэн үг юм. Харин тухайн хувь тоон үзүүлэлтийг 100% гэж үзвэл 2902 хүн амиа хорлосон байх магадлалтай юм. Мөн тухайн судалгааны нэгдсэн дүгнэлтэд статистикийн шугаман хандлага тооцох, аргачлалаар тооцож үзэхэд улсын хэмжээнд амиа хорлолт 2017 онд 332, 2018 онд 312, 2019 онд 293, 2020 онд 275 болж буурахаар байна⁷ гэжээ. Харин Хөвсгөл аймгийн тухайд тухайн дэвшүүлсэн таамаглал нь эсрэгээрээ огцом нэмэгдсэн байна. **Цагдаагийн ерөнхий газраас** гарсан тоон мэдээллээр “2012-2016 онд улсын хэмжээнд 1098 нь золгүй байдлаар амь насаа алдсан, улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар 187 хүн амиа хорлосон байх ба энэ нь жилд дунджаар 37 хүн, сард 3 хүн нас барсан гэсэн үзүүлэлт болно” гэжээ.⁸ Энэ нь дан ганц Хөвсгөл аймагт гарч буй амиа хорлолтын үзүүлэлтээс бага байгаа нь судалгааг хэрхэн үнэн бодитой гаргаж байгааг илтгэх үзүүлэлт юм.

⁴ <https://vip76.mn/content/48174> Б.Өнөрмаатай хийсэн ярилцлага

⁵ <https://ikon.mn/n/172g>

⁶ Улсын ерөнхий прокурорын газрын сургалт судалгааны төв, *Монгол улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгаа*. 2017 он Улаанбаатар хот, 24 дахь тал

⁷ Улсын ерөнхий прокурорын газрын сургалт судалгааны төв “*Монгол улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгаа /2012-2016/*” Улаанбаатар, 2017 он 157 дахь тал,

⁸ Улсын ерөнхий прокурорын газрын сургалт судалгааны төв “*Монгол улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгаа /2012-2016/*” Улаанбаатар, 2017 он 160 дахь тал,

Бидний орон нутагт 2011-2020 оны хооронд хийсэн судалгаанд хамрагдаагүй, судалгаанд хамрагдсан ч амиа хорлосон эсэх нь эргэлзээтэй хэргийг оруулаагүй. Энэ төрлийн судалгааг хийхэд хамгийн бодит байх хэлбэр нь эрүүгийн хэргээс гадна задлан шинжилгээний дүгнэлт юм. Судалгааны хугацаанд Хөвсгөл аймагт дүүжлэгдсэн байдалтай амиа хорлосон болгож харагдуулж аллагыг нуух зорилготой гэмт хэрэг 10 жилийн хугацаанд 2 удаа бүртгэгдсэн. Эрүүгийн хэрэг үүсгэгдээгүй, болон дуудлага мэдээлэлд ороогүй амиа хорлолтууд цөөнгүй гарч байсан. Эдгээрийг судалгаанд оруулаагүй.

Иймд амиа хорлолтын судалгааг маш нарийн, дэлгэрэнгүй гаргах нь цаашдын судалгаа, шинжилгээний ажилд чухал ач холбогдолтой юм. Тухайн судалгааг хэн, ямар албан тушаалтан хэрхэн, ямар эх сурвалжийг баримталж гаргахыг тодорхой болгох шаардлагатай байна. Мөн судалгааг буруу, дутуу гаргаснаас үүдэн амиа хорлолттой тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил явахгүй, төр засаг анхаарал хандуулахгүй байх үндсэн шалтгаан болж байна.

Монгол улсад амиа хорлолтын үзүүлэлтээр орон нутгаас Хөвсгөл аймаг тэргүүлдэг. Бидний судалгааны объект нь 2011-2020 оны хооронд Хөвсгөл аймагт гарсан амиа хорлож нас барсан бүхий л эрүүгийн хэрэг, задлан шинжилгээний дүгнэлт, тогтоол, шүүхийн шинжилгээний албанд байх эрүүгийн хэргийн болон гэрэл зургийн архив зэрэг материалууд, өөрт байх тэмдэглэл бүхий бусад зүйлс зэрэг болно.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь дуудлагаар очиж шинжээч томилсон тогтоолын дагуу 10 жилийн хугацаанд нийт 1449 удаа талийгаачийн цогцост задлан шинжилгээ хийж ажилласан байна. Эдгээр хийгдсэн шинжилгээний дүгнэлтээр гадны нөлөөтэй буюу гэмтлээр 105, зам тээврийн ослын улмаас нас барсан 258, усанд живж нас барсан 120, золгүй байдлаар буюу ахуйн ослоор 88, осгож нас барсан 61, галд шатаж угаартаж нас барсан 17, архины хордлого болон бусад бодисын хордлогоор 121, өвчний улмаас 262, **амиа хорлосон хэлбэрээр 425 хүн** тус тус нас барсан байна.



График №1

Тухайн амиа хорлож нас барсан 425 тохиолдлыг авч үзвэл дүүжлэх 328 буюу (77.2%), өндрөөс унах 14 буюу (3,3%), усанд живэх 34 буюу (8%), өөрийгөө хутгалах 5 буюу (1,2%), буудах 33 буюу (7,8%), хорт бодис уух 1 буюу (0,2%), техник ашиглан амиа хорлох 2 буюу (0,47%), өөрийгөө шатаах 5 буюу (1,2%), зэрэг хэлбэрүүдээр амиа хорлож нас баржээ.

Нийт амиа хорлож нас барсан иргэдийн хамгийн бага нь 9 настай ба хамгийн ахмад нь 78 настай иргэд байгаа ба насыг төрөлжүүлэн авч үзвэл 16-50 насны иргэдийн дунд амиа хорлох явдал их байна.




График №2

Амиа хорлож нас барсан иргэдийг хүйсээр нь авч үзвэл 369 эрэгтэй (86.8%), 56 эмэгтэй (13,2%) тус тус харьцаатай байна.



График №3

Амиа хорлож нас барсан иргэдийг Хөвсгөл аймгийн газар нутгийн байршлаар Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоныг судалгаанаас харахад хамгийн өндөр тоон үзүүлэлт бүхий Мөрөн хотод нийт амиа хорлолтын 105 удаа буюу 24,7 %, Хатгал тосгонд 27 удаа буюу 6,3%, Түнэл, Ринченлхүмбэ сумуудад 26 удаа буюу 6,1% амиа хорложээ. Харин хамгийн бага нь Арбулаг суманд 6 удаа, Цагаан-Уул суманд 5 удаа, Шинэ-Идэр суманд 4 удаа тус тус амиа хорложээ.



График №4

Тухайн орон нутаг, нэгжийн хүн амын тооны нягтралаар нь судалж үзэхэд 2011-2020 оны хооронд 10 жилийн дунджаар 100,000 хүнд ногдох амиа хорлолтын тоон үзүүлэлтээр судалгаа гаргаж үзэхэд Хөвсгөл аймгийн ихэнх сум суурин газрууд дэлхийн дунджаас давсан үзүүлэлтийг гаргасан байна. Дэлхийн амиа хорлолтын дундаж үзүүлэлт 100,000 хүнд 11,4 амиа хорлолт байдаг. Харин Хөвсгөл аймаг 10 жилийн дунджаар 100,000 хүн тутамд “33,27 амиа хорлолт”, 2020 оны байдлаар 100,000 хүн тутамд “46,6 амиа хорлолт”-ын үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар дэлхийн хамгийн их амиа хорлолт бүртгэгдэж буй улс буюу 1-рт Литв “31,9”, 2-рт Оросын холбооны улс “31”⁹ аас даруй 15 –аар их байх жишээтэй.



График №5

Харин Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын үзүүлэлт 100,000 хүнд 96 амиа хорлолт, Хатгал тосгон 100,000 хүнд 82 амиа хорлолт, Ринченлхүмбэ 100,000 хүн 53 амиа хорлолт, Түнэл сум 100000 хүн тутамд 60 амиа хорлолт, Баянзүрх сум 100,000 хүн тутамд 53 амиа хорлолтын үзүүлэлттэй гарчээ. Бага үзүүлэлтээр Цагаан-Уул сум 100,000 хүн тутамд 9, Шинэ-Идэр сум 100,000 хүн 12 амиа хорлолтын үзүүлэлттэй гарчээ.

⁹ [Suicide Rate by Country 2021 \(worldpopulationreview.com\)](https://www.worldpopulationreview.com/suicide-rate-by-country)



График №6

Аймгийн хэмжээнд нийт амиа хорлолтын шалтгаан тогтоох судалгаагаар нийт амиа хорлосон иргэдийн 81 нь бүтэлгүйтсэн хайр сэтгэлээс, 102 нь гэр бүлийн маргаан, хардалт, 15 нь хагацал, зовлонгоос, 53 нь гэмт хэрэгт холбогдсон болон бусад хариуцлагаас зугтсан байж болзошгүй, 97 нь архинд донтох эмгэгээс, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 13, хүсээгүй жирэмсэлсэн шалтгаанаас 2, хүнд өвчин туссанаа мэдсэнээс 6, сэтгэцийн эмгэг өөрчлөлтөөс 54, бүртгэгдсэн байна.



График-№7

Дээрх судалгааг 2011 оноос 2020 онуудад хийгдсэн задлан шинжилгээний дүгнэлтийг нэг бүрчлэн судлах, мэдээлэл цуглуулах, тоон үзүүлэлтийг боловсруулах, нэгтгэх, судалгааны нэгдсэн тайланг гаргах, харьцуулах, хянаж шалгах зэрэг 6 үе шаттай хийлээ. Тухайн нийт 425 тохиолдлуудад хэргийн газрын үзлэг, ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэх ажил, цогцост хийсэн задлан шинжилгээний дүгнэлт, тогтоол, хэргүүд дээр ажиллаж байсан мөрдөгч нараас авсан асуумж, тодорхой хэргүүдийн хавтаст хэргийн материал зэргээс мэдээллийг цуглуулж судалгааг гаргасан болно.

Хүн амын дундах амиа хорлолт ба амиа хорлохыг завдах үйлдлийг бууруулах арга зам

Дээрх судалгаанаас харахад бүхий л амиа хорлох шалтгаан нь сэтгэл гутрал, сэтгэцийн тулгамдсан асуудал¹⁰, эмгэг өөрчлөлттэй шууд холбоотой нь харагдаж байна. Дэлхий улс орон бүр амиа хорлолт ба амиа хорлохыг завдах үйлдлээс урьдчилан сэргийлэх талаар янз бүрийн арга хэмжээ зохион байгуулж ажиллаж байна. Амиа хорлолт нь ерөнхийдөө маш олон хүчин зүйлээс шалтгаалдаг гэж үздэг бөгөөд үүнийг төрөлжүүлбэл

1. Гадаад хүчин зүйл: (Нийгмийн хүчин зүйл болох ард иргэдийн ядуурал, ажилгүйдэл, эд зүйлийн хомстол, гэр бүлийн маргаан, хагацал, зовлон, хайр сэтгэл, хүчирхийлэл, зэрэг өөрөөс бус гадна нийгмийн харилцаанаас үүдсэн тулгамдаж буй асуудал)
2. Дотоод хүчин зүйл: (Тухайн хүний өөрөөс нь шалтгаалсан онцлог бүхий өвчин, сэтгэцийн эмгэг, донтолт, уур, бухимдал, ганцаардал, стресс гэх зэрэг бусад шалтгаан)

Дээрх судалгаанаас ажиглахад амиа хорлосон иргэдээс амьдралын түвшин, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар судалгааг гаргахад дундаж болон ядуу, нэн ядуу хүмүүс, бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой хүмүүс, ажилгүй хүмүүс дийлэнх хувийг эзэлж байна. Харин амьжиргаа сайтай, эд хөрөнгө элбэг, дээд болон түүнээс дээш боловсролтой хүмүүс нийт амиа хорлолтын 1-2%-ийг эзэлж байна. Тухайн тохиолдлуудыг бусдыг амиа хорлоход хүргэх гэсэн зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж шалгадаг бөгөөд Хөвсгөл аймгийн хэмжээнд 10 жилийн хугацаанд тухайн 425 тохиолдлоос 2 тохиолдол шүүхээр ял шийтгэгдсэн байна.



График №9



График №10

¹⁰ Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль 3. 1. 2 Улаанбаатар хот, 2013 он



График №11

Оросын амиа хорлолтын онцлог шинж чанарыг судалсан хэд хэдэн бүтээл гарсан бөгөөд үүнээс Д.Д.Богоявленскийн «Оросын амиа хорлолт ба Оросын шинэчлэл» нийтлэл, мөн С.В.Богдановын «Амиа хорлох зан байдал» нийтлэлийг нэрлэж болно. 20-р зууны сүүлч 21-р зууны эхэн үеийн нийгмийн өөрчлөлтийн хүрээнд Оросын хот, хөдөөгийн оршин суугчдын «Архидан согтуурахтай тэмцэх кампанит ажил» -ын үеэр амиа хорлох явдал эрс буурсан нь ажиглагдсан. Амиа хорлолтын тархалт 8-15% -иар тархах нь хүн амын архаг архидалтын өвчлөлөөс хамаарна ¹¹. Богданов 1990-ээд оны эхээр ОХУ-д амиа хорлох явдал эрс нэмэгдсэн шалтгааныг тайлбарлажээ. Үүнд Зөвлөлтийн нийгэм, улс төрийн тогтолцоо, түүний үзэл суртлын уналт, ёс суртахуун, ёс суртахууны үнэлэмжийг дахин үнэлэх, хүн амын орлогын түвшинг огцом буурах, аж ахуйн нэгжүүдийг хаах, ажилгүйдлийн түвшинг нэмэгдүүлэх зэрэг явдлаас хамаарсан гэж үзсэн. Богданов богино хугацаанд болсон эдгээр эрс өөрчлөлтүүд нь ихэнх хүн амын амьжиргааны түвшинг огцом бууруулж, хүмүүсийг өөртөө итгэлгүй, сэтгэл гутралд хүргэсэн гэж онцолж байна. Эндээс хамгийн чухал нь амиа хорлох асуудлыг төрийн байгууллагууд болон шинжлэх ухааны нийгэмлэгийн өмнө тавих шаардлагатай байна гэж дүгнэсэн юм.¹²

Манай улсад ажилгүйдлийн түвшин, архидалт өндөр байгаа нь нөлөөлж байгааг үгүйсгэхгүй бөгөөд нийгмийн хүчин зүйлээс нэлээдгүй шалтгаалж байгаа нь ойлгомжтой байна. Судалгаанаас харахад ажилгүй, тэтгэвэрт гарсан, малчин хүмүүс 90 гаруй хувийг эзэлж байна. Бид амиа хорлолт ба амиа хорлохыг завдах үйлдлийг маш өнгөц, үзэгдэх тухайн цаг хугацаа, нөхцөл байдлыг харж дүгнээд байгаа нь хамгийн том алдаа болж байгаа юм. Харин хэдэн тооны нийлбэр, ялгавраас бус алс хэтийн хүрээг нь оновчтой зөв тодорхойлж асуудал нэг бүрд нь хандсан ач холбогдол бүхий ажил хийх нь харин тухайн асуудлыг бууруулах, зогсоох үндэс болох юм. Хөвсгөл аймагт гарч буй амиа хорлолтын шалтгаануудад судлаачийн зүгээс дүн шинжилгээ хийж үзэхэд дараах далд шалтгаантай холбоотой амиа хорлолтууд байна. Эдгээр асуудлыг бид нарын тогтоож судлан шийдвэрлэж болно гэж үзэж байна. Цаашид дараах асуудал тус бүрт нь нарийвчилсан судалгаа хийж ажиллах нь зайлшгүй юм. Үүнд:

1. Орон нутаг, хөдөө болон хот суурин газрын жендерийн тэгш бус байдалтай холбоотой асуудал. (Gender imbalance): Хөдөө мал маллаж байгаа айл өрхүүдэд эмэгтэй хүн тун ховор байна. Монголчууд эрэгтэй хүүхдээ малаа маллуулаад эмэгтэй хүүхдээ сургуульд явуулж боловсролтой болгоно гэж зорьж явуулдаг бөгөөд боловсролтой болсон эмэгтэйчүүд нь буцаж хөдөөнөө очдоггүйгээс үүдэн тэр хөдөөний орчинд байх гэр бүл үймүүлэх, гэр бүлийн харилцаанаас гадуур явдал, араар тавилт, хардалт зэрэг шалтгаанаас үүдэлтэй амиа хорлолтууд гарч байна.

¹¹ Д. Богоявленский, Оросын амиа хорлолт ба Оросын шинэчлэл СОЦИС. - 2002. - № 5. - S. 76-80 тал

¹² С. Богданов, 20-р зууны сүүлч - 21-р зууны эхэн үеийн нийгмийн өөрчлөлтийн хүрээнд Оросын хот, хөдөөгийн оршин суугчдын амиа хорлох зан байдал, Москвагийн их сургуулийн эмхэтгэл. - 2011. - № 3. 148-157 тал

2. Орон нутагт үүссэн цус ойртолтын асуудал (population inbreeding): Энэ нь ах, дүү хамаатан садан, ураг, төрлүүд хоорондоо гэрлэж үр хүүхэдтэй болж буй асуудал бөгөөд энэхүү шалтгааны уршгаар ил болон далд хэлбэрийн биеийн гажиг, сэтгэцийн эмгэг, өөрчлөлт, элдэв өвчлөлт, оюуны хомстол, шизофренитой хүмүүс олшрох тэр бүгдийн нөлөөнөөс бий болсон амиа хорлолтууд байна. Энэхүү асуудал нь гарал үүслийн тодорхойгүй байдал. Төрийн зохицуулалт муу байдлаас шалтгаалж буй юм.
3. Амиа хорлож нас бардаг удамшлын асуудал. (Inheritance): Аав, эмээ, өвөө, төрсөн ах, эгч, хамаатан, садан гэх зэрэг ойр дотноороо амиа хорлож байна. Энэхүү үзэгдэл ажиллах хугацаанд нэлээдгүй тохиолдсон.
4. Боловсролын асуудал. (education): Амьдралын үнэ цэнэ, амьдрах утга учир, эх оронч үзэл, аливаа зүйлийг томоор харах, уудам сэтгэх чадвар дутмаг, зэрэг асуудалтай холбоотой, нэг уулын амнаас цааш газар байхгүй, нэг бүсгүйгээс өөр бүсгүй танихгүй гэж боддог хязгаарлагдсан давчуу бодол, сэтгэл гутралаас шалтгаалсан амиа хорлолтууд байна.
5. Хорт зуршил. (bad habit): Бид архи, тамхи, зэрэг хорт зуршлыг хортой гэдгийг нь мэдсээр байж боловсролтой, боловсролгүй, эцэг, эх, өвөө, эмээ, багш, сурагч гэлтгүй бүгд хэн ч хамаагүй хязгааргүй, өдөр, шөнөгүй хэрэглэсээр байна. Хорт зуршлуудын сөрөг үр дагаврыг мэдсээр байж хэрэглэсээр хордож, бэлгийн сулралд орж, өвчин эмгэгт нэрвэгдэж эхнэр нөхөртөө хаягдаж, ард иргэдэд муу үлгэр дууриалал үзүүлж эрүүл бус үр хүүхэд төрүүлж, эд мөнгөөр хохирч, гэмт хэрэг үйлдэж ирээдүйдээ сөрөг үр дагавар авчирч байгаа гэдгээ ухамсарладаггүй. Энэ шалтгаантай холбоотой амиа хорлолт тэргүүлэх байр суурь эзэлж байна.
6. Ажилгүйдэл (Unemployment): Энэ нь ажил олдохгүй, ажил хийх боломжгүй, орлогогүй, орлогоосоо давсан хэрэглээтэй, ядуугаас үүдсэн сэтгэл гутралтай холбоотой амиа хорлолт юм. Энэ хүмүүсийг удирдан чиглүүлдэг байгууллага, сэхээтэн байдаггүй. Харин хөдөлмөрийг нь шулах, үнэгүй ажиллуулах, зэрэг хандлагууд нийгэмд элбэг байдаг.
7. Шударга бус байдал (injustice): Энэ бол амиа хорлох тэргүүлэх шалтгаан юм. Амиа хорлож буй тохиолдлуудад дүн шинжилгээ хийх явцад шударга бус явдал, эд хөрөнгөний ялгавартай байдал, авилга, хээл хахуультай холбоотойгоор сэтгэл гутралд орох, сэтгэлийн тулгамдсан асуудал үүсэх, архи уух, амьдрах хүсэл зорилгогүй болж амиа хорлох тохиолдлууд нэлээдгүй гарсан. Тухайлбал дээр дурдсан ажилд орох, ажлаас халагдах, гадуурхагдах, улс төр, нам, ах дүү, хамаатан садан, нутаг ус, дов жалгын үзэл гаргах, айлган сүрдүүлэх, мөнгөгүй хүн өөрийгөө хэн ч биш гэж бодох сэдэл гэх зэрэг маш өргөн хүрээтэй асуудал юм.

Гадаадын орнуудад хэрэглэж буй урьдчилан сэргийлэх аргуудаас: Эрдэмтэн П.В.Пучков, Л.С.Беляева нар Саратов хотын сэтгэл мэдрэлийн эмгэг судлалын диспансерийн статистикт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр амиа хорлох гол шинж чанаруудыг онцлон тэмдэглэв. Амиа хорлох оролдлогыг залуу насандаа (18-35 нас) ихэвчлэн хийдэг гэж тэд тэмдэглэв. 36-50 насны бүлгийн хүчтэй үзүүлэлт. Судлаачид өвчтөнүүдийн асуулгад дүн шинжилгээ хийсний дараа амиа хорлох оролдлогын гол сэдлийг тодорхойлжээ. Үүнд (гэр бүлийн доторх зөрчил, сэтгэцийн эмгэг, хувь хүний доторх зөрчил, архи, мансууруулах бодис донтох, өвчин, бэлгийн, нийгэм, хөдөлмөрийн шалтгаан, ганцаардал гэх мэт). Үүний зэрэгцээ эрдэмтэд урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамгийн чухал зүйл бол **нөхцөл байдалд байнгын хяналт тавих явдал юм гэжээ.**¹³

¹³ Пучков, П. В. Саратов дахь амиа хорлох зан үйлийн шинж чанарууд, 2011 он, - № 6, 77-79 дэхь тал

Америк болон барууны улс орнуудад амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх үндэсний төвөөс ярилцах болон захидал солилцох хэлбэрээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үнэ төлбөргүй үйлчилгээ явуулдаг бөгөөд дуудлагаар очиж ажилладаг байна. Харин манай улсад 2019 оноос энэ төрлийн үйлчилгээг явуулдаг гэх 1800-2000 гэх тусгай дугаар бүхий утас ажиллуулж эхэлсэн гэх ба тандан судалж үзэхэд зөвхөн Улаанбаатарт байх төдийгүй. Гар утасны нэгжгүй хүн ярьж болохгүй, дуудлага өгөхөд орон нутагт шийдэх боломжгүй зэрэг асуудалтай зүйл олон байна.

WARNING SIGNS OF SUICIDE:
The behaviors listed below may be some of the signs that someone is thinking about suicide.

TALKING ABOUT:

- Wanting to die
- Great guilt or shame
- Being a burden to others

FEELING:

- Empty, hopeless, trapped, or having no reason to live
- Extremely sad, more anxious, agitated, or full of rage
- Unbearable emotional or physical pain

CHANGING BEHAVIOR, SUCH AS:

- Making a plan or researching ways to die
- Withdrawing from friends, saying good bye, giving away important items, or making a will
- Taking dangerous risks such as driving extremely fast
- Displaying extreme mood swings
- Eating or sleeping more or less
- Using drugs or alcohol more often

If these warning signs apply to you or someone you know, get help as soon as possible, particularly if the behavior is new or has increased recently.

National Suicide Prevention Lifeline 1-800-273-TALK Crisis Text Line Text "HELLO" to 741741

 www.nimh.nih.gov/suicideprevention

Амиа хорлолтын анхааруулга:
Амиа хорлох талаар бодож байгаа хэн нэгэнд доор жагсаасан зан байдлын зарим шинж тэмдгүүд илэрч болно.

Дараах зүйлийн тухай ярих: МЭДРЭМЖ

- Үхэхийг хүсч байна
- Их гэм эсвэл ичсэн
- Бусдад дарамт болох
- Хоосон, найдваргүй, баригдсан эсвэл шалтгаангүй амьдрах
- Маш их гунигтай, их түгшсэн, цочсон, уур, бухимдалтай
- Сэтгэл хөдлөлтийн болон бие овдөлтийг гэсвэрлэх чадваргүй

ЗАН БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

- Үхэх аргын талаар судалгаа хийж төлөвлөгөө гаргах
- найзаас салах ёс гүйцэтгэх, чухал зүйл өгөх, гэрээслэл бичих
- Эрсдэлд орохуйц хурдан жолоодох
- Сэтгэл санааны хямрал, өөрчлөлт
- Илүү их эсвэл бага хэмжээгээр идэж, унтах
- Мансууруулах бодис, согтууруулах ундаа илүү их хэрэглэх

Хэрэв эдгээр анхааруулах тэмдгүүд бүхий шинжүүд танд эсвэл тандяг хүмүүст илэрсэн бол аль болох түргэн тусламж аваарай.

National Suicide Prevention Lifeline 1-800-273-TALK Crisis Text Line Text "HELLO" to 741741

 www.nimh.nih.gov/suicideprevention

Анхааруулах хуудсыг эх хувиар болон орчуулсан байдлаар харуулав.

Сэтгэл зүйн зөвлөгөөг орон нутагт ард иргэдийн стресс, бухимдал зэрэг сэтгэцийн тулгамдсан асуудлыг эртнээс эдүгээ хүртэл лам, бөө, домч, мэргэ төлөгч, үзмэрч нар шийдэж ирсэн. Эдгээр хүмүүс нь сэтгэл зүйн эмчилгээг арга засал хийх, дом хийх, шившлэг хийх, ном унших зэрэг шинжлэх ухаалаг бус аргаар сэтгэл засал хийлгэж цаг алдаж хүндэрч явсаар эмгэг болж сэтгэцийн эмнэлэгт эсвэл амиа хорлолтод хүргэж байна. Дээрх шашны зан үйл, арга засал хийж буй хүмүүсийн буруу аргын сөрөг нөлөөнөөс үүссэн эрсдэлүүд нь цаг алдах хүчин зүйл болдог байна.

Олон улсын судалгаанаас харахад ихэнх улс орнуудад амиа хорлолттой холбоотой урьдчилан сэргийлэх судалгаа, шинжилгээний ажлыг маш олон янзаар хийж байсан ба хийгдсэн судалгаа бүрээс тодорхой хэсгийг уншиж судалж үзэхэд тухайн газар орчин, цаг хугацаа, улс орон, нийгэм соёлын онцлог, хөгжлийн түвшин зэрэг бүхий нөхцөл байдлаас шалтгаалсан амиа хорлолтын шалтгааныг нарийн судалж тогтоосныг үндэслэн хийгдсэн урьдчилан сэргийлэх болон таслан зогсоох арга хэмжээг авч ажиллах нь хамгийн үр дүнтэй гэдэг нь тодорхой болж байна.

Уг ажлыг тухайн чиглэлээр судалдаг, суралцсан мэргэжлийн хүн хийх нь үр дүнтэй юм. Тэгтэл энэ чиглэлээр манай улсад амиа хорлолтыг дагнан судалдаг судлаач мэргэжилтэн байхгүй байна. Зөвхөн энэ асуудалд тусгай мэдлэг шаардана гэж орхигдуулж болохгүй юм.

ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын хийх явц үр дүнгээс харахад амиа хорлож буй тохиолдлуудын шалтгаан нөхцөлийг нарийн тодорхойлж, зөвхөн тухайн амиа хорлож буй үйл явдлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэж тогтоож буй байдлаар хязгаарлахгүйгээр нэг хэрэг бус нийгмийн өргөн цар хүрээнд авч үзэж төр засгийн бодлого шийдвэрийг уялдуулж, тухайн асуудалд чиглэсэн бодитой ажлуудыг зохион байгуулж ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Дээрх судалгаагаар төр засгийн түвшинд шийдвэрлэж болох асуудлуудыг хөндсөн.

Гадаадын улс орнуудад хийгдэж буй амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх ажлуудыг судалж Хөвсгөл аймаг болон Монгол улсын хэмжээнд амиа хорлолтыг бууруулах чиглэлээр хийгдэж болох зарим ажлыг тодорхойлсон. Бид амиа хорлолтыг тухайн хэргийн газарт очиход харагддаг үзэгдлээс бус хэргийн цаана ямар нөхцөл байдал бий болсны улмаас энэхүү хэрэг гарсан шалтгааныг судалгаагаар нарийн тогтоох нь чухал гэдгийг ойлгосон. Өнөөгийн амиа хорлолтын нөхцөл байдлын судалгааг бодитой, үнэн, гаргаагүй, төр засаг, холбогдох хүмүүсийн сонорт хүргээгүйгээс, үүсэх үр дагавар нь тодорхой ажил хийгдэхгүй байгаагаас маргааш, нөгөөдөр амиа хорлож эрсдэх эрдэнэт хүний амь нас юм.

Амиа хорлож буй үйлдлүүдэд ихэнх үед тохиолддог сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой тулгамдсан асуудлыг орон нутагт эрт илрүүлж, оношлох, эмчлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг шийдвэрлэх арга зам дутмаг байна. Энэ үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, ард иргэдэд энэ төрлийн ойлголттой болгож, анхаарлын төвд оруулж эхэлбэл амиа хорлолт тодорхой хэмжээнд буурах хандлага байгаа гэдэг нь олон улсад жишгээс харагдаж байна.

Иймд амиа хорлох, амиа хорлохыг завдах үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд бие хүний гадаад болон дотоод хүчин зүйлсэд үүсэж буй сөрөг нөлөөлөл, эмгэг өөрчлөлтийг эрт илрүүлж, оношилж, эмчилж, эдгээж нийгмээ эрүүлжүүлж, хүн бүр аз жаргалтай, ирээдүйдээ итгэлтэй, ажилтай, орлоготой, эрүүл, саруул, элэг бүтэн, эх оронч үзэлтэй, иргэн бүр аз жаргалтай, сайн сайхан амьдралыг бий болгох чиглэлээр жирийн нэг иргэнээс эхлээд төр засаг хүртэл хичээх хэрэгтэй байна.

САНАЛ

1. Орон нутагт ард иргэдийн дунд үнэ төлбөргүй сэтгэл зүйн зөвлөгөө өгч сурган зааварладаг мэргэжлийн сэтгэл зүйч ажилладаг үйлчилгээний цэг байгуулж ажиллуулах
2. Орон нутагт болон нийслэлд амиа хорлохыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаар дагнасан дуудлагын үнэгүй утас ажиллуулж тусламж, үйлчилгээ, үзүүлж хэвших.
3. Ард иргэдийг амиа хорлолтоос хэрхэн урьдчилан сэргийлэх, хэнд хандах, хэрхэн зөвлөгөө авах талаар ойлголттой болгох.
4. Сэтгэцийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэг, сэтгэл гутрал, янз бүрийн донтолт, архаг өвдөлт, сэтгэл хөдлөлийн хурц өвчтэй хүмүүсийг эрт илрүүлэх, эмчлэх, асрах чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллах.
5. Улс орон даяар цус ойртолтын тандалт судалгаа хийх. Үүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулах.
6. Орон нутагт жендерийн тэгш бус байдлын асуудлыг тэнцвэржүүлэх талаар төр засгаас тодорхой бодлого, арга хэмжээ зохион байгуулж ажиллах.
7. Эцэг эхчүүд болон багш сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтнууд нь хүүхдүүдийнхээ чөлөөт цагийг хэрхэн эрүүл өнгөрөөж байгаа тал дээр анхаарал хандуулах, өөрсдөө зөв үлгэр дууриалал үзүүлэх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нийгмийн боловсрол эзэмшүүлэх.

8. Амиа хорлолтын сөрөг үр дагавар түүнээс үүссэн эргэн тойрны хөндөгдөж буй эрх ашиг болон эсрэгээрээ амьдрал ямар үнэтэй, амьдрах ямар сайхан байдгийг хүүхэд, залуучуудад харуулсан кино контент хийх.
9. Ард иргэдэд амиа хорлосон үйлдэлд ёс суртахуун, нийгэм, шашин, үзэл баримтлалын талаас гарч болох бүх сөрөг үр дагавруудыг тайлбарлан сурталчилж, ойлгуулж амиа хорлолтыг жигшүүлэх ажиллагаа зохион байгуулж эх оронч үзэлтэй болгох.
10. Улс орон даяараа шударга бус байдалтай тэмцэж, төр засгаасаа эхлээд жирийн иргэн хүртэл авилга, хээл хахуульгүй шударга ёсыг сахидаг шударга нийгмийг бий болгоход хичээнгүйлэн зүтгэх.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль. 2013 он

Монгол эх сурвалж:

- Глобал Императив. Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх: *Дэлхийн эрүүл мэндийн байгууллага*, 2014 он
- Улсын ерөнхий прокурорын газрын Сургалт судалгааны төв, *Монгол улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгаа*. Улаанбаатар хот, 2017 он

Гадаад эх сурвалж:

- Богоявленский, Д. Д. *Оросын амиа хорлолт ба Оросын шинэчлэл*, ОХУ, 2002 он
- Богданов, С.В. 20-р зууны сүүлч - 21-р зууны эхэн үеийн нийгмийн өөрчлөлтийн хүрээнд Оросын хот, хөдөөгийн оршин суугчдын амиа хорлох зан байдал / С.В.Богданов / *Москвагийн их сургуулийн эмхэтгэл*, 2011 он
- Пучков, П. В. *Саратов дахь амиа хорлох зан үйлийн шинж чанарууд*, 2011 он
- World Health Organization, *Preventing Preventing suicide*, 2014 он,

Цахим эх сурвалж:

- <https://www.who.int/ru/news-room/fact-sheets/detail/suicide>
- <https://www.who.int/ru/news-room/fact-sheets/detail/suicide>
- <https://vip76.mn/content/48174> Б.Өнөрмаатай хийсэн ярилцлага
- <https://ikon.mn/n/172g>
- [Suicide Rate by Country 2021 \(worldpopulationreview.com\)](https://www.worldpopulationreview.com/suicide-rate-by-country)

BASIC RESEARCH ON SUICIDE CASES IN KHUVSGUL PROVINCE OVER THE LAST 10 YEARS AND WAYS TO REDUCE

T.Burenkhaan

Ph.D candidate, Senior forensic expert in forensic service of Khuvsgul province

ABSTRACT:

There is no doubt that suicide and attempted suicide is one of the most pressing issues facing children, youth and the general public in today's society. Every day there are suicides that frighten the society, hurt the people, cause controversy and divide the people. We are constantly confronted with this negative social phenomenon, but there is no real work to reduce, reduce or

prevent it. In Khuvsgul aimag, my team conducted a baseline study on suicide cases over a 10-year period from 2011-2020. In Khuvsgul aimag, the number of suicides among young people has risen sharply in recent years, with 63 suicides in 2020 and 46.6 suicides per 100,000 population. According to a study, one person commits suicide every six days. If Khuvsgul is one of the countries in the world, the suicide rate is four times higher than the world average, and 14.7 times high than Lithuania, which has the highest suicide rate in the world (31.9 per 100,000 people). This should not be the case in a country with a small population like Mongolia. That is why we need to find all possible ways to combat this.

KEY WORDS:

Suicide, Preventing suicide, Social nature of suicide, Theories and Conceptions of Suicidal Behavior.

---o0o---

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН АНХНЫ ДАРГА, ГАВЬЯАТ
ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР,
ПРОФЕССОР Г.СОВДЫН НЭРЭМЖИТ ШИЛДЭГ ӨГҮҮЛЛИЙН
ШАЛГАРУУЛАЛТ БОЛЛОО**



Үндсэн хуулийн Цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Галдангийн Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн Судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Улсын ерөнхий прокурорын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, сургалтын хэлтэс, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран амжилттай зохион байгууллаа. Энэ жилийн уралдаанд нийт 7 өгүүлэл ирүүлснээс зохион байгуулагчдын зүгээс тус бүр доктор эрдэмтдийн багаар шалгаруулалтыг явуулж, нэгдсэн дүнгээр Ч.Болормаагийн “Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх ялын бус эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгох нь” сэдэвт өгүүлэл 2020 оны хууль зүйн сэдэвт шилдэг өгүүллээр шалгарлаа.

Шагналыг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор П.Амаржаргал, ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн дарга доктор, дэд профессор Б.Айбек, УЕП-ийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, сургалтын хэлтсийн хяналтын прокурор, доктор Б.Өнөрмаа нар гардууллаа.

Энэхүү өгүүллийн уралдааны зорилго нь хууль зүйн салбарын тулгамдсан асуудлыг хөндөж, шинэлэг санаа дэвшүүлсэн шилдэг өгүүллийг шалгаруулж урамшуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих юм.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, ҮР НӨЛӨӨ



Б.Анхбаяр

МУИС-ийн ХЗС-ийн магистрант

ТОВЧЛОЛ:

Дэлхийн эдийн засаг Ковид-19 цар тахлын улмаас хүнд хямралд өртөж байгаа бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулалтад шууд нөлөө үзүүлж байна. Ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд тэдний эдийн засгийн хөгжил, хөрөнгө оруулалтын стратеги болон бодлогод ихээхэн нөлөөлж, сөрөг үр дагавар авчрах төлөвтэй байна.

Улмаар улс орнууд цар тахлын хариу арга хэмжээ болгон гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх эсхүл богино хугацааны бодлого боловсруулж гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах, дэмжих чиглэлээр арга хэмжээ авч эхлээд байна.

Иймд гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалтын эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт хийж буй улс орнуудын бодлогын арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулан судалж цаашид хямралын нөхцөл байдлыг олон улсын чиг хандлага, туршлагын дагуу даван туулах саналыг дэвшүүлэх оролдлого хийсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Үндэсний аюулгүй байдал, Хараат байдал, Хямрал, Хяналтын зохицуулалт

УДИРТГАЛ

Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын хямрал нь гадаадын хөрөнгө оруулалт (цаашид “ГХО” гэх)-г огцом уналтад хүргэж байна. Дэлхийн хөрөнгө оруулалтын урсгал (inflow) 2019 онд 1.54 их наяд доллар байсан бол 2020 онд 40 хүртэл хувиар буурсан бөгөөд энэ нь 2005 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш анх удаа ГХО-г нэг их наяд доллараас доош түвшинд хүргэсэн¹ түүхэн үйл явдал боллоо.

Дэлхийн ГХО-н урсгал 2021 онд 5-10 хувиар буурч 2022 онд сэргэх төлөвтэй байх боловч энэ нь маш өөдрөг төсөөлөл гэдгийг судлаачид дүгнэж байна. Учир нь энэхүү нөхцөл байдал цаашид хэрхэн үргэлжлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд хорио цээрийн арга хэмжээнүүд нь ГХО-н төслүүдийг удаашруулж, үндэстэн дамнасан аж ахуй нэгжүүдийн төслүүдийг дахин үнэлэхэд хүргэж байна.

¹ UNCTAD, *World investment report*, Нью-Йорк, UNPublications, 2020, p10

Хямралын үеийн засгийн газруудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинэ хязгаарлалтыг бий болгож, зарим тохиолдолд өөрчлөлт оруулж ГХО-г хязгаарлах эрх зүйн зохицуулалтад ач холбогдол өгч байна².

Тодруулбал, ковид-19 цар тахлын хөл хорио, хязгаарлалтын улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй, хямралд өртсөн компаниуд болон эдийн засгаа хамгаалах нь тухайн улсын үүрэг тул дэлхийн улс орнууд дараах хэлбэрээр ГХО-д хязгаарлалтын түр болон байнгын шинжтэй зохицуулалтыг улсын орны хөгжлийн түвшингээр ялгамжтай хийж байна.

Хөгжингүй орнуудын хувьд хямралд өртсөн компаниудаа хамгаалах, эдийн засгийн хараат бус байдлаа баталгаажуулах шаардлагаар гадаадаас орж ирэх хөрөнгө оруулалтад хязгаарлалт шинээр тогтоож байхад хөгжиж буй орнуудын хувьд ГХО-н нээлттэй бодлого баримталж хязгаарлалтыг сулруулах, дэмжих зохицуулалт хийх хандлага ажиглагдаж байна.

Харин Монгол Улсын хувьд Ковид-19 цар тахлын энэ хүнд цаг үед гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эсхүл дэмжих талаар ямар нэгэн зохицуулалт хийгээгүй бөгөөд энэ талаар хараахан бодлого боловсруулаагүй байгаа нь энэхүү сэдвийг судлах шаардлага болж байна.

Энэхүү өгүүллийн хүрээнд Ковид-19 цар тахлын үед олон улс дахь ГХО-г хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг бусад орны туршлагатай харьцуулан судалж, өөрийн орны үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, цаашид анхаарах зүйлсийг тодорхойлон санал дэвшүүлэхийг зорьсон болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

А. Ковид-19 цар тахлын үеийн ГХО-н хязгаарлалтын олон улсын бодлого, чиг хандлага

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрх зүйн зохицуулалтын ойлголт, онолын үндэслэл

Профессор М.Сорнаража нь “Гадаадын хөрөнгө оруулалтын олон улсын эрх зүй” бүтээлдээ хөрөнгө оруулалтын эрх зүйн түүхэн хөгжлийг Колоничлолын үе ба колоничлолын дараах үе хэмээн авч үзсэн³ байдаг.

XVIII-XIX зуунд хөрөнгө оруулалтыг колоничлолын тэлэлтийн хүрээнд голчлон хийсэн. Эзэнт гүрэн, хаант засаглалын тогтолцоо нь ГХО-н хамгаалалт болж байсан тул гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах, эсхүл түүнийг хязгаарлах шаардлагагүй байсан.

Харин эзэнт гүрнүүд татан буугдсаны дараа ГХО-г хамгаалах хэрэгцээ шаардлага хуучин эзэнт гүрнүүдэд үүссэн. Үүний зэрэгцээ колоничлолын үеийн төгсгөл нь үндсэрхэг үзлийг хүчтэй өдөөсөн юм⁴. Колоничлолын хүлээснээс гарсан улс орнууд нь хуучин колоничлогч орон болон бусад улс орноос хараат бус байх, бүрэн эрхт байдлаа хамгаалах ГХО-г хязгаарлах зохицуулалт хийж эхэлсэн.

“Эдийн засгийн сонгодог онол”-ын дагуу ГХО нь хүлээн авагч улсын эдийн засагт ашигтай гэж үздэг. Жишээлбэл, хүлээн авагч орны өсөлт, инновацийг сайжруулж, чанартай ажлын байр бий болгох, хүний капиталыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, менежментийн болон бизнесийн хариуцлагатай үйл ажиллагааны талаарх сайн туршлагыг нэвтрүүлдэг юм⁵. Гэвч “Хамааралт байдлын онол”-ын дагуу эдийн

² Мөн тэнд р88

³ Э.Байгал. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй. 2017, 22 дахь тал

⁴ M.Sornarajah. *The international law on Foreign investment*, Cambridge university press, 2010, 22 дахь тал

⁵ OECD, *Investment screening in times of COVID-19 and beyond*, Судалгааны тайлан, 2020, 1 дэх тал

<http://www.oecd.org/coronavirus/policy-responses/investment-screening-in-times-of-covid-19-and-beyond-aa60af47/#figure-d1e42>. [Сүүлд үзсэн: 2021.01.05]

засгийн сонгодог онолоос эрс ялгаатай тайлбарлагддаг. Учир нь, хөгжингүй орнуудад төвтэй үндэстэн дамнасан корпорацийн үйл ажиллагаа нь хөгжиж буй орнуудын эмзэг байдлыг нь далимдуулан өөрсдийн хараат байдалд өртүүлдэг, бие даасан байдалд нөлөөлдөг хэмээн үздэг. Хамааралт байдлын онолын нэг давуу тал нь хөрөнгө оруулалтаас илүүтэйгээр хүний эрх, хүрээлэн буй орчны асуудалд ихээхэн анхаарал хандуулдаг бөгөөд аливаа улсын иргэдийн эрх ашиг улсынхаас дээгүүр тавигдах ёстой гэж үздэгээрээ онцлог юм.⁶

Түүхэн хөгжлийн явцад ГХО-ыг хязгаарлах явдал нь дан ганц хөгжиж буй орнуудад хамааралтай асуудал байсан бол одоо хөгжингүй орнуудад чухлаар тавигдах судлагдахуун болон өргөжсөн байна. Учир нь, АНУ, Европын улсуудын тэргүүлэгч компаниудыг Ази (Хятад, Энэтхэг) болон бусад орнуудаас гадаадын хөрөнгө оруулагчид худалдан авах, эзэмших болжээ. Үүний үр дүнд тэд өнгөрсөн хугацаанд хөгжиж буй орнуудын адил бүрэн эрхт байдалд суурилсан үлэмж хэмжээний хамгаалалт бий болгож, хөрөнгө оруулалтын хамгаалалтын хил хязгаарыг шинэчлэн тогтоож эхлээд байна.⁷ 1990-ээд онд Латин Америк эдийн засгийн сонгодог онолын үзэл баримтлалаасаа ухарч, либералчлалын хандлагыг хүлээн зөвшөөрөх болсон ч өдгөө дахин хамааралт байдлын онол зарим улсад ноёрхож эхэлсэн гэж болно.⁸

Зарим улс дахь ГХО-н талаарх нээлттэй бодлого нь өнөөдөр ГХО-г дотогш оруулахыг хязгаарлах бодлого болон хувирч байна. Энэхүү өөрчлөлт нь өнөөдөр дэлхийн аль ч улсад анзаарагдах болсон.⁹

ГХО-ыг хянах, хязгаарлах нь тухайн улсын бүрэн эрхт байдлаас улбаатай эрхийн асуудал¹⁰ бөгөөд ГХО-н хязгаарлалтыг гадаад хөрөнгө оруулагчийг хянах, нэвтрэх үеийн шалгалт хийх, шаардлага, хязгаарлалт тавих зэрэг хэлбэрээр зохицуулдаг.

ГХО-г хязгаарлах бодлого нь дараах нийтлэг шалтгаантай байдаг. Үүнд:

- Эдийн засгийн шалтгаан - *ихэвчлэн хөгжиж буй орнуудад түгээмэл байдаг бол үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шалтгаан нь өндөр хөгжилтэй орнуудад чухал шалтгаан болдог байна.*
- Үндэсний аюулгүй байдлын болон Улс төрийн - *ГХО, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшихийг хязгаарлаж буй салбарууд нь ихэвчлэн байгалийн нөөц баялгийг ашиглах болон батлан хамгаалах салбар байна. Мөн эрчим хүч, тээвэр, харилцаа холбооны салбарт энэ хязгаарлалтыг түгээмэл хэрэглэдэг байна.*

Гадаад улсаас МУ-н нутаг дэвсгэр, эрх зүйн зохицуулалт руу шилжин орж байгааг үнэлж болох аливаа биет болон биет бус зүйлийг “гадаадын хөрөнгө оруулалт” гэж хэлж болно. Харин гадаадын хөрөнгө оруулалтын Хязгаарлалт¹¹ гэдэг нь хөрөнгө оруулалт хийх үйл явцад хөрөнгө оруулалтад шаардлага тавих, хязгаарлахыг ойлгох бөгөөд Зохицуулалт¹² гэж хөрөнгө оруулалтыг хэм хэмжээ эсхүл хязгаарлалтаар хянах процесс, үйлдлийг ойлгоно.

ГХО-г хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг шууд ба шууд бус хязгаарлалт гэж ангилдаг¹³.

Шууд хязгаарлалтын зохицуулалт гэдэгт гадаадын хөрөнгө оруулагчдын зах зээлд нэвтрэх, үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх хязгаарлалт, хувь эзэмших тоо хэмжээг тодорхой

⁶ Э.Байгал. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй. 2017 он. 36 дахь тал

⁷ M.Somarajah, *The international law on Foreign investment*, Cambridge university press, 2010, 5 дахь тал

⁸ Э.Байгал. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй. 2017 он. 36 дахь тал

⁹ Э.Байгал. Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй. 2017 он. 39 дэх тал

¹⁰ M.Somarajah, *The international law on Foreign investment*, Cambridge university press, 2010, 88 дахь тал

¹¹ Black's law dictionary p1457 Ninth edition, USA, 2009

¹² Black's law dictionary p1426 Ninth edition, USA, 2009

¹³ A.Hardin, L.Holmes, *Service trade and Foreign direct investment*, 1997, 34 дэх тал

<https://www.pc.gov.au/research/supporting/service-trade-foreign-direct-investment/servtrad.pdf> [сүүлд үзсэн: 2020.12.25]

зааж өгсөн зохицуулалтууд хамаардаг. Үүнд: хөрөнгө оруулалтын хэмжээ, тодорхой салбарт эзэмших хувь, хөрөнгө оруулах дотоодын шууд шаардлага болон тухайн улсын зах зээлд нэвтрэх шалгуурт заасан хязгаарлалтууд орно.


Шууд бус хязгаарлалтын зохицуулалтад гадаадын хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, үйл ажиллагаа, зах зээлд нөлөөлөх байдал зэрэг хамаардаг. Үүнд: эдийн засгийн үр ашгийн тооцоо, компанийн удирдлагын шаардлага, үндэсний ашиг сонирхлын шалгуур зэрэг нь ордог байна.

Ковид-19 ба хязгаарлалтын бодлого

Дэлхийн өнцөг булан бүрд олон улс Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахын тулд эрчимтэй алхамууд (хөл хорио тогтоох, хил хаах, тусгаарлалт)-г хийсээр ирсэн. Эдгээр алхмуудын үр дүнд ажилгүйдлийн түвшинг ихэсгэж, олон бизнес эрхлэгчид санхүүгийн хувьд хүнд байдалд орсон. Ийм бизнесийг зохих хяналтгүйгээр олж авахаас хамгаалахын тулд зарим улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиа чангатгасан байдаг.¹⁴

2019 оноос эхлэн сүүлийн жилүүдэд хөгжингүй орнуудын ихэнх нь үндэсний аюулгүй байдлын үүднээс стратегийн ач холбогдол бүхий салбаруудад оруулсан хөрөнгө оруулалтыг илүү нарийвчлалтай шалгаж эхэлсэн. НҮБ-ын Худалдаа хөгжлийн баг хурал (UNCTAD)-ын тооллогоор 54 эдийн засаг гадаадын хөрөнгө оруулалтад нөлөөлөх 107 бодлогын шинэ арга хэмжээг нэвтрүүлжээ.

Сүүлийн жилүүдэд үндэсний аюулгүй байдалтай холбоотой хөрөнгө оруулалтын бодлого баримтлах чиг хандлага үргэлжилж байна. Эдгээр арга хэмжээний ихэнх нь хөгжингүй эдийн засагтай орнуудад хэрэгжиж ирсэн. Ковид-19 цар тахлын дараа энэ чиг хандлага улам хурдсах төлөвтэй байгаа нь дотоодын чухал аж үйлдвэрүүд гадны эзэмшилд өртөж болзошгүй гэсэн болгоомжлолыг олон улс орнуудад төрүүлээд байна¹⁵.



Зураг №1.¹⁶

Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD) нь үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар ГХО-н бодлогын өөрчлөлтийн талаар судалгааг 62 улсад хийсэн байна. Тус судалгаа (зураг №1)-аар сүүлийн 5 жилийн хугацаанд ковид-19-аас хамааралгүй байдлаар зохицуулалтын шинэчлэл эрчимжиж байгаа бөгөөд хийгдэхээр хүлээгдэж байгаа төлөв ч ажиглагдаж байна. Мөн Ковид-19 цар тахлын дэгдэлтийн улмаас 2020 онд

¹⁴ Bird&Bird LLP, *Foreign direct investment & Covid-19 pandemic*, 2020, 2 дах тал <https://www.lexology.com/library/detail.aspx?g=98866c35-1a1b-4d19-9716-4ffc0bb664f9>. [Сүүлд үзсэн: 2021.02.01]

¹⁵ UNCTAD, *Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан*, Нью-Йорк, UNPublications, 2020, 97 дахь тал

¹⁶ OECD, *Investment screening in times of COVID-19 and beyond*, Судалгааны тайлан, 2020, 2 дах тал <http://www.oecd.org/coronavirus/policy-responses/investment-screening-in-times-of-covid-19-and-beyond-aa60af47/#figure-d1e42>. [Сүүлд үзсэн: 2021.01.05]

шинэчлэл эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд хүлээгдэж байгаа шинэчлэл мөн хэмжээгээр их байгаа нь харагдаж байна.

Хязгаарлалтын зэрэгцээ уул уурхай, эрчим хүч, санхүү, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг төрөл бүрийн салбарт либералчлалын алхам хийгдсэн. Зарим орнууд засаг захиргааны журмыг хялбарчлах талаар хүчин чармайлт гаргаж, зарим нь ГХО-г нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтыг урамшуулах дэглэмийг өргөжүүлсэн.

Газар зүйн хувьд шинэ зохицуулалтын мөн чанар нь бүс нутгуудад эрс ялгаатай байна. Хөгжиж буй эдийн засагтай орнуудад хэрэгжүүлсэн 52 бодлогын арга хэмжээ нь хөрөнгө оруулалтыг либералчлах, дэмжих, хөнгөвчлөхтэй холбоотой байсан бол зөвхөн 11 нь хязгаарлалт, зохицуулалттай холбоотой байв. Харин хөгжингүй орнуудын хувьд ихэнх нь хязгаарлалтын зохицуулалтыг эрчимжүүлэх хандлагатай байна.

Ковид-19-ийн хямрал нь ГХО-д шууд нөлөөлж, удаан хугацааны үр дагаварт хүргэж болзошгүй юм. Үүний үр дүнд 2021 онд ГХО-н шинэ хязгаарлалт¹⁷ бий болох бөгөөд энэ нь зарим орнуудад үйлчилж эхлээд байна.

Ковид-19 цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн огцом өөрчлөлт нь олон улсын засгийн газруудыг ГХО-н урсгалыг шалгах механизмыг сайжруулах эсвэл шинээр нэвтрүүлэхэд хүргэсэн. Хөрөнгө оруулалтын хяналт шалгалт цар тахал эхлэхээс өмнө аль хэдийнээ цэцэглэн хөгжиж байсан бөгөөд хямрал нь энэ хандлагыг өдөөх бус харин ч хурдацтай явагдах нөхцөлийг бүрдүүлж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татаж болжээ.

Цар тахалтай холбоотой шинэ хязгаарлалтын зохицуулалт, бусад орны туршилага

Европын холбоо (ЕХ)-ны ГХО-н хязгаарлалтууд нь Европын улс төрийн хөтөлбөрт 2019 оноос эхлэн орсон¹⁸ бөгөөд энэ нь Хятадын “Нэг бүс, зам” санаачилга болон ЕХ-ны АНУ-тай өрсөлдөх чадвараас санаа зовсны хариу үйлдлээр боловсруулагдсан юм.¹⁹ Харин цар тахлын хямралын үед дан ганц үндэсний аюулгүй байдлаар зогсохгүй opportunist M&A²⁰ буюу дампуурлын худалдан авах ажиллагаатай тэмцэхийн тулд ГХО-н хязгаарлалтыг ашиглах болсон. Ковид-19 хямрал эхэлснээс хойш хэд хэдэн улс (ялангуяа Итали, Испани, Унгар, илүү хязгаарлагдмал хүрээнд Франц, Герман) гадаадын шууд хөрөнгө оруулалтын нэмэлт хязгаарлалтыг нэвтрүүлсэн бөгөөд бусад (чех, польш) олон улс орнууд нэмэлт хязгаарлалтыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэж байна.

Урьд өмнө үзэгдэж байгаагүй энэ нөхцөл байдал нь оппортунист худалдан авагчдад хямралын улмаас үйл ажиллагаа доголдсон компаниудыг эзэмших, хөрөнгө оруулах эсхүл хяналтыг олж авах боломжийг олгож байгаа юм.²¹

Улмаар ЕХ-ны бүс нутгийн түвшинд 2020 оны 3-р сарын 25-ны өдөр Европын Комиссоос цар тахлын үед ЕХ-ны гишүүн бус орнууд хөрөнгө оруулалт хийх замаар гишүүн орны капиталын хөдөлгөөн хийх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх эсвэл холбогдох салбарыг эзэмшихийг оролдож байгаа талаар гишүүн орнуудад сэрэмжлүүлэг удирдамж өгсөн. Европын Комиссоос ГХО-г шалгах үндэсний дэглэмийг бүрэн ашиглахыг зөвлөж, ийм хяналтын дэглэмгүй гишүүн орнуудаас зохицуулалт бий болгохыг уриалсан байна.²²

Үндэсний аюулгүй байдал, ялангуяа стратегийн болон чухал дэд бүтцийн салбарууд

¹⁷ UNCTAD, *Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан*, Нью-Йорк, UNPublications, 2020, 4 дэх тал

¹⁸ REGULATION (EU) 2019/452 OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL

¹⁹ White & Case LLP, *COVID-19 Foreign Direct Investment (FDI) - An Overview of Restrictions in Western Europe*, EU, 2020 <https://www.lexology.com/library/detail.aspx?g=2545c249-4d5d-40e4-b513-aa1dda17b415>. [Сүүлд үзсэн: 2021.01.10]

²⁰ “Opportunistic Acquisitions” гэдэг нь дампуурал, хямралын замаар тухайн хөрөнгийг худалдаж авах, эзэмшихийг ойлгоно. Цар тахлын үед дотоодын компаниуд эдийн засгийн гүн хямралд өртсөн байх бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчид бизнесээ худалдах нь салбарын онцлогоос хамаарч үндэсний аюулгүй байдал, эрх ашигт сөргөөр нөлөөх эрсдэл байгаагай шууд холбоотой юм.

²¹ Jade-Alexandra Fearn, *New Challenges for Foreign Direct Investment in the Age of COVID-19*, Proskauer Rose LLP, USA, 2020 <https://www.lexology.com/library/detail.aspx?g=38438bff-cf09-4f40-b75f-a173e09b3a7a> [Сүүлд үзсэн: 2021.01.10]

²² European Commission, *Communication from the Commission, Guidance to the Member States concerning foreign direct investment and free movement of capital from third countries, and the protection of Europe’s strategic assets, ahead of the application of Regulation (EU) 2019/452 (FDI Screening Regulation)*, 25.3.2020, C(2020) 1981 final.

дах ГХО-ийн илүү олон зохицуулалт, хязгаарлалтын талаарх 2018 онд ажиглагдсан бодлогын чиг хандлага 2019 онд болон 2020 оны эхний саруудад үргэлжилж, эрчимжсэн. Цар тахлын үеэр стратегийн ач холбогдол бүхий салбар, дотоодын чухал үйлдвэрүүдийг хамгаалахын тулд хэд хэдэн улс ГХО-г таних, хязгаарлах талаар шинэ зохицуулалт баталж, одоо мөрдөж буй хуулиудыг бэхжүүлсэн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь Ковид-19 цар тахлын эсрэг хариу үйлдэлтэй шууд холбоотой. Үүнд:

ЕХ-ны гишүүн орнууд

- Цар тахлын өмнө Испани улс ГХО-ын дэглэмийг либералчилж, урьдчилсан зөвшөөрөл шаардлагатай байсан тодорхой салбаруудыг тогтоосон. Гэсэн хэдий ч 2020 онд Испанийн Эзэн хааны 3 удаагийн зарлигаар ГХО-н зохицуулалтаа эрс чангатгасан анхны ЕХ-ны гишүүн улс болсон.

Ковид-19-ийн хариу арга хэмжээний бодлогын багцын нэг зүйл бол шууд хөрөнгө оруулалтыг либералчлах дэглэмийг зогсоосон юм. Учир нь, энэхүү цар тахал нь Испанийн компаниуд, тэр дундаа стратегийн салбарын зарим компаниудад заналхийлж байна гэж үзсэн. Тиймээс чухал дэд бүтэц, технологи, эрүүл мэнд, харилцаа холбоо, эрчим хүч, тээвэр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүхий эд, хүнсний аюулгүй байдал зэрэг тодорхой салбар дахь компанийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг эзэмших, менежментийн эрхийг олж авахад засгийн газрын зөвшөөрөл шаардлагатай²³ болсон. Мөн шууд бус хөрөнгө оруулалтын хувьд 1 сая еврогоос дээш хөрөнгө оруулах тохиолдолд зөвшөөрөл авах босго тогтоож түр арга хэмжээ нэвтрүүлсэн.²⁴

Хэрэв гадаадын хөрөнгө оруулагч нь гадаадын засгийн газартай шууд болон шууд бусаар холбоотой тохиолдолд бүх салбар дахь хөрөнгө оруулалтад хатуу дэглэм үйлчилдэг. Тиймээс шинэ зохицуулалтууд нь ЕХ-ны гишүүн бус эсвэл төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтад чиглэсэн байна. Энэ нь Хятадаас засгийн газрын хяналтад байгаа худалдан авагчдын оппортунист хэлбэрээр авах ажиллагаатай шууд холбоотой юм.

- Франц улс 2019 оны сүүлээр ЕХ-ны гишүүн бус хөрөнгө оруулагчдын зөвшөөрөл авах хяналтын босго хэмжээг 33.33 хувиас 25 хувь болгон бууруулж, салбарыг өргөжүүлж, хяналтын системийг бэхжүүлсэн.

2020 оны 04 сарын 28-ны өдөр стратегийн ач холбогдол бүхий салбарын жагсаалтад багтсан компаниудын хувьцааг ЕХ-ны гишүүн бус хөрөнгө оруулагч эзэмшихтэй холбоотой хяналтын босгыг 25 хувиас 10 хувь болгож дахин бууруулсан байна.

- Цар тахлын өмнө Италийн засгийн газар ГХО-г хянах эрх мэдлээ хэрэгжүүлэх хандлага нэмэгдсэн байв. Улмаар 2020 оны 4-р сарын 7-ны өдөр Италийн засгийн газар шинэ салбарууд болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын дэглэмд аль хэдийн хамрагдсан салбаруудад эрх мэдлээ эрс өргөжүүлсэн.

Ковид-19-н шинэ дэглэм нь шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтын цар хүрээг стратегийн салбарт өргөжүүлсэн бөгөөд үүнд: (i) нэн чухал дэд бүтэц (ус, эрүүл мэнд орно); (ii) чухал технологи, давхар хэрэглээний зүйлс (үүнд хиймэл оюун ухаан, робот, биотехник); (iii) чухал хангамж; (iv) эмзэг мэдээлэлд нэвтрэх (үүнд хувийн мэдээлэл орно); (v) мэдээллийн хэрэгсэл; болон (vi) санхүү, зээл, даатгал орсон.

Тодруулбал, дээрх салбар дахь компанийн хувьцааны 10% ба түүнээс дээш хувийг эзэмших, эсхүл 1 сая еврогоос дээш шууд бус хөрөнгө оруулалт хийх тохиолдолд засгийн газраас урьдчилсан зөвшөөрөл авах шаардлагатай болсон. Эрүүл мэндийг стратегийн салбар болгон оруулах нь цар тахлын эсрэг шууд хариу арга хэмжээ

²³ Article 7, Royal Decree-Law 8/2020

²⁴ Article 1, 2, Royal Decree-Law 11/2020

болж байна. Эдгээр хязгаарлалтыг 2020 он дуустал ЕХ-ны гишүүн бус улсын хөрөнгө оруулагчид тавьсан байна.

- Герман улс 2019 онд батлан хамгаалах, нэн чухал дэд бүтцийн салбарт гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмших, зөвшөөрөл авах компанийн хувьцааны босгыг 25%-иас 10% болгон бууруулахаар шинэчлэл хийсэн.

2020 оны 5-р сарын 20-ны өдөр Герман улс нийтийн эрүүл мэндийн чухал салбаруудад анхаарлаа төвлөрүүлж, Гадаад худалдаа, төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Халдварт өвчнийг эмчлэх вакцин, эм, хамгаалалтын эмнэлгийн тоног төхөөрөмж, бусад эмнэлгийн бүтээгдэхүүнийг боловсруулж, үйлдвэрлэж байгаа Германы компаниудын хувьцааны 10 хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмших, менежментийн эрхийг олж авахад Засгийн газраас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай гэж заасан. Энэ нь АНУ-н ерөнхийлөгч Д.Трампын вакцины үйлдвэрлэлийн хомстлыг арилгах зорилгоор Германы үйлдвэрийг худалдан авах тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласантай холбоотой гэж үздэг.

Бусад орнууд

- Австралийн засгийн газар үндэсний эрх ашгийг хамгаалах зорилгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоонд тодорхой өөрчлөлт оруулахаа мэдэгдсэн. Улмаар 2020 оны 03 сарын 29-ний өдрөөс эхлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ, хөрөнгө оруулагчийн төрлөөс үл хамааран заавал зөвшөөрөл авах шаардлагатай болсон. Гэхдээ хувьцаа эзэмших хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй. Харин мэдүүлгийг хянах хугацааг 6 сар хүртэл сунгаж, дотоодын бизнес эрхлэгчид болон ажлын байрыг хамгаалж, дэмжих хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд оруулах бодлогыг баримталж байна. Энэ нь хязгаарлалтын дэглэмийг ихээхэн чангатгаж байгааг харуулж байна.
- 2020 оны 4-р сарын 18-ны өдөр Канад улс цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад чухал шаардлагатай байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар «сайжруулсан хяналт» хийхээ зарласан. Энэ арга хэмжээ нь Канадын бизнес эрхлэгчдийн үнэлгээ буурч, улсын эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхолд заналхийлж болзошгүй төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт зэргээс үүдэлтэй «оппортунист хөрөнгө оруулалт»-ийн хариу үйлдэл байв. Эдийн засаг цар тахлаас сэргэх хүртэл энэ бодлого хэрэгжих болно.
- Япон улс 2020 оны 4-р сарын сүүлчээр үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой гэж үзсэн салбаруудынхаа жагсаалтад нэмэлт вакцин, эм, эмнэлгийн дэвшилтэт тоног төхөөрөмжийг нэмж оруулахаар төлөвлөж байгаа тухай мэдээлснээр зохицуулалтын өөрчлөлт эхэлсэн. Ийнхүү ГХО-г шалгах механизмд хамаарах бизнесийн хамрах хүрээг өргөжүүлэн бизнес эрхлэх эсвэл аль хэдийн бүртгэлтэй бизнесүүдийн цар хүрээг өргөжүүлсэн. Засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчдын Засгийн газраас урьдчилж зөвшөөрөл авах шаардлагатай 12 салбарын үндэсний аюулгүй байдалд хамааралтай жагсаалтад орсон Японы аж ахуй нэгжүүдийн хувьцааны босго хэмжээг 10 хувиас 1 хувь болгон бууруулж, одоо мөрдөж буй дүрмийг улам чангатгасан. Энэ хууль 2020 оны 5-р сарын 7-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Мөн 2020 оны 5-р сарын 8-ны өдөр Сангийн яам үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой гэж үзсэн 12 салбарын 518 компанийн жагсаалтыг гаргажээ.
- Өмнөд Африкт гадаадын хөрөнгө оруулалтыг шалгах механизмыг нэвтрүүлсэн. Шинэ хуулиар гадаадын компанитай нэгдэх нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эсэхийг үнэлэх үүрэг бүхий тусгай хороо байгуулахаар заасан.

- Энэтхэг улс сүүлийн хэдэн жилийн хугацаанд, ялангуяа 2017 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжоо зөөлрүүлжээ. Гэвч өнөөдрийн байдлаар 2020 оны 4-р сарын 17-ны өдөр Энэтхэгийн засгийн газар “оппортунист худалдан авалтыг хязгаарлах зорилгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг чангатгахаа мэдэгдсэн. Шинэ хязгаарлалт нь Энэтхэг улстай хуурай хиллэдэг Хятад, Пакистан, Бангладеш, Непал, Мьянмар, Бутан, Афганистан зэрэг орны хөрөнгө оруулагчдад хамааралтай юм. Ийм хөрөнгө оруулагчдад Энэтхэгийн аль ч салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатайг зохицуулжээ. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь дотоодын компаниудыг гадаадууд эзэмшихээс урьдчилан сэргийлэх ялангуяа Хятадаас орж ирэх хөрөнгө оруулалтад нөлөө үзүүлэх зорилготой байна.
- Шинэ Зеланд улс гадаадын хөрөнгө оруулагч гэдэгт гадаадын иргэн хуулийн этгээд, засгийн газрууд хамаарна. Салбарын хязгаарлалт ойн аж ахуй, загасчлал, газрын салбарт 25 хувийн хувьцаа эзэмшихэд хязгаарлалт үйлчилдэг. Цар тахлын улмаас Засгийн газраас үндэсний ашиг сонирхлын шаардлагаар нислэг, боомт, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбарт ГХО-г түр хугацаагаар зогсоосон.

Харин хязгаарлалтын эсрэг буюу дэмжих арга хэмжээнд хөрөнгө оруулалтыг онлайн аргаар хөнгөвчлөх, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын цар тахалтай холбоотой үйлчилгээ, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах шинэ хөшүүргийг хөгжиж буй орнууд бий болгосон.

Цар тахлын үеэр үйлдвэрлэлийн процесс, бараа бүтээгдэхүүнийг хүргэх ажлыг хурдасгах зорилгоор хэд хэдэн улс (жишээлбэл, Хятад, Мьянмар, Серби, Тайланд, Индонез, Малайз) аж ахуй нэгжүүдийн захиргааны ачааллыг хөнгөвчлөх, хүнд суртлыг бууруулах арга хэмжээ авсан. Тухайлбал, хөдөлмөр их шаардсан дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг түргэсгэх, эрүүл мэндийн болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн бизнес эрхлэгчдэд хурдан шуурхай зөвшөөрөл олгох, хөрөнгө оруулалтын өргөдлийн төлбөрийг бууруулах зэрэг арга хэмжээнүүд орно. Мөн иргэний үнэмлэхийн хүчинтэй байх хугацаа, хууль ёсны дагуу ирсэн гадаадын иргэдийн оршин суух, ажиллах зөвшөөрлийг цар тахлын төгсгөл хүртэл сунгаж байна.

Б. Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрх зүйн зохицуулалтын чиг хандлага ба ковид-19

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар гадаад бодлого, эдийн засгийн суурь зарчмыг “*дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай*”²⁵ байна хэмээн олон улсын нийтлэг чиг хандлага бүхий эдийн засгийг зорин тогтоосон. Ингэхдээ “*Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна*”²⁶ хэмээн үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах талаар зохицуулснаар ГХО-н хязгаарлалтын зохицуулалтын эх үндэс тавигдсан байна.

Улмаар 1993 онд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”, 2012 онд “Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль” болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2013 оны “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-г баталсан билээ.

Аливаа улсын ГХО-н хязгаарлалт нь тухайн улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалтай шууд хамааралтай бөгөөд түүнд суурилсан хууль тогтоомжоор тодорхойлогддог. Монгол Улс 1992 онд ардчилсан үндсэн хууль баталснаас хойш 2 удаа

²⁵ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 5 дугаар зүйл 1 дэх хэсэг.

²⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 5 дугаар зүйл 4 дэх хэсэг.

гадаад бодлогын болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал баталсан байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.2.2.2-т “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална” 3.6.1.4-т “Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно...”²⁷ хэмээн 2 агуулгаар хязгаарлалтын бодлогыг баталсан байна.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.18-т “Эдийн засаг, худалдааны чөлөөт бус, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ.”²⁸ хэмээн үндэсний аюулгүй байдлын суурь үзэл баримтлалыг тогтоосон байна.

Дээрхээс үзвэл, аль нэг улсаас орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ нийт хөрөнгө оруулалтын 33 хувиас хэтрэхгүй бөгөөд гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтыг шууд хязгаарлах, мөн нөлөө бүхий төсөл нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхгүй байх шаардлагыг суурь зарчим болгожээ.

Үүний дагуу дээрх хязгаарлалтын бодлогын түвшинд 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан бөгөөд улмаар ГХО-ыг хязгаарласан зохицуулалтын хувьд Монгол Улс бусад орнуудтай харьцуулахад нээлттэй, харьцангуй бага зохицуулалттай тооцогддог.

Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч Монгол Улсын хуулиар хориглосноос бусад салбарт ямар нэгэн хязгаарлалтгүйгээр, эсвэл Засгийн газраас зөвшөөрөл авах шаардлагагүйгээр хөрөнгө оруулалт хийх боломжтой юм. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид зарчмын хувьд хуулийн этгээдийн аль ч хэлбэрээр ямар ч төрлийн эдийн засгийн үйл ажиллагааг тэгш эрхтэйгээр эрхлэх боломжтой. Зөвхөн төрийн өмчит компани стратегийн салбарт (уул уурхай, банк санхүү, харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл) хөрөнгө оруулалт хийн монгол компанийн хувьцааны 33 хувиас дээш хувийг эзэмшихээр байвал зөвшөөрөл авахаар зохицуулсан.²⁹

Гадаадын компани Монгол Улсад бизнес эрхлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эсвэл төлөөлөгчийн газар гэсэн статусын аль нэгийг сонгох хэрэгтэй болдог. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 25-аас доошгүй хувийг гадаадын компани эзэмшсэн байх ба 100 мянган ам.доллараас доошгүй хөрөнгө оруулалт хийсэн байх ёстой.³⁰ Гадаадын хөрөнгө оруулалтын доод хэмжээтэй холбоотой дээрх шаардлага нь анхлан бага хэмжээтэй хөрөнгө оруулалт хийсний үндсэн дээр цаашид үргэлжлүүлэн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх эсэхээ шийдэх сонирхолтой байгаа хөрөнгө оруулагч нарт бэрхшээл учруулж болохыг тэмдэглэх нь зүйтэй юм.

Судлаачийн хувьд энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийх явцад Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас гадна 11 салбар хуулиар ГХО-г хязгаарлахаар зогсохгүй хориглох зохицуулалт тусгасан байх бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй байдал үүсгэх, ГХО-н эрх зүйн орчныг ил тод бус, бүрхэг харагдуулах эрсдэлтэй юм.

OECD-с гаргадаг гадаадын шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтын зохицуулалтын индекс нь дараах дөрвөн чиглэлээр хөрөнгө оруулалтын хязгаарлалтын зэрэглэлийг үнэлдэг.

²⁷ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010

²⁸ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. 2011

²⁹ Хөрөнгө оруулалтын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2013. 21-р зүйл

³⁰ Хөрөнгө оруулалтын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2013. 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг.

- (i) гадаадын этгээдийн хувь эзэмших эрхийн хязгаарлалт;
- (ii) хөрөнгө оруулалтын шалгуур болон урьдчилан зөвшөөрөл авах шаардлага;
- (iii) удирдлагуудтай холбоотой журам;
- (iv) үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой бусад хязгаарлалтууд зэрэг болно.³¹

Дээрх үзүүлэлт бүхий индексээр Монгол улс 0.07³² (*0-нээлттэй, 1-хаалттай*) буюу худалдаа болон хөрөнгө оруулалтыг либералчлах олон улсын хөгжлийн чиг хандлагыг даган эдийн засгийн ихэнх салбаруудаа ГХО-тад нээлттэй байна. Харин агаарын тээвэр, тээвэр, уул уурхай олборлох зэрэг салбаруудад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хязгаарласан тодорхой зохицуулалтууд байна гэж үнэлэгджээ.

Монгол Улсад 1990-2019 оны хооронд нийт 26.8 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд 2019 онд 2.89 тэрбум ам.долларын ГХО хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6.2 хувийн өсөлттэй байсан³³. Харин цар тахлын үед 2020 оны ГХО удааширч, 2019 онтой харьцуулахад 244 сая ам.доллараар бууралттай байна³⁴.

Монгол Улс ковид-19 шалтгаанаар 2020 оны 04 сарын 29-ний өдөр “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх», нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар батлан гаргасан.

Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.13-г заасны дагуу эрсдэл үүссэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд тусгайлан шаардлага тавьж, хязгаарлалт хийх талаар зохицуулснаас өөр хөрөнгө оруулалттай холбоотой зохицуулалт хийгээгүй байна.

Гэвч Ковид-19 цар тахал дэлхийн хэмжээнд хамгийн наад тал нь 2022 он хүртэл үргэлжлэх төлөвтэй энэ хямралын цаг үед Монгол Улсын ГХО-д хандах хандлага, хязгаарлалт болон дэмжлэгийн талаар бодлогын зохицуулалт хийгдээгүй байгаа нь анхаарал татаж байна.

Учир нь, дэлхийн ихэнх улс орнууд цар тахлын хямралын үеийн үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хараат бус байдлыг тодорхойлон дотоодын эдийн засаг, аж ахуй эрхлэгчдийг хамгаалах бодлогыг боловсруулан өөрийн орны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж эхлээд байна. Гэвч Монгол Улсын хувьд энэ талаар тусгайлан боловсруулсан бодлого, арга хэмжээ авч эхлээгүй байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Дэлхий дахинд нүүрлээд буй Ковид-19 цар тахал нь ГХО-н салбарт сүүлийн 15 жилийн хугацаанд үзэгдээгүй эдийн засгийн хямралыг авчрахын зэрэгцээ дагалдах эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох өдөөгч болж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд ГХО-г хязгаарлах эрх зүйн зохицуулалт нь тухайн улсын хөгжлийн түвшингөөс хамааран харилцан адилгүй байж ирсэн. Тухайлбал, хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн хөгжлийн тулгуур нь гадаадын хөрөнгө оруулалт татах тул ГХО-д нээлттэй бодлого баримталж зохицуулалтыг хийж байна. Харин хөгжингүй орнуудын хувьд үндэсний аюулгүй байдлын үүднээс хөрөнгө оруулалтын орох урсгалыг шалгах, хязгаарлах дэглэмийг илүүтэй баримталж байсан. Гэвч Ковид-19 цар тахлын улмаас энэхүү хязгаарлалтын арга хэмжээ илүү эрчимжиж үндэсний аюулгүй байдлаар хязгаарлагдахгүй

³¹ OECD, Foreign direct investment regulatory restrictiveness index, 2020 <https://goingdigital.oecd.org/en/indicator/74/>. [Сүүлд үзсэн:2021.01.15]

³² <https://data.oecd.org/fdi/fdi-restrictiveness.htm#indicator-chart> [Сүүлд үзсэн:2021.01.15]

³³ Д.Ган-Очир, Гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүний үр өгөөж, илтгэл, 2020, 4 дэх тал

³⁴ Үндэсний хөгжлийн газар, Тойм судалгаа, танилцуулга, УБ, 2021

стратегийн болон дэд бүтцийн салбар дах дотоодын компаниудыг opportunist acquisition буюу дампуурлын худалдан авах ажиллагаанаас хамгаалах шаардлагаар үргэлжилж байна. Учир нь, тухайн улсын стратегийн ач холбогдол бүхий салбар дахь аж ахуй нэгжийг санхүүгийн чадваргүй байдлыг далимдуулж гадаадын хөрөнгө оруулагч худалдан авах, эзэмшил тогтоох нь тухайн улсын эдийн засаг үндэстэн дамнасан корпорац, гуравдагч улсын нөлөөнд автах эрсдэлтэйг онцолсон байна.

Энэхүү хариу арга хэмжээ нь эдийн засгийн ач холбогдол бүхий салбараа дахин тодорхойлох, байнгын болон түр зуурын шинжтэй байх бөгөөд улс бүр өөрийн орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн онцлогт тохируулан арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

ГХО-н шууд хязгаарлалтын онцлог зохицуулалтын хувьд улс орнууд стратегийн ач холбогдол бүхий салбарын хүрээг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын сөрөг жагсаалт батлах, мөн тухайн батлагдсан салбар дахь хөрөнгө оруулалтын зайлшгүй зөвшөөрөл авах зохицуулалтыг чангатгасан арга хэмжээ зонхилж байна.

Харин шууд бус хязгаарлалтын зохицуулалтыг салбар хуулиудаар салбарын онцлогт тохирсон хязгаарлалт тогтоох, ГХО-г хянан шалгах хугацаа, журмыг өргөтгөх арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

ГХО-г хязгаарлах эрх зүйн зохицуулалтын нийтлэг чиг хандлага нь үндэстэн дамнасан компаниуд, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, нөлөөнөөс дотоодын эдийн засаг, аж ахуйн нэгжийг хамгаалах, хараат байдлыг хязгаарлах байдлаар эрчимжиж байна. Учир нь, Хятад болон Энэтхэг зэрэг үйлдвэрлэгч орнууд хөрөнгө оруулалтын зах зээлд түрэмгийлэн орж ирэх хандлагатай шууд холбоотой юм.

Монгол Улс ГХО-г хязгаарлах эрх зүйн зохицуулалтын талаар ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байгаа нь хөгжиж буй буурай эдийн засагтай орнуудтай адил байх боловч энэ нь үндэсний эдийн засгийн хувьд эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Энэхүү хямралын цаг үед үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь төрийн Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг юм.

Дээр дурдсанчлан дэлхийн шууд хөрөнгө оруулалтын орчин өдөр бүр өөрчлөгдөж, ЕХ-ны орнууд цар тахлын эсрэг ГХО-н дэглэмийг нэвтрүүлэх эсвэл одоо байгаа дэглэмийг чангатгахыг уриалж байна.

Иймд Монгол Улсын хувьд ГХО-д хязгаарлалтын талаар арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байх боловч ковид-19-н энэ хямралын цаг үед дотоодын стратегийн ач холбогдол бүхий салбар дахь эрсдэлтэй хуулийн этгээдүүдийг судлан тодорхойлж, тэдгээрийг хамгаалах, opportunist acquisition хийгдэхээс сэрэмжлэх зорилгоор ГХО-н шууд бус хязгаарлалтын аргаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлөх юм.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Үндсэн хууль. *Төрийн мэдээлэл*. 1992 он.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он.
- Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. 2011 он.
- Хөрөнгө оруулалтын тухай хууль. *Төрийн мэдээлэл*. 2013 он.
- German Foreign Trade and Payments Act. 2013 он.

Монгол хэлээр:

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Гадаадын хөрөнгө оруулалт – эрх зүйн асуудал*, ХЗҮХ хэвлэх үйлдвэр, УБ, 2010 он.

- М.Уянга. *Олон улсын эдийн засгийн эрх зүй*. 2014 он.
- Б.Тамир. *Олон улсын хувийн эрх зүй* (Орчин үеийн чиг хандлага). 2019 он.
- Д.Ган-Очир, *Гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүний үр өгөөж*, илтгэл, 2020 он.
- Үндэсний хөгжлийн газар, *Тойм судалгаа, танилцуулга*, УБ, 2021 он.

Гадаад хэлээр:

- A.Hardin, L.Holmes, *Service trade and Foreign direct investment*, 1997.
- M.Sornarajah, *The international law on Foreign investment*, Cambridge university press, 2010.
- Erica Owen, *Unionization and Restrictions on Foreign Direct Investment*, Article, Texas A&M University, 2013.
- UNCTAD, *World investment report*, New-York, UN Publications, 2020.
- European Commission, *Communication from the Commission, Guidance to the Member States concerning foreign direct investment and free movement of capital from third countries, and the protection of Europe's strategic assets, ahead of the application of Regulation (EU) 2019/452 (FDI Screening Regulation)*, Brussels, 2020.
- OECD, *Foreign direct investment regulatory restrictiveness index*, 2020.
- Jade-Alexandra Fearn, *New Challenges for Foreign Direct Investment in the Age of COVID-19*, Proskauer Rose LLP, USA, 2020.
- White & Case LLP, *COVID-19 Foreign Direct Investment (FDI) - An Overview of Restrictions in Western Europe*, EU, 2020.
- Bird&Bird LLP, *Foreign direct investment & Covid-19 pandemic*, 2020.
- Graham Coop and Robert Volterra, *Client Alert: Increased control of foreign investment in response to COVID-19*, UK, Volterra Fietta LLP, 2020.

Цахим эх сурвалж:

- <https://goingdigital.oecd.org/en/indicator/74/>
- <https://data.oecd.org/fdi/fdi-restrictiveness.htm#indicator-chart>
- <https://www.lexology.com/library/detail.aspx?g=38438bff-cf09-4f40-b75f-a173e09b3a7a>
- <https://www.lexology.com/library/detail.aspx?g=2545c249-4d5d-40e4-b513-aa1dda17b415>
- <http://www.oecd.org/coronavirus/policy-responses/investment-screening-in-times-of-covid-19-and-beyond-aa60af47/#figure-d1e42>
- <https://www.lexology.com/library/detail.aspx?g=98866c35-1a1b-4d19-9716-4ffc0bb664f9>
- www.Legalinfo.mn

INTERNATIONAL TREND AND EFFECTIVENESS OF RESTRICTIONS TO FOREIGN DIRECT INVESTMENT AMID COVID-19 PANDEMIC

B.Ankhbayar

LL.M. Candidate, School of law, National university of Mongolia, Lawyer

ABSTRACT:

Covid-19 outbreak has been a severe impact to the global economy and therefore, foreign direct investments are affected. Hence, there is a tendency, especially for the developing countries to reevaluate their economic development, investment strategies and policies.

In direct response measure to the pandemic, countries are in process of adopting amendments to the laws on restrictions to, or mid-term policies to either restrictive measure or encouraging foreign investments.

Therefore, necessity to undertake comparative study on policies on restricting foreign investments of developing countries and Mongolian regulatory environment to further demonstrate effective and internationally proven measures to curb state of distress is evident.

KEYWORDS: National security, Dependence, Crisis, Screening regulation

---00o---

“ЮНИСОЛЮШН ПАРТНЕРС” ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь редакцийн нийтлэлийн бодлого, үйл ажиллагаандаа баримтлах журмыг шинэчилж олон улсад нэр хүнд бүхий Скопус (Scopus)-ийн судалгааны бүтээлийн санд сэтгүүлээ бүртгүүлэх зорилт тавин ажиллаж байгаа билээ.

Энэхүү зорилтын хүрээнд 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын салбартаа тэргүүлэгч технологийн компани болох PLAGSCAN GmbH-ийн Монгол улс дахь албан ёсны төлөөлөгч “Юнисолюшн Партнерс” ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Санамж бичиг байгуулсанаараа бид өөрсдийн сэтгүүлд ирүүлсэн нийтлэл бүрийн давхцалыг (plagiarism) тус программаар шалгах боломж бүрдэж байгаа юм.

Санамж бичгийн хүрээнд академик ёс зүйг эрдэмтэн, судлаач, олон нийтэд түгээх, оюуны өмчийг хүндэтгэх, хамгаалах, шинэ технологи, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх чиглэлээр талууд хамтран ажиллах юм.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ



Б.Энхболор

МУИС-ийн ХЗС-ийн магистрант

ТҮЛХҮҮР ҮГС:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ИХШХШТХ-н хугацааны зохицуулалт, практикт хэрэгжихгүй байгаад нөлөөлөх хүчин зүйлс, ерөнхий хугацаа, хэргийн хөдөлгөөний менежмент, урьдчилсан хэлэлцүүлэг

ТОВЧЛОЛ:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар хэрэг маргааныг тодорхой хугацааны дотор шийдвэрлэх, хуулийн хугацааг шүүх өөрчлөхгүй байхаар заасан. Практикт иргэний хэргийг хуулиар тогтоосон ерөнхий хугацаанд хянан шийдвэрлэх нь бэрхшээлтэй бөгөөд хэргийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэхгүй байгаа нь үргэлж шүүмжлэл, асуудал дагуулж байна. Цаашлаад шүүхийн шийдвэр хууль ёсны байх, шүүгчийн хараат бус бие даасан байдлыг алдагдуулж, хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхээр шүүхэд хандсан иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг сонирхол хөндөгдөх нөхцөл үүсэж буй нь уг асуудлыг зайлшгүй судлах шаардлагатайг харуулж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа процесс ажиллагааны доторх хугацаагаар буюу талуудын хүсэл зоригт үндэслэн шүүхээс тогтоосон хугацаанд түргэн шуурхай хэрэг маргааныг шийдвэрлэх боломжтой ба энэ нь хэргийн оролцогчийн эрхээ хэрэгжүүлэхийн хажуугаар үүргээ биелүүлэх, хариуцлагатай хандахад ч нөлөөлөх хүчин зүйл болох юм.

Өгүүлэлдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаатай холбоотой онолын болон практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж түүнийг шийдвэрлэх арга замыг онолын үзэл баримтлал болон бусад улс орны туршлагад үндэслэн судалж, дүн шинжилгээ хийн өөрийн зүгээс тодорхой саналыг нэмэрлэхийг эрмэлзсэн болно.

УДИРТГАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид ИХШХША гэх/ нь иргэн, хуулийн этгээд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандан, нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч хянан шийдвэрлэх цаг хугацаа, үйл явц юм.

Одоогоос 18 жилийн өмнө Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдах үед иргэний эрх зүйн маргааны тоо, төрөл одоо үетэй харьцуулахад харьцангуй цөөн, хэргийн ачаалал бага байсан ба өнгөрсөн хугацаанд манай улсын эдийн засаг тодорхой хэмжээнд хөгжиж, худалдааны эргэлт, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, иргэний эрх зүйн харилцаа улам бүр хүрээгээ тэлж байна.

Хүрээгээ тэлж буйтай холбоотой үр дагавар нь шүүхийн ачаалал нэмэгдэхэд хүргэж, хэрэг маргааныг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсээд байна. Иймд ИХШХША-ны хугацааны зохицуулалтыг онол практикийн түвшинд нарийвчлан судалж, бусад улс орны туршлагад үндэслэн, дүн шинжилгээ хийн өөрийн зүгээс тодорхой саналыг дэвшүүлэхэд судалгааны зорилго оршино.

ИХШХША-ны хугацааг хэрэгжүүлэхэд практикт тулгамдаж буй гол хүчин зүйлс

Өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзвэл аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргаж, шүүх ИХШХША-ны хүрээнд түүнийг шийдвэрлэдэг.

ИХШХША-ны хугацааг хуулиар тогтоосон хугацаа болон шүүхээс тогтоосон хугацаа гэж ангилжээ.¹ Хуульд зөвхөн дээд хугацааг заасан бол шүүх энэ хугацааны дотор, түүнийг хэтрүүлэхгүйгээр ажиллагаа явуулах үүрэгтэй. Харин шүүхээс хэргийн оролцогчид зориулсан хугацааг хуульд заасан эрхийн дагуу өөрчлөн тогтоож байгаа бол хуульд заасан хугацааг хязгаарлах үндэсгүй юм.² Хууль заавал хэрэгждэг байх нь төрийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим бөгөөд хэрэв батлагдан гарсан хууль тунхагын шинжтэй, хэрэгжихгүй бол иргэдийн эрх ашиг хөндөгдөж, иргэдийн шүүхэд итгэх итгэл буурах, шүүх эрх мэдэл хүчгүйдэх зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгоно. Судлаачид ИХШХШ хугацааны зохицуулалт практикт хэрэгжихгүй байгаа гол хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Шүүгчийн орон тоо хүрэлцээгүй, ажлын ачаалал хэт өндөр: Нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 310 хэргийг шийдвэрлэхэд 282 өдөр, шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд 14 өдөр, гомдлын хуралд 8 өдөр, шүүгчдийн зөвлөгөөнд 7,8 өдөр, шүүгч сургалтад 10 өдөр, ёс зүйн хороонд 1,2 өдөр нийт 323 өдрийг зарцуулж байгаа нь хэргийн ачаалал харьцангуй ихтэйг харуулж байна. Тодруулбал, шүүгч жилд 230 өдөр ажиллана гэж үзвэл 93 өдрөөр ажлын ачаалал илүү байгаа бөгөөд үүнийг ажлын өдөр болон амралтын өдөр ажиллаж нөхөж байна. Илүү ажиллаж буй 93 өдөр нь ажлын 744 цаг болж байгаа бөгөөд шүүгч жилд 1840 цаг ажиллах ёстой гэж үзвэл 40 хувиар илүү ачаалалтай ажиллаж байна³ Тухайлбал Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн ачааллын судалгааг 2021 оны 03 дугаар сарын байдлаар харахад 140 нэхэмжлэл /хэрэг үүсээгүй/, 489 хавтас бүхий 444 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байна. 30-342 хоногоор хугацаа хэтэрч шийдвэрлэгдээгүй байгаа 110 хэрэг байна. Он дамжсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн хэргүүд дээрх хугацаа хэтэрсэн хэргүүдийн дийлэнх хувийг эзэлж байна. Долоон хоногт дунджаар 90-120 шүүх хуралдаан товлогдож байна. Нэг шүүгч дунджаар 73 нэхэмжлэл, хэрэгтэй байна. Эдгээр тоо баримтуудаас шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалал буурахгүй, ээдрээ төвөгтэй, 2-10 хавтас бүхий хэргүүд олон, хугацаа хэтэрсэн хэргийн эзлэх хувийн хэмжээ буурахгүй, ачаалалтай байгаа нь харагдана.⁴

¹ А.Дугармаа нар, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, гарын авлага*, УБ, ВСИ, 2007, 41 дэх тал

² Улсын дээд шүүх, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар*, Нэмэлт өөрчлөлттэй 2 дахь хэвлэл, УБ, Интерпресс, 2008, 202-203 дахь тал

³ http://www.civilcourt.gov.mn/hr/fullstory_court2/1247 [Сүүлд үзсэн: 2020.11.15]

⁴ Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэргийн хөдөлгөөний 7 хоногийн тойм

2. Шүүгчийн туслах, нарийн бичгийн даргын орон тоо хүрэлцээгүй, ур чадвар дутуу байгаа нь мөн дээрх ажлын ачаалал өндөр байгаатай шууд холбоотой. 2 шүүгч дундаа 1 нарийн бичигтэй ба 7 хоногийн 2 эсвэл 3 өдөр л шүүх хуралдаан зарлах боломжтой байна. Албан бус тоогоор 2020 онд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс ажлаас гарсан 10 албан хаагч, ажилд шинээр томилогдсон 21 албан хаагч, албан тушаал өөрчлөгдсөн 12 /байгууллага дотроо/, 8 /өөр байгууллага руу шилжсэн/ гэсэн тоо байх ба захиргааны ажилчдын тогтвор суурьшилгүй байгааг харуулж байна. Шүүхийн захиргааны ажилтнууд тогтвор суурьшилгүй байгаа нь шүүхийн ачааллыг нэмэгдүүлж, шүүхийн ажлын уялдаа холбоог алдагдуулахад хүргэж байна⁵. Ажлын ачаалал их байгаагаас болж захиргааны ажилтнууд ачааллаа дийлэхгүй байх, шинээр орж байгаа албан хаагч ажилдаа мэргэшиж дадах хугацаанаас өмнө ажлаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөөр байна.
3. Хэргийн оролцогчийн зүгээс нөлөөлөх хүчин зүйл: Хэргийн оролцогчийн гомдол гаргахтай холбогдсон хугацааны зохицуулалт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн бусад хугацааны зохицуулалтаас илүү өндөр түвшинд хэрэгждэг⁶. Учир нь уг хугацааг баримтлахгүй бол хэргийн оролцогчид гомдол гаргах эрхгүй болсноор тэдний эрх ашиг шууд зөрчигдөх үр дагавартай байдаг. Харин хэргийн оролцогчид үүрэг болгосон бусад хугацааны зохицуулалтууд нь шүүх хэргийг хугацаанд шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой боловч тухайн зохицуулалтыг зөрчсөнөөр бий болох эрх зүйн үр дагавар байхгүй, уг үйлдлийг таслан зогсоох хариуцлагын механизм сул байгаагаас болж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугацаандаа хэрэгжихгүй байна. Тухайлбал, тогтоосон хугацаанд нэхэмжлэлийг гардаж авдаггүй, хариу тайлбараа 14 хоногтоо өгдөггүй, нотлох баримтыг шүүх хуралдаанаас өмнө өгөх үүргээ биелүүлдэггүй зэрэг хэргийн оролцогчийн олон шалтгааны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол цөөнгүй байдаг⁷.
4. Шүүх хуралдаан хойшлох нөхцөл байдал: Шүүхийн практикт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтэрдэг шалтгааны дийлэнх хувийг зохигчдын хуулиар олгогдсон эрхийг хангах зорилгоор шүүх хуралдааныг хойшлуулдгаас үүдэлтэй⁸. Энэ нь хэргийн оролцогч өмгөөлөгч авах, өмгөөлөгчийн хурал давхцах, нотлох баримт цуглуулах үүргээ удаа дараа биелүүлэхгүй байх, хэргийн материалтай танилцах, нотлох баримт бүрдүүлэх хүсэлт, нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх зэрэг хүсэлтээр удаа дараа хойшилдог. Шүүх хуралдааныг хойшлуулахыг хуулиар зөвшөөрсөн хэдий ч хэргийн оролцогчийн нэг болох зөвхөн өмгөөлөгчтэй холбоотойгоор гарах хүсэлтүүд буюу өмгөөлөгч авах, өмгөөлөгчийн шүүх хуралдаан давхардсан, өмгөөлөгч өвчтэй, өмгөөлөгч өөрөө үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, хэргийн материалтай танилцаж амжаагүй” гэх мэт олон шалтгаануудыг ээлжлэн тоочиж, шүүх хуралдаан удаа дараа хойшлуулж байгаа⁹ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг алдагдуулдаг гол хүчин зүйлийн нэг юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс жил бүр гаргадаг шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээгээр 2013 онд 458 хэрэг, 2014 онд 893 хэрэг, 2015 онд 769 хэрэг, 2016 онд 781 хэргийн шүүх хуралдаан хойшилсон тоон үзүүлэлт гарсан байх ба албан бус судалгаагаар нийт

⁵ <http://www.judcouncil.mn/main/7826> [Сүүлд үзсэн: 2020.03.05]

⁶ С.Жавхлан, *Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг дагаж мөрдөх асуудал, практик хэрэгжилт. Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд*, УБ, 2015, 37 дахь тал

⁷ Мөн тэнд, 39 дахь тал

⁸ Б.Хишигбаатар, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, практик хэрэглээ” Шүүх эрх мэдэл №3, (2017), 117 дахь тал

⁹ Ч.Ичинхорлоо, “Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа буюу хурд” Шүүх эрх мэдэл №3, (2014), 56 дахь тал

хойшилсон хэргийн 90-ээс дээш хувийг хэргийн оролцогчийн эрхийг хангах зорилгоор, зохигчдын хүсэлтээр хойшлуулдаг гэсэн судалгаа гарсан. Хуульд заасан үндэслэлээр шүүх хуралдаан хойшлуулах хүсэлт ирүүлсэн тохиолдолд шүүх түүнийг хүлээн авахаас өөр аргагүй ба үүнд тодорхой хязгаарлалт тогтоогоогүйн улмаас шүүх хуралдаан олон удаа хойшлох тохиолдол байсаар байна.

Дээрх нөхцөлүүдээс харвал ХХША-ны хугацааны хэрэгжилт муу байгаа нь шүүгчийн болон шүүхийн захиргааны албан хаагчдын орон тоо хүрэлцээгүй, ажлын хэт их ачаалалтай, хэргийн оролцогчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, шүүх хуралдаан хэргийн аль нэг оролцогчийн хүсэлтээр их хойшилдог зэргээс үүдэлтэй болох нь харагдаж байна.

Судлаачид хууль ёсыг тогтоодог шүүх байгууллагад хууль хэрэгжихгүй байгаа нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх зарчмыг алдагдуулж, эрх зүйт төрийн үнэт зүйлийг үгүй хийж буй явдал хэмээн үзсэн нь хуульд зааснаар хэрэгжихгүй байгаа хугацааны талаарх асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. Иймд нотлох баримт гаргаж өгөх, цуглуулах ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх, мөн анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгож, талууд эрх үүргээ хэрэгжүүлэх боломжийг тодорхой болгох үүднээс урьдчилсан хэлэлцүүлгийн үе шаттай болгон зохицуулах боломж байна гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг дагаж мөрдөхийг зөвхөн шүүхээс шаардах биш, харин иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах процесс ажиллагааг хуулийн хугацаанд явуулахад саад болж буй дээрх хүчин зүйлүүдийг шийдвэрлэх, хязгаарлалт тогтоох зэргээр практикт бодитой хэрэгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх нь илүү чухал юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гагцхүү дан ганц шүүхийн ажиллагаа бус нөгөөтээгүүр зөрчигдсөн эрхээ хамгаалуулах иргэн, хуулийн этгээд, хуульч, өмгөөлөгч нарын хамтын ажиллагаа юм.

ХХША-ны хугацааг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим орны туршлага, хэргийн хөдөлгөөний менежмент

Гадаад улсуудын практикт ИХШХША-ны хугацааг талууд өөрсдөө тогтоох, эсхүл хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан шүүх тогтоодог, мөн хуулиар тусгайлан тогтоож өгдөг, түүндээ хариуцлага тооцдог жишиг түгээмэл байдаг. Үүнийг хэргийн хөдөлгөөний менежментээр зохицуулдаг улс орнууд ч цөөнгүй байна. Хэргийн хөдөлгөөний удирдлагын хөгжлийг АНУ-ын судлаач Вүүдс судлаад уламжлалт (traditional), идэвхгүй (passive), идэвхтэй (active), ялгавартай (differential) гэсэн 4 үндсэн загварыг шүүхийн захиргааны хөгжлийн явцад боловсруулсан¹⁰ гэж үзжээ. Хэргийн хөдөлгөөний менежмент дээрх загваруудыг дараалан хөгжүүлсэн боловч ямар хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийн хөдөлгөөний менежментийн буюу мониторингийн арга хэрэгслийг ашиглахаас хамаарч нийтлэг (General) болон тусгай (Delay-Triggered) гэж ангилагдаж байна.

Тусгай хэргийн хөдөлгөөний менежментийг зөвхөн тодорхой хэрэгт эсхүл процессын алдаа, удаашрал гардаг шүүхэд, мөн шүүхийн эдийн засаг, хүн хүчний нөөц бололцоо хязгаарлагдмал үед тэргүүлэх чиглэлээр сонгон хэрэглэхэд тохиромжтой байна. Нийтлэг хэргийн хөдөлгөөний менежментийг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нийтлэг байдлаар сайжруулах шаардлагатай, шүүхийн тогтолцоог саяхан өөрчилж шинэтгэсэн, шүүхийн төсөв, хөрөнгө хэргийн хөдөлгөөний мониторингийн системийг нэвтрүүлэхэд хангалттай үед өргөн ашигладаг.

Хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх, буцаад түүндээ хариуцлагын арга хэмжээг авч, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга замыг цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай. Үүнийг дагаад практикт суурилсан эрх зүйн шинэ орчинг бүрдүүлж, түүнд нийцүүлэн хууль тогтоомжид

¹⁰ Шүүхийн судалгаа, мэдээллийн төв, *Хэргийн хөдөлгөөний менежмент бодлогын судалгаа*, УБ, 2013 он, 5 дахь тал

өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломж байна гэж үзнэ.

Япон улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулиар тогтоосон ерөнхий хугацаа байхгүй бөгөөд “Oral argument” буюу аман хэлэлцүүлгээр эхэлдэг. Өөрөөр хэлбэл хэргийн ээдрээ төвөгтэй байдал, хүндэтгэн үзэх шалтгаант нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж шүүх хурлыг шударга, хурдан шуурхай явуулахын тулд шүүх хоёр талтай зөвлөлдөж, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн шүүх хуралдааны төлөвлөгөөг боловсруулна. Үүнд нотлох баримт гаргаж өгөх, цуглуулах хугацаа, гэрч асуух хугацааг тогтоож энэ хугацаанд талууд дээрх эрхээ хэрэгжүүлж, нэхэмжлэл болон тайлбар татгалзлаа нотлох үүрэгтэй байна.¹¹

Холбооны бүгд найрамдах Герман улсад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацааг хуульчлан тогтоогоогүй, харин процесс ажиллагааны дотор хэрэгжүүлэх үйл ажиллагааны хугацааг хуульчилжээ.¹² Жишээлбэл, нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулахдаа тодорхой хугацаа зааж, яаралтай, цаг алдахгүй хүргүүлэх тухай заасан байдаг. Түүнчлэн шүүгч нь хэргийн зохигчийн хариу тайлбар гаргах, нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах, шүүх хуралдаан хэзээ, хаана болох хугацааг аман хэлбэрээр буюу уулзалт хийж тогтоож болдог байна.

Оросын холбооны улсын хуульд зааснаар процесс ажиллагаа явуулах эрх нь холбооны хуулиар тогтоосон буюу шүүхээс тогтоосон хугацаа дуусахад дуусгавар болно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны буюу хуульд заасан эсхүл шүүхээс тогтоосон хугацаа дууссаны дараа гаргасан гомдол, баримт бичгийг шүүх үнэлдэггүй бөгөөд, хугацаа алдсан хугацааг сэргээх талаар өргөдөл гаргаагүй бол шүүх хэлэлцэхгүй, буцааж өгөх талаар хуульчилсан байна.¹³

Дээрх харьцуулалт хийсэн улс орнуудын хувьд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг Монгол улстай харьцуулахад илүү урт хугацаанд байхаар эсвэл талуудын оролцоо, хүсэлтийг харгалзан уян хатан байдлаар зохицуулсан байдал харагдаж байна. Тухайлбал Япон болон ХБНГУ-ын хувьд ХХША-ны ерөнхий хугацааг хуульчлаагүй байна. Хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдлаас хамаарч иргэний ХХША явагдах хугацаа ч гэсэн ялгамжтай байхаас өөр аргагүй. Тухайлбал онцгой ажиллагааны хэрэг маргаанд хэргийн оролцогчийн зүгээс аль болох түргэн шуурхай хэргээ шийдвэрлүүлэх хүсэл сонирхол байдаг. Гэтэл хэргийн ачаалал их, хугацаа хэтэрсэн, олон удаа хойшилсон шүүх хуралдаанууд зарлагдсанаас болж шүүх хуралдаан зарлах өдөр, цаг байхгүй зэргээс шалтгаалан бусад хэргийн адил ерөнхий хугацааг баримтлан шийдвэрлэх нь маргалдагч талгүй хүсэлтээр үүсэх хэргийн хувьд урт хугацаа гэж оролцогч үздэг. Хэрэв хэрэг маргааныг урьдчилсан хэлэлцүүлгээр оруулж, талуудын оролцоо, хүсэлтийг харгалзан шүүх хуралдаанд бэлтгэх үе шат илүү тодорхой байвал олон дахин шүүх хуралдаан зарлаж, бусад хурлыг зарлах боломжгүй нөхцөл байдал үүсгэх асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

БНСУ-ын Дээд шүүх 2011 оноос иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим шүүх (electronic case filing) хэрэгжсэнээр албан ёсоор иргэд хэрэг маргааныг цахимаар шийдвэрлэх боломжтой болж энэ арга барилыг хэрэгжүүлж байна. Энэ нь мэдээллийн технологид суурилсан нээлттэй, ил тод, шуурхай, хүртээмжтэй байх шүүх засаглалын шинэчлэлт юм. Тухайлбал, иргэн, хуулийн этгээд интернет цахим хуудсыг ашиглан нэхэмжлэл гаргаж, хариуцагч хариу тайлбар бичих, талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай материалаа явуулах, хэргийн материалтай цахимаар танилцах, шүүх хурал товлох боломжтой болсон. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг

¹¹ <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2834&vm=2&re=02> [Сүүлд үзсэн: 2020.10.12] Code of Civil Procedure of Japan, 1996

¹² Шүүхийн ерөнхий зөвлөл, *Шүүх эрх мэдэл, мэдээлэл арга зүйн улирлал тутмын эмхэтгэл*, №3, УБ, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, 2017, 114 дэх тал

¹³ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/92c0c4341cf6b1cbad13613f2912da0c48a13586/ [Сүүлд үзсэн: 2020.10.12] Гражданский процессуальный кодекс Российской Федерации статья, 2002

цахимжуулсанаар шүүгч, шүүхийн бусад ажилтнуудын ажлын ачаалал эрс буурсан бөгөөд цаасан хавтаст хэрэг гэсэн ойлголт байхгүй болж, хавтаст хэргийг 100 хувь электрон хэлбэрт оруулснаар хэргийн оролцогчид үйлчилгээ авч, шүүхэд хандахад цаг, орон зайн бэрхшээл учрахгүй болсноор тэдний цаг хугацаа зардлыг асар их хэмнэж улмаар байгаль орчины тэнцвэрт байдалд ч хувь нэмрээ оруулах болсон¹⁴.

Монгол улсад Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахал гарч улмаар цар тахал тархах, болзошгүй бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комиссын шат дараалсан шийдвэрүүд гарч, тодорхой үеүдэд хөл хорио тогтоосон. Үүнтэй холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 11 сарын 24-ний өдрийн 116 дугаар тогтоол, тогтоолын 2 дугаар хавсралтаар “Иргэний хэргийн хөдөлгөөний түр аргачлал”-ыг баталж уг аргачлалаар цахим шүүх хуралдааныг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, улмаар шүүхүүдэд цахим шүүх хуралдааныг явуулж эхэлсэн. Одоо ч хөл хориотой, хөдөө орон нутаг байгаа оролцогчдын хүсэлтээр Zoom аппликэйшн ашиглаж, шүүх хуралдааныг амжилттай зохион байгуулж байна. Энэ тохиолдолд шүүх хуралдааны дэгийг сахиулахад бэрхшээлтэй, техник хэрэгслийн хүрэлцээ муу зэрэг шалтгаан нөхцөл олон байгаа хэдий ч цаашид энэ шинэчлэлийг хийх бүрэн боломж байгааг, энэ нь олон төрлийн давуу талтай болохыг дээрх цаг хугацаанд бид харлаа.

ДҮГНЭЛТ, САНАЛ

ИХШХША-ны хугацаа нь практикт хэрхэн хэрэгжиж байгааг гадаадын болон дотоодын эрдэмтэн судлаачдын судалгаа болон шүүхийн одоогийн нөхцөл байдалд тулгуурлан харьцуулан судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрч байна. Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд тодорхой хугацааг тогтоон, иргэний зөрчигдсөн эрхийг түргэн шуурхай шийдвэрлэхээр хуульчилсан байна. Шүүх эрх мэдлийн нэр хүнд, нийгэмд үзүүлэх нөлөө шүүхийн шийдвэрийн чанараас хамаардаг боловч шүүхийн шийдвэр чанартай байх, шүүхийн процесс ажиллагаа хуульд заасан хугацаандаа биелэгдэх эсэх нь зөвхөн шүүхээс хамаарах асуудал биш юм. Энэ нь шүүхийн хүний нөөц, ажиллах нөхцөл, иргэдийн эрх зүйн ухамсар, шүүхийн удирдлага, хэргийн хөдөлгөөний менежмент зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалахаар байна. Хуулиар тогтоосон хугацаанд зохигч үүргээ биелүүлээгүйгээс үүсэх хариуцлага, эргээд тэднийг шалгах асуудал дутмаг учир шүүх хуралдааныг нэг талын хүсэлтээр олон удаа хойшлуулах нь практикт түгээмэл байна. Энэ нь эргээд шүүхэд маш их ачаалал болохоос гадна шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулж, үүнд шүүгчдийг, захиргааны ажилчдыг буруутгаж, татгалзан гаргах зэрэг асуудлыг бий болгосор байна. Иймд ИХШХША-ны хугацааны хэрэгжилтийг дээшлүүлж, иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг түргэн шуурхай хамгаалах, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн хэт ачааллаас болж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа практикт хэрэгжихгүй байгаа тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хугацааны талаарх зохицуулалтыг тодорхой, боловсронгуй болгох.
2. Шүүх хуралдаанд бэлтгэх үе шатанд хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, нотлох баримт гаргаж өгөх, цуглуулах ажиллагааг тодорхойлж, урьдчилсан хэлэлцүүлэг хийх.
3. Хэргийн оролцогч хуулиар болон шүүхээс тогтоосон хугацаанд үүргээ биелүүлээгүйгээс зөрчигдсөн эрхээ хамгаалах боломжоо алдана гэсэн үндсэн зарчмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах. Улмаар иргэн, хуулийн этгээд шүүх болон хэргийн бусад оролцогчийг хүндэтгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцлагатай оролцох нөхцөлийг бүрдүүлэх.

¹⁴ <http://www.judcouncil.mn/main/print:page.1.1012--.html>

4. Нэг хүний эрх бусдын эрхээр хязгаарлагддаг тул хэргийн оролцогч эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, санаатайгаар ажиллагаанд саад учруулсан, удаашруулсан тохиолдолд тухайн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай байна.
5. Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, цахимаар шүүх хуралдааныг хэлэлцүүлэх зэрэг тогтолцоог илүү боловсронгуй болгож, техник хэрэгсэл болоод цахимаар шүүх хуралдаан явуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, мэдээллийн технологид суурилсан нээлттэй, ил тод, шуурхай, хүртээмжтэй байх шүүх засаглалыг бий болгох.
6. Процесс ажиллагааны доторх хугацааг тогтоохдоо одоо шүүхийн практикт хэрэглэгдэж байгаа хэргийн хөдөлгөөний удирдлагын менежментийг илүү боловсронгуй болгох, улмаар практикт хуульд заасан хугацааг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлийг илүү олон талаас харж, үе шаттай арга хэмжээ авах зайлшгүй шаардлага тулгарч байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
- Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2014 он

Монгол хэлээр:

- А.Дугармаа нар, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, гарын авлага, УБ, 2007 он
- С.Жавхлан, *Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг дагаж мөрдөх асуудал, практик хэрэгжилт. Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд*, УБ, 2015 он
- Б.Хишигбаатар, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, практик хэрэглээ*. Шүүх эрх мэдэл №3, 2017 он
- Ч.Ичинхорлоо, *Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа буюу хурд*. Шүүх эрх мэдэл №3, 2014 он
- Д.Хуяг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд*, УБ, 2015 он
- Т.Мөнхжаргал, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /Ерөнхий анги/, УБ, 2011 он*
- Шүүхийн судалгаа, мэдээллийн төв, *Хэргийн хөдөлгөөний менежмент бодлогын судалгаа*, УБ, 2013 он
- Шүүхийн ерөнхий зөвлөл, *Шүүх эрх мэдэл, мэдээлэл арга зүйн улирлал тутмын эмхэтгэл*, №3, УБ, 2017 он

Гадаад хэлээр:

- Code of Civil Procedure of Japan, 1996, <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2834&vm=2&re=02>
- Гражданский процессуальный кодекс Российской Федерации статья, 2002 http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/92c0c4341cf6b1cbad13613f2912da0c48a13586/

Цахим эх сурвалж:

- <http://www.civilcourt.gov.mn>
- <http://www.judcouncil.mn>
- <http://legalinfo.mn>

CHALLENGES IN THE CIVIL PROCEEDINGS AS PER THE TIME LIMITS

B. Enkhbolor

LL.M. Candidate, School of Law, NUM

KEY WORDS:

Proceedings, Time Regulation by the Civil Procedure Code of Mongolia, Factors Not Being Implemented in Practice, General Time Limit and Case Management

ABSTRACT:

It was stipulated in the Civil Procedure Code that the disputes must be resolved within the specified period of time and that time limit shall not be changed by the court. In practice, as it's tough to resolve the civil cases within the set time limit and the failure to resolve the cases within the time limit has always been criticized and caused problems. The fact that it undermines the fair court decision and independence of the judges and affects the interests of the individuals and legal entities who seek for legal proceedings indicates the issue needs to be addressed further.

In civil proceedings, it is possible to resolve the disputes expeditiously within the time limit of the process or the time limit set by the court based on the parties' interests and it is a factor for the parties to exercise their rights and act responsibly.

I aimed to identify the theoretical and practical issues related to the time limit of the civil proceedings and studied the ways to address the issues based on the theoretical concepts and the experience of the other countries and analyzed and made some recommendation in the article.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Баярсайхан “МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ” цол хүртлээ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Д.Баярсайханд Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жил, Ардын хувьсгалын 100 жил, Ардчилсан хувьсгалын 32 жилийн ой, Монголын үндэсний уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 14 дүгээр зарлигаар “**МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ**” цол хүртээлээ.

Монгол Улсын Гавьяат багш Д.Баярсайханы ажил байдлын талаар товч дурдвас 1979 онд Нийслэлийн 18-р дунд сургууль, 1984 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр тус тус төгсөж, 1984-1990 оны хооронд Булган аймгийн прокурорын газар / Орлогч прокурор/, 1990 онд Улсын Ерөнхий Прокурорын газар /Хяналтын прокурор/, 1991-1992 онд Нийслэлийн прокурорын газар /Орлогч прокурор/, 1992-1993 онд Улсын Ерөнхий Прокурорын газар /Хэлтсийн дарга/, 1993 оноос одоог хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуульд багшилж байна.

Монгол Улсын Гавьяат багш Д.Баярсайхан нь Эрх зүйн онол, Харьцуулсан Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессын эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүй, Хүний эрхийн чиглэлээр сүүлийн 30 гаруй жил судалгааны ажил хийж байна. Тэрээр 1998 онд МУИС-ийн Хамгаалуулах зөвлөлд “Монгол Улсын төрийн бүрэн эрхт байдлын Үндсэн хуулийн эрх зүйн асуудлууд” сэдвээр хууль зүйн ухааны докторын зэргийг хамгаалсан.

Туурвисан бүтээлийн хувьд нэг сэдэвт судалгааны бүтээл болон дангаар бичиж гаргасан сурах бичиг, ном, гарын авлага 16, хамтарч гаргасан ном, судалгааны бүтээлүүд 21, эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллүүд 37, гадаадад хэвлэгдсэн эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл 4-ийг тус тус бүтээн туурвисан хөдөлмөрч эрхэм билээ.

Монгол Улсын Гавьяат багш Д.Баярсайхан Танд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зүгээс халуун баяр хүргэж, цаашдын эрдэм судлалын их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе.

ШИНЭ ЭРДЭМТНИЙ ТАНИЛЦУУЛГА



Д.Сундуйсүрэн

*ДХИС-ийн Удирдлагын академийн Удирдахуйн ухааны профессорын багийн профессор,
хууль зүйн ухааны доктор*

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Удирдахуйн ухааны профессорын багийн профессор Д.Сундуйсүрэн нь 2020 онд Монгол Улсын ДХИС-ийн түшиглэсэн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-д “Хүн барьцаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудал” сэдвээр хууль зүйн ухааны докторын зэрэг амжилттай хамгааллаа.

Тэрээр 1986-1990 онд Цагдаагийн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2004-2006 онд ОХУ-ын ДХЯ-ны Удирдлагын академийг удирдлагын менежер мэргэжлээр төгссөн, 2007-2009 онд МҮДС-д “Монгол Улсын авлигатай тэмцэх байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

Д.Сундуйсүрэн нь “Хүн барьцаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудал” сэдэвт докторын зэрэг хамгаалсан судалгааны ажлаараа хүн төрөлхтний орчин цагийн тулгамдсан асуудлын нэг болсон хүн барьцаалах гэмт үйлдлийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс нягтлан судалжээ.

Түүний судалгааны ажил нь хүн барьцаалах гэмт хэргийг тус улсын үе үеийн Эрүүгийн хуулиудад хуульчилж ирсэн түүхэн уламжлал, тэдгээрийн онцлог, уг гэмт хэргийн бүрэлдэхүүн болон адил төстэй бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудлын онол, мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны практикт Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг хэрэглэж байгаа өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тал бүрээс нь харьцуулан судалж, тухайн институтын эрүүгийн эрх зүйн үндэслэлийг боловсронгуй болгох санал, асуудал дэвшүүлэхийн зэрэгцээ хүн барьцаалах үйлдлийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, практикт тулгамдаж буй асуудлуудыг онол, практикийн түвшинд цогц байдлаар дагнан судалсан шинэлэг бүтээл юм.

Хүн барьцаалах үйлдлийн ойлголт, түүний мөн чанар, бусад ойролцоо төрлийн гэмт хэрэг, үйлдлээс ялгагдах шинж, онцлог, хууль зүйн учир холбогдлыг эрүүгийн эрх зүйн онолын үүднээс тодорхойлж, үндэсний болон гадаадын зарим улсын Эрүүгийн хууль тогтоомжийн зохицуулалтыг харьцуулан судалсан нь онол-танин мэдэхүйн ач

холбогдолтой бөгөөд тухайн салбар эрх зүйн сургалт, судалгаанд бүтээлчээр хэрэглэж болох хэрэглэгдэхүүн болсон байна.

Хууль зүйн ухааны доктор Д.Сундуйсүрэн нь Архангай аймгийн Цагдаагийн хэлтэст 1990-1994 онд хэсгийн төлөөлөгч, ахлах төлөөлөгч, 1994-1997 онд Сургалт, боловсон хүчин хариуцсан дэд дарга, 1997-2000 онд Эрүүгийн алба эрхэлсэн дэд дарга, 2000-2004 онд тус аймгийн цагдаагийн хэлтсийн дарга, 2006-2007 онд Нийслэлийн цагдаагийн газар, Улсын мөрдөн байцаах газрын дэд дарга, 2007-2011 онд Авлигатай тэмцэх газрын дэд дарга, 2012-2017 онд Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч, 2017 оны 3 дугаар сараас Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Удирдахуйн ухааны профессорын багийн профессороор ажиллаж байна.

Тэрээр Цэргийн гавьяаны одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, Цагдаагийн алдар хүндэт тэмдэг, АТГ-ын хүндэт тэмдгээр тус тус шагнагдаж байсан эрхэм хүндтэй нэгэн билээ.

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Удирдахуйн ухааны профессорын багийн профессор, хууль зүйн ухааны доктор Д.Сундуйсүрэн Танд баяр хүргэж, цаашдын эрдэм судлалын их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе!

ШИНЭ ЭРДЭМТНИЙ ТАНИЛЦУУЛГА



Ч.Сайнтөр

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт, бригадын генерал,
Хил судлалын ухааны доктор*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын төрийн цэргийн байгууллага хариуцсан ахлах референт, бригадын генерал Ч.Сайнтөр “Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам” сэдвээр доктор, профессор, хурандаа Ц.Ганболдын удирдлагад 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хил судлалын ухааны докторын зэрэг амжилттай хамгааллаа.

“Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам” сэдэвт хил судлалын ухааны докторын зэрэг хүртсэн судалгааны ажил нь Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн түүхэн уламжлал, шинэчлэлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, дотоодын төстэй чиг үүрэг бүхий байгууллагын хүний нөөцийн бодлоготой харьцуулж, хөрш зэргэлдээ зарим улсын сайн туршлагыг нутагшуулах арга замыг эрэлхийлэн диссертацийн түвшинд анх удаа судалснаараа онцлог байна.

Түүнчлэн, Хил хамгаалах байгууллага өнөөг хүртэл хүний нөөцийн бодлогоо гагцхүү дүрмээр зохицуулж ирсэн, үүгээрээ ижил төст бусад байгууллагаас хоцрогдонгуй байгааг судалгааны олон төрлийн арга ашиглан дүгнэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлж, тус байгууллагын хүний нөөцийн бодлогыг эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр анх удаа боловсруулж, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийг санал болгосонд уг судалгааны ажлын ач холбогдол орших юм.

Хил судлалын ухааны доктор Чоёндиваагийн Сайнтөр нь Харьков хотын Цэргийн ар талын дээд сургуулийг төгсөж ирснээсээ хойш хил хамгаалах салбарт офицероос ХХЕГ-ын дэд дарга хүртэл тасралтгүй 35 жил ажилласан, хил хамгаалах болон хил судлалын салбарт жинтэй хувь нэмэр оруулж яваа хилчин генерал-судлаач билээ.

Тэрээр 2017 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт төрийн цэргийн байгууллага хариуцсан ахлах референтээр ажиллаж байна.

Хил судлалын ухааны доктор, бригадын генерал Ч.Сайнтөр Танд баяр хүргэж, цаашдын эрдмийн их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе!

“ХУУЛЬЧДЫН НОМЫН САН”-Д ИРСЭН ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

Д.БАЯРСАЙХАН

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2020

Уг бүтээлийг зохиогч 2014 онд хэвлүүлсэн “Эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий анги” сурах бичгийн үндсэн бүтцийг өөрчлөхгүйгээр Монгол Улсын 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн, агуулгыг шинэчлэх замаар дахин хэвлүүлжээ. Уг бүтээлийн ялгарах гол онцлог нь тухайн шинжлэх ухааны уламжлалт хандлагыг улам баяжуулж, шинэчлэн хөгжүүлэхэд анхаарсан ба эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий ангийн суурь ойлголт, зарчим, судлагдахууныг орчин үеийн мэдлэгийн шинэ арга зүйд тулгуурлан авч үзсэнд оршино. Үүний зэрэгцээ Олон улсын гэрээ конвенц, Дэлхийн эрүүгийн процессын загвар хуулийн үзэл баримтлал, гадаадын өндөр хөгжилтэй орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, чиг хандлагыг зохих хэмжээнд тусган, харьцуулсан судалгааны зарим асуудлыг тусгайлан хөндөж оруулснаараа онцлогтой бүтээл болжээ.

---o0o---


Болдбаатарын ТАМИР

ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙ

ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Б.Тамир. Олон Улсын хувийн эрх зүй: Орчин үеийн чиг хандлага. Уб., 2019


МУИС-ын Хууль зүйн сургуулийн багш Б.Тамирын энэхүү бүтээлд олон улсын хувийн эрх зүйн үндсэн асуудал (шүүхийн харьяалал, хэрэглэгдэх хууль, гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх)-аас гадна орчин үеийн хөгжлийн чиг хандлага, ялангуяа хоёр өөр улсын шүүхэд нэгэн зэрэг хэрэг үүсгэх, сул талыг хамгаалах зорилго бүхий шүүхийн харьяалал, шүүхийг сонгох хэлэлцээр, гадаад улсын хуулийг шүүхийн бус байгууллага хэрэглэж болох эсэх, гэм хорын тусгай төрөлд хэрэглэгдэх хуулийг сонгох журам, түүнчлэн энэ салбарт шинэ зохицуулалт шаардаж буй зарим харилцааны талаар онцлон дурджээ.



Ц.Давхарбаяр, Д.Янжинхорлоо. “Иргэний эрх зүйн хэм хэмжээг арилжаа (худалдаа)-ны харилцаанд тайлбарлан хэрэглэх онол, арга зүй. Уб., 2020

Шүүгчийн хууль тайлбарлан хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх нь шүүхийн сургалтын нэг үндсэн зорилт юм. Энэ зорилтын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс МУИС-ийн Хууль зүйн сургуультай хамтран эрүү, захиргаа, иргэний эрх зүйн хууль тайлбарлах онол, арга зүй сэдэвт сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулжээ. Гарын авлагад хуулийг тайлбарлах, хэрэглэх онол, иргэний эрх зүйн хэм хэмжээг арилжаа (худалдаа)-ны харилцаанд тайлбарлан хэрэглэх, арилжааны харилцаанд баримтлах зарчмыг тодорхойлж, гадаадын зарим орны энэ төрлийн харилцаанд хэрэглэж буй хэм хэмжээ, тэдгээрийн онцлогт хамаарах асуудлуудыг хөндөж, арилжааны маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн зарим шийдвэрийг жишээ болгон дүгнэсэн зэрэг нь онол болон практикийн ач холбогдолтой болжээ.

---ооо---



Д.Зүмбэрэлхам. Төрийн алба: шинэтгэлд шимтэхийн учир /илтгэл, өгүүлэл, ярилцлага, нийтлэл/ Уб., 2020

2020 онд үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойтойгоо золгож байгаа Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөл бол төрийн албаны шинэтгэлийн зорилгоор төрийн бодлогын хүрээнд тусгайлан байгуулсан байгууллага билээ.

Төрийн албаны албан тушаалын шатлан дэвших тогтолцоо, түүний шалгуурууд, сул байгаа албан тушаалын чиг үүргийг түр орлон гүйцэтгүүлэх журам, албан тушаалын тодорхойлолтыг гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирсон байдлаар нэгдсэн байдлаар багалж мөрдүүлэх, төрийн албан хаагч нэг бүрийн суралцан хөгжих тогтолцоог бүрдүүлэх, төрийн албанд чадахуйн зарчмыг суурь болгон баримтлах зэрэг зарчмын шинжтэй гол асуудлууд 2017

онд Төрийн албаны хуулийг шинэчлэн найруулахад тусгагдан хэрэгжилтийн шатандаа орсон. Эдгээрийг боловсруулах, хэрэгжүүлэн зохион байгуулах үйл явц хэрхэн өрнөж ирсэн түүхийн зарим хэсгийг энэ номноос унших, мэдэх боломжтой. Мөн төрийн албаны шинэтгэлийн талаар тавьсан илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ярилцлага нь хувь хүний бүтээл гэхээсээ илүү тухайн цаг үеийн үйл явдлыг гэрчлэх баримт болж байна.

БАГ-ЭРДЭНИЙН БУЯНХИШИГ

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ЭРХ ЗҮЙ**

УЛААНБААТАР 2021 ОН

Б.Буянхишиг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Уб., 2021

Зохиогч энэхүү бүтээлдээ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим, дараалал, нэхэмжлэлийн агуулгыг тодорхойлох, шийдвэр гаргах үйл явц, түүний эрх зүйн үр дагавар, мөн шийдвэрийг хянуулах процессын талаар тусгажээ. Энэ нь зохиогчийн зааж буй материаллаг эрх зүйн хичээлийг процесст хэрхэн хэрэгжих тухай эхлэн суралцагсад хүргэх энгийн зорилготой ажээ.

---000---

**“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД НИЙТЛЭГДЭХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГА /ЗАГВАР/**

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА ХӨГЖЛИЙН БОДЛОГО

/Бүтээлийн ерөнхий гарчиг нь 10pt хэмжээтэй, Times New Roman, **Bold**, **ТӨМ ҮСГЭЭР**/

ELECTORAL SYSTEM AND DEVELOPMENT POLICY

/Бүтээлийн гарчиг Англи хэлээр/



/Бүтээлээ ирүүлэхдээ зохиогчийн зураг (300-аас доошгүй нягтаршилтай, dpi, jpg, өргөтгөлтэй), цахим шуудан, холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байх./

М.Долгорсүрэн

ШУА-ийн Философийн хүрээлэн ЭШДэдА

/Зохиогчийн овог, нэр нь Times New Roman, 11 pt хэмжээтэй, **BOLD ITALIC**. Мөн эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй албан тушаал нь монгол, англи хэл дээр, *Times New Roman, 10 pt хэмжээтэй, налуу байна.*/

ТОВЧЛОЛ:

Өгүүлэлд зохиогч тус бүтээлийн товч утгыг Монгол болон Англи хэл дээр бичиж хавсаргана. Өгүүллийн товч утга нь өгүүллийн агуулгыг ойлгомжтой байдлаар хураангуйлсан нэг цогцолбор байна.

/Бүтээлийн товчлолыг ирүүлэхдээ Times New Roman, 11 pt хэмжээтэй ирүүлэх./

ТҮЛХҮҮР ҮГС:

Түлхүүр үгс нь 5 хүртэлх тооны холбоо нэр үгээс бүрдэх ба бүтээлийн гарчигт ороогүй үгээс бүрдсэн байна. Түлхүүр үгсийг Монгол болон Англи хэл дээр бичиж хавсаргана.

/Бүтээлийн товчлолыг ирүүлэхдээ Times New Roman, 11 pt хэмжээтэй ирүүлэх./

ҮНДСЭН ХЭСЭГ:

Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж буй эрдэм шинжилгээний бүтээл нь MS Word програмаар, үндсэн бичвэрийг Times New Roman, 11 pt, мөр хоорондын зай 1 (single); эшлэл, зүүлтийг Times New Roman, 10 pt, мөр хоорондын зай 1 (single) хэмжээтэй байхаар бичих бөгөөд .docx өргөтгөлөөр ирүүлэх.

Бүтээл нь гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өмнө нь хэвлэн нийтлэгдээгүй байх, агуулгын хувьд зохиогчийн эрх зөрчөөгүй байх, Эшлэл, зүүлтийг стандартын дагуу тэмдэглэсэн, зохиогчийн эрхийн зөрчилгүй, зүй бус хэллэг ашиглаагүй байх шаардлагыг хангасан байна.

Өгүүлэл нь гарчиг, түлхүүр үгс, товчлол, эх сурвалжийн жагсаалт, хавсралтаас гадна 2500-аас доошгүй үгтэй байна.

Үндсэн хэсэгт гадаад, дотоодын эрх зүйн онолын болон эрдэмтдийн бүтээл, тохиолдол (англ. *case*) ашиглан дэвшүүлсэн санаагаа илэрхийлэх, өөрийнх биш санаа, өгүүлбэрт эшлэл заавал авсан байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ:

Дүгнэлт, саналыг бичихдээ Үндсэн хэсэгт дурдаагүй шинэ санаа оруулахгүй бөгөөд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэх арга зам санал болгосон байвал зохино.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ:

Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийн эшлэлийг хуудасны доод талд (англ. *footnote*), үргэлжлүүлэн дугаарлах байдлаар авах бөгөөд бүтээлийн төрлөөс үл хамааран дараах байдлаар эшлэл авсан байвал зохино:

Нэг зохиогчтой бүтээлээс эшлэхдээ зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, бүтээлийн нэр (налуу), хэд дэх удаагийн хэвлэл болох, хэвлэн нийтэлсэн газар, хэвлэлийн байгууллага, хэвлэн нийтэлсэн он, хуудасны дугаар гэсэн дараалал баримтална.

Жишээлбэл: С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо (харьцуулсан эрх зүй), УБ, Адмон, 2001, 98 дахь тал

Хоёр болон түүнээс дээш зохиогчтой бүтээлээс эшлэхдээ хоёр зохиогчтой бол хоёулангийнх нь овгийн эхний үсэг, нэрийг; хоёроос дээш зохиогчтой бол гол зохиогчийн нэрийг бичээд “нар” хэмээх олон тооны нөхцөлийг залгана. Зохиогчдын нэрээс бусад нь нэг зохиогчтой номоос эшлэхтэй адил байна.

Орчуулгын бүтээлээс эшлэхдээ зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, бүтээлийн нэр (налуу), “орч.” гээд орчуулагчийн нэр, хэвлэн нийтэлсэн газар, хэвлэлийн байгууллага, хэвлэн нийтэлсэн он, хуудасны дугаар гэсэн дараалал баримтална.

Жишээлбэл: Чезаре Беккариа, Гэмт хэрэг ба ялын тухай, орч. Г.Эрдэнэбат, УБ, Нээлттэй нийгэм форум, 2017, 23 дахь тал

Цахим хуудсаас эшлэхдээ бүтээлийн эшлэл, холбогдох цахим хуудсын холбоос (англ. *URL*), цахим хуудсыг үзсэн сүүлийн огноог бичнэ.

Жишээлбэл: Хууль зүйн үндэсний хүрээлэн, Нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, *Судалгааны тайлан*, УБ, ХЗҮХ, 2013 он, 33 дахь тал <https://legaldata.mn/buteel/pdf?id=215>. [Сүүлд үзсэн: 2020.09.28]

Өгүүлээс эшлэхдээ зохиогчийн овгийн эхний үсэг, нэр, бүтээлийн нэр (хашилтад), нийтлэгдсэн сэтгүүлийн нэр (налуу), дугаар, он, хуудасны дугаар (тодорхойлох цэгээр тусгаарлана) гэсэн дарааллыг баримтална.

Жишээлбэл: Ж.Амарсанаа “Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц ба Монгол Улсын үндэсний хууль тогтоомж: Уялдуулах арга зам” Хууль дээдлэх ёс сэтгүүл №3 (2005), 70 дахь тал.

Хууль тогтоомжоос эшлэхдээ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn)-ээс авах бөгөөд дам эх сурвалж хэрэглэхгүй байвал зохино.

ЭХ СУРВАЛЖ

Ном зүй нь гагцхүү тухайн эрдэм шинжилгээний бүтээлд ашигласан бүтээлээс бүрдэх бөгөөд зохиогч, бүтээлийг цагаан толгойн үсгээр дарааллуулж бичнэ. Эх сурвалжийг Times New Roman, 11pt, мөр хоорондын зай 1 (single) хэмжээтэй бичих мөн баруун зүүн талаасаа зэрэгцэн байна. Ингэхдээ Гадаад болон Дотоодын эх сурвалжийг бүлэглэн бичнэ.

Жишээлбэл:

I. Эрх зүйн эх сурвалж:

- Монгол улсын үндсэн хууль. 1992 он.
- Сонгуулийн тухай хууль. 2015 он.
- Сонгуулийн автомажуулсан системийн тухай хууль. 2011 он.

II. Монгол эх сурвалж:

- С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо (*харьцуулсан эрх зүй*), УБ, Адмон, 2001

III. Гадаад эх сурвалж:

- 宋晓燕, 中国外商投资制度改革, 从外资三法到 “外商投资法”, 2019
- David sneath, “Constructing Socialist and Post-Socialist Identities in Mongolia”, Mongolians after socialism: Politics, Economy, Religion, 2012.

IV. Цахим эх сурвалж:

- <https://www.legalinfo.mn/law/details/19?lawid=19>

---o0o---

“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” сэтгүүлд нийтлэл хүлээн авах хугацаа

Дугаар	Нийтлэл хүлээн авах хугацаа	Хянан магадлагаа /A Peer-Review/	Эх бэлтгэл, Хэвлэл
I улирал	I/1-II/15	II/20-III/15	III/20-III/30
II улирал	IV/1-V/15	V/20-VI/15	VI/20-VI-30
III улирал	VII/1-VIII/15	VIII/20-IX/15	IX/20-IX/30
IV улирал	X/1-XI/15	XI/20-XII/15	XII/20-XII/30
Mongolian Journal of Law (Англи хэл дээрх дугаар)	I/1-X/30	XI/1-XII/20	XII/20-XII/30

“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь олон улсын стандартад нийцсэн, хянан магадлагаа бүхий (A Peer-Reviewed), мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүл болох эрхэм зорилт тавин, Сэтгүүлийн зөвлөлийг гадаад, дотоодын нэр хүндтэй эрдэмтэн, профессор, судлаачдаар бүрдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор нийтлэл хэвлүүлэхэд нэг бүтээлийн хянан магадлагааны хураамж (A Peer-Review fee) 50,000 төгрөг болно. Та өөрийн бүтээлээ сэтгүүлд ирүүлэхдээ хянан магадлагааны хураамжаа (Төрийн сан: 100900012009) тоот дансанд тушааж, баримтаа хавсарган ирүүлээрэй.